

ГАРЧИГ

Ерөнхий хэсэг	4-4
Судалгааны арга зүй.....	5-5

I Бүлэг. Баянхонгор аймгийн байгаль, цаг уур, нийгэм-эдийн засгийн нөхцөл

Баянхонгор аймгийн тухай ерөнхий ойлголт.....	6-6
Байгаль цаг уурын нөхцөл	
Уур амьсгалын нөхцөл.....	6-8
Газрын гадарга.....	8-9
Хөрс, хөрсөн бүрхэвч.....	9-14
Ургамал, ургамлан бүрхэвч.....	14-15
Ан амьтан.....	15-15
Ус зүй.....	15-22
Инженер геологийн нөхцөл.....	22-22
Орчны бохирдол.....	22-23
Дүгнэлт	23-23
Нийгэм-эдийн засгийн нөхцөл	
Нийгэм-эдийн засгийн суурь нөхцөл.....	23-23
Хүн ам	23-24
Газар тариалан.....	24-25
Мал аж ахуй.....	25-26
Үйлдвэрлэл, үйлчилгээ.....	27-28
Дэд бүтэц, зам харилцаа, бусад салбар.....	29-31
Дүгнэлт	31-31

II Бүлэг. Баянхонгор аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал

Баянхонгор аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц.....	32-34
2.2. ХАА-н ангиллын газрын бүтэц, ашиглалт, хамгаалалтын байдал.....	34-35
2.2.1 Тариалангийн газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал.....	35-37
2.2.2 Жимс, жимсгэний газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал.....	37-39
2.2.3 Хадлангийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.....	39-40
2.2.4 Бэлчээрийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.....	40-48
2.2.5 ХАА-н барилга байгууламжийн газар.....	48-49
2.2.6 ХАА-д ашиглах боломжгүй газар.....	49-49
Дүгнэлт	49-49
2.3. Хот тосгон бусад суурины ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал	
2.3.1. Хот, тосгон бусад суурины ангиллын газрын бүтэц	49-50
2.3.3.2. Хот, тосгон бусад суурины тэг гортигийн доторхи газрын ашиглалт, хамгаалалтын байдал.....	50-53
2.3.3. Амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын газрын ашиглалт, хамгаалалтын байдал.....	53-57
2.3.3.4. Үйлдвэр уурхайн газрын ашиглалт, хамгаалалтын байдал.....	57-57
Дүгнэлт	57-58
2.4. Зам, шугам сүлжээний ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалт.	

2.4.1	Зам, шугам сүлжээний ангиллын газрын бүтэц.....	58-58
2.4.2	Автозамын зурвас газар.....	58-58
2.4.3	Инженерийн шугам сүлжээний зурвас газар.....	58-59
Дүгнэлт		59-59
2.5.	Ойн сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.	
2.5.1.	Ойн сангийн ангиллын газрын бүтэц.....	59-59
2.5.2.	Ойн сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.....	59-65
Дүгнэлт		65-65
2.6.	Усны сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.	
2.6.1.	Усан сангийн ангиллын газрын бүтэц.....	65-66
2.6.2.	Усны сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.....	66-67
Дүгнэлт.....		67-67
2.7.	Тусгай хэрэгцээний ангиллын газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал.	
2.7.1.	Тусгай хэрэгцээний ангиллын газрын бүтэц.....	67-67
2.7.2.	Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.....	67-70
2.7.3.	Улсыг батлан хамгаалах зориулалтын газар.....	70-70
Дүгнэлт.....		

III Бүлэг. Газрын менежментийн бүсүүд, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт

3.1 ХАА-н ангиллын газрын менежментийн бүсүүд, түүний нөөц нөхцөлийн төлөвлөлт

3.1.1.	Тариалангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт.....	71-76
3.1.2.	Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх талаар төлөвлөсөн асуудлууд.....	76-82
3.1.3.	Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх талаар гаргасан зөвлөмж.....	82-87
3.1.4.	Хадлангийн газрын менежментийн бүсүүд, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт.....	87-88
3.1.5.	Хадланд шинээр эзэмших талбайнууд, тэдгээрийн товч тодорхойлолт.....	88-88
3.1.6.	Хадлангийн эдэлбэр газрын ашиглалтыг эрчимжүүлж, хамгаалалтыг сайжруулах.....	89-90
3.1.7.	Бэлчээрийн менежментийн бүсүүд, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт	
3.1.8.	Бэлчээрийн менежмент.....	90-92
3.1.9.	Бэлчээрийг зөв зохистой ашиглах, хамгаалах талаар.....	92-96

3.1.10. Бэлчээрийн усан хангамжийн асуудал.....	96-105
3.1.11. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт.....	
3.1.12. Тэжээл үйлдвэрлэл түүний хэтийн төлөв.....	106-107

3.2 Хот тосгон бусад суурины суурьшилийн бүсийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт

3.2.1. Баянхонгор хот, сумын төвүүдийн эзэмшил газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт.....	107-110
3.2.2. Баянхонгор хот, сумын төвүүдийг үер, усны аюулаас хамгаалах талаар	
3.2.3. Үйлдвэр уурхайн бүс газар, тэдгээрийн нөөц, нөхцөлийн төлөвлөлт	110-112
3.2.4. Амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын газрын төлөвлөлт.....	112-114

3.3 Зам, шугам сүлжээний газрын төлөвлөлт

3.3.1. Автозамын газрын төлөвлөлт.....	114-114
3.3.2. Төмөр замын газрын төлөвлөлт.....	114-114
3.3.3. Шугам сүлжээний газар, түүний төлөвлөлт.....	114-115

3.4. Ойн сангийн газрын төлөвлөлт.....115-118

3.5. Усны сангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт.....118-119

3.6. Улсын тусгай хэрэгцээний газрын бүсүүд, түүний нөөц, нөхцлийн төлөвлөлт

3.6.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, нөхцлийн төлөвлөлт.....	119-121
---	---------

3.7. Биологийн төрөл зүйлийг хамгаалах талаар.....121-121

IV бүлэг. Газар ашиглалтын экологи - эдийн засгийн үнэлгээ

4.1. Газрын экологийн чадавхи, түүний хадгалалт, хамгаалалт.

Газар хамгаалалтын арга хэмжээ.....	121-125
Нэн ховор, ховор ургамал тэдгээрийн тархалт.....	125-128
4.1.1. Газрын экологийн чадавхи.....	
4.1.2. Газрын экологийн төлөв байдал, түүний хадгалалт, хамгаалалт.....	
4.1.3. Газрын хадгалалт, хамгаалалт.....	

4.2. Газрын эдийн засгийн үр ашиг, удирдлага, зохион байгуулалт.

4.2.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт.....	
4.2.2. Газрын эдийн засгийн үнэлгээ.....	

Ерөнхий дүгнэлт.....	128-129
----------------------	---------

Ашигласан хэвлэлийн жагсаалт.....	130-130
-----------------------------------	---------

Ерөнхий хэсэг

Монгол улсад Газрын тухай багц хууль батлагдсанаар Газрын харилцааны олон асуудлууд хууль эрх зүйн хүрээнд цогц байдлаар үе шаттайгаар хэрэгжиж байгаагийн нэг илрэл бол улс, аймаг сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж мөрдөх явдал юм.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө гэдэг нь аймгийн хөгжлийн алс хэтийн бодлогыг газрын нөөцийн төлөвлөлтөөр дэмжихийн хамт, газрын нэгдмэл сангийн ангилал бүрт эдийн засгийн үр ашигтай цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг тодорхойлсон зураг төслийн баримт бичиг байдаг. Өөрөөр хэлбэл байгалийн унаган төрх байдал, одоогийн төлөв байдалд үнэлэлт дүгнэлт өгч, түүний нөөц баялгийг тооцоолсны үндсэн дээр газар ашиглалтын хамгийн ашигтай хувилбар, төлөвлөгөөг боловсруулахын дээр цаашид газрын нөөц баялгийг хэрхэн хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга замуудыг зааж өгсөнөөрөө шинэлэг юм. Энэхүү бичиг баримтыг мөрдлөг болгосноор тухайн бүс нутагт газрын шинэтгэлийн олон асуудлууд хуулийн дагуу шийдэгдэхээс гадна, газар эзэмшигч ашиглагчийн эрх ашиг хамгаалагдаж газар ашиглах таатай, тогтвортой орчин бүрдэнэ.

Энэ ажлын хүрээнд Баянхонгор аймгийн газар ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгч нийгэм эдийн засгийн хөгжилийг газрын менежментийн бодлогоор дэмжин зохицуулах зорилт тавив.

Баянхонгор аймгийн Засаг даргын захиалгаар Газрын чиглэлийн мэргэжилийн эрх бүхий байгууллага “Глобус” ХХК нь 2006-2007 онд Баянхонгор аймгийн Газар Зохион Байгуулалтын Ерөнхий Төлөвлөгөө боловсруулах ажлыг одоо мөрдөгдөж буй арга зүй, зааврын дагуу эрдэмтэн мэргэд, оюутан залуусын хүч оюуныг нэгтгэн зангидаж, мэргэжилийн баг бүрдүүлэн хийж гүйцэтгэлээ. Уг ажлыг хийж гүйцэтгэхэд манай байгууллагын ажилтан мэргэжилтнүүдээс гадна Ус Цаг Уурын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн, Дархан хотын ХАУТЛаборатори, ХААИС, ШУА-ийн Ботаникийн хүрээлэн, Усны институт, Ой усны хайгуул судлалын төв, Эрчим Хүчний Судалгаа Хөгжилийн Төвийн мэргэжилтэнгүүд өргөн оролцсон юм.

Уг ажлыг гүйцэтгэхэд оролцсон албан байгууллага, хувь хүмүүс, мэргэжилтнүүдэд болон тоон болон зурган мэдээлэлээр хангаж, хөндлөнгийн хяналт тавьж ажилласан Газрын албаны хамт олонд зохиогчийн зүгээс гүн талархал илэрхийлье.

Тайланг эмхтгэн бичсэн Д. Цэцгээ

Судалгааны арга зүй

Уг ажлыг гүйцэтгэхдээ ГХГЗЗГ-аас боловсруулан гаргасан “Аймгийн Газар Зохион Байгуулалтын Ерөнхий Төлөвлөгөө Боловсруулах арга зүйн зааврыг” /1/ мөрдлөг болгон ажиллав. Үүнд юуны өмнө хөрс, ургамал, ус зүй, цаг уур, ан амьтан гэсэн байгалийн унаган нөхцөл байдлын судалгааг хийсэн бөгөөд үүн дээр тухайн бүс нутгийн нийгэм эдийн засгийн судалгаа, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр”, “Мянганы зам”, “Баянхонгор аймгийн хөгжлийн үндсэн чиглэл”, Баянхонгор аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”, Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”, “Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр” /2-22/ зэрэг олон баримт бичгүүдийг өргөн дэлгэр ашиглав. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байгаль орчны урт хугацааны бодлого хөтөлбөрийг бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ” гэснийг үндэслэн Баянхонгор аймгийн Газар Зохион Байгуулалтын Ерөнхий Төлөвлөгөөг нутаг дэвсгэрийн бүсчилсэн зохион байгуулалт буюу нутаг дэвсгэрийг бүсчлэн төлөвлөх аргаар гүйцэтгэсэн болно. Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, практик амьдралыг онолын зарчмуудтай нь холбон судалж, харьцуулан жиших, газар зүйн судалгааны гол арга болох хээрийн судалгаа, зураг зүйн аргуудыг өргөн хэрэглэсэн.

Арга зүйн зарчим нь газрын менежментийн бүсийг нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, төлөвлөлтийн аргаар дэмжих явдал байв.

Төлөвлөлтийн ажлыг

2005-2010 он хүртэл ойрын,

2010-2015 он хүртэл дунд,

2015-2020 он хүртэл хэтийн гэсэн 3 үе

шаттайгаар төлөвлөв. Зургийн ажлыг 1:100 000 масштабын байр зүйн зураг болон Америкийн LANDSAT хиймэл дагуулын панхроматик сувгийн 1 цэг нь 15 м зөвшөөрөгдөх чадвартай мэдээлэл, Хятад-Бразилийн хамтарсан CBERS-2 хиймэл дагуулын 1 цэг нь 20 м зөвшөөрөгдөх чадвартай мэдээлэлийн 5 сувгийг ашиглан гүйцэтгэсэн ба зургийг тоон хэлбэрт оруулах ажлыг газар зүйн мэдээллийн системийн GIS-ийн ARCVIEW- 3.2, ARC INFO-3.5, ERDAS 8,7 программ хангамж ашиглан боловсруулав. Үүнд: аймгийн нутаг дэвсгэрээр

Экосистемийн зураг 1:1 500 000

Хөрсний зураг 1:1 500 000

Хадлан бэлчээрийн зураг 1:1 500 000

Ургамалжилтын зураг 1:1 500 000

Гүний усны зураг 1:1 500 000

Геологийн тойм зураг 1: 1 500 000

Хадлан бэлчээрийн зураг 1:1 500 000

Ойн сангийн зураг 1: 1 500 000 масштабаар үйлдэж тайлангийн 1-р бүлэгт хавсаргаснаас гадна ГЗБЕТ-ний зургийг 1: 200 000 масштабтайгаар хэвлэж хавсаргав. Аймгийн Газрын Алба санал болгосны дагуу

хадлан, тариалангийн газрын төлөвлөлтийн хэсэгчилсэн зургийг 1:25 000

уул уурхай, аялал жуулчлалын төлөвлөлтийн зургийн 1:50 000

ерөнхий төлөвлөгөөний үндсэн зургийг 1: 100 000

бэлчээрийн менежментийн зургийг 1:100 000 масштабаар,

сум тус бүрээр тус тус хэвлэв.

Ажлын тайлан нь Баянхонгор аймгийн байгаль, цаг уур, нийгэм -эдийн засгийн нөхцөл, Баянхонгор аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц, ашиглалт хамгаалалтын одоогийн байдал, Газрын менежментийн бодлогын бүсүүдийн төлөвлөлт, Газар ашиглалтын экологи-эдийн засгийн үнэлгээ гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрдэж байна.

I Бүлэг. Баянхонгор аймгийн байгаль, цаг уур, нийгэм-эдийн засгийн нөхцөл

1.1. Баянхонгор аймгийн тухай ерөнхий ойлголт

Баянхонгор аймаг нь манай орны баруун өмнөд хэсэгт, хойт талаараа Архангай, зүүн талаараа Өвөрхангай, Өмнөговь, урд талаараа БНХАУ-тай 140 км, баруун талаараа Говь-Алтай, Завхан аймагтай хиллэн оршино. Улсын хилийн зурвас газар 74,5 мянган га газар болно. Тус аймаг нь хойноосоо урагш сунасан хэлбэртэй говь, хээр тал, хангай хосолсон нийт 11597.8 мянган га талбайг эзлэх ба энэ нь манай улсын нийт нутаг дэвсгэрийн 7.6 % -тай тэнцэнэ. Хойд хэсэг Хангайн нурууны өмнөд хэсгийн тэгш өндөрлөг, болох ойт хээрт, дунд хэсэг Говь - Алтайн уулсын ар, Нууруудын хөндий, Хангайн нурууны өвөр болох говь, тал хээрт , өмнөд хэсэг Говь-Алтайн уулс, Алтайн цаад говийн цөлөрхөг хэсэгт хамаарна. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 19,5% нь буюу 2265,5 мянган га талбай улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг. Үүнээс 1361,5 мянган га дархан цаазат газарт, 810,7 мянган га байгалийн цогцолбор газарт хамрагдана.

Нийт нутаг нь далайн түвшнээс дээш 1000-1400 м өргөгдсөн боловч хамгийн нам газар нь Эхийн гол 720 м, хамгийн өндөр цэг Их Богд уул 3957 м өндөрт оршино Аймгийн нутгийн урд хилээс хойт хил хүртэл 565 км, баруунаас зүүн хил хүртэл 300 орчим км зайтай байна.

Засаг захиргааны зохион байгуулалтын хувьд 20 сум 100 багт хуваагдах бөгөөд аймгийн төв Баянхонгор хот нь Улаанбаатар хотоос 630 км, Бүсийн тулгуур төв Эрдэнэт хотоос 700 км зайтай оршино. Тус аймаг нь 2006 оны байдлаар 82 229 хүн амтай байгаагаас 26 252 нь аймгийн төвд оршин сууж байна. Нийт хүн амын 41.1 % буюу 27.4 мянга нь хөдөлмөрийн чадвартай, үүний 63.0% нь ХАА-н үйлдвэрлэлд ажиллаж байна.

Иргэдийнхээ сайхан амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлж, орон нутгийнхаа онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлж, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд жигд хөгжсөн, ХАА, аж үйлдвэр хосолсон нутаг болох зорилт тавьж байна. Үүний тулд аймгийг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг боловсронгуй болгож, бүс нутаг, хөдөөд чиглэсэн төрийн бодлогыг хүчтэй болгох шаардлагатай.

1.2 Баянхонгор аймгийн байгаль, цаг уурын нөхцөл

1.2.1 Уур амьсгалын нөхцөл.

Баянхонгор хотын агаарын жилийн дундаж температур -0,7 хэм, 1-р сарынх -18,4 (-18 - -30) хэм, 7-р сарынх 15 (15-30) хэм байна. Жилд 216,3 мм хур тундас унадаг, Агаарын даралт 810 гПа баруун хойд зүгийн салхи зонхилох бөгөөд салхины дундаж хурд 3,1 м/сек, хамгийн их салхитай 5-р сард 3,9 м/сек хүрнэ.

Баянхонгор аймгийн нутаг нь умардын хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнөдийн хэт хуурайд шилжих явцад үүссэн эх газрын эрс тэс уур амьсгалтай. Монгол орны уур амьсгалын мужлалаар дараах бүсүүдэд хамрагдаж байна. Үүнд:

- I. Чийглэгдүү сэрүүн /Хангайн уулархаг/
- II. Хуурайдуу сэрүүвтэр /Хээрийн /
- III. Хуурай дулаан /Говийн /

Иймд тус аймгийн уур амьсгалын нөхцлийг тус бүрээр нь авч үзэх нь зүйтэй /хүснэгт 1/.

I. Чийглэгдүү сэрүүн бүсэд Галуут, Эрдэнэцогт, Жаргалант, Гурванбулаг сумдын Хангайн нурууны өмнөд хэсгийн уулархаг нутгууд хамрагдана. Энэ бүсийн жилийн дундаж агаарын температур -3.2°C агаарын үнэмлэхүй их температур 7-р сард 36.5°C , үнэмлэхүй бага температур 1-р сард -50°C -т хүрч байна. Жилд дундажаар 210-230 мм хур тунадас унана. Хур тунадасны хэмжээ дулааны улиралд 190 мм хүйтний улиралд 30 орчим мм байна. Салхины жилийн дундаж хурд 4.0 м/с, хүчтэй салхитай /15м/с-с дээш/ өдрийн тоо жилд дундажаар 10-15 орчим байна. Уур амьсгалын энэхүү үзүүлэлтүүд нь тус бүс нутгийн өвөл нь харьцангуй удаан үргэлжилж, зун нь сэрүүн байдаг онцлогтойг харуулж байна. Энэ бүсэд намрын эхний хүйтрэлт 8-р сарын эхний 3-р 10 хоногт, хаврын эцсийн хүйтрэлт 6-р сарын 2-р 10 хоногт ажиглагдаж байна.

II. Байгаль уур амьсгалын хуурайдуу сэрүүвтэр бүсэд Баянбулаг, Заг, Баян-Овоо, Бөмбөгөр, Өлзийт, Хүрээмарал зэрэг сумдын Хангайн нурууны шувтрага үзүүрээс нууруудын хотгорын хойт хэсгийг хамарсан талархаг нутгууд хамрагдана. Энэ бүсэд жилийн дундаж агаарын температур 0°C байх ба агаарын үнэмлэхүй их температурын дундаж 15.0°C , үнэмлэхүй бага температурын дундаж -22.0°C , үнэмлэхүй их температур 7-р сард $30-35^{\circ}\text{C}$, үнэмлэхүй бага температур 1-р сард -45°C -д хүрдэг байна, Үүний 90 орчим % нь хүйтний улиралд унадаг байна. Энэ бүсийн нутагт намрын эхний хүйтрэлт 9-р сарын 2-р 10 хоногт, хаврын сүүлчийн хүйтрэлт 6-р сарын эхний 10 хоногт тохиолдох ба 9-р сарын сүүлч 10-р сарын эхээр тогтвортой цасан бүрхүүл бий болж, 9-р сарын сүүлч хүртэл цастай байна. Цасан бүрхүүлийн зузаан 10-15 см байна. Тус бүс нутагт салхины жилийн дундаж хурд 4-5 м/с, голчлон баруун, баруун хойт зүгээс салхилна. Хаврын салхины дундаж хурд 6 м/с байдаг. Жилдээ 10-15 өдөр шороон шуургатай, 5-8 өдөр цасан шуургатай байна. Энэ бүсэд өвөл нь чийглэгдүү сэрүүн бүсийн өвлөөс үргэлжлэх хугацаа богино, хахир хатуу биш байдгаараа ялгаатай. Уур амьсгалынхаа нөхцлөөр энэ бүс ХАА-н үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэхэд бусад бүсүүдээсээ харьцангуй тохиромжтой байна.

III. Аймгийн төв, өмнө хэсгийн тухайлбал нууруудын хотгор, Говь- Алтайн нуруу ба түүний цаадах говийн Баянцагаан, Шинэжинст, Баян-Өндөр зэрэг сумдын нутаг нь Монгол орны уур амьсгалын хуурай дулаан бүсэд хамрагдана. Энэ бүсийн уур амьсгалын үзүүлэлтүүдийг “Тоорой” дахь цаг уурын станцын олон жилийн ажиглалтын мэдээнд тулгуурлан үзүүлбэл дараах байдалтай байна. Жилийн дундаж агаарын температур $+2.5^{\circ}\text{C}$, агаарын үнэмлэхүй их температурын дундаж 20°C -с дээш, үнэмлэхүй бага температурын дундаж $-10-15^{\circ}\text{C}$, хамгийн их халуун нь $40-45^{\circ}\text{C}$ -д, хамгийн их хүйтрэлт нь $-35-40^{\circ}\text{C}$ -д хүрч байна. Энэ бүсэд жилд дундажаар 70 мм хур тунадас унана. Үүний 85-90% орчим нь хүйтний улиралд унадаг. Бороо орсон өдрийн тоо жилд дундажаар 20-28, цасан бүрхүүлтэй хоногийн тоо 20-35 байна. Цасан бүрхүүлийн зузаан 5 см орчим байдаг ба 2-р сарын эхний 10 хоногт гэхэд арилдаг байна. Жилийн дундаж салхины хурд 6.1 м/с. Шороон шуургатай өдрийн тоо жилд дундажаар 20-30 хоног, цасан шуургатай өдрийн тоо 3-5 хоног байна. Энэ бүсийн нутгуудад хавар, зун гангийн давтагдал их /20-25/ ажиглагддаг, өвөл нь хүйтэн боловч богино 110 хоног, зун нь халуун болж хуурайшин, хур тунадас маш бага унадаг, нилээд удаан 160 орчим хоног үргэлжилдэг онцлогтой. Намрын цочир хүйтрэл 10-р сарын сүүлчийн 10 хоногт тохиолддог.

Хүснэгт 1

Уур амьсгалын үзүүлэлт

№	Уур амьсгалын үзүүлэлтүүд	Уур амьсгалын мужууд		
		I	II	III
		Чийглэгдүү Сэрүүн /Хангайн/	Хуурайдуу сэрүүвтэр /Хуурай хээр/	Хуурай дулаан /Говийн /
1	Жилийн дундаж агаарын температур	-3.2°с	0°с	+2.5
2	Агаарын үнэмлэхүй их температурын дундаж	15.0-с бага	15.0-20.0	20.0-30.0
3	Агаарын үнэмлэхүй бага температурын дундаж	-25-30.0	-22.0	-10.0-15.0
4	Агаарын температур 5°с-с дулаан байх хоногийн тоо	130 хүртэл	130-150	150-дээш
5	Агаарын температур 10°с-с дулаан байх хонгийн тоо	70-90	90-110	110-с дээш
6	Хур тунадасны хэмжээ жилийн дундаж мм	210-230	170	70-80
	Дулааны улиралд /мм/	190	140-150	60-65
	Хүйтний улиралд /мм/	20-30	20	10-15
9	Бороо орсон өдрийн тоо	50-с их	30-50	30-с бага
10	Цас орсон өдрийн тоо	30-с их	20-30	20 хүртэл
11	Салхины жилийн дундаж хурд (м/с)	4.0 м/с	4.0-5.0	5-6
12	Зүгийн давтамж	БХ-2.8%	ЗХ-39%	Б-28%
13	Хүйтрэлтгүй хоногийн тоо	80-с бага	80-100	100-с дээш
14	15 м/с –с дээш хүчтэй салхитай хоногийн тоо	10-15	15-20	20-с дээш

1.2.2 Газарзүйн байрлал, гадаргын онцлог

Тус аймгийн нутаг нь физик газарзүйн мужлалаар хойт хэсгээрээ Хангайн их уулт мужид, төв, урд хэсгээрээ Алтайн говийн мужид, төв хэсгийн урд талаараа Говь-Алтайн их уулт мужид тус тус хамрагдаж байна. Газрын гадаргуугийн хотгор гүдгэрийн хэв шинж нь муж бүрт янз бүр байна. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 3.1 орчим хувийг Хангай, Говь-Алтайн нурууны, Далайн төвшинээс дээш 2400-4000 м өргөгдсөн уулс бүхий гадаргуу эзэлж байна.

Хангайн нурууны тус аймагт харьяалагдах хэсэгт Эрхэт хайрхан, Эмгэнт, Гурван ангархай, Цохиот, Өндөр Жаргалант, Үнэгт хайрхан, Цогт Сүмбэр зэрэг далайн түвшинөөс 3000 м-с дээш өргөгдсөн уулс бүхий Хайрханы, Бөөргийн, Унтаа Ямаатын, Гурван ангархай, Ногоон нуурын, Өлзийт Хавцгайн, Далтын, Жаргалантын, Цохиотын Бугатын, Тоонтын, Донойн гэх мэт 20-50 км үргэлжилсэн өндөр нуруунууд оршдог ба эдгээрийн ноёлох оргил Гурван ангархайн уул далайн төвшинээс дээш 3595 м-т өргөгдсөн байна.

Аймгийн нутгийн төв, өмнөд хэсэгт Говь-Алтайн нурууны салбар уулсууд, тухайлбал Их Богдын нуруу, Баянцагааны нуруу, Хар Аргалантын, Эдрэнгийн нуруу зэрэг далайн түвшинээс дээш 3000 м өргөгдсөн уул нурууд оршдог ба эдгээрийн ноёлох оргил нь 3957 м өндөр “Тэргүүн Богд” уул байна.

Хангайн нурууны салбар уулсын орой нь бөмбөгөрдүү байдалтай хажуу нь налууувар, уулсын энгэр өвөр нь гуу жалгаар ар талаасаа харьцангуй их хэрчигдсэн байна. Уулсын хаяа бэл нь голуудын хавчуу хөндий, багавтар

дэнжүүдийг үүсгэнэ. Энэ бүс нь газрын гадаргуу, Ургамлын бүтэц, бүрэлдэхүүнийхээ хувьд сарлаг ямаанд илүү тохиромжтой.

Хангай, Говь-Алтайн нурууны уулаас салбарласан, далайн түвшинээс дээш 1600-2400 м-т өргөгдсөн бэсрэг уулс, хотгор бүхий газар аймгийн нийт нутгийн 34.5 орчим хувийг эзэлнэ. Бэсрэг уулсын орой нь шовгордуу хэлбэртэй, Хяр, хад чулуу элбэгтэй ус салхины элэгдэлд ихээхэн автагдсан. Уулсын бэл хормой нь тэгшивтэр гадаргатай тал хээрийн ургамал зонхилсон хөндий, дэнжүүдийг үүсгэдэг. Бог мал адуунд нилээд тохиромжтой нутаг байна.

Физик газар зүйн бүсчлэлийн хувьд тус аймгийн нутгийг өндөр уулын, хээрийн, говийн гэсэн 3 бүсэд хуваадаг.

Өндөр уулын бүсэд Галуут, Жаргалант, Заг, Гурванбулаг, Баянбулаг, Эрдэнэцогт сумдын нутаг хамрагдана. Энд далайн төвшинээс 2300-3800 м өргөгдсөн уул нурууд элбэг бөгөөд Эрхэт Хайрхан, Өндөр Жаргалант, Түжил, Асгат Гурванбулаг зэрэг 2300 м –с дээш өргөгдсөн оргилууд байна. Энэ бүсийн 288 190 га газар нутаг нь Хангайн нурууны байгалийн цогцолбор газарт хамаарагддаг.

Нутгийн төв хэсэгт тухайлбал Баян-Овоо, Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, сумдын нутаг тал хээрийн бүсэд хамрагдах ба энд ерөнхийдөө талархаг боловч уул толгод, ухаа гүвээ бүхий газрууд ихэвчлэн тохиолдоно.

Аймгийн өмнөд хэсгийн Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Баянговь, Баянлиг, Богд, Жинст, Баацагаан сумуудын нутагт жижиг ухаа толгод, хужир марзтай жижиг, том нуурууд, элсэн манхан бүхий уудам их нутаг дэвсгэр говийн бүсэд хамрагдана. Хамгийн нам газар нь Зээрэнч, Номч, Цэнхэрийн говиуд далайн түвшнээс дээш 750-960 м өндөрт оршино. Энэ бүсийн 1 361 500 га талбай нь Говийн Их Дархан цаазат газарт, 522 570 га талбай нь Говь-Гурван сайханы байгалийн цогцолбор газарт тус тус харъяалагддаг болно.

1.2.3 Хөрс, хөрсөн бүрхэвч

Хөрс үүсгэгч эх чулуулаг. Хөрсний физик хими шинж чанар уг хөрсийг үүсгэгч эх чулууллагаас ихээхэн хамаарах бөгөөд газрын гадаргын хотгор гүдгэрээс тэдгээрийн тархалт харилцан адилгүй байна. Тус аймгийн нутагт ихэвчлэн дараахи хөрс үүсгэгч эх чулууллагууд тогтсон байна.

1. Элювийн хурдас - Э
2. Элюви-делювийн хурдас- ЭД
3. Делювийн хурдас -Д
4. Аллювийн хурдас -А

Эллювийн хурдас нь өгөрших үйл явцад орж ан цав гарч хагарсан хурц ирмэг бүхий хад чулуу бөгөөд анхны үүссэн байрандаа үлддэг бөгөөд уулын орой, хяраар тохиолдоно.

Делювийн хурдас нь элювийн хурдасны задрал бутрал, өгөршилийн үр дүнд бий болож улмаар бороо цас, салхины нөлөөгөөр уулсын хормой хотгор, хөндийн ёроолд бөөгнөрөн тогтсон байх ба ихэвчлэн уул хоорондын өргөн нарийн хөндийгээр тархана. Харин аллювийн хурдас нь их төлөв голын хөндийн нуга, татам, дэнжид усны үйл ажиллагаагаар үүсэж тогтсон бүрэлдэхүүнд нь лаг шавраас өгсүүлээд голын том хайрга чулуу хүртэл тохиолдоно. Эдгээр хурдсууд нь механик бүрэлдэхүүний хувьд голдуу дунд шавранцар, хөнгөн шавранцар, элсэнцэр байна.

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр нь манай орны байгалийн хэд хэдэн бүс бүслүүрт хамаарагддаг тул хөрсөн бүрхэвч ихээхэн алаг цоог, олон янзын хэв шинж бүрдлээс тогтоно. Тухайлбал: нутгийн хойт хэсгийг эзлэх Хангайн нурууны уулын тойргийн хэсэгтээ уулт ойт хээрийн хүрэн хөрс зонхилж тархана. Аймгийн нутгийн нилээд хэсгийг өндөр уул, бэсрэг уул эзлэх тул хөрсөн бүрхэвчийн 50 орчим хувийг уулын хөрсний хэв шинж, дэд хэв шинжүүд эзэлнэ. Түүнээс гадна гадаргыг гүдгэр хотгор, далайн төвшинээс дээш өргөгдсөн байдал хур тунадас, дулаан хүйтний горим зэрэг цаг уурын өвөрмөц нөхцөл байдлаас болж хөрсний босоо ба хэвтээ бүсчлэлийн зүй тогтол зохих хэмжээгээр илэрсэн байна. Дээрхи зүй тогтлыг үндэслэн аймгийн нутгийн нийт хөрсөн бүрхэвчийг :

- Уулын хөрс
- Уулсын хоорондох хотгор хөндийн хөрс
- Бэсрэг уулт хээрийн хүрэн ба талархаг хээрийн цайвар хүрэн хөрс
- Цөлөрхөг хээрийн бор /Говийн/ хөрс
- Голын хөндийн алювийн хагшаа хурдаст нугын хөрс
- Ердийн нуга-намгийн хөрс
- Цөлжүү хээрийн сайр чулуурхаг бор саарал хөрс
- Нугын давсархаг /хужирт/ хөрс
- Хагас бэхжсэн буюу эоловийн элсэн хөрс гэсэн ерөнхий бүлэг болгон авч үзэв.

Уулын хөрс: Уулын хөрс нь аймгийн бүх нутгийн 54.2% буюу 5120.4 мянга орчим га талбайг эзэлнэ /хүснэгт 2/. Уулын хөрсийг түүний тархалтын гадарга, газарзүйн байршилт, өндөршилт, цаг уурын онцлог зэргийг харгалзан Өндөр уулын хөрс, Уулын хөрс, Бэсрэг уулт хэлбэрийн уулын цайвар хүрэн хөрс, Цөлөрхөг хээрийн, Говийн уулын бор хөрс гэж 5 ерөнхий хэв шинжид хуваан үзэж болох бөгөөд тэдгээр нь дотроо шинж чанар, морфологийн зохион байгуулалтаараа мөн хэд хэдэн уулын хөрсний бүс бүрдлийг үүсгэдэг байна.

Уулын хөрсний үүсэж тогтох нөхцөл нь цаг уурын нилээд өвөрмөц онцлогтой. Тухайлбал: өндөр уулын буюу заримдаг тагийн хөрс нь ихээхэн чийглэг сэрүүвтэр цаг уурын нөхцөлд үүсдэг байхад бэсрэг уулт хээрийн уулын хүрэн ба цайвар хүрэн хөрс нь харьцангуй хуурай гандуувтар нөхцөлд үүснэ. Түүнээс гадна эндэхийн уулын хөрсний онцлог бол ихээхэн чулуурхаг, чулуутай байхын зэрэгцээ хөрсний ялзмагт үеийн нимгэн зузаан харилцан адилгүй /налуу хажуугийн эгц огцом байдлаас болж / зарим газраа маш нимгэн, тогтворжилт муутай сул хөгжсөн байна. Уулын эдгээр хөрсний дотроос хөдөө аж ахуйн үйлдвэрлэл ялангуяа бэлчээр хадлангийн эдэлбэрт гол ашиглагддаг хөрс нь уулын хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн, уулын хар шороон ба уулын нугын хөрс, цөлөрхөг хээрийн уулын бор хөрс юм. Уулын тундрын уулын нугат хээрийн заримдаг тагийн хөрс зарим нэг уулын уулын сулавтар хөгжилтэй хад чулуу ихтэй хөрс нь бэлчээрийн эдэлбэрт зөвхөн улирлын буюу хязгаарлагдмал байдлаар ашиглагддаг онцлогтой байна.

Уулсын хоорондох хотгор хөндийн хөрс: Энэ ангилалд хамаарагдах хөрс нь тус аймгийн нутагт орших Хангайн нурууны өмнөд хэсгийн нуруунуудын хоорондох өргөн нарийн ам хөндийнүүд, налуувтар хажуунууд, уулын бэл хормой, голын дэнж зэрэг тэгшивтэр, ухаархаг, долгиорхог гадаргад түгээмэл тархаж ХАА-н үйлдвэрлэлийн гол эдэлбэрт /Хадлан, тариалан, бэлчээр/ ашиглагддаг хүрэн хөрсний бүх төрөл дүрс ангиуд багтана. Хотгор хөндийн хөрсийг түүний гадаргын байдал, ургамлын нөмрөг, чийгийн горим, ялзмагт үеийн нимгэн, зузаан, ялзмагийн агууламж, өнгө, бүтэц, морфологийн шинж чанрыг нь үндэслэн хүрэн хөрс, нугын хүрэн хөрс, хар шороон гэсэн ерөнхий 3 хэв шинжид хуваадаг. Мөн хүрэн хөрсийг дотор нь хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн гэсэн 3 дэд хэв шинжид хуваана. Эдгээр хэв шинжийн дотроос хүрэн хөрсний дэд хэв шинж тус аймагт нилээд түгээмэл

тархаж нийт хөрсөн бүрхэвчийн 21%-г буюу 737.2 мян.га талбайг эзэлнэ. Хүрэн хөрсний үүсэн хөгжих үйл явц нь эх газрын эрс тэс хуурайвтар уур амьсгалын нөхцөлд хялгана, хазаар өвс, ерхөг, хиаг, биелэг, дааган сүүл элдэв үетэн алаг өвс агь шарилж сийрэгхэн ургахаас гадна харгана гололсон бут сөөг бүхий ургамалшилын доор явагдана. Хөрсний механикийн бүрэлдхүүн нь ихэвчлэн элсэнцэр, хөнгөн шавранцар зонхилох боловч хаяа дунд шавранцар, элсэрхэг байх нь цөөнгүй тохиолдоно. Хөрсний дээд давхрага дахь ялзмагийн хэмжээ /0-20 см/ түүний механикийн бүрэлдхүүнээс хамаарч янз бүр байх бөгөөд тухайлбал элсэнцэр хөрсөнд 1.0-2.0%, ерөнхий азот 0.1-0.2% хөнгөн шавранцар, дунд шавранцар хөрсөнд 1.5-2.8%, азот 0.2-0.3%, харин элсэрхэг хөрсөнд ялзмагийн хэмжээ 1%-аас үл хэтэрнэ. Тэгэхдээ зарим нэг хөнгөн, дунд шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй элэгдэл, эвдрэлд нэрвэгдээгүй газрын хөрсний ялзмаг агууламж 3 % орчим буюу түүнээс ч их байх явдал цөөнгүй байна. Ялзмаг азотын агууламж гүн рүүгээ доошлох тутам нилээд хэлбэлзэлтэй буурч ВС буюу С давхрагадаа ул мөрийн төдий л болж байна. 100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор дунджаар 1.0-3.0 мг, солилцох кали 10-20 мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 10-20 мг/экв байх бөгөөд кальций, магнийн харьцаа ихээхэн хэлбэлзэлтэй байгаа нь ажиглагдана. Хөрсний орчин рН 6.6-7.8 байгаа нь саармаг буюу шүлтлэг орчинтой болохыг харуулж байна.

Дээр дурьдсан морфологийн ба физик химийн чанар нь Хөдөө аж ахуйн таримал болон бэлчээр хадлангийн ургамлын ургац болвсрох нөхцлийг төдийлөн сайн хангаж чадахгүй байна. Гэвч энэ ангилалд хамаарагдаж буй бүх төрлийн хөрс нь хөдөө аж ахуйн гол эдэлбэр болох хадлан, тариалан, бэлчээрт бүрэн ашиглагдаж байна.

Бэсрэг уулт хээрийн хүрэн ба талархаг хээрийн цайвар хүрэн хөрс: Энэ ангилалд аймгийн нутгийн төв хэсгийг эзлэх бэсрэг уулт хээр, Их нууруудын хотгорын талархаг хээр зэрэг гадаргад тархсан хүрэн ба цайвар хүрэн хөрсний бүх төрөл дүрс ялгаврууд хамаарагдаж аймгийн хэмжээгээр бүгд 625.6 га буюу нийт нутгийн 14.6%-г эзэлнэ. Энд хөрс үүсэх нөхцөл нь харьцангуй гандуу, хуурайвтар байх бөгөөд хөрсний гадаргын ургамлын нөмрөг нь тачир сийрэг байна.

Хөрсний морфолог физик-химийн шинж чанраас үзэхэд ялзмагт үе нь нимгэвтэр /Дунджаар 16-26 см/, цайвардуу бор хүрэн буюу шаравтар бор өнгөтэй, тосорхог нилээд бөөмөнцөр бүтэцтэй ихээхэн хуурай, харьцангуйгаар сайр чулуурхаг элс, элсэнцэр, хөнгөн шавранцар зэрэг хөнгөвтөр механик бүрэлдхүүнтэй учраас хөрсний өнгөн хэсэг нь салхины элэгдэлд зохих хэмжээгээр нэрвэгдсэн. Дээд давхрага дахь ялзмагийн хэмжээ 1-2% орчим байна. Хөрсний карбонатын илэрц / давсны хүчилд буцлах байдал/ хүрэн хөрсөнд ихэвчлэн шууд ялзмагт үеийн доороос, харин цайвар хүрэн хөрсөнд ялзмагт үеийн дундаас буюу заримдаа өнгөн хэсгээсээ эхлэх тохиолдол цөөнгүй байна. Эндэхийн хөрсний үржил шим, шинж чанар, ус чийгийн горим зэрэг нь бусад хөрснөөсөө харьцангуй доогуур хэмжээнд байх тул бэлчээрийн эдэлбэрт голчлон ашиглагдаж газар тариаланг зөвхөн усалгаатайгаар өндөр эрчимжсэн нөхцөлд хөгжүүлнэ.

Цөлөрхөг хээрийн бор /Говийн/ хөрс: Энэ хэв шинжийн хөрс нь тус аймгийн Их нууруудын хотгорын мужид хамаарагдах Бөөнцагаан, Адгийн цагаан, Орог нуурын хотгор хөндийнүүд, Говь-Алтайн уулсын ар өвөр хэсгийн ам хөндий – хоолойнууд зэрэг ухаархаг, долгиорхог, Тэгшивтэр гадаргатай цөлөрхөг хээрийн бүсийн 1295.0 мян.га нутагт тархана.

Энд хөрс үүсэх нөхцөл нь хур, чийг, тунадас харьцангуйгаар бага салхины нөлөө ихтэй зуны цагт нилээд халуун болохоор хөрс үүсвэрийн явц хуурай гандуу нөхцөлд явагддаг. Ургамалан нөмрөгт Хялгана, /монгол өвс/, Хазаар өвс, Таана

хөмүүл, Агь шарилж, Баглуур, Бударгана, Тэсэг, Харгана, дэрс зэрэг өвслөг бутлаг ургамал нилээд сийрэг ургана.

Хөрс нь гол төлөв үргэлжийн хуурай салхины нөлөөн доор байдаг тул хөрсний өнгөн хэсгийн нунтаг наанги шороон хэсэг нь хийсч үйрмэг сайр чулуу буюу дан элс болсон байх нь цөөнгүй тохиолдоно.

Цөлөрхөг хээрийн ерөнхий шинж гэвэл хөрсний үе давхрагын илэрц нь ялзмагт үе нь дунджаар 10-20 см орчим зузаан цайвар бор буюу борзгор хул шаргал өнгөтэй ихээхэн хуурай, бургисан тоосорхог бөөмөнцөр бүтэцтэй байна. ВК буюу ВКС давхаргаар эхлэн чулуурхаг байдал нь улам ихсэж С давхаргадаа бараг элс сайр чулуу болсон байх нь олонтой тохиолдоно. Карбонатын илэрц нь ихэнх тохиолдолд өнгөнөөсөө буюу 3-4 см-н давсны хүчилд /гүнээс эхлэн буцлах бөгөөд хамгийн их хуримтлал нь 20-40 см гүнд ажиглагдана. Механик бүрэлдхүүний хувьд гол төлөв элсэнцэр, хөнгөн шавранцар голлох боловч хаана элсэрхэг, дунд шавранцар байх нь бас тохиолдоно. Хөрсний дээд давхрага дахь /4-18см /ялзмаг/ 0.4-1.0% /,фосфор калий, кальций, магни зэрэг шим тэжээлийн бодисын агууламжаар цайвар хүрэн, зарим нэг хүрэн хөрстэйгээ нилээд ойролцоо байх боловч элсэрхэг, элсэнцэр механик бүрэлдхүүнтэй хөнгөн хөрсөнд арай ядмаг байна. Цөлөрхөг хээрийн хөрс нь хөдөө аж ахуйн ач холбогдлоор үржил шим муутай доод чанарын хөрсөнд тооцогдож зөвхөн бэлчээрийн эдэлбэрт ашиглана.

Цөлжүү хээрийн сайр чулуурхаг бор саарал хөрс:

Энэ хөрс нь алтайн цаадах говийн хуурай цөлийн бүсэд харъялагдах Шинэжинст, Баян-Өндөр, Баянлиг сумуудын нутагт нилээд хэмжээгээр тархаж нийтдээ 1127.0 мян.га талбайг эзэлнэ. Тэнд хөрс үүсэх нөхцөл нь ихээхэн гандуу хуурай, хур, чийг тунадас туйлын бага, салхины нөлөө ихтэй нөхцөлд явагдана.

Хөрсний ерөнхий шинж тэмдэг нь бор хөрстэйгээ ихээхэн ойролцоо бөгөөд харин ялзмагт үе нь арай нимгэн /5-10см/ ерөнхийдөө цайвар бор буюу хул шаргал өнгө зонхилох боловч ялзмагт үеийн өнгөн хэсэгт боровтор саарал туяа зохих хэмжээгээр ажиглагдана. Хөрс нь өнгөн хэсгээсээ ихээхэн сайр чулуурхаг ихэвчлэн карбонатлаг зарим газраа хужирлаг мараалаг шинж чанартай байна.

Механик бүрэлдхүүний хувьд элс,элсэнцэр зонхилох боловч хааяа хөнгөн дунд шавранцар байх нь тохиолдоно. Бор саарал хөрс нь зөвхөн бэлчээрийн эдэлбэрт хязгаарлагдмал байдлаар ажиглагдана. Дээр дурьдсан гол хэв шинжийн хөрснүүдээс гадна голын хөндийн хөрс, Нугын ба нуга-намгийн хөрс, хужир мараат давсархаг хөрс, хагас бэхжсэн буюу золовийн элсэн хөрс гэх мэт байгалийн аль бүх районд түгээмэл чанартай бүсийн чанартай хөрс зохих хэмжээгээр тархаж ХАА-н аль нэг эдэлбэрийн хэрэгцээнд ашиглагдаж байна.

Уулархаг хээрийн бүсэд орших Байдраг, Заг, Галуут сумын нутагт усалгаагүй тариалангийн бараг 80% буюу 12000 орчим га талбай байрлаж байв. Тариалангийн талбайд гол төлөв элсэнцэр, хөнгөн шавранцар механикийн бүрэлдхүүнтэй бага зэрэг чулуурхаг, чулуутай хүрэн хөрсний дүрс ялгаврууд зонхилж тархана. Энд хөрсний шинж чанар үржил шим бүтцийн хувьд төдийлөн сайнгүй учир агроүйлдвэрлэлийн III группэд хамаарагдана. Тариалангийн талбайн 20-иод хувийг буюу 2000 гаруй га талбай нь говийн ба тархай тариалангийн бүсэд оршиж байв. Бууцагаан, Баацагаан, Баянцагаан, Баян-овоо, Бөмбөгөр Өлзийт, Шинэжинст зэрэг сумуудын нутагт зөвхөн усалгаатай газар тариалан эрхэлж байна. Энд гол төлөв голын хөндийн хагшаа хурдаст аллювийн нугын ба нугын элсэнцэр, шавранцар зэрэг янз бүрийн механикийн бүрэлдхүүнтэй харилцан адилгүй үржил шимтэй ихэвчлэн карбонатлаг мараалаг хужирлаг /давсархаг/ шинж чанартай хөрстэй юм.

Хүснэгт 2

Баянхонгор аймагт тархсан хөрсний бүтэц

	Хөрсний хэв шинж	Эзлэх талбай,		Хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрс үүсгэгч эх чулуулаг	Хөрсний тархалтын гадарга
		Мян.га	Хувь			
1. Уулын хөрс, 5120.4га 54.2%						
1	Өндөр уулын хөрс	623.8	6.6	Хөнгөн шавранцар, дунд шавранцар,	Элюви	Уулархаг гадарга
	Уулын хар хүрэн болон хүрэн хөрс	1884.2	20.0	Хөнгөн шавранцар, дунд шавранцар,	Элюви	Уулархаг гадарга
	Уулын цайвар хүрэн хөрс	798.1	8.5	Хөнгөн шавранцар, элсэнцэр	Элюви	Уулархаг гадарга
	Цөлөрхөг хээрийн уулын цайвар хүрэн ба бор хөрс	1499.7	15.8	элсэнцэр	Элюви	Уулархаг гадарга
	Говь цөлийн уулын бор ба бор саарал хөрс	312.0	3.3	элсэнцэр	Элюви, элюви-делюви	Уулархаг гадарга
2. Тал хөндийн хөрс, 3840.9га 40.6%						
2	Уулсын хоорондох хотгор хөндийн хар хүрэн ба хүрэн хөрс	737.2	7.8	Хөнгөн шавранцар, элсэнцэр	делюви	Уул хоорондын нарийн ам
3	Бэсрэг уулт хээрийн хүрэн ба талархаг хээрийн цайвар хүрэн хөрс	625.6	6.6	Хөнгөн шавранцар, элсэнцэр	делюви	Уул хоорондын хөндий
	Нугын хүрэн ба мараалаг хүрэн хөрс	20.9	0.2			
4	Цөлөрхөг хээрийн бор /Говийн/ хөрс	1 295.0	13.7	Элсэнцэр, элсэн	делюви	Уул хоорондын хөндий
5	Цөлжүү хээрийн сайр чулуурхаг бор саарал хөрс	1 127.0	11.9	Элсэнцэр, элсэн	делюви	Уул хоорондын хөндий
	Хагас бэхэжсэн	35.2	0.4	Элс	Эолови	Тал хөндий

	буюу эоловийн элсэн хөрс					
3. Голын хөндийн хөрс , 554.7га буюу 4.7%						
6	Голын хөндийн алювийн хагшаа хурдаст нугын хөрс	84.3	0.9	Хөнгөн шавранцар, дунд шавранцар, элсэнцэр	аллюви	Голын хөндий
7	Ердийн нуга-намгийн хөрс	98.6	1.0	Дунд шавранцар	аллюви	Голын хөндий
8	Цэвдэгт	73.7	0.7		аллюви	
9	Цөлөрхөг хээрийн нугат бор хөрс	141.1	1.5	элсэнцэр	аллюви	Нам дор газраар
10	Нугын давсархаг /хужирт/ хөрс	60.8	0.6	Дунд шавранцар	аллюви	Нам хотосоор
	Уулын эх чулуулаг	31.9	0.3			
	Сайр гуу жалга	3.2	0.003			
	Нийт	9 426.9	100			

1.2.4 Ургамал, ургамлан бүрхэвч

Баянхонгор аймгийн нутаг нь ургамал газар зүйн мужлалаар хангайн уулын ойт хээрийн провинц ба умард говийн цөлийн хээрийн провинцид хамаарагддаг. Ургамалжилтын бүс бүслүүрийн ялгаа тод ялгарсан өндөр уулын хуурай хээр говь хосолсон нутаг юм.

Гурванбулаг, Баянбулаг, Заг, Жаргалант, Галуут, Эрдэнэцогт сумдын нутаг нь өмнөд Хангайн уулын хээрийн тойргийн Заг, Байдраг, Баянхонгорын районд хамаарагдах бөгөөд Хангайн нурууны өмнөд хэсгийн нурууны уулархаг хэсэг өндөр уулын орой, ар хажуугаар бушилз-алаг өвс-улалжит нуга голлон уулсын өмнөд энгэр хажуугаар жижиг үетэн бушилзат, ботууль-алаг өвст, жижиг үетэн-хялганат сийрэг ургамалтай уулын хээрийн чулуурхаг хувилбарууд зонхилно. Эндхийн гол горхи бүхий уулсын хоорондох нарийн хөндийн нугархаг хээрийн үндсэн төрхийг хадгалж үетэн-алаг өвст, үетэн-улалж-алаг өвст, ботууль-алаг өвст, жижиг үетэн-алаг өвст төрлүүд тархана.

Урагшлах тутам уулсын өндөр аажим намсаж нам бэсрэг уул зонхилон Хүрээмарал, Бууцагаан, Бөмбөгөр, Баян-овоо, Өлзийт сумдын нутгийн бэлчээр, хадлан ихээхэн хээржсэн жижиг үетэн-алаг өвст, ботууль-алаг өвст, хялгана-жижиг үетэн-агьт уулын хээрийн төрлүүд, уул толгодын хоорондох өргөн хөндийгөөр хялгана-жижиг үетэн-агьт, хялгана-харганат, хялгана-хазаар өвст хээрийн хувилбарууд тархана. Энд говийн хуурайжуулах нөлөө тодорхой тусч уулын хээрийн монгол өвст хэв шинжүүд түрж орж ирэн монгол өвс-хазаар өвст, монгол өвс-харганат, монгол өвс-таанат, зээргэнэт төрлүүд өргөн хөндийгөөр үргэлжлэн тохиолддог.

Хангайн өмнөд энгэрийг огтлон урсах Заг, Байдраг, Түйн голын хөндийгөөр үетэн-улалж-алаг өвст, жижиг улалж-алаг өвст, дэрс-хиаг-алаг өвст-төрлүүд

тархана. Голын хөндийн татмын бэлчээрийг зун-намрын улиралд сэлгээгүй ашигласнаар ихээхэн талхлагдсан байна.

Хангайн нурууг Говь-Алтайгаас тусгаарлаж байгаа уудам хөндий хоолой буюу Баацагаан, Жинст, Богд сумын нутаг нь Бөөнцагаан, Орог нуурын районд хамаарагдана. Энд монгол өвс-таанат, монгол өвс-хазаар-өвст, монгол өвс баглуурт, бударганат, Бунгийн харгана, Тэсэг, Цагаан шаваг, Шар мод бүхий монгол өвст сөөгт цөлөрхөг хээр зонхилно. Нууруудын зах ба нам хотгор хоолойгоор дарс-жигжиг-улалжит дэрс-бударганат, зэгст, сийрэг загт, шар бударганат бүлгэмдлүүд тохиолдоно. Эндэхийн довцог элснүүдээр элсний шарилж, хар суль, заг, чихэр өвс сийрэг ургана. Энд Монгол орны чихэр өвсний нөөцийн 70 % орчим ургадаг.

Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст, Баянлиг сумдын нутаг нь Говийн Алтайн уулархаг цөлийн хээрийн I тойрогт орно. Баянцагааны нуруу орчмын өндөр уулсын оройгоор Бушилз-үетэнт хээржсэн нуга зурваслан түүнээс доошлоход уулын хээрийн хялганат болон жигжиг үетэн- ботуульт, бүлгэмдүүд бүслүүр үүсгэн уулын доод бие болон бэсрэг уул нам толгодоор жинхэнэ цөл, цөлөрхөг хээрийн монгол өвс-таана-бударганат, баглуур-бударганат сийрэг загт элсний шарилж-алаг өвст сийрэг ургамалтай чулуурхаг хувилбарууд ургамалан нөмрөгийн үндсэн шинжийг бүрдүүлнэ.

Аймгийн хойд хэсгээр 12,6 мянган га шинэсэн ой, өмнөд хэсгээр 477,8 мянган га заган ойтой. Энэ нь нийт нутаг дэвсгэрийн 4,2% буюу 490,4 мянган га талбайг ой эзлэнэ. Үүнээс заган ой 97,4%, шинэсэн ой 2,6%-ийг эзлэнэ.

1.2.5 Ан амьтан

Алтай Хангайн уулсаар аргал, янгир, ирвэс шилүүс, буга, бор гөрөөс, гахай, хүдэр, дорго Говийн бүсэд хар сүүлт, хавтгай, мазаалай, хулан, зэгэсний гахай зэрэг дархан цаазтай, улаан номд орсон амьтад, тал хээрт цагаан зээр байдгаас гадна аль ч бүсэд тарвага, үнэг, чоно, хярс, мануул зэрэг үслэг ан элбэг. Говийн нүцгэн хуруут гүрвэл, тэмээн сүүлт могой зэрэг хэвлээр явагчид, бүргэд, ёл, цасны хажир, тас, шонхор, хойлог, ятуу, хулан жороо, хуруут хун, хээрийн галуу, ангир, нугас, тоодог, халбаган хушуут, итэлгэн цахлай, өрөвтас, зэрэг 150 гаруй шувуу бүртгэгджээ. Тарвага агналтаар улсад тэргүүн байрт орж байсан боловч одоо энэ амьтан ховор амьтдын тоонд орохоор болоод байна. Зэвэг, алгана, зурхай, хадран зэрэг цөөн төрлийн загастай.

1.2.6 Ус зүй.

Аймгийн нутаг дэвсгэр Төв Азийн гадагш урсгалгүй болон Хойд мөсөн далайн ай савд хуваагддаг.

Тус аймагт 299 (168) гол горхи тоологдсоны нийлбэр урт нь 3559 км болж байгаагаас гадна 104 (69) 34 нуур, 837 (459) булаг шанд гадаргын усны сүлжээг бүрдүүлж байдгаас 61 гол горхи, 38 нуур, 55 булаг шанд ширгэсэн мэдээтэй байна. Усны нөөцийг янз бүрийн аргаар тооцож үзэхэд хоорондоо их зөрөөтэй тоонууд гарч байна. Усны нөөц 1,815 – 0,55 шоо км, Гадаргын усны нийт нөөц 1,504 - 0,45 шоо км үүнээс ашиглаж болох нөөц нь 0,05 шоо км, ул хөрсний усны нөөц 0,347- 0,1 шоо км, үүнээс ашиглах боломжит нөөц нь 0,05 шоо км юм.

Нутгийн хойт хэсэгт Хөх нуур, Биндэръяа хөх нуур орших ба Хангайн нурууны өвөр талаас эх авах Байдраг, Түй, Цагаантуруут, Харгана, Сүмбэр, Заг, Шаргалжуутын голууд нууруудын хөндийд орших Бөөнцагаан 252 км²,

Адгийн цагаан, Орог 140 км² нууруудыг тэжээнэ. 1957 онд Их Богд ууланд газар хөдлөхөд Улиастай битүүтийн амыг нураг асга дарснаас 14-25 м гүн Оюу, Номин, Биндэръяа зэрэг нуурууд үүссэн.

Түүнчлэн Хангайн нуруунаас эх авсан Хар ус, Шар ус, Буянт, Говь-Алтайн салбар уулсаас эх авсан Баянцагаан, Далан түрүү, Уртын гол зэрэг олон гол горхи, Дуут, Хуримт, Бөөрөг, Баян нуур, Олгой зэрэг олон нуур байдаг.

Агуйт, Хуримт, Үхэг, Өргөөт, Халиут, Тээл, Ичээт зэрэг 22 рашаан байдгаас хамгийн алдарттай нь Шаргалжуутын рашаан юм. Шаргалжуутын рашааны талбай нь 0,25 ам км ба 47-92° С хэмийн 150 гаруй дулаан булгаас нийтдээ 54 л/с ундарга бүрэлдэнэ. Усны температурыг дунджаар 81,2° С гэвэл дулааны урсгал 18,4 10⁶ Дж с буюу тухайн бүс нутгийн нөөцийн 50%-д хүрнэ. Дулааны алдагдал харьцангуй бага 39% байна. Рашаан нь Шаргалжуутын голын горимд нилээд нөлөө үзүүлэх бөгөөд дулааны улиралд голын усны тэжээлийн 2,3% болно. Хүйтний улиралд нөөц нь багасаж гулидралын халиа тошин үүсэхэд зарцуулагдана.

Эдгээрт хамгаалалтын болон, эрүүл ахуйн бүс тогтоогоогүй ашиглаж байна

Түйн голын дагуу Баянхонгор, Богд сумын орчимд 2 харуул, Байдрагийн голын дагуу Жаргалант, Бууцагаан сумын орчимд 2 харуул, Заг, Цагаан туруут, Шаргалжуут, Шар усан голууд, Орог, Бөөнцагаан, Хөх нуурын орчим тус тус усны харуулууд ажиллаж байна.

Байдраг гол

Хангайн нурууны өврийн Буга, Нарийнтээл, Мандал голуудын бэлчир орчмоос Байдраг нэртэй болох ба Заг, Цагаантуруут гол түүнд цутгаж урссаар Бөөнцагаан нуурт цутгана. Мөн ус их үед Адгийн цагаан нуурт цутгах бөгөөд харин ус багатай үед газрын доогуур шургана. Голын ус хурах талбай 27277 ам км, 310 км урт. Байдраг гол Хангайн нурууны өврийн голуудын нэгэн адил голын дагууд урсац нь алдагдаж газрын доорх урсацыг тэтгэн Нууруудын хөндийн нууруудад цутгадаг онцлогтой. 1988 оны 10-р сард Байдрагийн гүүрний дэргэд усны өнгөрөлт 7.40, тэр үед барьж байсан услалтын системийн орчим 8.30 хүрч байснаа Бөөнцагаан нуурт дөнгөж 0.48 шоо м/с ус хүрч, усалгаанд 1.80 шоо м/с авч, үлдсэн 6.0 шоо м/с нь газрын доогуур нуурт цутгаж байсныг хэмжиж тогтоожээ.

Түйн гол

Хангайн нурууны Хөл саяны давааны өврөөс эх авч Орог нуурт цутгана. Голын ус хурах талбай 9410 ам км, 243 км урт. Түй голын онцлог бол Хангайн нурууны өврөөс эх авах голуудын адил урсацын алдагдал их байх ба Жинст сумын орчимд газар доогуур шургаж эргэж ил урсдагт оршино. Түй голын олон жилийн дундаж өнгөрөлт Баянхонгор сумын орчимд 3.15, Богд сумын орчимд 1.91 шоо м/с болно. 1989 оны 5-р сард Түй голын усны өнгөрөлт Түй, Шаргалжуут голын бэлчирт 0.50, Бор балгасын орчимд 0.50, Уу-буланд 0.80, Богд сумын орчим 0.81, Орог нуурын цутгаланд 0.61 шоо м/с тус тус байлаа. Харин 1988 оны 10-р сард Жинст сумын Уу-булангийн орчимд өнгөрөлт 4.92 хүрээд Богд сумын нутагт 1.34 болон буурч Орог нуурт 1.37 шоо м/с ус цутгаж байжээ.

Нийт 69 нуур байгаа бөгөөд нийлбэр талбай нь 528 км² боловч энд 50 га-гаас дээш талбай бүхий нийт 519,6 км² талбайтай 40 нуурыг оруулав.

Хөх нуур Хангайн нурууны Жаргалант уулын өвөрт 2649 м үнэмлэхүй өндөрт байдаг морены хурдсанд хаагдаж тогтсон тагийн хэт цэнгэг нуур 17.2 км² талбайтай 12.8 км урт, 1.7 км өргөн эргийн шугмын урт 32.8 км буюу ихээхэн хэрчигдсэн хөгжлийн коэффициент 2.49 хүрнэ. Усны хамгийн гүн 43.5 м дундаж нь 15.5 м эзэлхүүн 206 сая м³ сэрүүвтэр устай усны температур 7 дугаар сард өнгөндөө 8-15.4⁰С ёроолдоо 8-10⁰С орчим. Нуурын ёроолд элс, элсэнцэр бор саарал лаг шавраас гадна эртний мөстөлийн бул чулуу хааяагүй тархжээ. Хур бороо, гадаргын ба гүний урсацаар сэлбэгддэг. 190 км² талбайгаас усжиж, олон жижиг нуур дамжин хоолойгоор Завхан голын томхон цутгал болох Хар-Усны голтой холбогддог. Усны эрдэсжилт өнгөнөөсөө гүн рүү буурч 33.5-45.2 мг/л гидрокарбонатын ангийн кальцийн төрөлд багтна. Чулуун ганц аралтай, ус, намгийн төрөл бүрийн шувууд элбэг. Баруун нуурын загасаар элбэг. Спорт – агнуур, рекреацийн боломж сайтай.

Хөх нуурын дээд нуур. Гурванбулаг сумын нутаг Цагаан битүүт уулын өвөрт 2652 м өндөрт байдаг мөстөлийн гаралтай цэнгэг нуур. 0.5 км² талбайтай, 1.7 км урт, 3.4 км. Усны шувуу, баруун нуурын загастай. Рекреацийн боломж сайтай. Усны температур 6, 7-р сард 13.2⁰-15.3⁰С хур бороо, булаг шандны усаар сэлбэдэг.

Зүүн салаа нуур Гурванбулаг сумын нутаг Хар Ус голын эхний мөстөлийн хунхад 2967 м үнэмлэхүй өндөрт тогтсон нуур. 0.5 км² талбайтай, 1.1 км урт 2.8 км. Гол горхи булгын усаар тэжээгддэг.

Заваг нуур. Гурванбулаг сумын нутаг Цагаан Битүүх уулын мөстөлийн хунхад тогтсон цэнгэг нуур. 1.5 км² талбайтай 2.7 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 6.4 км, 29 м гүн, эзэлхүүн 18 сая м³, 31 км² талбайгаас усждаг.

Загийн хөх нуур. Жаргалант сумын нутаг Загийн голын эхэнд 2357 м өндөрт байдаг цэнгэг нуур. 2.3 км² талбайтай. 5.4 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 1.3 км

Сангийн далай нуур. Баянбулаг сумын нутагт 2566 м өндөрт байдаг уулс хоорондох битүү хотгорт тогтсон тектоник гаралтай гадагш урсгалгүй, давстай нуур. 3.4 км² талбайтай 2.9 км урт, 1.9 км өргөн, эргийн шугамын урт 7.2 км. Нүүдлийн шувууд хуран цуглардаг. Хур тунадас гүний усаар сэлбэгддэг. Усны температур 6, 7 дугаар сард 18.7⁰-20.1⁰С хүрч 10 дугаар сараас 4 дүгээр сард хөлдөж 1.0-1.2 м зузаан мөсөөр хучигдана.

Давсан Айраг нуур. Хүрээмарал, Жаргалант сумын заагт 2222 м өндөрт байдаг давст нуур. 0.7 км² талбайтай, 1.9 км урт 0.7 км өргөн, эргийн шугамын урт 4.4 км.

Баянцагаан нуур Галуут Жаргалант сумын заагт 1974 м өндөрт байдаг давст нуур. 4.4 км² талбайтай, 3.8 км урт, 1.6 км өргөн эргийн шугамын урт 8.8 км, 245 км² талбайгаас усжих ба хур бороогоор сэлбэгддэг.

Баян нуур. Галуут сумын нутагт 1957 м өндөрт байдаг тектоник гаралтай нуур. 0.6 км² талбайтай, 1.3 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 4.2 км.

Олгой нуур. Галуут сумын нутаг Галуут хавцалын ард байдаг гадагш урсгалтай термокарстын гаралтай цэнгэг нуур. Усны мандал 2041 м 1.5 км² талбайтай 3.7 км урт 0.6 км өргөн, эргийн шугамын урт 8.4 км. Байдрагийн голтой усан холбоотой.

Хөх бүрдийн нуур Баян-Овоо сумын 1331 м өндөрт байдаг Давст нуур 0.8 км² талбайтай 1.6 км, урт эргийн шугамын урт 4 км, усны эрдэсжилт 92.71 г/л.

Адгийн цагаан нуур. Баацагаан, Жинст сумын заагт 1285 м өндөрт байдаг гадагш урсгалгүй давстай нуур 11.5 км² талбайтай, 7.6 км урт, 2.2 км өргөн хур бороогоор сэлбэгддэг учир түвшин нь их хэлбэлзэж гантай жил, хатаж ширгэн хур ихтэй үед эргийн шугамын урт 22 км хүрдэг. Нуурын эрдэсжилт тогтворгүй, ерөнхий эрдэсжилт 3.04-5.87 г/л, сульфат натрийн төрөлд багтана. Эргэн тойрон зэгэс ургадаг. Малын тэжээл, хашаа, хороонд их хэрэглэж экологийн тэнцвэр алдагджээ.

Цагаан нуур. Баацагаан Жинст сумын заагт 1284 м өндөрт байдаг нуур. Усны түвшин тогтворгүй зарим жилд хатаж ширгэх ба устай үед нуурын талбай 9.1 км², урт өргөн нь 3.2 км, усан хилийн урт 16.6 км хүрдэг.

Давсан нуур. Богд, Жинст сумын заагт 1330 м өндөрт байдаг нуур. 0.6 км² талбайтай, 1.2 км урт 0.9 км өргөн. Эргийн шугамын урт 4 км боловч усны түвшин их тогтворгүй, зарим жилд бараг хатаж давсны нимгэн давхаргаар хучигддаг. Нуурын шорвог усны эрдэсжилт 309.63 г/кг найрлагаараа карбонатын төрлийн нуурт багтана. Нуурын талсжсан давсыг орон нутгийн чанартай ашиглана.

Холбоолжин нуур. Жинс, Богд сумын заагт 1330 м өндөрт байдаг шорвог нуур. 3.1 км² талбайтай, 2.9 км урт, 2.0 км өргөн эргийн шугамын урт 10.2 км боловч усны түвшин тогтворгүй. Хур бороо гүний усаар тэжээгдэх ба усны эрдэсжилт 4.78 г/л, сульфат натрийн төрлийн нуурт багтана.

Ногоон нуур. Богд сумын нутагт Орог нуурын хаяанд 1230 м өндөрт байдаг шорвог нуур 0.6 км² талбайтай, 1.5 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 3.8 км

Шорвог нуур. Баян-Өндөр, Баянцагаан сумын заагт 2209 м өндөрт байдаг шорвог нуур. 0.6 км² талбайтай, 1.5 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 3.8 км боловч тогтворгүй, зарим жил хатаж тойром болдог. Өмнөөс нь жижиг гол цутгадаг.

Ногоон нуур. Баян-Өндөр, Шинэ Жинст, Баянговь сумын заагт 1772 м өндөрт байдаг шорвог нуур. 0.6 км² талбайтай, 1.4 км урт, 1.1 км өргөн, эргийн шугамын урт 3.6 км.

Хүн нуурын шал. Баянлиг сумын нутагт 952.7 м өндөрт байдаг шал. Ус ихтэй үед 16.7 км² талбайтай, 6.8 км урт., 4.6 км өргөн эргийн шугамын урт, 21.4 км хүрэх ба сайр дагаж буух уруйн усаар сэлбэгдэж ихэвчлэн хатаж тойром болдог.

Загын шал нуур. Баянлиг, Өмнөговь аймгийн Гурван Тэс сумдын нутагт Таван Загийн хоолойд 1032 м өндөрт байдаг, хатаж ширгэдэг тойром. Устай үед 33.1 км² талбайтай, 21.0 км урт, 4.7 км өргөн, эргийн шугамын урт 49.4 км хүрдэг. Усны түвшин тогтворгүй, ихэвчлэн хатаж ширгэдэг.

Бөөн цагаан нуур. Баацагаан сумын нутаг олон нуурын хөндийд байдаг бүлэг нуурын хамгийн том нуур. 252.0 км² талбайтай, 24 км урт, 19.0 км өргөн, эргийн шугамын урт 81 км. Эрэг нь намхан, элсэрхэг, нуурын олон эгнээ далан, зээг байдаг. Тектоник гаралтай үлдэгдэл нуур. Хур тунадас, гадаргын ба гүний урсацаар сэлбэгддэг. Нийтдээ 33500 км² талбайгаас усжина. Усны балансны орлогод Байдрагын гол, зарлагын хэсэгт ууршилт зонхилно. Нуурын хамгийн гүн 16 м дундаж гүн 9.9 м, 6 м гүн талбайн 70% эзэлхүүний 46%-ийг эзэлдэг. Эзэлхүүн 2385 сая м³, усны мандлын үнэмлэхүй өндөр 1312 м. Говийн халуун хуурай уур амьсгалын нөлөөгөөр дулаанын их шингээдэг, усны температур 5-р сард мандалдаа 12-13.0°C хүрдэг. ёроолдоо 9.2°C байдаг бол 7, 8-р сард өнгөндөө 22-24.0°C хүрдэг. 12-р сар 4-р сарын эцэст хүртэл хөлддөг. Нуурын

тунгалагшилт зун 2.0-2.5 м өвөл 4-5 м болж нэмэгдэнэ. Ёроолд нь хүхэр устөрөгчийн үнэртэй бараавтар лаг, наанги мөн ялзмагт шавар, эрэг хавиар том жижиг мөхлөгт элс, гүйхэн булан тохойд ургамал тархсан байдаг. Усны ерөнхий эрдэсжилт 304.1-573.8 мг/л рН 9.2 сульфат натрийн төрөлд багтана. Нуурт нүүдлийн олон шувуу хуран цугларахаас гадна Монголын баруун нуур усны загас жараахай байдаг. Эрэг дагуугаа торгон элсэн хаялага, далан зээгтэй. Агнуурт-спорт, аялал зуулчлал, хөдөлмөрчдийн сувилалын боломж сайтай.

Орог нуур. Богд сумын ар хормойд 1271 м өндөрт байдаг тектоник гаралтай нуур. Эргийн байдал адилгүй, өмнөд этгээдэд Их Богдын уулын хормой алгуур намсаж тэгшивтэр гадарга үүсэж уулын хормойгоос олон арван булаг ундарч орчныг намагжуулдаг. Нуурын баруун хойд талаар 10 гаруй км урт 1.0-1.5 км өргөн элсэн тарамцаг эмжиж бас эртний нуурын зүүн хойд талаас цутгадаг Түйн голын адагт томхон садраа адаг үүсэж намагжина. Нуурын талбай 1957 оны газар хөдлөлтийн үед сүрхий өөрчлөгдөж 140 км² шугамын урт 75 км хүрсэн боловч тогтворгүй зарим жилд хатдаг. 1890 оноос хойш 7 удаа ширгэсэн. Усны гүн 5 м, эзэлхүүн 420 сая м³. Нуурын ёроолд хүхэр устөрөгчийн сулавтар үнэртэй хар хөх, цайвар лаг шавар тархаж гүйхэн устай учраас бараг ёроолоо хүртэл жигд халдаг. Усны температур 5-р сард мандалдаа 15-18.0⁰С байдаг бол 7, 8-р сард өнгөндөө 25.0⁰С хүртэл халж 11-р сараас 4-р сард хөлддөг. Усны тунгалагшилт бага /0.2-0.5 м/ нийтдээ 10500 км² талбайгаас усжих Түйн гол хэд хэдэн гол цутгана. Гадагш урсгалгүй ерөнхий эрдэсжилт 1.75-5.01 г/л рН=9.22 нуурын зүүн хэсэгт цутгал голын нөлөөгөөр гидрокарбонат ион ихсэж баруун тийшлэхэд ион натри хлори нэмэгдэх ба карбонат ион шинээр бий болжээ. Нүүдлийн шувууд хорогдохоос гадна баруун нуур усны загас амьдардаг. Рекреацийн боломж сайтай.

Борвой нуур. Бууцагаан сумын төвөөс баруун урагш 1755 м өндөрт байдаг шовгор нуур. 0.5 км² талбайтай, 1.2 км. Ёроолын лаг шаврыг эмчилгээнд ашигладаг. Шорвог усны эрдэсжилт 214.11 г/кг хлорт натри, сульфат натри, сульфат магни зонхилж найрлагаараа сульфат натрийн төрөлд багтана. Нуурын эрдэс давсыг орон нутгийн чанартай ашигладаг.

Хэрсэнгийн цагаан нуур. Бууцагаан сумын нутагт Адгийн Цагаан нуураас баруун хойш 1287 м өндөрт байдаг шорвог нуур. Хуртай жилд 1.2 км² талбайтай, 2.2 км урт, 1.2 км өргөн, эргийн шугамын урт 6.2 км.

Дунд цагаан нуур. Баацагаан сумын 1290 м өндөрт байдаг шорвог нуур. 1.3 км² талбайтай, 2.0 км урт 1.1 км өргөн эргийн шугамын урт 5.2 км боловч улирлаар их өөрчлөгддөг. Зарим жилд хатаж ширгэдэг.

Хажуу цагаан нуур. Баацагаан сумын нутагт 1283 м өндөрт байдаг шорвог нуур. 1.3 км² талбайтай 2.1 км урт, 1.8 км өргөн, эргийн шугамын урт 6.4 км.

Баян бүрд нуур. Жинст сумын нутаг, Орог нуураас баруун хойш 1264 м өндөрт байдаг шорвог нуур. 0.6 км² талбайтай, 2.5 км урт, 0.5 км өргөн эргийн шугамын урт 5.2 км орчим. Нутгийнхан заримдаа Орог нуур гэнэ.

Зээрийн ус нуур. Баян-Өндөр сумын нутаг Долоон Цэнхэрийн хоолойн зүүн үзүүрт 1299 м өндөрт байдаг шорвог тойром. Хуртай үед ус тогтож 1.2 км² талбайтай, 2.2 км урт 1.3 км өргөн, эргийн шугамын урт 5.8 км орчим болдог.

Бухын ширээ нуур. Баянлиг, Өмнөговь аймгийн Гурван Тэс сумдын заагт Загын шал, Хүн нуурын шалын хоорондох тектоник хотост 990 м өндөрт

байдаг ширгэдэг тойром. Хуртай үед сайрын уруй хуримтлагдахад 1.8 км² талбайтай, 2.5 км урт 1.4 км өргөн, эргийн шугамын урт 7.2 км болдог.

Хөөвөр нуур. Шинэ Жинст сумын нутагт Ингэн хөөврийн хоолойн элсэн дунд 697 м өндөрт байдаг эоловын гаралтай хатаж ширгэдэг тойром. Хуртай жилд 2.0 км² талбайтай, 2.7 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 11.8 км болдог.

Онгон улааны нуур. Шинэ Жинст сумын Онгон улааны өвөрт 729 м өндөрт байдаг тойром. Сайр дагаж буух уруйн ус ирэхэд 3.1км² талбайтай, 3.2 км урт, 1.2 км өргөн, эргийн шугамын урт 9.0 км болдог.

Бага цагаан нуур. Баацагаан, Жинст сумын зааг Адгийн Цагаан нуурын хотгорт 1283 м өндөрт байдаг бүлэг нуурын нэг. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.3 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км хүрдэг.

Цагаан нуур. Жинст сумын нутаг Хөнөгийн хоолойд 1270 м өндөрт байдаг эрдэст нуур. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.1 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км хүрдэг.

Жинст тойром. Шинэ Жинст сумын нутаг 2077 м өндөрт байдаг шорвог тойром 0.5 км² талбайтай, 1.6 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км боловч улирлаар өөрчлөгддөг.

Хоолойн шал тойром. Шинэ Жинст, Баян-Өндөр сумдын заагт Долооны Цэнхэр Хоолойд 1310 м өндөрт байдаг тектоник гаралтай эрдэст нуур. Эрдэнгийн нурууны ам хавцал дагаж буух уруйн үерийн ус буухад 0.5 км² талбайтай, 1.4 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км тойром тогтдог.

Загийн тойром. Баянлиг, Өмнөговь аймгийн Гурван Тэс сумдын зааг Таван Загийн уудам хоолойд 990 м өндөрт байдаг тойром. Хуртай жилд 0.5 км² талбайтай, 1.7 км урт, 0.4 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км ус тогтдог.

Бухын шал тойром. Баянлиг, Өмнөговь аймгийн Гурван Тэс сумдын зааг Бухт уулын баруун тектоник хотост 981 м өндөрт байдаг шорвог ус 0.6 км² талбайтай, 1.4 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км. Ихэвчлэн хатаж ширгэдэг.

Их ширээ худгийн тойром. Баялиг, Өмнөговь аймгийн Гурван Тэс сумдын заагт тектоник гаралтай хотост 1060 м өндөрт байдаг шорвог нуур. 0.5 км² талбайтай, 1.2 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км.

Өмнө тойром. Шинэ Жинст сумын нутаг Ногоон Цавын арын уудам хоолойд 800 м өндөрт байдаг ширгэдэг тойром. Тал талаас сайрын уруйн ус буух үед 0.6 км² талбайтай, 1.6 км урт 0.6 км өргөн эргийн шугамын урт 3.8 км ус тогтдог.

Туулайт тойром. Шинэ Жинст сумын нутаг Онгон Улаан, Тооройтын Хөх уулын хоорондох тектоник хотост 762 м өндөрт байдаг эрдэст тойром. Хур бороотой үед тал талаас сайрын уруй буухад 1.1 км² талбайтай, 1.7 км урт, 1.1 км өргөн ус тогтож эргийн шугамын урт 4.8 км хүрдэг.

Хүснэгт 3

Нууруудын морфометрийн үзүүлэлтүүд

Д/д	Нуруудын нэр	Өндөр м	Талбай га	Урт км	Өргөн км	Дундаж гүн м	Усны эзэлхүүн км³	Эргийн шугам км	Хөгжлийн коэффициент
3-112	Хөх нуур	2649	17.2	12.8	1.0	43.0	0.2060	32.3	2.249
3-113	Зүүн салаа нуур	2967	0.5	1.1	0.4	3.8	0.0008	2.8	1.117
3-114	Заваг нуур	2766	1.5	2.7	0.5	29.0	6.0180	6.4	1.480
3-115	Загийн хөх нуур	2357	2.3	5.4	0.4	25.0	0.0230	13.0	2.419
3-116	Сангийн далай нуур	2566	3.4	2.9	1.1			7.2	1.102
3-117	Давсан айраг нуур	2222	0.7	1.9	0.3			4.4	1.483
3-118	Баян цагаан нуур	1974	4.4	3.8	1.1	3.0	0.0053	8.8	1.184
3-119	Баян нуур	1957	0.6	1.3	0.4	2.5	0.0006	4.2	1.529
3-120	Олгой нуур	2041	1.5	3.7	0.4	2.5	0.0016	8.4	1.935
3-121	Хөх бүрдийн нуур	1931	0.8	1.6	0.5	2.5	0.0008	4.0	1.262
3-122	Адгийн цагаан нуур	1285	11.5	7.6	1.5	1.5	0.0090	22.2	1.847
3-123	Цагаан нуур	1284	9.1	3.2	2.8	0.7	0.0020	16.6	1.553
3-124	Давсан нуур	1330	0.6	1.2	0.5	1.0	0.0002	4.0	1.457
3-125	Холбоолж нуур	1330	3.1	2.9	1.0	1.5	0.0018	10.2	1.635
3-126	Ногоон нуур	1230	0.6	1.7	0.3	1.0	0.0002	3.8	1.384
3-127	Шорвог нуур	2209	0.6	1.5	0.4	1.5	0.0003	3.8	1.384
3-128	Ногоон нуур	1772	0.6	1.4	0.4	1.3	0.0004	3.6	1.311
3-129	Хүн нуурын шал	953	16.7	6.8	2.4	1.1	0.0050	21.4	1.478
3-130	Загийн шал нуур	1032	33.1	21	1.5	1	0.003	49.4	2.42
3-131	Бөөнцагаан нуур	1312	252	24	11	16	2.385	81	1.44
3-132	Орог нуур	1217	140	31.8	2	6.3	0.42	75	1.79
3-133	Борвойн нуур	1755	0.5	1.2	0.4	0.8	0.0001	3	1.2
3-134	Хэрсэнгийн цагаан нуур	1287	1.2	2.2	0.5	1.6	0.0004	6.2	1.6
3-135	Дунд цагаан нуур	1290	1.3	2	0.6	0.6	0.0002	5.2	1.29
3-136	Хажуу цагаан нуур	1283	1.3	2.1	0.6	0.9	0.0003	6.4	1.58
3-137	Баян бүрд нуур	1264	0.6	2.5	0.2	1.3	0.0002	5.2	1.89
3-138	Зээрийн ус нуур	1299	1.2	2.2	0.5			5.8	1.49
3-139	Бухтын ширээ нуур	990	1.8	2.5	0.7	2	0.0016	7.2	1.52
3-140	Хөөвөр нуур	697	2	2.7	0.1	1.6	0.0014	11.8	2.35
3-141	Онгон улааны нуур	729	3.1	3.2	0.9	2	0.0031	9	1.44
3-142	Бага цагааны нуур	1283	0.5	1.3	0.3	1	0.0002	3	1.2
3-143	Цагаан нуур	1270	0.5	1.1	0.4	1	0.0002	3	1.2
3-144	Жинст тойром	2077	0.5	1.6	0.3			3.4	1.36
3-145	Хоолойны шар тойром	1310	0.5	1.4	0.3	0.7	0.0001	3.2	1.28
3-146	Загийн цагаан нуур	1070	0.5	1.7	0.2	1.32	0.0003	3.2	1.43
3-147	Бухтын шал тойром	981	0.6	1.4	0.4	0.8	0.0005	3.4	1.24
3-148	Их ширээ худгийн тойром	1060	0.5	1.2	0.4	0.9	0.0002	2.8	1.12
3-149	Өмнө тойром	800	0.6	1.6	0.3	1.1	0.0008	3.8	1.38
3-150	Туулайт тойром	762	1.1	1.7	0.6			4.8	1.29
3-151	Хөх нуурын дээд нуур	2652	0.5	1.7	0.2	2.5	0.0002	3.4	1.36

1.2.7 Инженер геологийн нөхцөл.

1909-1958 онд зургаан удаа 6-гаас дээш баллын хүчтэй газар хөдлөлт болсны нэг нь 1957 онд Их Богд ууланд 11 баллын хүчтэй газар хөдлөлт юм.

1.2.7 Байгаль орчны бохирдол

Баянхонгор аймагт дараах бохирдуулагч эх үүсвэрүүд байна.

Уурын зуух 101, тээврийн хэрэгсэл 5500, шатахуун түгээх станц 80, айл өрхийн зуух 21 500 байна

Өвлийн улиралд Баянхонгор хотын байнгын галлагаатай 6 уурын зуух, гэр хорооллын 6433 өрх айл, 600 гаруй машины утаа тортог, дулааны улиралд шатахуун түгээх станцууд, бохирын цооног, 89,5 га талбайг эзлэх хогийн цэгээс байгаль орчин ихээр бохирдож байна. Түүнчлэн Баянхонгор хотын хог хаягдлын цэг ундны усны эх үүсвэрийн салнины дээд талд байрладаг нь маш зохисгүй асуудал бөгөөд хог тээврийн машин байхгүй байгаагаас гэр хорооллын орчмын гуу жалгуудаар руу хог хаях явдал ихсэж, ил задгай хаясан хогноос Баянхонгор хотын баруун, баруун хойд талыг тойрсон хогон цагираг бий болоод 5 жил болж байна. Энэ орчмын айлууд хогон дотроо амьдарч байна.

Гэр хорооллын айлуудын муу ус жорлонгийн цооног стандартын шаардлага хангадаггүй хөрсийг ихээхэн бохирдуулдаг бөгөөд 1 хашаанд дундажаар жорлон, бохирын цооногонд 4,5м² талбай зарцуулдаг гэж үзвэл зөвхөн Баянхонгор хотын хэмжээнд байдаг 6000 гаруй айлын хашаа мөн сумын төвүүдийн хашааг дээр нь нэмбэл зөвхөн энэ зориулалтаар ямар хэмжээний газар бохирдож байгаа нь гарна.

Сумын төвүүдийн хувьд хогийн цэгийн байршил, талбайн хэмжээ баланс дээрх тоо хэмжээнээс төдийлэн өөрчлөгдөөгүй байгаа боловч хогийг цуглуулах, тээвэрлэх, устгах, зайлуулах арга хэмжээ зохион байгуулалт муутай байдгаас цаас, нийлэг уут, картон зэрэг салхи шуурганд хийсэн орчныг бохирдуулж байна.

Галуут, Заг, Баян-Овоо, Гурванбулаг, Бөмбөгөр, Баян-Өндөр, Жаргалант, Шинэжинст, Бууцагаан, Өлзийт сумын нутагт ашигт малтмалын 66 орд газрын 14 481 га талбайг 46 аж ахуйн нэгж ашиглалтын лицензээр эзэмшиж байгаа бөгөөд жилд дунджаар 600 орчим га-д хөрс хуулалт хийж, 200 орчим га-д техникийн нөхөн сэргээлт хийж байна.

Сүүлийн үед алт ухах нэрийдлээр зөвшөөрөлтэй зөвшөөрөлгүй олон аж ахуйн нэгж, иргэд хувь хүмүүс газар дэлхийг ухаж сэндийчлээд зогсохгүй алт угаах явцдаа хүн малын ундны хэрэгцээнд ашиглагддаг булаг шанд голын усыг ашиглах, гольдрилыг өөрчлөх тэрч байтугай мөнгөн ус, цианид натри зэрэг онц аюултай химийн бодисыг ашиглаж хүн малыг хордуулж байна.

Байгалийн ил задгай урсгал усанд хир буртаг, машин тэргээ угаах, байнга мал бэлчээх зэргээр голын усыг бохирдуулах, ойр орчмын бургас, өвс ургамлыг устгах зэргээр байгаль орчныг бохирдуулж доройтолд оруулж байна.

Байгалийн гамшигт үзэгдэл

1944, 1956, 1968 оны мич, 1952, 1964, 1976, 1988 оны луу, 1960, 1984 оны хулгана, 1961, 1985 оны үхэр, 1967, 1979 оны хонь, 1992, 1993, 2001, 2002 жилд нийт 1940 оноос хойш 17 удаа их хэмжээний зуд нүүрлэж байв.

Цөлжилтийн байдал, элсний тархалт.

Баянхонгор аймгийн говь талын нутагт салхины нөлөөгөөр элсний нүүлт эрчимтэй явагдаж тал хээр тэр бүү хэл хүн амын суурьшил, хот суурингийн газрын ойролцоо элсэн хуримтлал их бага хэмжээний элсэн довцог элбэг тохиолдоно. Хэдийгээр сум, орон нутгийн захиргаа ойн зурвас байгуулах, мод тарих зэргээр цөлжилттэй тэмцэж байгаа боловч төдийлэн дорвитой үр дүнд хүрэхгүй байна.

Дүгнэлт

Байгаль цаг уур, ус зүй, хөрс ургамлан бүрхэвч, газрын гадаргуугын хувьд Баянхонгор аймаг бүхэлдээ нийгэм эдийн засгийн тодорхой салбарууд тэр дундаа уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх цаашилбал туслах чанартайгаар өрхийн газар тариалан, малын тэжээлийн аж ахуй, уул уурхайн салбарыг хөгжүүлэх бололцоотой. Мөн эмчилгээний чухал ач холбогдолтой улсдаа ховорхонд тооцогддог Шаргалжуутын халуун рашаан сувилал ажилладаг. Гагцхүү дээрх салбаруудыг хөгжүүлэхэд байгаль орчин газрын нөөц нөхцөлд тулгуурласан зөв менежментийн бодлого хэрэгтэй. Иймд ашиглалтын явцад ямар өөрчлөлт гарсан, цаашид хэрхэн ашиглах, хамгаалах талаар дараа дараагийн бүлэгт дэлгэрэнгүй дурьдах болно.

1.3 Нийгэм –эдийн засгийн нөхцөл

1.3.1. Нийгэм - эдийн засгийн суурь нөхцөл

Аймгийн нийт бүтээгдэхүүний 74%-ийг ХАА, 26%-ийг үйлдвэр үйлчилгээний салбар үйлдвэрлэж байна. 21,4 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бөгөөд үүний нэг хүнд ногдох хэмжээ нь 186,7 мянган төгрөг байна. Энэ нь улсын дунджаас 283,5 мянган төгрөгөөр доогуур үзүүлэлт юм. Аймгийн нийт төсвийн зарлага 7,5 тэрбум төгрөг бөгөөд нийт төсвийнхөө 14,1 %-ийг татварын орлогоор бүрдүүлж үлдсэн хэсгийг санхүүгийн дэмжлэгээр нөхөж байна.

1.3.2. Хүн ам

Баянхонгор аймаг 1990-ээд оны үед 91,7 мянган хүн амтай байсан бол 2007 оны байдлаар 82 229 хүн амтай, тэдний 48,4% нь эрэгтэй, 51,6 % нь эмэгтэй болно. 42,5% буюу 34 848 хүн төв суурингуудад амьдарч байгаагийн 28,9 % буюу 23733 нь Баянхонгор хотод оршин суудаг бөгөөд хөдөө 57,5 % буюу 47 240 хүн амьдарч байна. Нийт өрхийн тоо 21 030 ба тэдний 30,7 % буюу 6433 нь Баянхонгор хотод оршин сууж үлдсэн 69,3 % нь 14502 нь хөдөөд амьдарч байна.

1000 хүн тутамд төрөлт 18,9 %, нас баралт 5,6 %, цэвэр өсөлт 13,3 байна. Хүн амын дундаж наслалт 63,5 дундаж өсөлт 0,9 % байна.

Хүн амыг насны бүтцээр нь авч үзвэл 15 хүртэлх насны хүүхэд 34,8%, 15-59 хүртэлх насны хөдөлмөрийн чадвартай хүн ам 59,5%-ийг, 60-аас дээш насны хүн ам 5,7 %-ийг эзлэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн албанд 37 816 хүн бүртгэлтэй байгаагийн 67,05% нь буюу 25354 нь ХАА-н салбарт ажилладаг байна. Боловсролын түвшингээр авч үзвэл нийт ажилагсдын 1696 нь дээд, 6037 нь дунд, 12159 нь бүрэн бус дунд, 5870 нь бага, 1262 нь боловсролгүй байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 3285, эдийн засгийн идэвхтэй хүн амаар (39,4 мянга) тооцсон ажилгүйдлийн түвшин 8.5 %, бодит ажилгүйдэл 25,8 % байна.

Баянхонгор аймагт 2 их дээд сургуульд 600 гаруй оюутан, 1 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 800 сурагч, 28 ерөнхий боловсролын сургуульд 18,3 мянган хүүхэд суралцаж, 760 багш ажилладаг. 26 цэцэрлэг 19 соёлын төв ажилладаг. 250 бүтэн өнчин, 2457 хагас өнчин, тахир дутуу 234 хүүхэд байгаагаас гадна 2900 орчим хүүхэд хог түүх, гуйлга гуйх, уртасгасан цагаар хүнд хүчир хөдөлмөрийг бага хөлсөөр эрхлэх зэргээр тэвчишгүй хөдөлмөр эрхэлж байна.

512 ортой нэгдсэн эмнэлэг, 38 ортой халдвартын тасаг, 20 ортой хувийн эмнэлэгээс гадна сум дундын 3 эмнэлэг, их эмчийн салбар 17 эмнэлэг ортой ажиллаж байгаа бөгөөд эрүүл мэндийн салбарт нийт 964 хүн ажиллаж байгаа нь 85 хүн тутамд 1 эрүүл мэндийн ажилтан ноогдож байна.

Аймгийн хэмжээнд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ (186,7) 172.0 мян, төг боловч нийт хүн амын 50,4 % буюу 41426 хүн ам АБДТДО байгаагийн 25975 хүн ам нэн ядуу амьдарч байна. Үүний 7812 хүн ам нь аймгийн төвд амьдардаг. Аймгийн малчин өрхийн 59,7% нь 100 хүртэл малтай байгаа нь малчин өрхийн амьдралын баталгаа доогуур байгааг харуулж байна. Нийт 24 мянган малчны 15,3 мянга нь буюу 54,5% нь 16-34 насны залуу малчид эзэлж байна. Нутаг дэвсгэрийн хувьд том, алслагдмал оршдог учир дэд бүтэц төдийлэн сайн хөгжөөгүй, том хотуудтай холбогдох боломж муутай учир хот хөдөөгийн ялгаа ихтэй байна.

1.3.3. Газар тариалан

Аймгийн эдийн засгийн салбарт газар тариалангийн үйлдвэрлэлийг туслах чанартайгаар эрхлэх бөгөөд үүнд өрхийн хэмжээний усалгаатай төмс, хүнсний ногоо тариалах явдал зонхилох байр суурийг эзэлнэ.

2006 онд аймгийн хэмжээгээр 375,6 га талбайд тариалалт хийсэний 3,7 га-д үр тариа, тэжээлийн ургамал, 208,9 га-д төмс, 162,6 га-д хүнсний ногоо тариалжээ. Эдгээрийн га нь инженерийн хийцтэй услалтын системд хамрагдаж байна. Дээрх талбайгаас 3,7 тн үр тариа, 1664 тн төмс, 964 тн хүнсний ногоо 8.2 тн тэж нэгж таримал тэжээл хураан авчээ. Нэг га-гийн ургац үр тарианд 8,0 цн, төмсөнд 64,8 цн, хүнсний ногоонд 70,3 цн байгаа нь улсын дунджаас 1,2-2,4 дахин доогуур байна. Хүн амын хүнсний ногооны хэрэгцээний 20 %-ийг өөрсдөө хангаж байна.

Нэг хүнд ногдох мах, гурил будаа, сүү, сүүн бүтээгдэхүүн хүнсний зүйлийн бүтцэд 88,4 %-ийг эзлэж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний норм, стандарт чанарыг хангахгүй байна. Мах 17,6 %, гурил 41 %, будаа 10 %, төмс хүнсний ногоо 9,4 %, сүү сүүн бүтээгдэхүүн 19,8 % байгаа нь цаашид витаминлаг, илчлэг сайтай загас, өндөг, жимс жимсгэнэ гэх мэт зүйлсийг хүнсэнд өргөн хэрэглэхийг шаардаж байна. Зөв зохистой хооллолтын дэглэм, хоолны бүтэц жор норм, эрүүл ахуй, ариун цэвэрийн шаардлага, тэжээллэг хоолны ач холбогдлын талаар хүмүүст ойлгуулж, тэдний зан үйлийн хэв

маягийг өөрчлөх, ухаалаг чанартай хэрэглээ төлөвшүүлэх ухуулага суртчилгаа муу хийгдэж

Ган, зудын улмаас олон удаа асар их хохирол үзэж байсан, байнгын эрсдэлд байдаг атлаа түүнээс хамгаалах, эрсдлийг бууруулах талаар өнөөг хүртэл тодорхой алхам хийж чадаагүй байгаагийн нэг илрэл нь хадлан тэжээл тариалах, бэлтгэх талаар тогтсон хэвшил, дадал, уламжлал байхгүй нийт тэжээлийн хэрэгцээний 0,5%-ийг бэлтгэж байгаа явдал юм.

Дөрвөн сумын төвд байгуулсан улсын тэжээлийн фондод төвийн районоос тэжээл тээвэрлэн хүргэж байгаа хуучирсан сэтгэлгээг халж, түүний тээвэрлэлтийн зардлаар орон нутагтаа тэжээл тариалах, байгалийн хадлан бэлтгэх талаар эргэлт гаргах хэрэгтэй.

Дд		өвс	хорголжин	хивэг	багсармал
1	Баянхонгор	859,5	411,7	47	13,6
2	Бууцагаан	797,0		4,9	
3	Заг	469,7	130,8		5,2
4	Баянговь	147,3	13,5		
	Дүн	2273,5	556,0	51,3	18,8

Тэжээлийн фондод байгаа тэжээлийн үнийг сонирхон үзвэл 22-25 кг бүхий нэг боодол өвс 2000 төг, шуудай хорголжин 6000 төг, шуудай хивэг 3000-4000 төг, шуудай багсармал 5000 төг байна. Өөр тийш нь тээвэрлэвэл үнэ бүр өсөх болно.

Зудын эрсдэлийг урьдчилан мэдэх боломжгүйгээс улсын тэжээлийн фондод байгаа тэжээлийг хэрэглэж болдоггүй, хэрэглэлгүй хадгалаад дараа өвлийг хүргэнэ гэвэл зуны бороо усанд ялзарч муудаад хэрэглэх аргагүй хор болдог. Иймээс сум бүр өөрсдийнхөө нутагт тэжээлийн ургамал тариалдаг, байгалийн хадлан бэлтгэдэг, бэлтгэсэн хадлангаа өвөлдөө хуваарьтай хэрэглээд дуусгадаг ийм хэвшил тогтоох зайлшгүй шаардлагатай. Ингэхгүйгээр мал аж ахуйг эрчимжүүлэх талаар ямар ч алхам хийж чадахгүй.

Аймгийн хэмжээгээр 3597,3 тн хадлангийн өвс хадаж нийтдээ 20.0 тн тэж. нэгж тэжээл бэлтгэснээр хонин толгойд шилжүүлснээр 1 малд 7.3 кг тэж. нэгж тэжээл оногдож байна. Энэ нь цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангахуйц тэжээлийн бат баазтай болох, хүн амын хүнсний хангамжийг дээшлүүлэх явдал чухлаар шаардагдаж байна.

1.3.4. Мал аж ахуй

Үйлдвэрлэлийн үндсэн салбарт хувийн хэвшлийн бэлчээрийн мал аж ахуй зонхилох байр суурийг эзэлнэ. Үүнд :

Тус аймаг түүхэндээ 1998 онд 2511,3 мянган толгой мал тоолуулж улсад тэргүүлж бол 2007 оны байдлаар 1 878 388 мянган толгой малтай байгаагийн 108 865 нь буюу 5,8 %-г үхэр, 78 378 нь буюу 4,2 %-г адуу, 531 667 нь буюу 28,3 %-г хонь, 1 136 426 нь буюу 60,5 %-г ямаа, 23 052 нь буюу 1,2 %-г тэмээ эзэлдэг ба ямааны тоогоор улсад тэргүүлж байна.

Өндөр уулын бүсэд нийт малын 37.6%, ямааны 6.7%, адууны 36.4%, тэмээний 3.1%, үхрийн 69.0%, хонины 39.1%, Энд голлон сарлаг үхрийг өсгөн үржүүлдэг. Жаргалант суманд “Байдраг” үүлдрийн өндөр гарцтай ширүүвтэр

ноост хонийг бий болгож 1983 онд нутгийн үүлдрээр батлуулсан одоо 13,6 мянган толгой (1496) хүрч байна. Хүрээмарал (1124), Баянбулаг (3 малчны 1099), Гурванбулаг сумын малчид Увсын “Баяд” үүлдрийн 88 хуцыг, Жаргалант сумын малчид Увсын “Өлгийн улаан” шилмэл омгийн 12 ухна авчирч сайжруулагчаар ашиглаж байна. Түүнчлэн хонин сүргийн үүлдэр угсааг сайжруулагчаар Сүхбаатар аймгийн үзэмчин хуц, Завхан аймгийн сартуул хуцыг ашиглах явдал түгээмэл байна.

Хээрийн бүсэд нийт малын 22.0% байгаагийн дотор үхрийн 18.25%, хонины 23.9%, ямааны 23.0% адууны 9.7% тэмээний 8.5%, Орон нутгийн байгаль цаг уурын онцлогт тохирсон нутгийн шилмэл үүлдрүүд болох Бөмбөгөр сумын Өлзийт голын улаан ямаа 8,4 мянга (12 өрх 2068), Баянцагаан хэшлийн илүү нугаламтай 264 хонь, Бууцагааны Баянбүрдийн хар ямааг 1,7 мянга, Баянхонгор суманд “Торгууд” үүлдрээр сайжирсан 190 хонь өсгөн үржүүлдэг. Галшир удмын хээлтүүлэгчийг Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут суманд адууны үүлдэр угсааг сайжруулагчаар ашиглаж байна.

Говийн бүсэд нийт малын 40.0% байгаагийн дотор үхрийн 11.7%, хонины 35.7%, ямааны 70.0%, адууны 34.6%, тэмээний 88.3% тус тус оршин байна. Баян-Өндөр сумын хос зогдорт, “Галбын говийн улаан” Богд суманд “Ханын хэцийн хүрэн” Шинэжинст, Баянлиг суманд Ламын гэгээний (сангарай улаан) хурдан шар тэмээний угшлыг судалж үржүүлэх ажлыг зохион байгуулж байна. Шинэжинст суманд нутгийн ямаанаас ашиг шим, ноолуурын гарц, чанарын хувьд давуу Залаа Жинстийн цагаан ямааг бий болгож нутгийн үүлдрээр 2001 онд батлуусан одоо тоо толгой нь 18 мянга (22 өрхийн 4420) хүрч байна. Түүнчлэн говийн 11 суманд Завханы Дөрвөлжингийн буурал, Сүхбаатарын Баяндэлгэрийн улаан омгийн ухныг сайжруулагчаар ашиглаж байна. Кубын “Альпан” үүлдрийн сүүний чиглэлийн ухны хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн 60 ямаанаас 50 ишиг бойжуулж авсан, дараа жил нь ахин 63 ямаанд хээлтүүлэг хийсэн үр дүнг нь хүлээж байна. Цаашид 2-р үеийн эрлийзийг гарган авч өөр хооронд нь үржүүлэх журмаар хээлтүүлэг явуулах юм.

Дүнгээр нь авч үзвэл өндөр ашиг шимт малын эзлэх хувь хонинд 4,7%, ямаанд 0,5%, үхэрт 0,03%, адуу, тэмээнд хувь эзлэх хэмжээнд хүрээгүй байна.

Жилд дундажаар 117,64 т буюу 130995,9 мянган төгрөгийн тэмээний ноос, 2651,2 ш буюу 62 973,9 мянган төгрөгийн тэмээний шир, 2230,28 т буюу 89014,36 мянган төгрөгийн хонины уртын ноос, 127 852,2 ш буюу 628 272,8 мянган төгрөгийн хонины нэхий, 44,92 т буюу 6833,44 мянган төгрөгийн ахар хурганы ноос, 207,92 т буюу 4 995 066,7 мянган төгрөгийн ямааны ноолуур, 9 т буюу 25 905,52 мянган төгрөгийн ямааны хялгас, 146 471 ш буюу 771 344,6 мянган төгрөгийн ямааны арьс, 46,4 т буюу 6563,14 мянган төгрөгийн бодын хөөвөр, 23,7 т буюу 5517,24 мянган төгрөгийн бодын хялгас, 9494,2 ш буюу 84 583 мянган төгрөгийн адууны шир, 21 375,8 ш буюу 204 007,6 мянган төгрөгийн үхрийн шир тус тус зах зээлд нийлүүлж байна.

2006 оны байдлаар үйлдвэрлэлийн үндсэн фонд 4960 сая төгрөг болсны дээр ХАА-н нийт бүтээгдэхүүн 15,8 тэрбум төгрөг хүрч өнгөрсөн таван жилийн дундажаас 29.0% -р өссөн байна. Одоогоор 35 аж ахуйн нэгж мал эмнэлэгийн үйл ажиллагааг явуулж байна. 1990 онд бог мал 1.5 ээлжийн хашаагаар хангагдсан, бод малын 83% нь хашаалсан байсныг устгаж үгүй хийсэн байна.

1.3.5. Үйлдвэрлэл, үйлчилгээ

2006 оны байдлаар талх нарийн боовны 1 үйлдвэр, 3 цех, архины 4 үйлдвэр, оёдол, гутал засвар хийх зэрэг төрөл бүрийн үйлчилгээ явуулдаг жижиг үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж, 3 578,3 сая квт.цаг эрчим хүч, 89,6 к.кал дулаан, 45,5 мянган л архи, 20,6 мянган л ундаа, 116,6 т талх, 142,3 т нарийн боов үйлдвэрлэж 646,3 кг алт, 6 000 т нүүрс олборлож, 2072,8 сая төгрөгийн барилга угсралт их засварын ажил гүйцэтгэжээ. Төрийн өмчийн үйлдвэрийн газрууд 151 712,7 мянган төг-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 16 371 030 мянган төг-ийн борлуулалт хийж байна. Боловсруулах үйлдвэрт 460, эрчим хүчний үйлдвэрт 445, барилгын салбарт 632 хүн тус тус ажиллаж байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 5,56 тэрбум төгрөг байна.

Одоогоор алт, нүүрс, давсны орд газруудыг ашиглаж байна. Алт агуулсан Баянхонгорын, Их Богдын, Онгон Улаан уулын гэсэн 3 их судал байгаагаас зөвхөн нэгийг нь л ашиглаж байна.

Бөмбөгөр, Шинэжинст, Баян-Овоо суманд 3000-4000 хүн хувиараа алт олборлон амьдарч байна. Бөмбөгөр, Галуут, Баян-Овоо сумдын нутагт гадны голдуу алт олборлогч 20 гаруй аж ахуйн нэгжүүдэд 2072 хүн ажиллаж жилд 600 гаруй кг алт орборлож байна.

Хувиараа ашигт малтмал олборлогчид гар багаж хэрэглэж байсан бол одоо дотоод шаталтын хөдөлгүүр бүхий бага оврын компрессор, эргэлт-цохилтот өрөм, хийн цохилтот алх хэрэглэн үндсэн ордод тэсэлгээний нүх гаргаж, түүнийгээ тэсрэх бодисоор цэнэглэн дэлбэлж, хүдрийг нураан олборлож байна.

Шороон ордоос бага оврын цахилгаан үүсгүүрээр тэжээгддэг усны шахуурга, хийн хөөрөг зэрэг тоног төхөөрөмж ашиглан усаар болон хуурайгаар алт олборлож байна. Хүдэр болон ашигт малтмалын агуулга бүхий шороогоо янз бүрийн овор хэмжээ, даацтай тээврийн хэрэгслэлээр зөөж байгаагаас гадна цахилгаанаар ажилладаг бөмбөлөгт, алхан, хүрдэн тээрмүүдийг ашигладаг болж гар аргаар олборлогч гэгдэхээсээ илүү бичил уурхайн хэмжээнд ажиллах болжээ.

Гар үйлдвэрлэлийн аргаар ашигт малтмал олборлох болсон нь сайн болон саар олон үр дагаварыг бий болгож байна.

Саараас нь дурьдвал байгаль орчин бэлчээр ус сүйтгэдэг, татвар төлдөггүй, нутгийн малчид, уул уурхайн компаниудын эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэх, гэмт хэрэг хэв журмын зөрчил нэмэгдэх, хүний эрх зөрчигдөх, химийн хорт болон аюултай бодисын зүй бус хэрэглээ өсөж байгаа, осол эндэгдэлийн тоо өсөн хүний амь нас эрсдэх, архидалт янхандалт бий болох, мэргэжлээс шалтгаалах болон нийгмийн халдварт өвчин дэлгэрэх нөхцөл бүрдэх гэх мэт

Сайн тал нь гэвэл хүмүүс өөрсдийн хүч хөдөлмөрөөр амьдралаа залгуулж, ам бүлээ тэжээж байгаагаас гадна дагалдах үйлчилгээний албан бус ажлын байруудыг бий болгож, зах зээл зам арилцааны сүлжээг үүсгэж, хөдөөд мөнгөний эргэлт бий болгож, малчдын орлого өсөж, худалдан авах чадвар өсөж байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн шинэ хуваарь ч үүсэж байна.

Хувиараа алт олборлогчидын тоо, ашиглалт явуулсан талбайн хэмжээг баримжаалахад жилд 500 кг алт олборлосон байх бололцоотой ч эдгээрийн дийлэнх хувь нь нууцаар гадагш борлуулагддаг болох нь тодорхой байна. 2005 онд 150 кг алт Монгол банкинд тушааж, төгрөгийн орлого олсон байна. Хойшид зохих эрх зүйн орчныг бүрдүүлж, түүний дагуу зохион

байгуулалтанд оруулж, үр ашигтай хөдөлмөрийн аюулгүй арга технологи хэрэглэн үйл ажиллагаа эрхлэхэд нь туслах, зааж сургах, байгаль нийгмийн өмнө тодорхой үүрэг хариуцлага хүлээдэг болгох, хөдөөд ядуурлыг бууруулах албан ёсны ажлын байр бий болгоход ашиглах шаардлагатай байна.

Шинэжинст сумын Хотгор дэрсний, Баянцагааны Алаг цахир, Загийн Шаригийн нүүрсний уурхайг борлуулах зах зээлийн хомсдолоос болон ашиглаж чадахгүй зөвхөн Өвөрчулуутын нүүрсний уурхайг ашиглаж байна.

Бууцагааны Бор-Овоо, Галуутын Давсан тал, Богдын Холбоожийн, Баян-Овоогийн Хойд Үүд, Баацагааны Бөөнцагаан зэрэг ордуудын давсыг ашиглаж байна.

Аймгийн төвийн орчимд 5-12 км-т нөөц нь тогтоогдсон барилгын материалын ордууд нилээд байгаа бөгөөд барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн хүчирхэг баазтай, барилгачин бэлтгэж байсан сургалтын төвтэй, усны аж ахуйн барилга угсралт, асфальт бетон зам хийх, мод боловсруулах үйлдвэрүүдтэй. Бумбатын тоосгоны үйлдвэрийг засварлаж жилдээ 70,0 хүртэл тоосго үйлдвэрлэх жижиг үйлдвэр, аймгийн төвд блок үйлдвэрлэх цех, албан байгууллагын гадна тохижилт, хамгаалалтын төмөр хайс, хашаа хийх, машин техникийн засвар үйлчилгээ хийх жижиг үйлдвэрүүд ажиллаж байна.

Шаргалжуутын рашаан сувилалд жил бүр 3500-4000 хүн ирж сувилуулж байгаагийн 1340-1850 хүн буюу 40-өөс дээш хувь нь Улаанбаатар хотоос, 470-600 хүн буюу 15% орчим нь Баянхонгор аймгаас ирж сувилуулагчид байна.

ХАА-н, Монгол шуудан, Хадгаламж, Хас зэрэг банкны 30 орчим салбар нэгж ажилладаг.

2003-2005 цэвэрлэх байгууламж, цэвэр усны нэгдсэн систем ашиглалтанд орсон. Ахуйн болон хэрэглээний цэвэр усыг хоёр гүний худгаас хлораторын байгууламж, түгээх шугамаар дамжуулан барилгажсан хэсгийн бүх объектод 4,8 км шугамаар хүргэж байна. Хувийн 9 орон сууц, нийтийн эзэмшлийн зориулалттай 31 орон сууц (нийт 607 өрхийн 1731 хүн амьдардаг) бүгд цэвэр ус, ариутгах татуургын системд холбогдсон бөгөөд энэ үйлчилгээг “Чандмань” ХХК гүйцэтгэж байна. Хоногт дунджаар 363,4 м куб усыг татан зайлуулж, ариутгах татуургад цэвэрлэж байна. Гэр хороололын иргэдэд гүний 4 худаг, 14 усан сангаас 2 автомашинаар ус түгээж нийт хэрэглээний 60%-ийг хангаж байна.

Сумдад болон аймгийн төвийн зарим байгууллагууд нам даралтын уурын зуухнууд ажиллуулж, аймгийн төвийн төсвийн байгууллагууд орон сууцны айл өрхүүдийг 6 төвлөрсөн уурын зуухаар дулаанаар хангаж байна.

Орон нутагтаа үйлдвэрлэх бололцоотой олон төрлийн бараа, хүнсний бүтээгдэхүүнийг Эрээн, Улаанбаатар хотоос зөөж хэрэглэж байгаа нь үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих, хүн амын суурьшилд сөрөг нөлөөтэй байгаад дүгнэлт хийж, ахуйн үйлчилгээ, жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар бодлого боловсруулан ажиллах шаардлагатай.

1.3.6. Дэд бүтэц, зам харилцаа, бусад салбар

Тус аймгийн нутгаар Баянхонгор-Шаргалжуутын 44 км, Баянхонгор-Нарийн тээлийн 57 км, Баянхонгор-Бөмбөгөрийн 102 км, Бөмбөгөр - Бууцагааны 79 км, Бууцагаан - Хүрээмаралын 43 км, Хүрээмэрэл - Баянбулагийн 52 км, Баянбулагаас - Отгоны чиглэлд 25 км, Бууцагаанаас - Дэлгэрийн чиглэлд 81 км нийт 483 км улсын чанартай томоохон замууд дайран гарч байгаагийн дотор Улаанбаатар - Алтайн зам ачаа болон зорчигч тээврийн онцгой чухал үүрэг гүйцэтгэнэ. Баянхонгор-Арвайхээрийн чиглэлийн сайжруулсан хайрган хучилттай зам барих ажил эрчимтэй явагдаж байгаа бөгөөд цаашид хатуу хучилттай болох асуудал Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан. Аймгийн төвд 2 урсгалтай хатуу хучилттай зам тавигдсан.

Орон нутгийн чанартай 4535 м урт шороон зам авто замын сүлжээний зонхилох хэсгийг буюу 90,4%-ийг бүрдүүлж байна. Далайн түвшнээс дээш 2800-3000 м өндөрт өргөгдсөн Цагаан хад, Тонгорго, Элбэх, Сэрвэн, Суу даваанд уул намгийн 70 гаруй км зам засаж 200 мянган га зэлүүд бэлчээрийг ашиглаж байв.

Мөн тус аймгийн хойт талын сумдын нутгаар баруун аймгуудаас Дархан, Улаанбаатарт тушаагдах мал тууврын зам дайран өнгөрнө. Энэ замд одоогийн байдлаар 142.2 мян.га бэлчээр нутаг хамрагдаж байна.

Баянтээг - Баянхонгорын 110 кВ-ын шугам ашиглалтанд ороод байгаагаас гадна Баянхонгор-Эрдэнэцогтын 6 кВ, Баянхонгор-Баян-Овоогийн 10 кВ, Баянхонгор-Өлзийтийн 6 кВ, Баянхонгор-Шаргалжуутын 10 кВ-ийн Жаргалант-Заг-Гурванбулагийн 10 кВ-ийн шугам ашиглагдаж байна, 2006 онд нийт 10,8 сая квт / цаг эрчим хүч хэрэглэсэн байна. 4 сум, нэг тосгоны үйлдвэр үйлчилгээний байгууллагууд 6000 гаруй өрх, 3000 гаруй байгууллага, нийт хүн амын 44,7 % байнгын цахилгааны найдвартай эх үүсвэрт холбогдоод байна. Баянхонгор хотод баригдсан 110/35/6 кВ-ийн дэд станцад суурилагдсан трансформатор нь 6300 кВа хүчин чадалтай бөгөөд одоогийн нийт ачаалал 2500 кВа байна. Станцийн 9 гаргалгаас 10 кВ-ын 54,7 км, 6 кВ-ийн 93,2 км, ЦДАШ, 10/04 кВ-ын 3 дэд стац, 6/04 кВ-ын 41 дэд станцаар дамжуулан түгээлт хийж байна.

Аймгийн төвд эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлэх ажил хийгдэж, цэвэр бохир усны шугам, цэвэрлэх байгууламж ашиглалтанд ороод байна.

Жаргалант сумын (100 станц 2, 60 станц 1) ЭХС-аас Заг 25 км, Гурванбулаг 55 км сумуудыг эрчим хүчээр хангадаг ба бусад 13 сумд Японы 100, 60 моторуудыг 2-3-ийг суурилуулан орой 4-5 цаг дизель станц ажиллаж эрчим хүчээр хангаж байгаа ба 3000 малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангаад байна.

Баянхонгор аймгийн холбооны АТС-ийн багтаамж нь 2306, гол кабелийн багтаамж нь 2936 нийт телефон хэрэглэгчдийн тоо 1798 байна. Үүрэн телефоны мобиком, скайтелийн операторууд ажиллан, интернетийн сүлжээнд холбогдоод байна. Өвөрхангай аймгийн 111-р станцаас скайтелийн тоон РРШ-аар дамжсан 2 МВ-ын урсгалаар Улаанбаатар хотын АТС-45-тай, Мобикомын нэг тоон урсгалаар Е-10 станцын урсгалтай холбогдож, нийт 60 сувгийн гарцаар улс хот хоорондын телефон яриа, факс, интернет үйлчилгээг явуулж байна. Эдгээр гарцыг дамжуулж байгаа сүлжээ аймгийн холбооны газраас 115-р станц хүртэл 16 км шилэн кабель, Урс -115-р станцаас Өвөрхангай РРШ-ын Урс-111-р станц хүртэл ТРРШ-аар дамжиж байна. Аймгийн төвөөс улс хот хооронд холбогдох сүлжээ нь үндсэндээ тоон технологид шилжсэн боловч хурд багтаамжийн хувьд хүрэлцээ муутай байна. Аймгийн төвөөс сум

хооронд аналоги технологитой сүлжээ ашиглаж байгаа бөгөөд релейны шугамын дагуу ердөө 2 сум л тоон технологи бүхий сувагтай байна. Орон нутгийн холбоонд агаарын шугамын нягтруулгын ОВ-3-3, ОВ-12-3 системүүд болон ган шугамаар 20 сум сууринг аймгийн төв болон улс хот хооронд холбож байна.

Радио релейны 7 станц байдаг нь Өлзийт суманд 114, Баян-Овоо суманд 115,116, Бөмбөгөр суманд 117, Бууцагаан суманд 118,119, Хүрээмарал суманд 120-р станцууд байдаг.

Баянхонгор аймгийн төвөөс Жаргалант Баянбулагийн чиглэлд 278 км бронз шугам, Баянлигийн чиглэлд 219 км БСА, шугам, Баянцагааны чиглэлд 246 км АС шугам, хийтдээ 743 км өнгөт шугам, бусад сумууд руу нийт 645 км ган шугамаар холбогдсон бөгөөд эдгээрийн нийт урт нь 1081 км байгаа юм.

Холбооны агаарын баганат шугамын уртыг сум хооронд хвч үзвэл Баянхонгор-26-Баяновоо-61-Галуут-75-Жаргалант-25-Заг-83-Баянбулаг-40-Хүрээмарал, Баянгийн ус – 43 -Гурванбулаг, Баянхонгор – 90 – Жинст – 27 – Богд – 92 – Баянлиг – 39 - Баянговь, Баянхонгор – 123 – Баацагаан – 93 – Баянцагаан – 33 - Баян-Өндөр, Баянцагаан –60 – Шинэжинст, Баянхонгор-15-Өлзийт, Баянхонгор-27-Эрдэнэцогт, Баянхонгор-52- Шаргалжуут, Баянхонгор-Дөвөнт гэсэн нийт 1004 км урт шугам байна.

Эдгээр шугамаар Баянхонгор - Жаргалант, Баянхонгор - Баянцагааны хооронд ОВ-12-3 системээр тус бүр 7 суваг, Баянхонгор-Баянлиг, Баянхонгор-Баянбулагийн хооронд ОВ-3-3 системээр тус бүр 3 суваг ялгаруулан ажиллаж байна. Эдгээр сумууд нь нягтруулсан сувгийн 66%-ийг эзлэнэ. Нийт хүн амын 25% нт үүрэн телефоны үйлчилгээ хэрэглэх боломжтой. Интернетийн үйлчилгээний хэрэглэгч 50 гаруйхан байна.

Тээвэр холбооны салбарт нийт 533 хүн ажиллаж байна.

1.3.7. Баянхонгор аймгийн нутагт сүүлийн жилүүдэд байгаль орчны болон нийгэм эдийн засгийн чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд

НҮБ-ийн Хөгжилийн Хөтөлбөрийн хүрээнд Нидерландын Вант улсын ЗГ-ын буцалтгүй тусламжаар “ Бэлчээрийн тогтвортой менежмент төсөл” 2003 оноос Богд, Галуут, Жинст, Эрдэнэцогт суманд амжилттай хэрэгжиж байна.

2003 оны 8-р сараас Швейцарын хөгжил хамтын ажмллагааны агентлагаас Бичил уурхайг дэмжих төслийг хэрэгжүүлж байна.

Дэлхийн банкны “Нам хүчдэлийн шугам сүлжээний алдагдал бууруулах” төслөөр гэр хороололын 8 дэд станцын 71 км шугам сүлжээг иж бүрнээр шинэчлэн модон тулгуурыг бетон хөлтэй болгож, агаарын хөнгөн цагаан шугамыг СИП бүрээстэй кабелиар сольж, 3500 айл өрхөд электрон тоолуурыг 3-тай болон 6-тай хайрцагт тавьж мантажилснаар алдаглыг 5% хүртэл бууруулсан болно.

Япон улсын Ойто мужтай хамтран “Нэг баг- Нэг шилдэг бүтээгдэхүүн” хөдөлгөөн өрнүүлж, Буриадын Кабанскийн районотой эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна
Давуу тал Зам харилцаа сайжрах, эрчим хүчний байнгын эх үүсвэрт холбогдох эхлэл тавигдаж байгаа, хүн амын зонхилох хэсэг амьдран суудаг

Баянхонгор хот цэвэр бохир усны системтэй болсон. Эрдэс баялагийн судалгаа харьцангуй сайн хийгдсэн, алт нүүрс, давсны орд газруудтай. Мал аж ахуйн түүний эдийн нөөц сайтай. Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газрууд олонтой тул аялал жуулчлал хөгжүүлэх бололцоотой.

Сул тал Нийслэл болон бүсийн тулгуур төвүүдтэй дэд бүтцийн холбоо бүрэлдээгүй, эдгээрээс алслагдсан, хөдөөд чиглэсэн дэд бүтэц байхгүй. Эдийн засгийн угтвар нөхцөл бүрэлдээгүйгээс хүн амын нягтшил багатай шилжилт хөдөлгөөн их, ядуурал, ажилгүйдлийн түвшин өндөр. Цөлжилт эрчимтэй явагдаж байгаа, Шинжлэх ухаан технологийн хөгжлийн түвшин доогуур, зах зээлд өрсөлдөх хэмжээний үйлдвэрлэл байхгүй, Ой мод, гүний болон гадарын усны нөөц бага, Бүлэг суурин болон бичил бүсийн төвүүд хөгжөөгүй. ХАА-н түүхий эдийн асар их нөөцтэй боловч түүнийг боловсруулах хөдөлмөр зохион байгуулалт, технологийн уялдааг хийж чадахгүй байна.

Боломж МАА-н түүхий эдэд тулгуурласан боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх, Алт болон ашигт малтмалын бусад орд дээр тулгуурлан ажилгүйдлийг бууруулах, Үнэт эдлэлийн гар урлалыг хөгжүүлэх, Аялал жуулчлалыг хөгжүүлэх

Дүгнэлт

Баянхонгор аймгийн нийгэм эдийн засгийн хөгжил урд жилүүдийн үзүүлэлттэй харьцуулахад ахиц байгаа боловч өнөөгийн түвшинд шаардлага бүрэн хангах хэмжээнд хараахан хүрээгүй байна. Иймд аливаа нийгмийн салбарын хөгжлийг өнөөгийн шаардлагын түвшинд аваачихын тулд нийгэм эдийн засгийн хөгжлийг газрын нөөц нөхцөлийн байдалтай уялдуулан төлөвлөх түүний дагуу хөгжлийн чиг хандлагыг удирдан зохицуулах шаардлагатай байна. Аймгийн төв түүнийг тойрсон 4 суурингаас бусад сумын төвүүд эрчим хүчний системд холбогдож чадаагүй, дулааны станц байхгүйгээс цахилгаан дулааны үнэ нийслэл хотоос 3 - 4 дахин өндөр байгаа нь боловсруулах үйлдвэр хөгжихөд сөргөөр нөлөөлдөг. Өвөрхангай-Баянхонгорын хатуу хучилттай замын ажил явагдаж байгаа боловч удааширалтай байна. Говь-Алтай, Ховдын чиглэлийн төв зам дайран өнгөрдөг ч үйлчилгээний соёлын түвшин доор байдаг учраас аялал жуулчлал хөгжиж чадахгүй байна.

Ирээдүйд Баянхонгор-Бууцагаан - Хүрээмарал сумын төвүүдийг дайрсан төмөр зам тавигдаж энэ чиглэлд зорчигч болон ачаа эргэлт хүн амын суурьшил нэмэгдэж, ХАА-н бүтээгдэхүүний хэрэгцээ өсөх боломжтой тул энэ орон зайг эзлэх бэлтгэлийг одооноос хийх шаардлагатай.

Баянхонгорын нутгаас алт олборлогч аж ахуйн нэгжүүд голчлон татвараа улсад тушаадаг тул тэдгээрийн үйл ажиллагааны эерэг тал орон нутагт мэдрэгдэхгүй зөвхөн сөрөг тал нь болох сүйтгэгдэж бохирдсон байгаль л үлдэж, нөхөн сэргээлтийнх нь ажилд орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд болон иргэдийн зүгээс хяналт тавьдаггүй зэрэг явдлуудад шүүмжлэлтэй хандах ёстой. Иймээс олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг явуулж алт олборлогчид Баянхонгорын нутгаас хэдий хирийн алт олборлож, орон нутгийн төсөвт ямар орлого оруулдаг, хэдэн ажлын байр бий болгосон, байгаль орчин яаж сүйтгэгдсэн, нөхөн сэргээлтийн ажлыг яаж хийсэн зэрэг асуудлаар ард нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг явуулах хэрэгтэй.

II Бүлэг. Баянхонгор аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц

ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал.

2.1 Баянхонгор аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц, түүний ашиглалт, хамгаалалт.

Газрын нэгдмэл сангийн 2006 оны жилийн эцсийн тайлангаас үзэхэд Баянхонгор аймаг нь нийт 11 597,8 мян.га нутаг дэвсгэртэй бөгөөд үүний 9016,7 мян.га буюу 77,7 % нь ХАА-н газар, 17,5 мян.га буюу 0.2 % нь хот тосгон бусад суурины газар, 5,1 мян. га буюу 0.04 % нь зам шугам сүлжээний газар, 243,8 мян. га буюу 2,1 % нь ойн сан бүхий газар, 51.1 мян. га буюу 0.4 % нь усан сан бүхий газар, 2 263.5 мян. га буюу 19,5 % нь улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзлэж байна /хүснэгт 4, диаграмм/.

Хүснэгт 4

Баянхонгор аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц, 2006 он

Д/д	Газрын үндсэн ангилал	Эзлэх талбай	
		мян.га	Хувь
1	Хөдөө аж ахуйн газар	9 016,7	77,7
2	Хот тосгон бусад суурины газар	17.5	0,2
3	Зам шугам сүлжээний газар	5.1	0,04
4	Ойн сан бүхий газар	243,8	2,1
5	Усан сан бүхий газар	51.1	0,4
6	Тусгай хэрэгцээний газар	2 263.5	19,5
	Бүгд	11 597, 780	100

Хүснэгтээс харахад ХАА-н газар, тусгай хэрэгцээний газар нилээд газар нутгийг эзлэн оршдог нь харагдаж байна.

Газрын нэгдмэл сангийн бүтэц



Газрын үндсэн ангиллын газрууд нь нийгэм эдийн засгийн хөгжилөөс хамааран байнга өөрчлөгдөж байдаг бөгөөд түүний өөрчлөлтийг сүүлийн 2 жилийн байдлаар харуулав /хүснэгт 5/.

Хүснэгт 5

Баянхонгор аймгийн нэгдмэл сангийн өөрчлөлт, га

Д/д	Газрын ангилал	2005	2006	Зөрүү, +, -
	Нийт нутаг дэвсгэр	11597780	11597780	0
1	ХАА-н газар бүгд	8982071.85	9016720.3	
	үүнээс			
	Бэлчээр	8968143.62	9002771.7	+34628.08
	Хадлан	10336	10336	0
	Тариалан	819.4	831.8	+12.4
	Атаршсан	851.5	849	-2.5
	ХАА-н барилга	1901	1911	+10
2	Хот тосгон суурины газар	16945.5	17497.1	+551.6
	Барилгажсан	402.4	422.7	+20.3
	Гэр хороолол	471.56	507.16	+35.6
	Нийтийн эдэлбэр	6883.3	6821.4	-61.9
	үйлдвэрийн	17.8	23.8	+6.0
	Уурхайн	9170.4	9722	+551.6
3	Зам шугам, сүлжээний газар	5103.1	5103.1	0
	Авто зам	4108.1	4108.1	0
	Төмөр зам	0	0	0
	Агаарын	9.8	9.8	0
	Шугам сүлжээ	985.2	985.2	0
4	Ойн сан бүхий газар	243832.75	243832.75	0
	Ой	239672.5	239672.5	0
	Ой мод огтолсон	4154	4154	0
	Мод үржүүлэг	1.25	1.25	0
	Ой тэлэн ургах	0	0	0
5	Усан сан бүхий газар	51118.4	51118.4	0
	Гол мөрөн	2648.6	2648.6	0
	Нуур цөөрөм	48004	48004	0
	Булаг шанд	465.8	465.8	0
6	Улсын тусгай хэрэгцээний газар	2298708.4	2263508.4	-35 200
	Тусгай хам.	2172260	2172260	0
	Хилийн зурвас	74500	74500	0
	Батлан хамгаалах	58.4	58.4	0
	Отрын бэлчээр	51860	16660	-35 200

ХАА-н газар нь нийт 9016720.3 га талбайтай бөгөөд үүнээс бэлчээр 9002771.7 га, хадлан 10336 га, тариалан 831.8 га, атаршсан газар 849 га, ХАА-н барилга байгууламжинд 1911 га ба ХАА-д тохиромжгүй газар 20,5 га тус тус эзлэж байна. Энд Өлзийт суманд 9 га, Жинст суманд 1.2 га, Богд суманд 0.7га, Бууцагаанд 1.5 га нэмэгдсэнээс тариалангийн газар бүгд 12.4 га-р нэмэгдэж Богд, Бууцагаан суманд атаршсан газраас 2.5 га тариалан руу шилжсэн учир уг хэмжээгээр атаршсан газар хорогдсон байна. Баянбулаг сумын нутагт өвөлжөө хаваржааны газар 10 га-р нэмэгдсэнээс ХАА-н барилга байгууламжийн доорхи газрын хэмжээ мөн тэр хэмжээгээр нэмэгджээ. Бэлчээрийн газар 1134.58 га талбайгаар хасагдаж барилга байгууламж 93.04 га талбайгаар тус тус нэмэгдсэн байна.

Хот тосгон бусад суурингийн газар нь нийт 17497.1 га газартайгаас барилгажсан талбай 422.7 га, гэр хороолол 507.16 га, нийтийн эдэлбэр 6821.4 га, үйлдвэрийн газар 23.8 га, уурхайн газар 9722 га байна. 2006 оны эцэс гэхэд барилгажсан талбай Баянбулагт 1.5 га, Богдод 0.5 га, Баянлигт 14.3 га, Баянхонгорт 4 га нэмэгдсэнээс нийт 20.3 га-р мөн газар өмчлөлийн хүрээнд гэр бүлийн хэрэгцээнд хашааны газар олгосноос гэр хороолол 35.6 га талбайгаар тус тус нэмэгдсэн байна. Мөн түүнчлэн үйлдвэрийн газар 6.0 га-р /Өлзийт/ нэмэгдсэн. Иймд нийтийн эдэлбэрийн газраас 61.9 га талбай хасагджээ. Уурхайн газар 551.6 га-р /Бөмбөгөр/ нэмэгдсэн учир энэ хэмжээгээр хот суурингийн газар нэмэгдэж энэ хэмжээгээр бэлчээрээс хасагдсан байна.

Зам шугам, сүлжээний газар нийт 5103.1 га талбай эзэлдэгээс авто зам 4108.1 га, агаарын тээвэр 9.8 га, шугам сүлжээ 985.2 га талбай эзэлдэг бөгөөд уг ангиллын газар ямар нэг өөрчлөлт ороогүй байна.

Ойн сан бүхий газар нь нийт 243832.75 га талбай эзэлдэгээс ой 239672.5 га, ой мод огтолсон газар 4154 га, мод үржүүлгийн газар 1.25 га талбайг тус тус эзлэх ба ой тэлэн ургах газар байхгүй байна. Уг ангиллын газар одоогоор ямар нэг өөрчлөлт ороогүй байна.

Усан сан бүхий газар нь нийт 22232.07 га газартайгаас гол мөрөн 12370 га, нуур цөөрөм 9126 га, булаг шанд 736 га байна. Энд гол мөрөнгийн талбай 7.23 га талбайгаар хорогдсон дүн гарчээ. Уг ангиллын газар ямар нэг өөрчлөлт ороогүй байна.

Улсын тусгай хэрэгцээний газар нь нийт 2263508.4 га газар эзэлдэгээс улсын тусгай хамгаалалтай газар 2172260 га, улсын хилийн зурвас 74500 га, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 58.4 га, аймаг дундын отрын бэлчээр 16660 га, шинжлэх ухаан сорилт туршилт болон цаг уурын станцын талбай 30 га тус тус байдаг байна. Энд өнгөрсөн онд Бууцагаан сумын нутагт аймаг дундын отрын бэлчээр 45200 га байсан бол одоо 10 000 болж даруй 35 200 га талбайгаар хорогдсон нь бэлчээрийн газарт нэмэгдэн оржээ.

Эндээс нэгтгэн дүгнэхэд газар өмчлөлийн ажил эрчимтэй өрнөж байгаатай уялдуулан барилга байгууламж, гэр хорооллын газарт мөн түүнчлэн газрын хэвлийн баялгийг өргөн дэлгэр ашиглах болсноос уул уурхайн салбарт нэлээд өөрчлөлт орсон байна.

2.2 ХАА-н ангиллын газрын бүтэц, ашиглалт, хамгаалалтын байдал

2006 оны эцсийн байдлаар ХАА-н газар нийт 9016720.3 га талбай эзлэж байгаагаас бэлчээр 9002771.7 га, хадлан 10336 га, тариалан 831.8 га, атаршсан газар 849 га, ХАА-н барилга байгууламжинд 1911 га ба ХАА-д тохиромжгүй газар 20,5 га тус тус эзлэж байна.

ХАА-н газрын бүтцийг сум тус бүрийн дэлгэрэнгүй тайлангаас үзэхэд харилцан адилгүй байгаа нь тухайн сумын оршиж байгаа бүс нутгийн байгаль, цаг уурын онцлог нөхцөл, аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн чиглэлээс шууд хамаарч байгаа, тухайлбал: Говийн бүсэд орших Баян-Өндөр, Шинэжинст, Баянлиг, Жинст, Баянговь, Баянцагаан сумдын ХАА-н эдэлбэр газрын 99.5-100.0

%-г бэлчээр эзэлж, тариалангийн талбай, хадлан маш бага, нэмэгдэл тэжээлийнхээ өчүүхэн хувийг бэлдэхүйц хэмжээтэй байхад Хангай хээрийн бүсийн Жаргалант, Галуут, Эрдэнэцогт, Гурванбулаг сумдын тариалан, хадлангийн талбай нь ХАА-н эдэлбэр газрын 0.3-0.6%-г эзлэж байгаа ба дотоодын хэрэгцээг бүдүүн ба шүүст тэжээлийн тодорхой хэсгийг өөрийн үйлдвэрлэлээс хангах бололцоотой байна.

Хад асга элс бүхий ХАА-д тохиромжгүй газрын дийлэнх нь Гурванбулаг, Баянбулаг, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Жаргалант сумдын нутагт оршино.

2.2.1 Тариалангийн газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал.

Баянхонгор аймаг нь хөрс, байгаль цаг уурын нөхцөлөөсөө шалтгаалж газар тариалангийн үйлдвэрлэлийг туслах чанартайгаар эрхэлдэг. Социализмын үед тариалангийн нийт талбай нь 14390 га-д хүрч байсан бөгөөд үүний 32% нь буюу 4579 га нь сумдын тариаланд ашиглагдаж, үлдэж буй 9557 га Байдрагийн САА-д, 179 га нь Номгон хоршоолд, 60 га нь Говийн ашигт ургамал тарималжуулах ЭШС-д, 18 га нь Эхийн голын ЭШС-д, 24 га нь аймгийн төвийн албан байгууллагуудын туслах аж ахуй тариалангийн газарт ашиглагдаж байжээ. Тэгвэл одоо 2006 оны газрын тоо бүртгэлээр 831.8 га тариалангийн газартай гэж бүртгэгдсэнээс төмс хүнсний ногоо 828.5 га, тэжээлийн ургамал 2 га, таримал ургамал, жимс, жимсгэнэ 1.3 га, талбайг эзлэх бөгөөд атаршсан талбай 849 га байна. Бидний судалгаагаар нийт 851.5 га талбай байгаа бөгөөд үүнээс 846.2 га нь төмс хүнсний ногоонд, 2 га нь тэжээлийн ургамалд, 3.3 га нь жимс жимсгэнэд ашиглагдаж байгаа бөгөөд 764.3 га талбай атарт байгаа нь газрын тоо бүртгэлийн материалаас төмс хүнсний ногооны талбай 23.0 га-р илүү гарч, атар 84.7 га талбайгаар дутаж байна. Эндээс харахад тус аймаг нь үр тарианы аж ахуйг бараг эрхэлдэггүй зөвхөн өрхийн хэмжээний төмс, хүнсний ногоог туслах чанартайгаар тариалдаг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл нийт эргэлтийн талбайн 99.4% нь төмс, хүнсний ногоонд үлдэх багахан хувь /0.6%/ нь бусад тарималд ашиглагддаг байна. / хүснэгт 6, хавсралт 1/.

Хүснэгт 6

Тариалангийн талбайн ашиглалтын өнөөгийн байдал

№	Сумын нэр	Хэмжээ, га-аар	Таримлын төрөл	Тарьсан хэмжээ, га-аар	Жилийн дундаж ургац цн/га-аар
1.	Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан	313	үр тариа	-	-
2	Гурванбулаг, Баянбулагаас бусад	415.2	Төмс	206	70-80
3	Гурванбулаг, Баянбулагас бусад	100	Хүнсний ногоо /нэр төрлөөр/	86	80-90
4	Шинэжинст, Бууцагаан	3.3	Жимс жимсгэнэ,	2.0	5кг/бут
6	Өлзийт	20.0	тэжээлийн ургамал	20.0	100
8		851.5		314	

Эндээс харахад тус аймаг нь нийт эргэлтийн талбайн 314 га буюу дөнгөж 37.2%-ийг ашиглаж бусад талбайг өнжөөдөг байна.


Хүснэгт 7

Тариалсан талбай, га

	2001	2002	2003	2004	2005	2006	2006/2005%
Үр тариа	0.6	6.8	8.9	11.5	3.4	4,1	120,6
Төмс	95.7	160.3	225.5	130.5	206.4	208,9	101,2
Хүнсний ногоо	42.6	62.6	99.4	55.1	86.2	162,6	188,6
Бүгд	138.9	229.7	333.8	197.1	296	375,6	126,9

Хураасан ургац, тн

	2001	2002	2003	2004	2005	2006	2006/2005%
Үр тариа	0.1	6.8	9.8	3.9	2.8	3,7	132,1
Төмс	212.6	81.1	937.1	841.4	1339	1664	124,3
Хүнсний ногоо	121.1	564.7	311.4	548.8	606.2	964	159,0
Бүгд	333.8	1382.5	1258.3	1394.1	1948.0	2631,7	135,1



Төмс, хүнсний ногооны тариалалт

Нийт тариалангийн болон атаршсан газрын хөрсний 0.2%-ийг уулын сулавтар хөгжилтэй цайвар бор, хүрэн хөрс, хуурай тал хээрт 5.5%-ийг хүрэн хөрс, цөлөрхөг хээрт 23.3%-ийг цайвар хүрэн хөрс, 0.1%-ийг цөлөрхөг хээрийн цайвар бор хөрс, хужир мараалаг нам хотосоор 17.2%-ийг цөлөрхөг хээрийн нугын бор хөрс, 25.4%-ийг нугын хужирлаг хөрс, урсгалт уст голын сав газраар 28.1%-ийг аллювийн нугын хөрс тус тус эзэлнэ. Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд нийт хөрсний ихэнхи хувийг элсэнцэр, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрс бүрдүүлнэ /хүснэгт 8/. Хөрсний үржил шимийн хувьд нийт талбай нь ялзмагт үе давхарга нимгэн, ялзмагийн агууламж бага, хөрсний шим тэжээлийн бодисын ангиллаар хөдөлгөөнт фосфороор бага, калиар дунд зэрэг хангалттай, ерөнхийдөө ядуувтар хөрстэй байна. Эндээс нэгтгэн дүгнэхэд нийт тариалангийн газрын га буюу % нь агро үйлдвэрлэлийн III групп, га буюу % нь агро үйлдвэрлэлийн IV группын хөрстэй байна. Иймд хөрсөн бүрхэвчийн хувьд малын тэжээл тарих боломжтой бөгөөд багахан хэмжээний газар усалгаатай нөхцөлд

нэмэлт бордоо, хөрс сайжруулалт хийсэний үндсэн дээр өрхийн хэмжээний төмс, хүнсний ногоо тариалж болох юм.

Хүснэгт 8

Хөрсний хэв шинж ба механик бүрэлдэхүүн.

Хөрсний хэв шинж	Эзлэх талбай		Хөрсний механик бүрэлдэхүүн	Эзлэх талбай	
	Га	хувь		Га	хувь
Хүрэн хөрс	89.6	5.5	Хүнд шавранцар	399	24.6
Цайвар хүрэн	378	23.3	Дунд шавранцар	126	7.8
Уулын с/х цайвар бор хөрс	3.2	0.2	Хөнгөн шавранцар	516	31.8
ЦХ-н цавар бор хөрс	1.5	0.1	Элсэнцэр	578.6	35.7
ЦХ-н нугын бор хөрс	279.8	17.2	Элсэн	2.7	0.2
Цөлийн бор саарал хөрс	2.2	0.1			
Нугын хужирлаг хөрс	412.3	25.4			
Аллюви нуга	456	28.1			
Дүн	1623	100	Дүн	1623	100

2.2.2 Жимс, жимсгэний газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

Тус аймгийн Шинэжинст сум анх 1970-д оны үед усалгаатай газар тариалан эрхэлж төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тарихаар Эхийн голд 20.8 га талбайг хагалж услалтын систем байгуулсан боловч зах зээлийн үед эвдэрч тоногдон ажиллахаа больсон байна. 2000 оноос сумын ногоо тарих хүсэлтэй иргэд уг талбайг дахин эзэмшиж эхэлснээр одоо 3.6 га газарт жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногоо тарьдаг ба үүний 1.3 га-д жимс жимсгэнэ тарьдаг. Мөн Бууцагаан суманд Нарангийн ам гэдэг газар 2 га газар саяханаас үхрийн нүд, чацаргана тарих болсон байна. Одоогоор тариалалт амжилттай явагдаж байна.

Хүснэгт 9

	Сумын нэр	Хэмжээ га-гаар	Таримал жимсний модны төрлүүд	Ургац, цн/га	Шимт чанар	Ашиглалтын өнөөгийн байдал
1	Шинэжинст	1.3	чацаргана	5кг/ бут	Сайн	Сайн
2	Бууцагаан	2.0	чацаргана, үхрийн нүд	5кг/ бут	Сайн	Сайн
	Бүгд	3.3				

Тариалангийн газрын нөхөн сэргээлт, ашиглалт хамгаалалт.

Тус аймаг нь анх 1960-д оны үед газар тариалан эрхэлж одоогийн Жаргалант суманд 20 мян. гаруй га талбайтай Байдраг ТАА байсан ба одоо тэр аж ахуй талбайгаа атаршуулж орхисоор 25 га талбайтай болжээ. Мөн Эрдэнэцогт, Өлзийт сумын Хөшөөт, Бумбат зэрэг газар тэжээлийн ургамал тариалж байсан түүхтэй. Одоогоор нийт эргэлтийн 831.8 га талбайн 297.4 га буюу дөнгөж 35.7%-ийг ашиглаж байгаа бөгөөд 331 га талбайг өнжөөж, 849 га талбайг атаршуулж орхиод байна. Дээрх атаршуулж орхисон талбайнуудын зарим нэгийг эргүүлэн тариаланд ашиглаж тэжээлийн ургамал тариалахад болохгүй юмгүй. Өнөөгийн нөхцөлд тариалж байгаа төмс, хүнсний ногооны талбайнууд нь ялзмагт үе үржил шимийн хувьд төдийлөн сайнгүй боловч шим ба эрдэс бордоо хэрэглэх, оновчтой агротехник мөрдөх, усалгаа сайн хийхэд өрхийн хэмжээний ургац авах бүрэн боломжтой. Одоо төмс хүнсний ногоо тариалж байгаа талбайнуудын 70- 80% орчим нь усалгаатай ашиглагдаж байна. Ашиглалтын явцад нийт тариалангийн талбайн 531 га буюу 32.7% нь салхины сул эвдрэлд орсон, 382 га талбай буюу 23.5% нь бага зэрэг хортон шавьжтай, 588 га буюу 36.3% хужир мараатай, 0.05 га буюу 0.03% химийн бохирдолтой болсон байна. Мөн нийт талбай их бага ямар нэг хэмжээгээр хог ургамалтай байв. Иймд дээрх газруудыг тордож сайжруулах, нөхөн сэргээх шаардлагатай байна.

Хүснэгт 10

Нөхөн сэргээлт, тордолт хийсэн болон тордолт хийхээр төлөвлөж буй тариалангийн газрын судалгаа

№	Арга хэмжээ	Газрын байршил	Талбайн хэмжээ, га-аар	Зарцуулсан ба зарцуулах хөрөнгө, мян.төг	Хөрөнгийн эх үүсвэр
1	Ойн зурвас байгуулах		10		Улсын төсөв
2	Эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээх	Бүх суманд	531		Улсын төсөв
3	Хог ургамал, хортонг устгах	Бүх суманд	200		Иргэд аж ахуйн нэгж
4	Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрс боловсруулалт хийх	Бүх суманд	300		Иргэд аж ахуйн нэгж
5	Хужир марааг саармагжуулах	Баянлиг, Баянговь, Шинэжинст	50		
6	Химийн бохидлыг арилгах	Шинэжинст	0.05		
7	Услалтын системийг сэргээн засварлах	Шинэжинст, Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан, Баян-Овоо			Улсын төсөв
8	Атаршсан талбайгаас шууд эргүүлэн ашиглах боломжтой	Жаргалант, Өлзийт, Баянлиг, Баянговь, Шинэ Жинст			-

Баянхонгор аймгийн нутагт 1971 оноос эхлэн услалтын систем эрчимтэй баригдаж улсын хөрөнгөөр 1531 га талбайд 14 инженерийн хийцтэй услалтын

систем баригдсанаас 840 га талбайг энгийн аргаар услаж байв. Инженерийн хийцтэй услалтын системүүд нь 40-200 га, энгийн аргаар услаж байгаа талбайнууд нь усны нөөц тариалангийн талбайн хэмжээнээс хамааран 40-50 га-н жижиг системүүд байсан ба ихэвчлэн төмс, хүнсний ногоо, ногоон тэжээл тариалах зориулалтаар баригдсан байна. Гэвч одоо эдгээрээс дөнгөж 111 га талбайг энгийн аргаар услаж ашиглаж байна. Бусад инженерийн хийцтэй услалтын систем бүгд тоногдон эвдэрчээ.

Бууцагаан сум аймгийнхаа бусад сумдыг бодвол харьцангуй сайн, олон газар багагүй хэмжээний талбайд тариалалт хийж байгаа цорын ганц сум байлаа. Ер нь ногоо тарьж аж амьдралаа дээшлүүлэх гэсэн хүсэлтэй иргэд олширч байгаа нь бидний орон нутагт ажиллахад тод ажиглагдсан. Мөн хуучин услалтын системтэй байсан газруудын услалтын системийг сэлбэж засах эргүүлж ашиглалтанд оруулах явдал нэн тэргүүнд чухал байна. Ийм газрууд олон байсныг дурьдах хэрэгтэй. Газар тариалангийн үйлдвэрлэлээ сэргээхэд орон нутгийн удирдлага идэвхи санаачилга гарган ажиллах хэрэгтэй байна.

Тариалангийн газрын эрх зүйн байдал. Тус аймагт газар өмчлөлийн ажлын хүрээнд газрыг иргэдэд эзэмшүүлэх, ашиглуулах ажил эрчимтэй өрнөж цаашилбал өмчлүүлэх тохироо бүрдсэн гэж үзэж болно. Уг ажил ямар түвшинд байгааг хүснэгт 11-аар харуулав. Хүснэгтээс харахад 831.8 га газрыг иргэд, 97.2 га газрыг аж ахуйн нэгж байгууллага, 48.1 га газрыг төрийн байгууллага эзэмшихээр албан ёсоор авсан байна. Цаашид энэ хэмжээн дээр тариалангийн газрыг өмчилөх хэлбэр ойрын жилүүдэд өсөх нь ойлгомжтой.

Хүснэгт 11

№	Газрын харилцааны хэлбэрүүд	Тоо хэмжээ					
		Иргэн		ААНБ		Төрийн байгууллага	
		Тоо	Га	Тоо	Га	Тоо	га
1	Эзэмшүүлсэн	-	831.8	-	97.2	-	48.1
2	Ашиглуулсан	-	-	-	-	-	-
3	Өмчлүүлсэн	-	-	-	-	-	-
	Бүгд	-	831.8	-	97.2	-	48.1

2.2.3 Хадлангийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал

Баянхонгор аймаг хэдийгээр Хангай говь хосолсон нутагтай боловч аймгийн хэмжээнд газрын тоо бүртгэлээр 10336 га хадлангийн газартай байгаа нь байгалийн хадлангийн эзлэх талбайгаар харьцангуй бага болохыг харуулж байна. Хадлангийн талбайн байршил, эзлэх талбай, зонхилох ургамлын хэв шинж, ургац, шимт чанар, тэжээлийн нөөц, одоогийн ашиглалтын байдал, хойшид авах арга хэмжээ зэргийг зураг болон дэлгэрэнгүй хүснэгтээр үзүүлэв /хүснэгт 12/. Хүснэгтээс харахад хадлангийн талбай нь ихэвчлэн Заг, Жаргалант, Гурванбулаг гэсэн хойд талын хангайн сумдаар төвлөрч байна. Энд бушилз-үетэнт, үетэн-алаг өвст, алаг өвс-үетэнт, жижиг дэгнүүлт үетэн-хялганат, хазаар өвс-үетэнт, дааган сүүл үетэнт, өндөр уулын нугын болон тал хээрийн ургамалжилт 50-55%-ийн ерөнхий бүрхэцтэй зонхилж, жилийн дундаж ургац өндөр 5-6 ц/га байх ба ойт хээрийн хадланг бодвол ургац их биш ч гэсэн шимт чанар сайтай, 100 кг тэжээлд 38-45 тэжээлийн нэгж агуулагдана. Харин хээрийн сумдын хуурай тал хээрт нь хиагт, хиаг-хялганат, жижиг дэгнүүлт үетэн-хялганат, үетэн-алаг өвст төрөл 35-40%-ийн ерөнхий бүрхэцтэй зонхилж, жилийн дундаж ургац өндөр 3-4 ц/га-т хэлбэлзэж нам хотосоор нь дэрс-хиаг-алаг өвст, дэрс-зэгст, зэгс-улалжит, үетэн-улалж-алаг өвст төрлүүд 40-45%-ийн

бүрхэцтэй 4-5ц/га ургацтай байна. Нийт хадлангийн 91.7 % нь Хангайн нурууны бүсэд, 3.9%-нь хуурай хээрийн бүсэд 4.4% нь Говийн бүсэд оршиж байна. Хадлангийн талбайгаас өвс бэлтгэж байгаа одоогийн практик нь талбайг шинжлэх ухааны үндэстэй зөв зохистой ашиглах шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна. Хадлан өвсийг жил бүр тогтмол хугацаанд бэлтгэдэг хадлангийн талбайг хөмрөөж өнжөөх, ургамлын хөгжлийн үе шатуудаар сэлгээтэй хадаж ашиглах, хашиж хамгаалах, цэвэрлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хөхэрэгжүүлэхгүй байгаа учраас хадлангийн талбайн ургац буурах, үр боловсорч гүйцээгүй үед жил бүр давтан хадсанаас үрээрээ сэргэж нөхөгдөн ургаж чадахгүйд хүрч, тэжээлийн ач холбогдол багатай ургамал голлон, хадлангийн талбайгаас хасагдах явдал ч гарсаар байна. Жишээлбэл: Галуут, Баян-Овоо, Өлзийт сумдад 3.0 мян орчим га талбай нь ашиглалтын буруугаас болж өвс бэлтгэхээ байснаар барахгүй талхлагдалд хүрсэн байна. 1990 оноос хойш хадлангийн талбайг хашиж хамгаалах, бордож услах зэрэг ургацыг нь дээшлүүлэхэд чиглэгдсэн тордолтын арга хэмжээг ямар ч суманд авч хэрэгжүүлэхгүй байна. Дээрх хадлангийн талбайгаас жилдээ дундажаар 2500-3000 тонн хадлан авдаг, тухайлбал 2004 онд 3095 тонн, 2005 онд 2574 тонн, 2006 онд 3597,3 тонн хадлан авсан байх жишээтэй. Сүүлийн жилүүдэд жил дараалан ган зуд болсон зэрэг байгалийн үзэгдэл хадлангийн талбайн гарцад нөлөөлснийг үгүйгэхгүй боловч гол нь хүний эерэг үйл ажиллагаа ихээхэн дутагдаж байна. Гарц муудсан шалтгаанаар ихэнхи талбайг хадахаа больж өвөл хаврын бэлчээрт хамгаалалт, сэлгээгүйгээр ашиглах болжээ. Иймд хадлангийн талбайг хаших, хөрс боловсруулалт хийж хөрсийг сийрэгжүүлэх, борог өвсийг цэвэрлэж улмаар олон наст ургамлын үр цацах, бордох, усжуулах зэргээр түүнийг тордон сайжруулах, гар ба морин хадуураар уулын жалга суга, хажуугийн жижиг талбайнуудыг жигд хадах зэргээр ургацыг нэмэгдүүлэх боломжтой. Ер нь байгалийн хүндрэлээс гадна хүний үйл ажиллагаа ашиглалт хамгаалалт, тордолтын асуудал төдийлэн хангалтгүй байна. Жинст, Баацагаан, Бууцагаан, Баянговь сумдын хадланг жил бүр сэлгээгүй нэг цагт хадсанаас ургац буурахын дээр нуурын усны түвшин ихээхэн буурсан байна. Хадлангийн талбайг одоогоор сум орон нутаг эзэмшиж байгаа бөгөөд цаашид иргэд, аж ахуйн нэгжид тодорхой хугацаагаар гэрээгээр эзэмшүүлснээр түүний ашиглалт, хамгаалалт тодорхой хэмжээгээр сайжрах боломжтой.

2.2.4. Бэлчээрийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.

Бэлчээрийн ургамалжилт. нь газар зүйн байрлал, газрын гадаргын тогтоц, байгалийн бүс бүслүүрээс шалтгаалан өөр хоорондоо өвөрмөц ялгаатай байдаг. Тухайлбал нутгийн хойд хэсэг нь Монгол улсын ургамал газар зүйн мужлалаар Евразийн хээрийн муж, Хангайн уулын ойт хээрийн провинцид хамаарч өндөр уул, ойт хээр, хуурай хээрийн ургамалжилт тод ялгарч байхад өмнөд хэсэг нь Умард говийн цөлийн хээрийн провинцид хамаарагдаж. Говь цөлийн ургамалжилт тод ялгардаг. Өөрөөр хэлбэл хангай, хээр, говь цөл хосолсон нутаг бөгөөд байгалийн энэ бүс бүслүүр нь нь нутгийн ургамал бүрхэвчийг тод ялган харуулдаг.

Хангайн нуруунд орших өндөр уулсын орой, хажуу хэсгээр зожир өвс-бушилзат, хаг хөвдөт, улалж-бушилзат, бушилз-үетэнт, бушилз-алаг өвс-улалжит, жижиг үетэн-бушилзат төрлүүд зонхилж арай нам хэсгээр нь ботууль-алаг өвст, жижиг үетэн-хялганат сийрэг ургамалтай уулын хээрийн чулуурхаг хувилбарууд зонхилно. Эндхийн гол горхи бүхий уулсын хоорондох нарийн ам хөндийгээр нугархаг хээрийн жижиг дэгнүүлт үетэн-агь-бушилзат, бушилз-жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, бушилз-улалжит, бушилз-алаг өвст, үетэн-улалж-алаг өвст, ботууль-алаг өвст төрлүүд зонхилон тархана.

Дундаж өндөр болон нам бэсрэг уулын бэлчээр нь хангайн сумдын бүх нутгаар түгээмэл тааралдах ба энд д.т.д. 2300-2500 м-ийн өндөрт болон түүнээс

доош орших уулсын бэлчээр хамрагдана. Уулсын хоорондох болон голын хөндийнүүдээр орших уулын цэвдэгт хар шороон, хар хүрэн нугын хүрэн хөрсийг даган үетэнт-улалж- алаг өвст, ботууль-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хээржсэн нугын бэлчээр зонхилохоос гадна жижиг дэгнүүлт үетэн-агь-алаг өвст, ботууль-агьт талхлагдсан бэлчээрийн эвшил ч элбэг тохиолдоно.

Ноён нуруунаас урагшилахад уулсын өндөр огцом намсаж Баян-овоо, Бөмбөгөр, Хүрээмарал, Бууцагаан, Өлзийт сумдын нутагт нам бэсрэг уулс, толгодорхог гадарга зонхилон тохиолдож ургамлан нөмрөгт говийн хуурайсаг нөлөө тод илэрнэ.. Энд бага зэрэг чулуутай, сийрэг ургамалтай харгана бүхий жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, ботууль-алаг өвст, хялгана-үетэнт, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст харгана-үетэнт төрлүүд зонхилж цөлөрхөг хээрийн бэсрэг уулын бэлчээрт монгол өвс-өрхөгт, монгол өвс-агь- хазаар өвст талхлагдсан бэлчээр, монгол өвс-боролзойт, монгол өвс-таанат төрлүүд элбэг тохиолдоно .

Уулсын бэлчээрээс доошлоод тал хөндий хээрийн бэлчээр залгах бөгөөд энд хуурай хээрт нь хиаг-жижиг дэгнүүлт үетэнт, ботууль-жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-хялганат, хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, хялгана-хиагт, хялгана-харганат, хялгана-харганат, хялгана-хазаар өвст хээрийн төрлүүд тал хээрийн бэлчээрийн хэв шинжийг бүрдүүлнэ. Харин цөлөрхөг хээрийн бэлчээрт монгол өвст хэв шинжүүд түрэн орж ирснээр монгол өвс-хазаар өвст, монгол өвс-харганат, монгол өвс-таанат, монгол өвс-баглуурт болон тэдгээрийн талхлагдсан хувилбарууд зонхилно. Эндээс урагшилах тусам газрын гадарга улам намсаж говийн нөлөө хүчтэй илэрч хээрийн ургамалжилт говь цөлийн ургамалжилтаар солигдон монгол өвс-таанат, монгол өвс-баглуурт, бударганат ,монгол өвс-харганат, монгол өвс-боролзойт, шавагт төрлүүд өргөн хөндийгөөр үргэлжлэн тохиолддог. Говь цөл рүүгээ гүн дотогшилох тусам таана, бударгана, баглуур, тэсэг, шавагт төрлүүд элбэг тохиолдоно .

Урсгал ус сайтай Заг, Байдраг, Түйн гол зэрэг Хангайн томоохон голын хөндийгөөр үетэн-улалж-алаг өвст, жижиг улалж-алаг өвст, дэрс-хиаг-алаг өвст-төрлүүд тархана. Голын хөндийн татмын бэлчээрийг зун-намрын улиралд сэлгээгүй ашигласнаар ихээхэн талхлагдсан байна.

Нууруудын зах ба давсархаг нам хотгор хоолойгоор дэрс-жижиг-улалжит дэрс-бударганат, зэгст, сийрэг загт, шар бударганат бүлгэмдлүүд тархана. Эндэхийн довцог элснүүдээр элсний шарилж, хар суль, заг, чихэр өвс сийрэг ургана. Цөлийн хээрт суль-элсний шарилжит элсний бэлчээр ч тохиолдоно.

Ийнхүү нийт бэлчээрийн 10.4% нь өндөр уулын, 10.6% нь ойт хээрийн, 17.5% нь хээрийн, 40.8% нь цөлөрхөг хээрийн, 16.2% нь цөлийн, 4.5% нь голын хөндийн бэлчээр байна. Судалгаанаас харахад өөрчлөлт орсон төрлүүд нь тал хөндий, нуга, нам хотосоор зонхилон тохиолдохын зэрэгцээ уулын энгэр, хажуу хормой, толгодыг хамарсан байна. Бэлчээрийн төлөв байдлыг авч үзвэл, нийт судалгаанд хамрагдсан газрын 34.5 % буюу 311493 га нь өвслөг ургамалтай, 24.5 % буюу 2210681 га нь сөөгтэй, 38.3% буюу 3449513 га нь чулуутай, 2.7 % буюу 245033 га нь довонтой байна. Чулуутай бэлчээр нь ихэнхидээ уулсын энгэр, хажуу бэл хормой, цөл цөлөрхөг хээрийн уул, тал хөндий, хоолойнуудыг хамарч байгаа бөгөөд чулуу ихтэй байх нь ургацыг бууруулаад зогсохгүй бэлчээрийг сайжруулахад нэмэлт зардал шаарддаг. Сөөгтэй бэлчээр нь хойд талын сумдын уулархаг гадарга, голын нугархаг хөндийгээр явган бургас, тавилгана, боролзгоно, зэргээр илэрч байхад цөлөрхөг хээрт харгана, голлон, тэсэг, шаваг, бударгана зэрэг сөөг, сөөгөнцөрүүд ноёлно. Довонтой бэлчээрийг нам хотосын улалжын болон дэрсний довон бүрдүүлнэ. Ер нь цэвэр бэлчээр элдэв нэмэлт тордоллогогүйгээр шууд ашиглах боломжтой байдаг.

Бэлчээр ашиглалтын одоогийн байдал. 2006 оны газрын тоо бүртгэлийн материалаас үзэхэд аймгийн хэмжээнд *бэлчээрийн газар 9 002 771.7 га* газрыг эзлэх бөгөөд энэ нь нийт нутаг дэвгэрийн 77.8%-ийг, ХАА-н газрын 99.8 % -ийг

эзлэдэг нь улсын дундажаас 2.2 хувиар давж байна. Газар ашиглалтын судалгаагаар аймгийн нийт бэлчээрийн 4.8% буюу 414.0 мян.га нь элдэв шалтгаанаар бүрэн ашиглагдахгүй байгаагаар судлагдсан байна. Үүнээс 141.0 мян.га нь өндөр уулын /цармын / бэлчээр бөгөөд зам харилцаа муутай газар орны бартаа ихтэй, 38.0 мян.га нь алслагдсан учраас ашиглагдахгүй байна. Үлдэх 185.0 мян.га бэлчээр нь усны хангамж муутайгаас шалтгаалж ашиглагдахгүй байна. Тухайлбал: Баянлиг суманд 88.0 мян.га бэлчээр, Баянцагаан суманд 266.0 мян.га бэлчээр, Заг суманд 34.6 мян.га бэлчээр тус тус усжуулагдаагүй учир ашиглагдахгүй байна.

Дээрхи сумдын ашиглагдахгүй байгаа бэлчээр зөвхөн усан хангамжийн байдлаас шалтгаалснаас гадна сум багийн төвөөс хэт хол алслагдсан байдал ч нилээд нөлөөлж байна. Тэрчлэн ашиглагдахгүй байгаа бэлчээр их хэмжээгээр бий болоход бэлчээрийн хангамж илүүдэлтэй байдал бас нөлөөлж ирсэн байна. Ийм байдлаас шалтгаалж Заг, Баянбулаг, Хүрээмарал, Гурванбулаг сумдад бэлчээр бүрэн дүүрэн ашиглагдахгүй байна. Одоогийн байдлаар бэлчээрийг зөвхөн нийтээр эзэмших зарчим баримталдаг. Монголчууд эрт дээр үеэс бэлчээрийг зун намрын, өвөл хаврын гэсэн нарийн хуваарьтайгаар ашиглаж ирсэн уламжлалтай билээ. Гэтэл сүүлийн жилүүдэд энэ хуваарь алдагдаж жилийн дөрвөн улиралд нэг газраа тойрон нүүдэллэх, нүүдлийн тоо цөөрөх, малын тоо толгой нэг дор хэт бөөгнөрөх, нутаг усаа бие биенээсээ өрсөн хэрэглэх, бэлчээрийн усжуулалт хангалтгүй зэргээс шалтгаалан бэлчээр ихээхэн талхлагдаж байна. Үүнд ажиллах хүчин хангалтгүй, унаа, хөсөг байхгүй, малчид өөрсдөө зах зээлд болон нийгмийн үйлчилгээнд ойр байх хүсэлтэй, өвлийн бэлчээрээ сахиж хамгаалах зэрэг олон нийгмийн болоод ахуйн хүчин зүйлүүд нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй юм. Энэ нь төрөөс бэлчээрийг зөв зохистой ашиглах талаар төрийн нэгдсэн бодлого, зохицуулалт байхгүйгээс бэлчээрийн менежментийн бодлого алдагдсаныг харуулж байна.

Тус аймагт зун намрын бэлчээрт нийт бэлчээрийн ойролцоогоор 36.6%-ийг, өвөл хаврын бэлчээрт үлдэх 58.9%-ийг ашигладаг байна. Тус аймгийн нутаг нь байгалийн бүс бүслүүрийн янз бүрийн нөхцөлд байх учир тухайн бүс нутгийн онцлогт тохируулан мал аж ахуйгаа хөтлөхийг эрмэлзэнэ. Өндөр уул, уулын нугархаг хээрт сарлаг хайнаг үхэр сүргийг хариулж, тэмээг ихэвчлэн цөл, цөлөрхөг хээрт, бог малыг дээрх бүс бүслүүрийн аль алинд нь жигд өсгөнө. Үүнд Хангайн өндөр уулын сумдад зуны улиралд аль болох дээр өндөр уулын нуга, хээрийн бэлчээрийг ашиглаж намар доошлон өвөл хаврын улиралд нарийн өвстэй, цас бага тогтдог нам ба бэсрэг уулсын энгэр бэлийн бэлчээрийг ашигладаг. Хээр, цөлөрхөг хээрийн бүсэд зуны улиралд гол горхи, булаг шанд бүхий нам хотосын бэлчээрийг бараадан нутаглах ба намар уулын бэл хормой дэнж даган өгсөж өвөл хавар нам жижиг толгод уулын нөмөр хажуугаар өвөлжинө. Тал хээрийн болон голын хөндийн бэлчээр, намаржаа, хаваржаа, зуслангийн ойролцоо бэлчээр сэлгээгүй ашигласнаас ихээр талхлагдсан байна. Мөн түүнчлэн урд ажиллаж байсан худгууд ихээр эвдэрч тоногдсон нь усаа даган хэт ихээр бөөгнөрч буух улмаар бэлчээр талхлагдалд орох бас нэг хүчин зүйл болжээ. Өвөл хавартаа ихэвчлэн уул нурууд, уулсынхаа өвөр, нөмөр нөөлөг газраар нутаглаж зун намартаа аль болох урсгал ус, гол горхи булаг шандаа даган нутагладаг байна. Тус аймгийн урд талын говийн сумдад газар нутаг хүрэлцээтэй боловч газрын гарц муу, ган зуд болсон, худаг ус хүрэлцээгүй зэргээс бэлчээрийн талхлагдал харьцангуй их байна. Иймээс бэлчээрийн нөөц ихтэй газарт худаг ус гаргаж зохистой ашиглах нь юу юунаас чухал асуудлын нэг болоод байна. Малчдын нийгмийн асуудал тэдэнд ойртсон үйлчилгээг сайжруулах явдал ч бэлчээр ашиглалтанд нөлөөлж байна. Ер нь цаашид дан ганц бэлчээрийн мал аж ахуйг дагнах явдал ахиц муутай бөгөөд аль болох малын тоо толгой чанаржуулах замаар цөөлөх, тооны хойноос хэт хөөцөлдөхгүй байх, өндөр үр ашигтай малыг төрөлжүүлэн өсгөх, бэлчээрийг хаших, тордох, цас

тогтоох, усжуулах, малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Судалгаанаас үзэхэд тус аймагт бэлчээрийн хангамж сайтай буюу 100-с дээш хувийн хангамжтай Гурванбулаг, Хүрээмарал, Баянбулаг, Баацагаан зэрэг сумд байна. Бэлчээрийн хангамж муутай сумдад Баянцагаан, Баян-Өндөр, Богд, Өлзийт, Баян-Овоо сумд орж байна. Ингэж бэлчээрийн хангамж сумдаар харилцан адилгүй байгаа нь нийт бэлчээрийн ашиглалтанд зохимжгүйгээр нөлөөлж аймгийн хэмжээгээр 416.5 мян.га бэлчээрийг талхлагдахад хүргэсэн байна. Талхлагдсан бэлчээрийн ихэнх хувь нь бэлчээрийн хангамж муутай сумдад ноогдож байна. Гэвч бэлчээрийн хангамж сайтай суманд ч бэлчээр ихээр талхлагдсан байна. Тухайлбал: бэлчээрийн хүрэлцээ сайтай Галуут суманд 241.7 мян.га Гурванбулаг 201.0 мян.га, Баянбулаг суманд 152.8 мян.га, Хүрээмарал суманд 263.2 мян.га, Баацагаан суманд 183.5 мян.га бэлчээр тус бүр талхлагдсан байна. Мөн бэлчээрийн хангамж хүрэлцээтэй говийн бүсийн сумдад эдэлбэр газрыг буруу ашигласнаас элсний нүүлт ихсэх хандлагатай байна.

Тус аймгийн хангайн бүсэд нийт бэлчээрийн 28.9% нь байдаг ба энэ бүсийн Эрдэнэцогт, Галуут, Байдраг, Гурванбулаг, Баянбулаг сумдын бэлчээр нь бусад сумдын нутгаас харьцангуй уулархаг, бартаа ихтэй байна. Эдгээр сумдын өндөр уулын бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад газар орны бартааг багасгаж, уул даваануудад зам засах зарим голууд дээр гүүр тавьж, гарц гармуудыг нь сайжруулах асуудал тавигдаж байна. Тухайлбал: энэ бүсийн сумдад бэлчээр ашиглалтыг сайжруулах зорилгоор Бүргэдийн даваа, Сэрвэнгийн даваа, Элбэгийн даваа, Ёлийн даваа, Мөрөнгийн даваа зэргийг засаж замтай болгох, Хар усан гол, Шар усан гол, Өлзийт, Жаргалант, Мандал зэрэг уулын түргэн урсгалтай голууд дээр гүүр тавих шаардлагатай. Ингэснээр эдгээр сумуудад 57.0 орчим мян.га талбай бэлчээрийн ашиглалтыг сайжруулах боломжтой байна. Хэдийгээр энэ бүсийн бэлчээр ургац зун-намрын улиралд дунджаар 3.8 цн/га, өвөл-хаврын улиралд 2.9 цн/га, жилийн дунджаар 3.5 цн/га байгаа ч талхлалтанд орсон хэсэгтээ 30-36% буурч 2.8-3.1 цн/га болтлоо буурсан байна.

Хуурай хээрийн бүсийн сумдад нийт бэлчээрийн 17.1 орчим хувь байна. Энэ бүсийн бэлчээрийн зун-намрын ургац дунджаар 3.1 цн/га, өвөл-хаврынх 2.3 цн/га, жилийн дундаж ургац 2.7 цн/га юм. Хээрийн бүсийн сумдын бэлчээрийн гол онцлог давуу тал нь бүх төрлийн малд тохиромжтой өвс ургамалтайгаас гадна аль ч улиралд бэлчээрийг хэдийд ч ашиглахад боломжтой юм. Энэ байдлаас хамаарч улирлуудын бэлчээрийн хил зааг, хувиарийг нарийн тогтоолгүй, нийтэд нь хавтгайруулж ашиглах явдал нийт сумдад гарч байгаа нийтлэг дутагдал болж байна. Ашиглалт нь замбраагүй байгаагаас аль тааралдсан газраа хашаа барьж, худаг уст цэгийг дуртай газраа гаргуулж, ингэснээрээ улирлын бэлчээрийн хил зааг тогтооход бэрхшээл учруулж, сумдын хоорондын газрын будлиан маргаан үүсэх нөхцөл бий болж байна. Энэ нь улирлуудын бэлчээр хоорондоо давхцан бэлчээр ихээхэн талхлагдах нөгөө талаар барьсан хашаа, гаргасан уст цэг зориулалтаараа ашиглагдахгүйд хүрээд байна. Талхлагдсан сумын бэлчээрийн хэмжээ зөвхөн Өлзийт, Баян-овоо, Бөмбөгөр сумдад 465.4 мян.га–д хүрч байгаа нь дээрх байдлыг баталж байна. Үүний зэрэгцээгээр говь хээрийн сумдад бэлчээрийн усан хангамж муу байгаа нь бэлчээрийн ачааллыг жигд бус болгох талхлагдах, үржил шим нь буурахын үндэс болж байна. Хэдийгээр усны байгууллагуудаас гаргасан тооцоогоор тус аймгийн хээрийн бүсийн сумдын бэлчээрийн усжуулалт 80-90 хувьтай байх бололцоотой ч одоогоор худаг ус эвдэрснээс энэ хэмжээ ихээхэн доогуур байна.

Анх худаг уст цэгийг гаргахдаа тооцоолсон бэлчээр усжуулалтын үзүүлэлт нь ундрага багатай янз бүрийн эвдрэлд орж ашиглагдахгүй шахам болсон явдал ч байна.

Говийн бүсийн 8 суманд аймгийн нийт бэлчээрийн 54.0 хувь орж байна. Энэ бүс нь хэдийгээр уудам их бэлчээртэй ч гэсэн бэлчээрийн зун-намрын ургац дунджаар 1.83 цн/га, өвөл-хаврын ургац 1.2 цн/га, жилийн дундаж ургац 1.53 цн/га байгаа нь

хангай, хээрийн бүсийн бэлчээрийн дундаж ургацаас даруй 2 дахин доогуур байна. Талхлагдсан бэлчээрийн хэмжээ ч говийн бүсийн сумдад / 2.367 мян.га/ нилээд их байна. Бэлчээрийн талхлагдлын шалтгаан нь бэлчээрийн ачаалал сум бүрд жигд биш, усжуулагдаагүй бэлчээрийн талбай харьцангуй их байгаа явдал юм. Тухайлбал: харьцангуй бага эдэлбэр нутагтай Баян-Өндөр, Баянцагаан, Богд сумдад усжуулагдаагүй бэлчээрийн талбай 70.0-202.4 мян.га хүрч байна. Үүнээс шалтгаалж бэлчээрийг жилийн 4 улирлын турш ашиглаж байгаа баг, хэсэг ч цөөнгүй байна. Бэлчээрийн хангамж 67.2 %-тай Баянцагаан суманд 0.6 мян.га бэлчээр талхлагдсан байхад, 146.3 % -н хангамжтай Баанцагаан суманд 103.1 мян.га бэлчээр талхлагдсан байна. Ийм учраас говийн сумдад бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад усан хангамжийг дээшлүүлэх, бэлчээрийн ачааллыг жигдрүүлэх арга хэмжээ авах нь чухал.

Бэлчээр усжуулалтын ажилд 2004 онд 50,0 сая, 2004 онд 40,0 сая (засварт 20,0 сая, шинээр худаг гаргахад 20,0 сая), 2006 онд 130,0 сая төг (засварт 60,0 сая, шинээр худаг гаргахад 70,0) зарцуулсан бөгөөд хөрөнгө оруулалт энэ түвшинд үргэлжилж, үр өгөөжийг хайрлан хамгаалж чадвал төлөвлөлтийн эцэст бэлчээрийн усан хангамжийн талаар асуудалгүй болох юм.

Сүүлийн жилүүдэд улсын төсвийн хөрөнгөөр шинээр гаргасан болон сэргээн засварласан худгууд

Баян-Өндөр

Он		Газрын нэр	Хөрөнгө
2004		Бор үзүүр	6 250 000
2005	Засвар	Хөтөл хөв	2 938 045
2005	Шинэ	Гурван шовхын үзүүр	10 142 616
2006	Шинэ	Шар хуруу	8 000 000
2006	Засвар	Бор толгой	2 721 716

Баян-Овоо

Он		Газрын нэр	Хөрөнгө
2004		Сумын төв	6 250 000
2005	Засвар	Талын толгой	2 976 507
2006	Шинэ	Алтны газар	8 500 000
2006	Засвар	Дээлт	2 839 943
2006	Засвар	Хөх эрэг	2 862 267

Өлзийт

Он		Газрын нэр	Хөрөнгө
2004		Байн хөндий	6 250 000
2005	Засвар	Эрдэний гэзэг	3 074 889
2005	Шинэ	Улаан дэл	4 852 357
2006	Засвар	Эрдэний гэзэг	2 886 540
2006	Засвар	Балжийн Ёндон	2 866 540
2006	засвар	Цагаан чулуут	2 995 774

Хүрээмарал

Он		Газрын нэр	Хөрөнгө
2004		Үзүүр хүүш	6 250 000
2005	засвар	Дэлгэр мөрөн	1 659 604
2005	Засвар	Талын овоот	2 562 866
2006	Засвар	Хөнөг	2 957 380

Баянлиг

Он		Газрын нэр	Хөрөнгө
2004		Хоолой худаг	6 250 000
2006	шинэ	Хар дов	8 500 000
2006	Засвар	Хатан суудал	3 950 177

Жаргалант

Он		Газрын нэр	Хөрөнгө
2005	засвар	Хөшгийн өвөр	3 267 630
2006	Засвар	Нарийн хамар	4 294 921
2006	Засвар	Баянхөндий	3 086 222

Баянхонгор

Он		Газрын нэр	Хөрөнгө
2005	Засвар	Хуурай Жаргалант	1 615 049
2006	Шинэ	Хар чулуут	5 500 000
2006	шинэ	Хаяа худаг	9 300 000

Эрдэнэцогт

Он		Газрын нэр	Хөрөнгө
2005	засвар	Цагаан дэнж	1 900 014
2005	Шинэ	Төлөг таваг	4 991 141

Бууцагаан

Он		Газрын нэр	Хөрөнгө
2006	2006	Хөтөл ус	9 000 000
2006	2006	Цүлэнгийн адаг	3 147 445

Баянцагаан

Он		Газрын нэр	Хөрөнгө
2004		Унтаагийн цахир	6 250 000
2006	засвар	Хүнгэнэхийн ам	3 274 842

Баацагаан

Он		Газрын нэр	Хөрөнгө
2006	засвар	Могой	2 892 810
2006	Засвар	Хар чулуут	3 063 619

Баянбулаг

Он		Газрын нэр	Хөрөнгө
2004		Зулын гурван толгой	6 250 000
2006	засвар	Өвдөгийн худаг	3 427 198

Баянговь

Он		Газрын нэр	Хөрөнгө
2006	засвар	Бор үзүүр	3 564 782

Заг

Он		Газрын нэр	Хөрөнгө
2004		Шинэ ус	6 250 000

Гурванбулаг

Он		Газрын нэр	Хөрөнгө
2006	шинэ	Морин мөрт	9 000 000

Жинст

Он		Газрын нэр	Хөрөнгө
2006	засвар	Шаазгайн тээг	3 269 508

Шинэжинст

Он		Газрын нэр	Хөрөнгө
2006	засвар	Замын хөх	3 452 894

Богд

Он		Газрын нэр	Хөрөнгө
2006	засвар	Бэгэлцэг	2 671 667

Хүснэгт 13

Бэлчээрээс бусад ангилалд шилжих газар, хэмжээ

№	Бусад ангилалд шилжих бэлчээрийн хэмжээ га-гаар					
	Газар тариалан, га-аар	Хадланд	Уурхайн газар	Амралт рашаан сувилал	Мод үржүүлгийн газар	Ногоон хэрэм
	31406	39833	14620	48	154	14078

Бусад ангиллаас бэлчээрт ашиглагдаж буй газар, хэмжээ

№	Газрын сангийн ангилал	Талбай га-гаар	Цаашдын ашиглалтын төлөв
1	Атаршсан газар	844	Цаашид олон настын үр цацаж бэлчээрт шилжүүлэх
2	Заган ой	125 000	бэлчээрт ашиглагддаг
3			

Бэлчээрийн газрын доройтол. Бэлчээрийн доройтолд бэлчээрийн даац хэтэрсэн, бэлчээрийг сэлгээгүй байнга ашигласнаас үүдэн гарах талхлагдал онцгой байр суурийг эзэлнэ. Аймгийн хэмжээнд нийт 4164672 га буюу нийт бэлчээрийн 46.7 % нь талхлагдаж төлөв байдал нь өөрчлөгджээ. Талхлагдсан бэлчээрийг талхлагдлын зэрэглэлээр авч үзвэл нийт талхлагдсан бэлчээрийн 1943250 га буюу 21.8 % нь дунд зэрэг, 2221422 га буюу 25.0 % нь их талхлагдсан байгаагаас харахад их талхлагдсан бэлчээрийн эзлэх хувь өндөр байгаа нь харагдаж байна. Бэлчээрийн талхлагдлаас гадна ашиглалтын явцад орчны нөлөөллөөр 7252 га нь техногенийн, 56491 га нь автогенийн, 32597 га гуу жалгатай, 40190 га нь хортон мэрэгчидтэй, 20263 га элсний нүүлттэй, 4817га ахуйн бохирдолтой байна. Өөрөөр хэлбэл нийт бэлчээрийн 46.7 % нь талхлагдаж, 1.8 % нь бусад нөлөөлөлд автжээ. \зураг, хүснэгт 14\.

Тус аймгийн бэлчээрийн ургамал хүн, мал, амьтны нөлөөгөөр ихээхэн өөрчлөгдөж тачир намхан ургамалтай, сийрэгхэн тусгагийн бүрхэцтэй, ургац багатай буюу эсвэл мал иддэггүй ургамал зонхилсон шарилжит, агьт, улалжит, дэрст, цахилдагт бэлчээр ихээр тархах болсон байна. Ялангуяа их талхдагдсан бэлчээрт үет болон алаг өвс бараг үгүй болжээ. Бэлчээрийн талхлагдлаас болж хөрсний элэгдэл, эвдрэл ихсэх, түүний ус, чийгийн горим алдагдаж улмаар хангамж нь багасах, үржил шим буурах, мал идэш тэжээлээр дутагдах, ургамалан бүрхэвч доройтох, мод, сөөг хатах, хээржих болон цөлжих үйл явц ихсэх зэрэг сөрөг үр дагавар ихээхэн гарч улмаар биологийн баялагийн нэг болох ургамлан нөмрөгийн нөөц хомсдох угтвар нөхцөлийг бүрдүүлж байна.

Бэлчээр ашиглалт, нүүдэл суудлын тоо, хүрээ нь уст цэгийн байршилаар тодорхойлогддог онцлогтой. Нэг талаар уст цэг нь малын орон зайн тархалт, цаг хугацааны байршлыг тодорхойлогч нь болдог. Иймээс уст цэгээ бараадан нутагласнаас хамгийн их өөрчлөлтөнд орсон бэлчээрийн газар нутаг нь тал хээр, голуудын хөндийн нуга, нам хотос, марзлаг давсархаг газрууд юм. Бэлчээрийн газрыг доройтуулагч нэг хүчин зүйл бол хортон мэрэгч, үлийн цагаан оготны тархалт байдаг. 2006 оны байдлаар ихэнхи сумдын нутагт үлийн цагаан огтоно тархсанаар 40190 га талбай сүйтгэгдэж бараг ургамлан бүрхэвчгүй улаан халцгай болжээ. Үүний зэрэгцээгээр тус аймгийн нутгаар баруун чиглэлийн аймгуудын автомашины зам дайран өнгөрдөг тул олон салаа зам /Бөмбөгөр, Баян-Овоо, Өлзийт\ гарч бэлчээрийн ургамлын төрх өөрчлөгдөж зарим нэг газраар \Богд, Жинст, Баян-Өндөр, Баянлиг, Баянговь сумдуудад \ элсний нүүлт явагдаж байгаа нь ажиглагдлаа. Усны эвдрэлд орж гуу жалга үүссэн бэлчээрийн газар бүх сумдуудад мэр сэр байгаа боловч хамрах хүрээ талбайн хувьд харьцангуй бага байлаа. Усны эвдрэлд орж хамгийн их гуу жалга үүссэн газар Хүрээмарал, Бууцагаан, Баянбулаг, Заг сумын бэлчээрт тэмдэглэгдсэн. Бохирдолтын хувьд бохирдсон бэлчээр мөн нийт сумдад багахан газрыг эзэлж байсан бөгөөд ихэвчлэн ахуйн бохирдолтын хэлбэрээр илэрч ганц нэг сумдын мал угаалгын цэг байрласан газарт химийн бохирдолтын хэлбэрээр илрэв. Мөн сүүлийн үед иргэд болон аж ахуйн нэгж байгууллагууд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй алт ухах явдал ихсэж бэлчээрийн газрыг ихээр онгичин сүйтгэж байна. Аймгийн хэмжээнд 7252 га бэлчээрийн газар техногенийн нөлөөлөлтэй байгаа бөгөөд үүний 6088 га газар нь Бөмбөгөр, Галуут сумын алт олборлодог аж ахуйн нэгжүүдийн үйл үйл ажиллагаатай холбоотойгоор илэрсэн. Нийт бэлчээрийн 2.1 % нь бэлчээрт тохиромжгүй газар байхаас гадна одоо ашиглаж байгаа бэлчээрийн 4.8% нь гуу жалга ихтэй зам харгуй бартаатай, алс хол оршдог, усан хангамж муу зэрэг шалтгаанаас ашиглалт багатай байдаг байна.

Хүснэгт 15

Нөхөн сэргээлт, тордон сайжруулалт хийх газар, хэмжээ /га-гаар/

№	Газрын доройтлын хэлбэрүүд	Байршил /Газар, усны нэр/	Хэмжээ, га-аар	Тайлбар
1	Талхлагдсан бэлчээр-бүгд	Нийт сум	4164672	
2	Үүнээс: Их		2221422	
3	Дунд зэрэг		1943250	
4	Элсжсэн	Говийн сумд	20263	Элсэн хунгар тогтсон
5	Зам харгуй гарсан	Бөмбөгөр, Баян-Овоо, Өлзийт	56491	Олон салаа зам гарсан
6	Хортон мэрэгчид тархсан	Бууцагаан, Өлзийт, Баянбулаг, Гурванбулаг	34852	
7	Үйлдвэр уурхайн үйл ажилагаагаар ухагдаж төнхөгдсөн	Галуут, Бөмбөгөр, Шинэжинст, Баянговь	7252	Алт болон бусад
8	Усны эвдрэлд орж гуу жалга үүссэн	Бууцагаан, хүрээмарал	32597	Гүнзгий гуу жалга

9	Бохирдлууд	Бүх сумд	4817	Малын сэг, өвөлжөө хаваржааны туурь, хогийн цэг г.м
	Бүгд		4320944	

Бэлчээрийн даац. Тус аймагт 2006 оны сүүлийн хагаст хонин толгойд шилжүүлснээр 2 390.5 мян. мал тоологджээ /хүснэгт 16/. Малын тоо толгой өсөх нь нэг талаар сайн боловч нөгөө талаар бэлчээрийн даац хэтэрч талхлагдалд их хэмжээгээр орох, ургамалан бүрхэвчийн бүтэц ихээр өөрчлөгдөх, цөлжих явц бий болоод зогсохгүй, ган, зуд болсон тохиолдолд мал олноор хорогдох аюултай байна. Бэлчээрийг зохистой ашиглах, түүний бүтээмжийг дээшлүүлэх нэг гол арга нь малын тоог бэлчээрийн даацад тохируулах явдал мөн. Бэлчээрийн даац гэдэг нь бэлчээрийн нэг га талбайд ноогдох хонин толгой буюу 1 хонин толгойд ноогдох бэлчээрийн талбайг хэлнэ. Бэлчээрийн даацыг тодорхойлохдоо Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 152-р тогтоолыг баримтлан адуу, үхрийг 6.0, тэмээг 5.0, ямааг 0.9, хонийг 1.0 гэсэн коэффициентээр тооцон хонин толгойд шилжүүлэв. Мөн тэжээлийн нөөцийн тооцоог гаргахдаа хээрийн бүсэд 1 хонин толгой жилдээ 5.7 цн, говийн бүсэд 4.7 цн өвс тэжээл хэрэглэдэг гэж тооцон сум бүрээр бэлчээрийн даацыг гаргалаа /хүснэгт 17/. Судалгаанаас үзэхэд 2006 оны байдлаар аймгийн бэлчээрийн хангамж дундажаар 65.7 % байгаа боловч сум тус бүрт харилцан адилгүй хамгийн их ачаалалтай сум Баянхонгор, Галуутад 139.2% байхад хамгийн бага Шинэжинст, Жинст суманд 60.2% байна. Сум тус бүрийн бэлчээрийн тэжээлийн хангамжийн хувь харилцан адилгүй байгаа нь тухайн сумын бэлчээрийн даац, малын тоо, хоорондоо зохицоогүйгээс шалтгаалж байна.

2000 онтой харьцуулахад нийт сумдад бэлчээрийн ачаалал харьцангуй буурсан байна. Энэ нь тухайн үеийнхээс малын тоо толгой хорогдсонтой холбоотой. Бидний тооцоогоор тус аймагт 3 637.2 мян. хонин толгой байх чадавхитай бөгөөд одоо байгаа мал нь 2. 390.5 мян. хонин толгой мал байгаагаас үзэхэд аль ч суманд бэлчээрийн даац хэтрээгүй хүрэлцээтэй байна. Гагцхүү түүнийг зөв зохистой үр өгөөжийг доройтуулахгүй ашиглах явдал чухал байна.

2.2.5 ХАА-н барилга байгууламжийн газар

Баянхонгор аймгийн хэмжээгээр ХАА-н барилга байгууламжийн газар нийт 1911 га талбай эзлэж байгаагийн дотор өвөлжөө, хаваржааны бууц газар, бэлчээр дэх уст цэг, мал угаах цэг, бусад мал эмнэлэгийн үйлчилгээ зэрэг МАА-н үйлдвэрлэлийн зориулалттай газар 1750.9 га /үүний 1391.2 га нь өвөлжөө хаваржааны дэвсгэр газар/, ХАА-н үйлдвэрлэлийн зориулалттай бусад газар 160,1 га байгаа нь ХАА-н газрын 0,002% болж байна. Өвөлжөө хөвөржааны доорхи газарт хашаа саравч, гэрийн буурь, өвс тэжээлийн хашаа, морины уяа, бие засах болон үнс хог хаядаг газар зэргийг оролцуулан, бэлчээр дэх уст цэгийн хамгаалалтын бүсийг ч 50 м-ийн радиусаар тооцов. Энд газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалттай газар байхгүй.

2.2.6 ХАА-д ашиглах боломжгүй газар

Байц хад, асга, элсэн манхан, өвс ургамалгүй гуу жалга, сайр зэрэг ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар аймгийн хэмжээнд 20.1 га байгаа нь нийт ХАА-н газрын 0,0002% болж байна.

Дүгнэлт

Нийт газрын сангийн 77,7 хувийг ХАА-н газар эзлэж байгаа нь бүс нутгийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд нийцэж буй билээ. Өөрөөр хэлбэл хүн амын өсөн

нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг өөрийн нутаг орныхоо ХАА-н үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангахад газар нутгийн хувьд хүрэлцээтэй байгаа бөгөөд гагцхүү түүнийг хэрхэн яаж зөв зохистой ашиглах бэ гэдэг асуудал өнөөдрийн бидний шийдэх асуудал болж байна. Одоогийн ХАА-н үйлдвэрлэлийн хөгжилийн чиглэлийг салбар тус бүрээр дурьдвал,

ХАА-н салбарт тэргүүлэх байр суурийг хувийн хэвшлийн мал аж ахуй түүний дотор 59 %-ийг ямаан сүрэг эзлэнэ. Иймд бэлчээр ашиглалтыг сайжруулах явдал нэн тэргүүний шийдвэрлэх асуудал байх бөгөөд үүнд бэлчээрийг шинжлэх ухааны үндэслэлтэй, малын төрөл, тоо толгойд зохицуулан сэлгэн ашиглах, бэлчээр усжуулах, малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зэрэг олон асуудлуудыг шийдэх хэрэгтэй. Аймгийн хэмжээнд нийт 2 456 284 га талбай бэлчээрт ашиглагддагаас нийт бэлчээрийн 30 % нь талхлагдаж 3.8% нь төлөв байдлын хувьд өөрчлөгдөхийн зэрэгцээ бэлчээрийн даац ихэнхи сумдад 1.0-2.8 дахин хэтэрсэн байна. Одоогийн мөрдаж байгаа газрыг нийтээр ашигладаг уламжлалт бэлчээрийн мал ахуйг хөгжүүлэх чиглэлийг хойшид дэмжих боловч түүнийг эрчимжүүлэх үүний тулд малын үүлдэр угсааг сайжруулах, өндөр ашиг шимт малыг өсгөх, бэлчээр ашиглалтыг сайжруулах, малын тэжээлийн бат бэх үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийг барих шаардлагатай.

Баянхонгор аймгийн хэмжээнд га хадлангийн газартай бөгөөд эдгээр нь бараг бүх сумдад байрлах ба жилдээ 3597,3 тонн хадлан авдаг. Хадлангийн талбайн ашиглалт тордолтыг сайжруулснаар энэ хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх боломж бий.

Газар тариалангийн үйлдвэрлэл газар зүйн нөхцөл байдлаас шалтгаалан тэргүүлэх чиглэлээр хөгжиж чадахгүй боловч орон нутгийн нөөц бололцоо, хуучин услалтын системийг ашиглан усалгаатай тариаланг дэмжих замаар өрхийн хэрэгцээний газар тариалан цаашилбал тэжээл үйлдвэрлэх чиглэлээр газар тариаланг хөгжүүлэх боломжтой.

2.3. Хот, тосгон бусад суурины ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал.

2.3.1. Хот, тосгон бусад суурины ангиллын газрын бүтэц.

Хот тосгон бусад суурингийн газар нь нийт 17497.1га газартайгаас барилгажсан талбай 422.7 га, гэр хороолол 507.16 га, нийтийн эдэлбэр 6821.4 га, үйлдвэрийн газар 23.8 га, уурхайн газар 9722 га байна. 2006 оны эцэс гэхэд барилгажсан талбай 20.3 га-р, гэр хороолол 35.6 га талбайгаар нэмэгдсэнээс нийтийн эдэлбэрийн газраас 55.9 га талбай хасагджээ. Энд Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийн дагуу иргэдэд шинээр 20 га газар олгосон байна. Мөн түүнчлэн үйлдвэрийн газар 6.0 га талбайгаар, уурхайн газар 551.6 га-р нэмэгдсэн учир энэ хэмжээгээр хот суурингийн газар нэмэгдэж харин бэлчээрээс хасагдсан байна. Хот суурингийн газарт Баянхонгор хот бусад 19 сумын болон Дөвөнтийн уурхайн төвийн эзлэж байгаа талбай болох 15309,5 га газар буюу аймгийн нийт нутгийн 0.001 %-нь хамрагдаж байна. Хот суурингийн газрын хэмжээг аймгийн нийт хүн амын тоонд харьцуулж үзвэл нэг хүнд 0.21 га газар ноогдож байгаа бөгөөд 2015 онд энэ үзүүлэлт хүн амын өсөлтийн улмаас 0.17 га болж буурах магадлалтай.

Хот суурин газруудын **хот байгуулалтын үнэлгээгээр** Баянхонгор аймгийн төв суурин газрууд нь дараахи үнэлгээтэй байна /хүснэгт 18/. Эндээс харахад усан хангамжаар Баянбулаг, Баян-Өндөр, Богд сум дунд зэрэг, Гурванбулаг хангалтгүй, бусад нь сайн, цэвдэг хөрс Жаргалант суманд алаг цоог, Баянбулаг, Гурванбулаг, Заг, Галуут суманд үргэлжийн цэвдэг хөрстэй байна. Газар чичирхийллийн баллаар Баян-Өндөр, Баянцагаан, Баянлиг, Баянговь, Заг, Жаргалант сум 9 балл, бусад нь 7-8 балл, ул хөрс Хүрээмарал, Эрдэнэцогт

суманд хүчтэй овоолттой Баацагаан, Бууцагаан, Баян-овоо суманд бага зэрэг овоолттой, Баянбулаг, Заг суманд суулттай, норматив ачаалал ихэнхи суманд 2.0-5.0 кг/см –ийн хооронд хэлбэлзэх ба хөрсний ус ихэнхи суманд 0.5-3.0 м-ийн хооронд хэлбэлзэж Баацагаан, Жинст суманд 5.0-7.8 м-ийн хооронд байна. Мөн Баян-Овоо, Өлзийт суманд уруйн үер орж ирдэг ба газрын гадаргын налуу ихэнхи суманд 1.5-2.5% байх ба Шаргалжуут, Гурванбулаг, Жаргалант суманд арай өндөр 5% байна. Ийнхүү Богд, Баацагаан, Загаас бусад сум барилгын уур амьсгалын II бүсэд багтана. Ер нь усан хангамж усны түвшин >3 байхад нэн тохиромжтой түүнээс доош бол тохиромжгүй, ул хөрс <3 бол нэн тохиромжтой, өндөржилтийн хувьд д.т.д 1500 м хүртэл тохиромжтой, газар чичирхийлэлийн хүч 6 хүртэл балл байхад барилгын төсөвт өртөг тусгайлан нэмэгддэггүй, нэлэнхүйдээ мөнх цэвдэгтэй хөрс барилгын өртгийг 40 %, хөрсний овойлт 50-20 % тус тус нэмдэг байна. Эндээс харахад байгаль экологийн хувьд суурин байгуулах боломжтой гэж үзэж болно.

2.3.2. Хот, тосгон бусад суурины тэг гортигийн доторхи газрын ашиглалт, хамгаалалтын байдал.

Тус аймгийн хэмжээнд 20 суманд аймгийн төв 1, сумын төв 19 байхаас гадна Шаргалжуут тосгон, Дөвөнтийн уурхай зэрэг суурьшил бүхий томоохон баг, бригадын төвүүд оршдог. Эдгээр төвүүдийн суурьшилийн бүс нь нийтдээ 2060.7 га газрыг эзлэх бөгөөд үүний цэвэр барилгажсан хэсэг 882.4 га гэр хороолол 1178.3 га байна /хүснэгт 19,20/. Тэгвэл аймгийн хэмжээгээр 1 хүнд 0.025 га суурьшсан бүс 0.010 га барилгажсан хэсэг, 0.014 га гэр хорооллын газар ноогдож байна. Эндээс харахад ихэнхи сумдад гэр хорооллын эзлэх талбай давамгайлж байгаа бөгөөд цаашид ч нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь улс орон зах зээлийн эдийн засагт шилжсэнээр улсын чанартай хөрөнгө оруулалттай томоохон хэмжээний барилга байгууламж баригдах асуудал хязгаарлагдсан учир барилгажсан газрын бүтэцийг зөвхөн Засаг захиргааны болон сургууль, цэцэрлэг, эмнэлэг, банк гэсэн төрийн захиргааны зайлшгүй шаардлагатай барилга байгууламжууд бүрдүүлж байгаатай холбоотой юм. Нийтийн үйлчилгээний салбарт хувийн хэвшлийнхний барьсан дэлгүүр, ТҮЦ, гуанз, зочид буудал зэрэг жижиг хэмжээний барилгууд зонхилох бөгөөд эдгээр нь хэмжээний хувьд бага, зарим нь хуучин барилгуудыг хувьчилж авсан байх жишээтэй. Ер нь барилгажсан хэсэгт ялангуяа сумын төвүүдэд хотын функциональ бүсүүдийн ялгаа, хил зааг бараг ажиглагдахгүй нэг нь нөгөөгөө орлох маягаар явдаг байна. Харин гэр хорооллын хувьд тодорхой зааг гарч ирэх боловч энд хүн амд зайлшгүй шаардлагатай эмнэлэг, сургууль, цэцэрлэг, худалдаа үйлчилгээ, цаашилбал, усан хангамж, хогийн цэг зэрэг асуудлууд төдийлэн хангалтгүй шийдэгдсэн байна. Хотын суурьшилын бүс дотор спорт, амралт цэнгээний бүс тодорхой бүс болж хөгжиж чадаагүй наадмын талбай, морь уралдуулах, барих газар зэргээр хязгаарлагдах бөгөөд зөвхөн зайлшгүй хэрэгцээт төрийн болон үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах барилга байгууламж, хүн амын амьдрах байр орон сууцны бүс түлхүү хөгжсөн байна. Хот суурин газарт эзлэх ногоон байгууламж 2.8 га талбайг эзлэж байгаа нь нийт суурьшилийн бүсийн дөнгөж 0.13 %-ийг эзлэж байна. Үйлдвэрийн бүс, жимс, жимсгэнэ, ногооны газар, өрхийн мал аж ахуйн бүс Баянхонгор хотоос бусад суманд бараг хөгжөөгүй ялгарч гардаггүй гэж хэлж болно. Энэ нь томоохон хотын хэмжээнд хүртэл хөгжиж чадахгүй байгаагийн нэг илрэл юм. Нэгэнт функциональ бүсүүдийн хил, зааг ялгаа тодорхой гарч ирэхгүй байгаа учир газар ашиглалт, хамгаалалтын ажил ямар нэг хэмжээгээр зөрчигдөж байгаа нь тодорхой. Гэвч сүүлийн жилүүдэд засаг төрөөс Газрын талаар явуулах бодлогыг боловсронгуй болгосноор газар түүний ашиглалт, хамгаалалт жил ирэх тусам сайжирч байна. Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд суурин газруудыг тохижуулах хатуу хучилттай явган хүний болон

зам тавих, цэцэрлэгжүүлэх, амралт зугаалга, спорт тоглоомын газрууд барих зэрэг арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байдаг боловч үүнийг хэрэгжүүлсэн газар байдаггүй тул нийтийн эзэмшил газрууд нь авто машин болон хүмүүсийн нөлд талхлагдан физик элэгдэлд орж байна. Ихэнх суурингуудад хөрсний өнгөн хэсэг тоосорхог болж бүтцээ алдсан, жижиг үйрмэг чулуу ил гарсан, ургамалан бүрхэвчийн зулгаралт үүссэн, унаган ургамал нь багасч лууль шарилж зэрэг хөл газрын ургамал ургасан байна.

Газрыг эзэмших, ашиглах, өмчлөх хууль, эрх зүйн асуудал. Тус аймагт газрын харилцааны тэр дундаа эзэмших, ашиглах, өмчлөх асуудал хуулиар зохицуулагдаж явагддаг бөгөөд үүнд гол төлөв эзэмшилийн хэлбэр давамгайлна /хүснэгт 21/. Одоогоор тус аймгийн хэмжээнд нийт 1000-д иргэн, аж ауйн нэгж байгууллагын газрын эзэмших, ашиглах, өмчлөх эрх баталгаажсанаас гэр бүлийн хэрэгцээнд 532.2 га газрыг, аж ахуйн хэрэгцээнд 9862.9 га газрыг, төрийн байгууллагад 137.9 га газрыг тус тус нь эзэмшиж, өмчилөхөөр олгоод байна. Одоогоор ашиглуулсан газар байхгүй. Цаашид өмчлөлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Хүснэгт 21

Хот суурингийн газрын харилцааны өнөөгийн байдал

№	Газрын харилцааны хэлбэрүүд	Тоо хэмжээ,га		
		Иргэн	ААНБ	Төрийн байгууллага
1	Эзэмшүүлсэн	226.4	9862.9	137.9
2	Ашиглуулсан	-	-	-
3	Өмчлүүлсэн	305.8	-	-
	Бүгд	532.2	9862.9	137.9

Хот суурин газрын доройтол. Хот суурин газруудад байгалийн болон хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр газар ашиглах явцад гарсан доройтолуудыг хүснэгтээр харуулав /хүснэгт 22/. Хүснэгтээс харахад нийт суурьшилын бүсийн 520.4 га буюу 25.3 % нь ямар нэг хэмжээгээр доройтолд орсон байна. Энэ нь хэдийгээр бага биш тоо бөгөөд төрөл зүйлийн хувьд ч олон байна. Эдгээр нь хот суурин газрын ил задгай хаясан хатуу хог хаягдал, нурсан барилгын туурь хог, гэр хорооллын жорлон муу усны бохир, шатахуун түгээх станцын ойр орчмын шатах тослох материалын хөрсөн дэх нэвчилт /химийн бохирдол/ зэрэг хүний хүчин зүйлсийн нөлөөллөөр үүссэн доройтлоор илэрч байгаа бол байгалийн хүчин зүйлд үерийн усны нөлөөгөөр үүсч бий болсон гуу жалга, хээрийн сумдын элсний нүүлт зонхилох байрыг эзлэж байна. Иймд хот суурин газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах, үерийн усны амыг хаах, гуу жалгыг дарах, элсний нүүлтийг ойн зурвас байгуулж зогсоох, хот суурингийн газарт эзлэх ногоон байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. ШТС-д газар олгохдоо хүн ам суурьшсан бүсээс зайдуу байлгах, хөрсөнд шатах тослох материал алдагдах боломжийг багасгах шаардлагатай.

Хүснэгт 22

Хотын газрын доройтлын байдал

№	Газрын доройтлын хэлбэрүүд	Байршил /Газар, усны нэр/	Хэмжээ, м ²	тайлбар
1	Хөрсний гүний ба өнгөн бохирдол	Нийт суманд	30865	үүнээс 24544 м ² биологий н, 4753

				м ² ахуйн хог, 1568 м ² химийн
2	Уруйд идэгдсэн	Баянлиг, Баянцагаан, Өлзийт, Баянхонгор, Гурванбулаг, Хүрээмарал, Шинэжинст	33904	Уруйд идэгдэж гуу жалга гарсан
3	Өнгөн бүрхэвч нь зулгарсан	Бүх суманд эзэмшил дотор	5113858	1-3 см зулгарсан
4	Элсжсэн	Богд, Баянхонгор, Бууцагаан, Жинст	25041	Элсний нүүлт
5	Ухсан нүх, овоолго шороо	Баян-өндөр	151	
	Бүгд		5203819	

Хот суурин газрын нөхөн сэргээлт, тордолт. Иймд хот суурин газрыг тодорхой зураг төслийн дагуу тохижуулах, доройтлоос зайлсхийх, түүний нөлөөллийг багасгахын тулд нэгэнт доройтсон газрыг нөхөн сэргээх явдал зүй ёсоор шаардагдана. Бидний судалгаагаар элсний нүүлтэнд өртсөн Богд, Баянхонгор, Бууцагаан, Жинст сумдад ойн зурвас байгуулах шаардлагатай байгаа бөгөөд 1 га ойн зурвас байгуулахад 3.500 мян.төг зарцуулагдана гэж үзвэл наад тал нь 20 га талбайд зурвас байгуулахад 70 000 мян.төг шаардлагатай байх жишээтэй. Дор дурьдсан ажлуудыг хийж гүйцэтгэхэд орон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилга чухал байна.

Хүснэгт 23

Нөхөн сэргээлт, тордолт хийх газрын судалгаа

№	Арга хэмжээ	Газрын байршил	Талбайн хэмжээ, га-аар	Зарцуулах хөрөнгө* мян.төг	Хөрөнгийн эх үүсвэр
1	Ойн зурвас байгуулах	Богд, Баянхонгор, Бууцагаан, Жинст	20га	70 000.	Сумын төсөв, гадны төсөл
2	Эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээх	Баян-Өндөр	0.2га	50.0	Тухайн аж ахуйн нэгжээс
3	Зүлэгжүүлэх, цэцэрлэгжүүлэх	Нийт сум	20	600.0	Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд
4	үерийн ам, гуу жалгыг дарах	Нийт сум	3.5га	400.0	Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд
5	Ахуйн хатуу хог хаягдлыг цэвэрлэх, хогийн цэг, жорлон муу усны цооногийг стандартын дагуу хийх	Нийт сум	5 га	600.0	Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд
6	ШТС орчмын	Нийт сум	0.5га	300.0	Аж ахуйн

	бохирдлыг арилгах				нэгж
	Бүгд			71 950.0	

2.3.3. Амралт, рашаан сувиллын газрын ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал.

Аймгийн хэмжээнд Шаргалжуутын улсын чанартай 1, Үхэг, Халиутын рашааны дэргэд орон нутгийн чанартай 2 амралт, рашаан сувилал, жуулчны баазын зориулалтаар 5 аж ахуйн нэгж нийт 22 га газар ашиглаж байгаа нь хот тосгон бусад суурингийн ангилалын газрын дөнгөж 1%-ийг эзлэж байна. Эдгээр газруудын хил зааг тодорхой бус, зориулалт чиглэлийнхээ дагуу тохижуулаагүй байгаа явдалд дүгнэлт хийж, хил заагийг нь тэмдэгжүүлэн удирдлагад нь албан ёсоор хүлээлгэн өгөх шаардлагатай. Иргэд байнга очдог рашаануудыг тодорхой хариуцсан эзэнтэй болгож, сувилуулагчдын хэрэгцээнд нийцүүлэн тохижуулах бодит хэрэгцээ байна.

Одоогийн байдлаар аялал жуулчлал, амралт сувилалын 3 гол бүс нутаг 1 дэд бүс нутаг байдаг бөгөөд хойшид дээрх бүс нутгийн үйл ажиллагааг сайжруулах, бусад үзэсгэлэнт болон түүх дурсгалын газруудад энэ салбарыг өргөжүүлэх боломж бий.

Эдгээр бүс нутгуудад байрлах аялал жуулчлал, амралт сувилалын болон түүх дурсгалын нөөц, нөхцлийн талаар сийрүүлбэл

1. Баянхонгор хот, Шаргалжуут орчмын бүс

Аймгийн төв Баянхонгор хот Номгон уулын ард, Түйн голын хөвөөнд Далайн түвшнээс дээш 1859 м өндөрт, Улаанбаатар хотоос 630 км зайд оршдог. Баянхонгор хот руу Улаанбаатараас 1 удаа тогтмол нислэг хийдэг, Нисэх хугацаа 1 цаг 30 мин.

Баянхонгор хотоос Түйн голыг гаталж зүүн тийш Шаргалжуут голыг өгсөн Шаргалжуут рашаан сувилал 58 км, баруун хойшоо Эрдэнэцогт сум 45 км, Өвгөн Жаргалантийн хүүхдийн зуслан 30 км буцаад Эрдэнэцогт сум 30 км, Шатар чулуун туурь 10 км, Баянхонгор хот 18 км Аялах замын урт 200 км, аялалын хугацаа 2-3 хоног

Түйн гол Шаргалжуутын голын бэлчирт 16-р зуны үед барьсан чулуун хийдийн балгас байдаг.

Өлзийт, Баацагаан, Баян-Овоо сумдын нутгийн заагт Нарийн голын хөндийд орших Уран хайрхан ууланд доод чулуун зэвсгийн үеийн том дарханы газар байжээ. Эндээс Монголын хамгийн эрт үеийн түүхэнд холбогдох чулуун зэвсгүүд олджээ. Энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтанд авчээ.

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутаг Шаргалжуутын голын баруун эрэг рүү түрж орсон хадат хамрын энгэрээр үргэлжилэх болронцор, боржин асган дотроос садран оргилох, их бага зуу шахам тооны буцламтгай халуун булаг байдаг. Баянхонгор аймгийн төвөөс 60 км, Эрдэнэцогт сумын төв хүртэл 42 км, Өлзийт сумын төв хүртэл 50 км зайтай далайн түвшнээс дээш 1492 м өндөрт, өндөр уулын давчуу аманд Шаргалжуутын рашаан байрладаг.

Шаргалжуутын рашаан хуучин төрмөлийн эриний үеийн боржин сэвхэт чулуу, диорит, хадан цагаан, цахиуржсан хадан цагаан зэрэг гүний ургаа чулуулагийн дороос оргилон гарахаас гадна тэр орчмын хад цохио мөн эдгээр чулуулагаас тогтжээ.

Шаргалжуутын рашааны урд араар 500 м орчим зайд 5 хэсэг шинэсэн төгөл бүхий ой модтой, Рашаанаас дээш голын дагуу уулынхаа араар ой мод үргэлжилнэ. Рашааны орчим цахилдаг ширэг зэрэг ургамалтай, хайр сайр, хад чулуу ихтэй хатуу газартай, үржил шимээр тааруухан хөрстэй, хур тунадас бага, уур амьсгал эрс тэрс, өндөр газар юм.

Шаргалжуутын рашааны голлох 54 булагийг шинжлэн дугаарласан, 90 Хэмийн халуун усанд тэсвэрлэн амьдарч чадах хар, улбар шар, ногоон, ягаан зэрэг янз бүрийн хурц тод өнгөтэй замаг элбэг ургадаг. Нутгийнхан 108 рашаан байдаг гэдэг бөгөөд ерөнхийдөө 100 орчим булаг байдаг. Ундрага нөөц маш сайтай булаг бүхэн 20 гаруй м зайд байгаа Шаргалжуутын голд урсан нийлдэг. Өвөл цагт Шаргалжуут гол рашаан хоёрын уулзвараас доош 2 км орчимд огт хөлддөггүй харзлан урсдаг. Гидрокарбонат, карбонат, сульфат, натри, нүүрстөрөгчтэй рашааныг чийг бам, үе мөч, бөөр нуруу, мэдрэлийн болон арьс өнгөний өвчинд уух, орох зэргээр ашигладаг.

Энд байгуулсан амралтын газар нэг ээлжинд зуны цагт 450, өвөл 150 хүн хүлээн авах хүчин чадалтай, жилд 3500 орчим хүн ирж сувилуулж байна.

Түйн голын зүүн гарын цутгал Өвгөнжаргалант голын хөндийд ой модтой үзэсгэлэнт газарт хүүхдийн зуслан оршдог.

Дөш толгой бол шовгор дүрсээ хадгалан үлдсэн унтарсан галт уул юм. Эндээс оргилж байсан хайлмал бодис Эрдэнэцэргт сумын өнөөгийн төв хүртэл 20-иод км урссан байдаг.

Эрдэнэцөгт сумын төв дээр байдаг ХҮ зууны үед баригдсан одоо бүтнээрээ байгаа сүмийг Хачин ламын сүм гэдэг.

Эрдэнэцөгт сумаас Баянхонгор хот орох замын баруун талын дэнжид хүн чулуун хөшөө, буган чулуун хөшөөнүүд, шатарын янз бүрийн дүрс, булш бүхий их талбайг хамарсан цогцолбор урсгал байдгийг Шатар чулуу гэж нэрлэдэг. Шатар чулууг 1998 онд улсын хамгаалалтанд авчээ.

Хангайн нурууны БЦГ-ын аялал жуулчлалын бүсийн Б хэсэгт Эрдэнэцөгт сумын Өвгөн жаргалантын зуслангаас Цагаан хадны даваа Тамчийн хавцгайт Согоот нуурыг дамжин Тонгорогийн даваа хүртэлх газруудыг хамруулсан байдаг. Цааш Орхон голыг уруудан Улаан цутгалан, Хоргой хүрэм хүртэл аялаж, Орхоны хөндийн аялал жуулчлалын бүсэд холбогдох бололцоотой.

2. Галуутын хавцал, Мандалын хийд орчмын бүс

Баянхонгор хотоос баруун хойшоо Баян-Овоо сум 28 км, Үхэгийн рашаан 50 км, Сүмбэр, Харгана голуудыг гаталж Галуут сум 61 км, Мандалын хийд 30 км, Галуутын хавцал 30 км, Үүдийн нуур 30 км, буцаад Баян-Овоо сум 25 км, Баянхонгор хот 28 км. Аялах замын урт 300 км, аялах хугацаа 2-3 хоног.

Баянхонгор аймгийн Галуут сумын Үхэгийн голын урд захад Ар Мухар уулын ар ёроолд далайн түвшнээс дээш 2400 м өндөрт Үхэгийн рашаан байдаг.

Галуут сумын төвөөс баруун тийш 20 орчим км-т Олгой нуураас Галуут гол хойшоо урсан гарахдаа 2 км орчим урт Галуутын хавцлыг үүсгэжээ. Хавцал нь 100-200 м орчим гүнзгий эгц цавчим бөгөөд өргөн нь дунджаар 10 м, хамгийн давчуу гшазраа 3 м орчим болно. Ийм давчуу хавцлаар энэ гол шаагин, эрчлэн хуйлран урсах нь сонин. Хавцлын эгц хажуугийн хад чулуунд үүссэн ялимгүй тавцангууд дээр хаврын цагт усны шувууд өндөглөдөг ажээ. Хавцлын дээрээс өнгийж харахад өндөг нь будаа шиг харагддаг.

Галуут сумын нутагт Сүмбэрийн голын хөндийд орших Олон нуур Арь хадын булан гэдэг газар бий. Энэ хавийн нууруудад хавар намрын улиралд усны шувууд ихээр цуглардаг.

Үүдийн нуур гэж хлор, сульфат натритай шавартай сайн рашаан бий. Үе мөчний өвчинд шавар түрхэж эмчилдэг.

Үхэгийн рашаан хуучин төрмөлийн эриний их хувирсан хөх занар элсэн чулуу, хүрэн хас, герциний үеийн боржин зэрэг чулуулагийн сайр асган дороос гарахаас гадна дөрөвдөгч галавын хурдсанд ихээхэн дарагджээ. 10 гаруй булгийн нийлбэр барагцаалбал 1 цагт 2400 л ус гарах нөөцтэй, халуун 30-57 хэм болно. Сэнжитийн нуруу, Тунсаг хайрхан, Дөрвөлжин хүрэн, Цохиотын нуруу зэрэг өндөр уулс хүрээлсэн, ус, ой мод, өвс ургамал тэгширсэн сайхан нутаг юм. Энд байгуулсан амралтын газар нэг ээлжинд 70 хүн хүлээн авах хүчин чадалтай, жилд 1000 орчим хүн ирж сувилуулж байна.

Цагаан туруутын голын хойд захад голын хойд захад боржин чулуун цохион дунд ХҮ зууны үед Монголчуудын барьсан Мандалын хийд байдаг. Тухайн үедээ Монголын соёлын нэг томоохон төв байсан баримт олон байдаг.

Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг Өргөөтийн голын зүүн талд далайн түвшнээс дээш 2200 м өндөрт Өргөөтийн рашаан байдаг. Галуут сумын төвөөс 50 км, Мандалын хийдээс хойш 30 км зайтай очих замын бартаа ихтэй.

Рашааныг Донойн зүүн, баруун, Өлтийн хойд, Хунх Үчлэг, Бүрэн хайрханы зэрэг араараа шинэсэн ойгоор бүрхмэл уул нурууд хүрээлэн оршино. Өргөөтийн голоос гадна түүнд цутгасан жижиг гол горхи, булаг шанд олонтой, намаг балчиг ихтэй.

Рашаан хавьд хуучин төрмөлийн эриний их хувирсан занар зэрэг тунамал чулуулаг, герциний үеийн боржин, хадан цагаан, хүрмэн чулуу элбэг. Өргөөтийн рашаан дунд зэрэг ширхэгтэй цайвар саарал боржин чулуун асган дороос оргилох 3-4 булаг байдаг. Халуун нь 40-42 хэм болно.

3. Орог нуур-Их Богд уул орчмын бүс

Баянхонгор хотоос Өлзийт сум 17 км, Жинст сум 83 км, Богд сум 28 км, Баянлиг сум 95 км, Баянговь сум 48 км, буцаад Их Богд уулын баруун талаар Баянхонгор хот 250 км Аялах замын урт 550 км, аялах хугацаа 4-5 хоног

"Хорсеман клуб" ХХК-ийн "Айбекс ибекс" жуулчны бааз Баянхонгор хотоос урагш 90 км, Жинст сумын төвөөс хойш 25 км Түйн голын эрэг дээр Хавцгайтын ам гэдэг газар байрладаг Нэг ээлжиндээ 35 хүн хүлээн авах бололцоотой.

"Монгол говь" ХХК-ийн "Алтан говь" ХХК-ийн жуулчны бааз Богд сумын нутаг Холбоожийн нурын ойролцоо байдаг. 1: гэртэй, нэг ээлжиндээ 60 хүн хүлээн авах бололцоотой.

"Хан гео" ХХК-ийн "Баян тур" жуулчны бааз 5 гэртэй нэг ээлжиндээ 20 хүн хүлээн авах бололцоотой.

Түйн голоос зүүн тийш ойрхон, Жинст сумаас зүүн урагш 20 км-т орших улаан давст Холбоож нуур байдаг. Энэ нуурын орчимд 200 орчим гангар хун байнга байдаг Энэ орчмоос эртний амьтадын чулуужсан яс, чулуужсан ургамал олддог.

Богд сумын нутагт Их Богд уулын хойд ёроолд 1198 м өндөрт орших 140 х.д.км талбайтай Орог нуурын хойд эргээр чихэр өвс үлэмж их ургадаг. Гантай жил штр гэж дундрах явдал бий. Нуурын зүүн урд захаар заган шугуй, баруун хойд захаар элсэн тарамцагууд байдаг.

Говь Алтайн нурууны ноён оргил Их Богд уул 3957 м өндөр, 1957 онд энэ ууланд 11 баллын хүчтэй газар хөдлөлж, араар нь их хагархай үүсэж, олон ам жалга дарагдаж, олон горхины ус нурангид боогдож шинэ нуурууд үүсэж, бас олон шинэ булаг гарсан.

4. Баянлиг-Баянговийн бичил бүс

Баянлиг сумын нутаг Цахир ууланд орших 40 гаруй м урт Цагаан агуйд одоогоос 700 000 жилийн тэртээ хүн орогнон сууж байсан ул мөр олджээ. Энэ нь манай гариг дээр хүн амьдарч байсан хамгийн эртний ул мөр юм. Төв Азид хүн үүссэн байж болох талаар эрдэмтэдийн дэвшүүлсэн таамаглал нотлогдож болох юм.

Баянлиг сумын Их Баян уулын Бичигтийн аманд сүг зурагтай хад байдаг. Энэ дурсгалыг хүрлийн үед холбогдоно гэж үздэг Эдгээр дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтанд авчээ.

Их Богд ууланд 1957 онд болсон газар хөдлөлөөр үүссэн хагархай Орог нуурын урд талаас эхлэн баруун тийш Баянцагаан уулын ар хүртэл 270 км үргэлжилнэ.

Аялал жуулчлал, амралт сувилалын зориулалтаар 22 га газар, ашиглагдаж байгаа нь туйлийн хангалтгүй үзүүлэлт юм. / Шаргалжуутын, Бөөнцагааны /,

2.3.4. Үйлдвэр уурхайн газрын ашиглалт, хамгаалалтын байдал.

2006 оны эцсийн газрын тоо бүртгэлээр үйлдвэрийн газар 23.8 га, уурхайн газар 9722 га байна. Энэ нь Баянхонгор аймгийн хүнсний үйлдвэрийн 17.8 га дээр нь Өлзийт суманд байгаа 6 га үйлдвэрийн газар юм. Уурхайн газрын хувьд Галуут суманд 3504.1 га, Эрдэнэцогтын 30 га, Баян-Овооны 1065.9 га, Өлзийтийн 170 га, Бөмбөгөрийн 3486 га, Загийн 225 га, Шинэжинстийн 421 га, Бууцагааны 9 га, Жаргалантын 810 га бөгөөд эдгээр нь тусгай зөвшөөрөл лицензийн дагуу алт олборлодог ашиглалтын лицензтэй аж ахуйн нэгжүүдийн олборлолтын талбай юм. Хамгийн сүүлд 2005 онд Бөмбөгөр суманд дээрх талбай 551.6 га-р нэмэгдсэн байна. Одоогийн байдлаар дээрх талбайнуудад их бага ямар нэг хэмжээгээр олборлолт хийж байгаа бөгөөд одоогоор үйл ажиллагаа бүрэн дуусаагүй нэрийдлээр нөхөн сэргээлт хийсэн газар бараг байхгүй гэж хэлж болно. Зөвхөн Жаргалант суманд 3.2 га-д нөхөн сэргээлт хийжээ.

Зөвшөөрөлтэй ашиглалтын лицензтэй аж ахуйн нэгжүүдээс гадна хайгуулын лицензтэй аж ахуйн нэгжүүд маш их газрыг ухан төнхөж эвдэн сүйтгэж байна. Тухайлбал Баянговь суманд 16 хайгуулын лицензтэй аж ахуйн нэгж 100 орчим га талбайг, ухаж төнхсөн. Мөн энд хувиараа алт олдборлогч “нинжа” нарын асуудал томоохон байр суурийг эзлэх бөгөөд албан бус мэдээгээр Бөмбөгөр, Шинэжинст, Баян-Овоо суманд 3000-4000 хүн хувиараа алт олборлон амьдарч байна. Эдгээр хүмүүс нь ихээхэн хэмжээний газрыг онгичин сүйтгэж алт олборлосны дараа ямар ч нөхөн сэргээлтийн ажил хийдэггүй ухсан газраа тэр чигээр нь орхиж байгаа нь байгаль орчинд багагүй хохирол учруулж байна. Албан бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааг бичил уурхай болгон зөв хөгжүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, томоохон үйлдвэр уурхайн ашиглаж байгаад орхисон талбайн үлдэгдэл нөөцийг болон технологийн хаягдлыг бүрэн гүйцэд ашиглах, үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд илрэлүүдийн нөөцийг эдийн засгийн эргэлтэнд оруулах зэрэгт бичил уурхайн үйл ажиллагааг ашиглах хэрэгтэй байна.

2007 оны 01-р сарын 01-ний байдлаар нийт 362 хайгуулын лицензээр 2 736 899 га газарт геологийн хайгуулын ажил хийгдэж байгаад нийт нутаг дэвсгэрийн 23,6 % хамрагдаж байна. Энэ нь хангалтгүй үзүүлэлт нийт нутаг дэвсгэрийн 65-70 % нь геологийн судалгаанд хамрагдах шаардлагатай.

Дүгнэлт

Тус аймгийн хэмжээнд 20 суманд аймгийн төв 1, сумын төв 19 байхаас гадна үйлдвэр дагасан Дөвөнтийн уурхай, сувилал дагасан Шаргалжуут тосгон зэрэг суурьшил бүхий томоохон баг, бригадын төвүүд оршдог. Эдгээр төвүүдийн суурьшилийн бүс нь нийтдээ 2060.7 га газрыг эзлэх бөгөөд үүний цэвэр барилгажсан хэсэг 882.4 га гэр хороолол 1178.3 га байгаагаас үзэхэд гэр хорооллын газар давамгайлж байна. Хот суурин газарт эзлэх ногоон байгууламж 2.8 га талбайг эзлэж байгаа нь нийт суурьшилийн бүсийн дөнгөж 0.13 %-ийг эзлэж байна. Мөн ашиглалтын явцад элдэв бохирдол, гуу жалга, ухагдаж төнхөгдсөн, элсжсэн зэрэг шалтгааны улмаас 520.4 га газар буюу нийт суурьшилийн бүсийн 25.3% газар дортойтсон байна. Хотын функциональ бүсүүдийн хил, зааг ялгаа зарим газарт тодорхой ялгарахгүй байгаа учир тэдгээрийг газар ашиглалтын хэм хэмжээнд ялган зааглаж хөгжүүлэх шаардлагатай.

Улсын чанартай 1, Орон нутгийн чанартай 2 амралт, рашаан сувилал, жуулчны баазын зориулалтаар 5 аж ахуйн нэгж нийт 22 га газар ашиглаж байгаа нь хот тосгон бусад суурингийн ангилалын газрын дөнгөж 1%-ийг эзлэж байна. Одоогийн байдлаар аялал жуулчлал, амралт сувилалын 3 гол бүс нутаг 1 дэд бүс нутаг байдаг бөгөөд хойшид дээрх бүс нутгийн үйл ажиллагааг сайжруулах, бусад үзэсгэлэнт болон түүх дурсгалын газруудад энэ салбарыг өргөжүүлэх боломж бий.

Үйлдвэрийн газар 23.8 га талбай эзэлдэгийн 17.8 га талбайг зөвхөн Баянхонгор сумын нутагт байрлах талх, нарийн боов, ундаа, архины цех зэрэг үйлдвэрийн газрын талбай эзэлдэг. Харин уурхайн газар 9722 га байгаа бөгөөд үүний 9705 га нь ашигт малтмал олборлолтын талбай, 17 га нь уурхайн суурьшилийн бүсийн барилга байгууламжийн газар байна.

2.4. Зам, шугам сүлжээний ангиллын газар, түүний ашиглалт

2.4.1. Зам, шугам сүлжээний ангиллын газрын бүтэц.

Зам шугам, сүлжээний газар нийт 5103.1 га талбай эзэлдэгээс 80.5% буюу 4108.1 га нь авто замын газар, 0,19 % буюу 9.8 га нь агаарын тээврийн газар,

19,3 % буюу 985.2 га нь шугам сүлжээний газар эзэлдэг бөгөөд уг ангиллын газар ямар нэг өөрчлөлт ороогүй байна. Эдгээрээс шугам сүлжээ, авто замын газар улс ардын аж ахуйд өргөн хэрэглэгдэх ба агаарын тээврийн хувьд аймгийн төвд онгоц буух нислэгийн зурвас багахан газартай.

2.4.2. Авто замын зурвас газар

Авто замын газар 4108,1 га байгаагаас улсын чанартай зам 433,6 га, орон нутгийн чанартай зам 3628,5 га, аж ахуй байгууллагуудын дотоодын зам 44,2 га, авто тээврийн барилга байгууламж болон зогсоолын газар 1,8 га тус тус байна. Эндээс харахад орон нутгийн чанартай зам нэлээд талбайг эзэлдэг байна. Замын сүлжээний байдлыг дор сийрүүлэв.

Тус аймгийн нутгаар Баянхонгор-Шаргалжуутын 44 км, Баянхонгор-Нарийн тээлийн 57 км, Баянхонгор-Бөмбөгөрийн 102 км, Бөмбөгөр - Бууцагааны 79 км, Бууцагаан - Хүрээмаралын 43 км, Хүрээмэрэл - Баянбулагийн 52 км, Баянбулагаас - Отгоны чиглэлд 25 км, Бууцагаанаас - Дэлгэрийн чиглэлд 81 км нийт 483 км улсын чанартай томоохон замууд дайран гарч байгаагийн дотор Улаанбаатар - Алтайн зам ачаа болон зорчигч тээврийн онцгой чухал үүрэг гүйцэтгэнэ. Орон нутгийн чанартай 3628 км урт шороон зам авто замын сүлжээний зонхилох хэсгийг буюу 88,3%-ийг бүрдүүлж байна. Мөн тус аймгийн хойт талын сумдын нутгаар баруун аймгуудаас Дархан, Улаанбаатарт тушаагдах мал тууврын зам дайран өнгөрнө. Энэ замд одоогийн байдлаар 142.2 мян.га бэлчээр нутаг хамрагдаж байна.

Авто замын хувьд зөвшөөрөгдсөн албан ёсны замаас гадна олон салаа гаргаж зорчих явдал нэлээд тохиолдох бөгөөд зөвхөн бэлчээрийн газраас гэхэд 56 491 га талбай авто замын нөлөөлөлд орсон баримт бий.

Монголын Иргэний Агаарын Тээвэр аймгийн төвд байнгын ажиллагаатай 1 нисэх буудалд 9,8 га газрыг иргэний нисэх буудлын зориулалтаар ашиглаж байн

2.4.3. Инженерийн шугам сүлжээний зурвас газар.

Шугам сүлжээний газар 985,2 га бөгөөд үүнээс холбооны шугам, мэдээлэл хүлээн авах станцын эзлэх талбай 648,3 га, эрчим хүчний шугам станцын эзлэх талбай 253,4 га, ус дулаан дамжуулах хоолойн эзлэх талбай 47,0 га, ус шахах өргөх байгууламжийн газар 36,5 га талбайг тус тус эзлэх ба үерээс хамгаалах далан суваг байхгүй. Эдгээрийн ихэнхи хэрэглээ Баянхонгор, Баян-Овоо, Өлзийт, Заг сумын нутагт ноогддог.

Эрчим хүчний сүлжээний байдлыг тодруулбал. Баянтээг - Баянхонгорын 110 кВ-ын 55,6 км шугам ашиглалтанд ороод байгаагаас гадна Баянхонгор - Эрдэнэцогтын 6 кВ-ын 21 км, Баянхонгор-Өлзийт 6кВ-ийн 10,1 км, Баянхонгор - Баян-Овоогийн 6 кВ-ийн 29,1 км, Баянхонгор – Шаргалжуутын 10кВ-ийн 49,3 км шугам Жаргалант -Заг-Гурванбулагийн 10 кВ-ийн 176,5 км шугам ашиглагдаж байна,

Дүгнэлт

Зам шугам, сүлжээний газар нийт 5103.1 га талбай эзэлдэгээс 80.5 % буюу 4108.1 га нь авто замын газар, 0,19 % буюу 9.8 га нь агаарын тээврийн газар, 19,3 % буюу 985.2 га нь шугам сүлжээний газар эзэлдэг бөгөөд эдгээрээс шугам сүлжээ, авто замын газар улс ардын аж ахуйд өргөн хэрэглэгддэг.

Шугам сүлжээний газар 985,2 га бөгөөд үүнээс холбооны шугам, мэдээлэл хүлээн авах станцын эзлэх талбай 648,3 га, эрчим хүчний шугам

станцын эзлэх талбай 253,4 га, ус дулаан дамжуулах хоолойн эзлэх талбай 47,0 га, ус шахах өргөх байгууламжийн газар 36,5 га талбайг тус тус эзлэдэг.

2.5. Ойн сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал

2.5.1. Ойн сангийн ангиллын бүтэц.

Ойн санд ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэрт шатсан, хөнөөлт хорхой шавьж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн захаас гадагш 100 м хүртэлх газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газар багтдаг бөгөөд тус аймгийн нийт нутаг дэвсгэрийн 2.1 %-ийг ойн сангийн газар эзэлдэг. Ойн санг ерөнхийд нь ойтой, ойгүй гэж 2 ангилах ба ойтой талбай нь дотроо ойгоор бүрхэгдсэн, ойгоор бүрхэгдээгүй гэж 2 хуваагдана. **Ойгоор бүрхэгдсэн талбай** гэдэгт тухайн судалгааны үед ойтой байгаа талбайг хэлэх бөгөөд **ойгоор бүрхэгдээгүй** талбайд одоогоор ой байхгүй боловч урьд өмнө ойтой байсан цаашид ой ургах бололцоотой газрууд шатсан ой, тармаг мод, ойжих болон ойжуулсан талбай орно. **Ойн бус талбайд** ойн сан доторхи тал хээрийн бүстэй залгаадаагүй цагаан энгэр, хадлан, бэлчээр, нуур, намаг, зэрэг газрууд орно. Тус аймаг газрын тоо бүртгэлээр нийт 243832.7 га ойн сангийн газартайгаас ой модоор бүрхэгдсэн талбай /заган ой ороод/ 239672.5 га, ой мод огтолсон газар 4154 га, мод үржүүлгийн газар 1.25 га талбайг тус тус эзлэх ба ой тэлэн ургах газар байхгүй байна /диаграмм/. Уг ангиллын газарт одоогоор ямар нэг өөрчлөлт ороогүй байна.

239 672.5 га буюу 98.27% ойгоор бүрхэгдсэн /заган ой ороод/
4 154 га буюу 1.70% ойгоор бүрхэгдээгүй /огтолсон ой/
1.25 га буюу 0.03% мод үржүүлгийн газар гэж тус тус тогтоожээ.


Дээрхээс харахад ойн сангийн ихэнхи газрыг ойгоор бүрхэгдсэн талбай түүний дотор говийн сумдад орших заган ой эзэлнэ.

2.5.2. Ойн сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.

Баянхонгор аймгийн Баян-Овоо 168 га, Галуут 5162 – 2749 = 2413 га, Жаргалант 1576 га, Өлзийт 242 га, Эрдэнэцогт 5392 – 3370 = 2022 нийт 12 540 га шинэсэн ойтойгоос 4435 га ой нь Хангайн нурууны байгалийн цогцолбор газрын нутаг дэвсгэрт байрлана.

Түүнчлэн Баянговь 6282 – 3882 = 2400, Баянлиг 57271 – 28151 = 29120, Баян-Өндөр 245254 – 96354 = 148 900, Шинэжинст 158237 – 96597 = 61 640, Баацагаан 3291 га, Богд 7445 га нийт 477 780 га ойтой бөгөөд эдгээрээс 31 520 га нь Говь Гурван сайханы БЦГ-т, 210 540 га нь Говийн Их ДЦГ-ын нутаг дэвсгэрт байрлана.


Ойн сангийн газрын бүтэц



■ ойгоор бүрхэгдсэн ■ ойгоор бүрхэгдээгүй ■ мод үржүүлгийн газар

Ойн модны бүтэц. Тус аймгийн ой нь байгаль цаг уур, газар зүйн байрлалаасаа шалтгаалан Хангайн буюу хар мод шинэсэн ой, говийн буюу заган ой гэсэн өөр хоорондоо эрс өөр шинж чанартай үндсэн 2 төрлөөс бүтнэ. Говийн сумдад орших заган ойн талбай 181.4 мян. га буюу ойн сангийн газрын 74.4 %-ийг эзлэх ба тэгвэл Хангайн сумдад орших ой 62.7 мян.га буюу 25.6 %-ийг эзэлдэг /Газрын тоо бүртгэлээр, диаграмм/.

Ойн модны бүтэц



Хангайн ойн ихэнхийг хар модон ой эзлэх бөгөөд уулын ард тагийн бүслүүрээс доошхи ойн чандруулаг хөрсөнд ургадаг шинэсэн ой нь бүтээмж муутай боловч ус, хөрсийг хамгаалах чадвар сайтай экологийн ач холбогдолтой ойд тооцогддог байна. Монгол орны ойг Өвөр байгалийн, Хангайн, Төв Азийн ой ургамалжилтийн 3 муж болгон хуваадаг бөгөөд хойт талын сумд болох Эрдэнэцогт, Галуут, Жаргалант, Баян-Овоо, Өлзийт сумдын ой нь Хангайн мужийн төв Хангайн хошууны ойд багтаж Түйн, Байдраг, Цагаан Туруутын голын саваар хэсэг хэсэг төгөл хэлбэрээр тархах шинэсэн ой болно. Эдгээр ой нь зөвхөн арчилгаа цэвэрлэгээний огтлолт явуулахыг зөвшөөрсөн аливаа ашиглалт, аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглосон хамгаалалтын шинж чанартай ой юм. 1991 онд тус аймагт хийгдсэн Ойн хайгуул төслийн төвийн ой зохион байгуулалтын ажлаар /33/ Хангайн ойг дараахи байдалд хуваажээ /хүснэгт 24/. Хүснэгтээс харахад байгалийн ойн ихэнхи хувийг шинэсэн ой эзэлж багахан хувийг Эрдэнэцогт суманд тохиолдох бургас эзэлдэг байна. Чансааны хувьд шинэс модны 3.7% нь IV ангийн чансаатай үлдэх 96.3% нь V ангийн чансаатай байх ба бургас тэр чигээрээ 100% V ангийн чансаатай байх тул нийт модны дундаж чансаа V ангид багтана.

Хүснэгт 24

Сумын нэрс	Ойн талбай						Ойн бус	Бүх талбай
	Ойгоор бүрхэгдсэн			Ойгоор бүрхэгдээгүй				
	шинэс	бургас	Дүн	Тармаг	Ойжих	огтолсон		
Жаргалант	1388	-	1388	188	-	-	-	1576
Галуут	4802	-	4802	50	310	-	60	5222
Эрдэнэцогт	4788	350	5138	116	122	16	-	5392
Баян-Овоо	168	-	168	-	-	-	-	168
Өлзийт	148	-	148	-	94	-	-	242
Дүн	11294	350	11644	354	526	16	60	12600
Хувь	89.6	2.8	92.4	7.1			0.5	100

Ойгоор бүрхэгдсэн талбайг ойн өтгөрлөөр хуваабал дараахи байдалтай байх бөгөөд аймгийн хэмжээнд дундаж өтгөрөл 0.55 байна /хүснэгт 25/.

Ойн өтгөрөл

Хүснэгт 25

Сумын нэрс	Модны нэр	Өтгөрөл							Дүн
		0.3	04	0.5	0.6	0.7	0.8	0.9	
Жаргалант	шинэс	70	168	680	442	28			1388
Галуут	шинэс	118	194	2138	2240	112			4802
Эрдэнэцогт	шинэс	152	216	1560	2304	450	106		4788
	Бургас			172	178				350
Баян-Овоо	шинэс			52	116				168
Өлзийт	шинэс		6	40	52	50			148
Дүн		340	584	4642	5332	640	106		11644
Хувь		2.9	5.0	39.9	45.8	5.5	0.9		100

Ойгоор бүрхэгдсэн талбайн ойн нөөцийг насны ангиар хувиарласан байдал. Хүснэгт 26

Сумын нэрс	Аж ахуй	Насны анги, га/ нөөц, мян. метр ³					Дүн	Дундаж нас	Дундаж өсөлт
		IV	V	VI	VII	VIII			
Жаргалант	шинэс								
	1		24/1.2	48/3.1	72/9.1		144 /13.4	117	0.1
	2	14/0.3	38/2.0	242 /18	642 /51	308 /26	1244 /98.1	127	0.8
Дүн		14/0.3	62/3.2	290 /21.1	714 /60.1	308 /26.8	1388/ 111.5	126	0.9
Хувь		1/0.3	4.5/ 2.8	20.9 /18.9	51.4 /53.9	22.2 /24.1	100 /100		
Галуут	шинэс	46/4.3	74/ 8.1	128 /14.1	142 /16.0	42 /7.1	466 /51.3	107	0.5
		212/ 16.3	536 /31.6	1268 /108.9	1860 /182.1	350 /36.1	4336 /380.7		
Дүн		258 /20.7	610/ 39.7	1396 /123.0	2002 /198.1	392 /43.2	4802 /432.1	114	3.8
Хувь		5.4/	12.7	29.0	41.7	8.2	100		

		4.8	/9.2	/28.5	/45.8	/10.0		
--	--	-----	------	-------	-------	-------	--	--

Судалгаанаас үзэхэд :

нийт талбайн 12,6 нөөцийн 14.3%-ийг 111-160 насны VIII ангийн ой, нийт талбайн 32, нөөцийн 34.7%-ийг 121-140 насны VII ангийн ой, нийт талбайн 24,5 нөөцийн 25.6%-ийг 101-120 насны VI ангийн ой, нийт талбайн 14,2 нөөцийн 14.2%-ийг 81-100 насны V ангийн ой, нийт талбайн 88,8 нөөцийн 4.3%-ийг 41-60 насны III ангийн ой, нийт талбайн 0,8 нөөцийн 0.2%-ийг 21-41 насны II ангийн ой, нийт талбайн 0,1 нөөцийн 0.1%-ийг 0-20 насны I ангийн ой, талбай нөөцийн мөн 0.1%-ийг X ба түүнээс дээш ангийн ой тус тус эзлэж дундаж нас нь насны ангийн VI анги буюу 110 жил, жилийн дундаж бүх өсөлт нь 9.6 , нөөц 543.6 мян. метр³ байна. Ойн нөөц гэдэг нь 1 га ойн ургаа модны ишний нийт эзэлхүүнийг хэлдэг бөгөөд дээр тархсан модны нийт нөөц аймгийн хэмжээнд мян. метр³ байна. Эндээс харахад Хангайн бүсийн ой нь байгалийн нөхөн ургалт байхгүй, ойн нөөцгүй, маш муу ойд тооцогддог байна.

Байгалийн ойн ихэнхи хувийг эзэлдэг **заган ой** нь урд талын говийн сумд болох Баацагаан, Баянговь, Богд, Баянлиг, Баян-Өндөр, Шинэжинст зэрэг 6 сумын нутагт Луулийн овогт багтах Зайсангийн заг тархана. Тархалтын хойд цэг нь Баацагаан, Бөөнцагаан нуурын урд хөвөө, урд тал нь Цагаан дэрсний худгаас баруун урагш Хятад Монголын хил дагуу , баруун тал нь Эдрэнгийн нурууны хойд урд биеэр Говь-Алтай аймгийн хилтэй залгаж зүүн тал нь Баянлигийн Хатан суудлаас зүүн урагш Өмнөговь аймгийн хилтэй нийлсэн 477780 га талбайг заган ой болон түүний бүрэлдэхүүнд орж байгаа бут сөөг эзлэнэ /34/ гэж бичжээ /хүснэгт 27/. Заган ой нь говийн сумдын цөл, цөлөрхөг хээрийн бүсэд элсэрхэг хөрсөнд ургаж говийн хөнгөн хөрс, тачир ургамлыг салхины элэгдлээс хамгаалахаас гадна ан амьтан мал сүргийн тэжээлийн арвин нөөц төдийгүй тэдний амьдрах таатай орчны бүрдүүлдэг учир аж ахуйн шинж чанаргүй зөвхөн хамгаалах, нөхөн ургалтыг дэмжих, арчилгаа, тордолгооны огтлолтоос бусад огтлолтыг хориглодог ой юм. Уг заган ой нь манай орны заган ойн нийтлэг шинж чанарыг агуулах бөгөөд ихэнхидээ холимог бус цэвэр ойн шинжийг агуулдаг, заг, сухай, шар мод, хармаг холилдон ургасан тохиолдол цөөн байна. Баянхонгор аймгийн заган ойд хийсэн судалгаагаар /1991/ заган ойн талбайг загаар бүрхэгдсэн, тармаг загтай, загжих талбай гэсэн 3 хэсэгт хувааж, загаар бүрхэгдсэн талбайд 0.3 ба түүнээс дээш өтгөрөлтэй талбайг, тармаг загтайд 0.2 ба түүнээс доош өтгөрөлтэй талбайг хамруулахад загаар бүрхэгдсэн талбай 148642 га буюу 31.1%, тармаг загтай 325520 га буюу 68.1%, огтолсон заг 3618 га буюу 0.8% байх ба загжих талбай байхгүй байжээ /хүснэгт 27/. Ерөнхийдээ заган ойн талбай урд 1975 оны судалгааны үеэс 5.8 %-иар буурсан байна.

Хүснэгт 27

Заган ойн төрөл

Сумын нэр	Загаар бүрхэгдсэн,га	Тармаг заг,га	Огтлогдсон талбай, га	Нийт талбай,га	Нийт талбайд эзлэх %
Шинэжинст	42204	116033		158237	33.1
Богд	6747	698		7445	1.6
Баянговь	6282			6282	1.3
Баянлиг	23233	30420	3618	57271	12.0
Баацагаан	3181	110		3291	0.7
Баян-Өндөр	66995	178259		245254	51.3

	148642	325520	3618	477780	
Дүн	31.1%	68.1%	0.8%		100%

Хүснэгтээс үзэхэд Баян-Өндөр сумын нутагт хамгийн их заг / 51.3%/ байна.

Загаар бүрхэгдсэн талбайн ойн нөөцийг насны ангиар хувиарласан байдал.

Хүснэгт 28

Сумын нэр	Насны анги, га/ м ³				
	II	III	IV	V	
Шинэжинст		10840 / 8672	31364/6273	-	42204/14945.0
Богд	674/5927	-	-	-	6747/5927
Баянговь	-	6282 / 1256	-	-	6282/1256
Баянлиг	-	23233/30447	-	-	23233/30447
Баацагаан	1959/392	1222 / 244	-	-	3181/636
Баян-Өндөр	-	4103 / 3283	49020/37216	13872/19421	66995/59920
Дүн	8706/6319	45620/43902	80384/43489	13872/19421	148642/113131

Хүснэгтээс харахад аймгийн хэмжээгээр загаар бүрхэгдсэн 148642 га талбайн нөөц 113131 м³ байх бөгөөд үүн дээр тармаг заг нэмэгдвэл нийт нөөц **235593 м³** болно. Үүний нийт талбайн 45.% нөөцийн 52.9% нь Баян-Өндөр сумын нутагт тархах заган ойд хамрагдана.

Загаар бүрхэгдсэн талбайг ойн *өтгөрлөөр* хуваабал дараахи байдалтай байх бөгөөд аймгийн хэмжээнд дундаж өтгөрөл 0.31 байна.

Заган ойн өтгөрөл

Хүснэгт 29

Сумын нэр	Өтгөрөл				Бүгд	Дундаж өтгөрөл
	0.3	04	0.5	0.6		
Шинэжинст	42204	-	-	-	42204	0.3
Богд	1025	5722	-	-	6747	0.38
Баянговь	6282		-	-	6282	0.3
Баянлиг	15240	-	7993	-	23233	0.37
Баацагаан	3181	-	-	-	3181	0.3
Баян-Өндөр	66995	-	-	-	66995	0.3
Дүн	134927	5722	7993	-	148642	0.31
%	90.8	3.8	5.4		100	

Заган ойн дундаж нас 18,3, ерөнхий дундаж өсөлт 6.5 мян.м³

Загийн дундаж чансаа III, дундаж өтгөрөл 0.31

Заган ойн бүх нөөц 235.5мян. м³, 1га талбайн нөөц-1.4 м³.


Заган ойн титмийн дундаж голч 1,1 м, дундаж өндөр 1-2 м

Заган ойг ургах орчин, хэв шинжээр нь хайргат элсний, элсэрхэг гүвэнт, шал тойрмын, сайр садаргын гэж 4 ангилахад тэдгээрийн ихэнхи нь сайр садаргын /68.4%/ болон элсэрхэг гүвэнт /22.3%/ гэсэн ангилалд бүгд хамрагдаж байв. Иймд заган ойг хамгаалах арга хэмжээнд бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх, уруйн уснаас хамгаалах, элсний нүүлтийг зогсоох, элс бэхжүүлэх, хөрс хамгаалах салхины хүчийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг онцгойлон авч хэрэгжүүлбэл зохино.

Ойн ашиглалт. Баянхонгор аймгийн ойн нь ерөнхийдээ үйлдвэрлэлийн ач холбогдолгүй хамгаалалтын шинж чанартай учир модыг зөвхөн арчилгаа, цэвэрлэгээний зориулалтаар мэргэжилийн байгууллагын хяналтан дор тодорхой заасан хэмжээгээр мод огтлохыг зөвшөөрдөг. Иймд ойг огтолж ашиглахаас өмнө нөхөн сэргээх, тарьж ургуулах үйл ажиллагааг нэн тэргүүнд явуулах хэрэгтэй. Гэвч аливаа ойлголт харьцангуй ухагдахуун байдаг бөгөөд энэ нь ойг огт ашиглахгүй, хүрч болохгүй гэсэн үг хараахан биш хөгширч нас гүйцсэн ойг мэргэжилийн байгууллагын хяналтан дор огтлох бусад дагалдах баялагийг хэм хэмжээнд нь ашиглахыг зөвшөөрдөг. Ер нь тус аймгийн хэмжээнд ойг ашиглалт талаасаа биш, ойг хамгаалах, нөхөн сэргээх талаас нь ойн менежментийн бодлого явуулах хэрэгтэй. Аймгийн статистик мэдээнээс харвал зүсмэл, материал мод модон эдлэл огт үйлдвэрлээгүй боловч хулгайгаар мод бэлдэж түлшинд хэрэглэх явдал мэр сэр байна. Аймгийн хэмжээнд 2006 оны байдлаар 4397 га буюу 1.70 %-ийг огтолсон байна. Говийн сумдад загийг түлшинд хэрэглэхийг хориглосон боловч хулгайгаар түлшинд хэрэглэх явдал байсаар байна. Зөвхөн Баянлиг суманд гэхэд 3618 га заган ойг огтолжээ. Цаашид модны нөөц багатай тус аймгийн хувьд энэ байдалтай хатуу тэмцэл хийх хэрэгтэй. Мөн ойн сангийн газрыг бэлчээрт өргөн хэрэглэж байгаа бөгөөд зөв зохистой хуваарьтай тодорхой хугацаанд сэлгэн ашиглах явдал чухал байна. Ялангуяа залуу загийн салаа салбар мөчир нахиа нь малын үнэт тэжээл болохоос гадна говийн бүс нутгийн хээрийн зэрлэг амьдын идэш тэжээл нөмөр нөөлөг газар нь болдог байна.

Ойг хамгаалах. арга хэмжээнд ойг гал түймэр, хөнөөлт хортон шавьж, өвчин болон тэдгээртэй тэмцэх, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, ойн хэвийн өсөлт нөхөн сэргэлтийг хангах, удмын санг хамгаалах арга хэмжээнүүд багтана. Аймгийн ЗДТГ, БОАлбанаас ойг ашиглах, хамгаалах хэтийн болон ойрын төлөвлөгөө боловсруулж ажиллах хэрэгтэй байгаа бөгөөд ялангуяа Эрдэнэцогт сумын ойд гарч байгаа ойн хортон шавьж хүр эрвээхэйг мэргэжилийн байгууллагын оролцоотойгоор устгах ажлыг нэн даруй зохион байгуулах хэрэгтэй байна. Огтолсон ойг нэн даруй ойжуулах хэрэгтэй байна. Учир нь ойгүй болсон газар хээрших процесс эрчимтэй явагдаж мод ургах экологийн нөхцөл алддаг учир аль болох хурдан хугацаанд нөхөн сэргээх ажлыг хийх хэрэгтэй.

Усан сан бүхий газрын бүтэц



Ер
нь
ойн
аш

иглалт хамгаалалт, тордолгооны ажил шаардлагын хэмжээнд хийгдэхгүй байгаа учир энэ тал дээр зохих байгууллага санаачилгатай ажиллах, түлшинд модыг их хэмжээгээр огтолж байгааг таслан зогсоох хэрэгтэй байна. Хөгширч муудсан модыг цэвэрлэх, ой нөхөн ургах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор арчилгааны, цэвэрлэгээний огтлолтыг бүх насны ангид багахан талбайд хийж болох юм.

Цаашид ойжуулалтын ажлыг 100 га талбайд, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг /арчилгааны огтлолт/ 540 га талбайд нийт 640 га талбайд дээрх 2 төрлийн нөхөн сэргээх ажлыг хийх шаардлагатай байгаа бөгөөд юуны өмнө ой ургаж байгаад гадны нөлөөгөөр ойгүй болсон талбайд эхлэн хийх хэрэгтэй байна. Ойн сангийн газар, ойн захаар оршин сууж байгаа иргэд малчдад ойг хамгаалах, түүнийг зөв зохистой ашиглах, гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгаа таниулга хийх, түр хугацаагаар гэрээгээр эзэмшүүлэх, хадлан хадах, мал бэлчээх зэрэг ажилд хяналт тавибал зохино.

Дүгнэлт

1. Судалгаанаас үзэхэд Хангайн ойн 92.4%-ийг ойгоор бүрхэгдсэн талбай шинэс, бургас, 7.1%-ийг ойгоор бүрхэгдээгүй талбай огтолсон ой, тармаг ой, ойжих талбай эзлэж үлдэх 0.5%-ийг ойн захын цагаан энгэр газар эзлэнэ. Ой модны бүтэцийн хувьд ойгоор бүрхэгдсэн талбайн 89.6%-ийг шинэс, 2.8%-ийг бургас эзлэнэ. Аймгийн хэмжээнд нийт модны дундаж чансаа V анги, дундаж өтгөрөл 0.55, дундаж нас нь насны ангийн VI анги буюу 110 жил, нөөц 543.6 мян. метр³ байна.
2. Заган ой нь нийт 477780 га талбайг эзлэн оршдоогоос загаар бүрхэгдсэн талбай 148642 га буюу 31.1%, тармаг загтай 325520 га буюу 68.1%, огтолсон заг 3618 га буюу 0.8% байх ба загжих талбай байхгүй байна. Энд Луулийн овогт хамрагдах Зайсангийн заг тархах бөгөөд заган ойн дундаж нас 18,3, дундаж чансаа III, дундаж өтгөрөл 0.31, бүх нөөц 235.5 мян. м³ байна.
3. Тус аймгийн ой нь хамгаалалтын бүсийн шинж чанартай учир ойг огтолж ашиглахаас өмнө нөхөн сэргээх, тарьж ургуулах үйл ажиллагааг нэн тэргүүнд явуулах хэрэгтэй.
4. Аймгийн хэмжээгээр нийт 4397 га талбайг огтолж 394 га талбай хортонд идэгдсэн учир 100 га талбайд ойжуулалтын ажлыг хийх шаардлагатай.
5. Одоогийн байдлаар заг шинэсэн ойг түлшинд хэрэглэхээс гадна малын бэлчээрт өргөн дэлгэр хэрэглэдэг.
6. Хулгайгаар мод бэлтгэх явдлыг бүрмөсөн зогсоох, элдэв төрлийн мод огтлолтыг тусгай зөвшөөрлөөр зөвхөн мэргэжилийн байгууллагаар хатуу хяналтан дор хийлгэх.
7. Гал түймэрээс урьдчилан сэргийлэх ажлыг хүчтэй болгох, хортон тархсан талбайд нэн даруй химийн хор цацах, устгал хийлгэх.

2.6. Усны сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.

2.6.1. Усны сангийн газрын ангиллын бүтэц.

Усан сан бүхий газарт гадаргуугийн усны эзлэж байгаа талбай, мөнх цас, мөсөн гол, түүнчлэн усны нөөц чанарыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай усны эрэг орчмын /хөвөө/ зурвас газар багтдаг. 2006 оны газрын тоо бүртгэлийн материалаас үзвэл усан сан бүхий газар нь нийт 51118.4 га талбай эзэлдэгээс гол мөрөн 2648.6 га буюу 5.2%, нуур цөөрөм 48004 га га буюу 93.9%, булаг шанд 465.8 га буюу 0.9%, байна. /зураг/.

Усан сан бүхий газарт голчлон Түйн гол, Байдрагийн гол, Хар усан гол, Шар усан гол, Загийн гол, Өлзийтийн гол, Бөөнцагаан нуур, Адгийн цагаан нуур, Орог нуур, Олгой нуур зэрэг гол мөрөн, нуур цөөрөм, усан сангийн эзлэх талбай хамрагдах бөгөөд эдгээр нь ихэвчлэн хурын усаар тэжээгдэнэ. Гэвч гадаргын ус нь хүрэлцээ муутай учир цаашид газар доорхи усыг голлон ашиглах нь зүйтэй. Газар доорх ус нь аймгийн бүх усны нөөцийн 22%-г эзлэх ба гадаргын усны нөөцийн тархац нь хэдхэн голын савд оршиж хязгаарлагдмал байдал үүсгэдэг нь ус хангамжид газар доорхи усыг ашиглахыг шаарддаг. Олон жилийн дундаж

урсацийн эзлэхүүний 70% нь халдашгүй нөөц буюу экологийн урсац болон учир урсацаас нийлбэр хэрэглээнд буцалтгүй авч ашиглах усны зөвшөөрөгдөх хэмжээ 30%-иас бага байх шаардлагатай. Хэрэв үүнээс ихээр авч ашиглавал усны түвшин буурах, нөөц хомсдох, ширгэж алгга болохоос гадна усны амьтан ургамалын төрөл зүйл хорогдоход хүрэх аюултай. Усны нөөц хуримтлуулах арга хэмжээнд Жижиг гол горхийн урсацад тохируулга хийж хэрэглээний ус бий болгох, Хаврын шар усны болон зуны борооны үерийн усыг хуримтлуулах усан сан цөөрөм байгуулах, Усны эх үүсвэрээс усалгаанд ашиглахаар авсан усны нилээд хэсэг нь суваг шуудуугаар дамжин усалгаатай талбайгаас гадагш гардаг. Энэ усыг буцааж гол руу оруулах, дахин ашиглах асуудлыг зураг төслийн хүрээнд шийдвэрлэх.

Усны нөөц. Баянхонгор аймгийн усны нийт нөөц нь гол төлөв Байдраг, Түйн голын сав, Говийн газар доорх усны нөөцөөс бүрэлдэх ба усны эх үүсвэрийн байдлаар ялгаж үзвэл:

- ✓ Гадаргын усны нөөц 690.56 сая м/куб. жил
- ✓ Газар доорх усны нөөц 199.24 сая м/куб.жил
- ✓ Булгуудын усны нөөц 0.58 сая м/куб.жил
бүгд 890.38 сая м.куб/жил

Усны нөөцийг сав газраар ангилан авч үзвэл

- ✓ Байдраг 470.30 сая м/куб жил/ ундрага нь 0.33 л/с.км²
- ✓ Түйн - 183.57 сая м/куб жил/ ундрага 0.387 л/с.км²
- ✓ Говийн газар доорх 4477.4 сая м.куб/жил

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн газар доорх усны нөөц нь мал сүргийн, ер нь ХАА-н ус хангамжинд ашиглахад хүрэлцээтэй бөгөөд газар доорх усны нөөцийн тархац нь аймгийн аль ч газар оронд байдаг онцлогтой. Иймээс цаашдын ус хангамжийн усны эх үүсвэрт голчлон газар доорх усыг авч үзэх нь чухал. Геологийн тогтоц, гидрогеологийн мужлал усжилийн комплекс, геоморфологийн ангилал, газар доорх усны нөөц, цэвдэг чулуулгийн байдлыг судлаад усны эрэл хайгуулын 3 үндсэн чиглэлийг ялгаж болно.

а/ Геоморфологийн хувьд уулс, өндөр улсын бэл хормой, аараг толгод жижиг хөндийд орших, геологийн янз бүрийн насжилттай үйрмэг бутархай хурдас, ан цавархаг аргиллит, сланец болоржин, элсэн чулуун уст давхаргад орших усыг мал сүргийн ус хангамжид ашиглахаар хайгуул явуулах, Энэ группын нөхцөлд дэх хайгуулд урьдчилсан хайгуул, шнек өрөмдлөг, цохилтын өрөмдлөг, зарим цэгт геофизикийн эрлийн ажлууд багтах юм.

б/ Уулс хоорондын хөндий, томоохон хотос, аараг, толгодын хоорондох хөндийд орших Палезой, Юра, гуравдагч, дөрөвдөгч насжилттай усжилийн комплексд орших уст давхаргыг илрүүлэх, ашиглах зорилготой хайгуулын ажил. Энэ группийн хайгуулын ажилд геофизикийн иж бүрэн хайгуулыг нэг бэлчээр (S=5км.кв)-т явуулдаг нормативаар, колонков хайгуулын нэг цооног өрөмдөх, урьдчилсан хайгуул гүйцэтгэх зэргийг багтаах ба уст давхрага орших гүн 100-150 м гүнд байхаар тооцох нь зүйтэй. Жаргалант, Гурванбулаг, Эрдэнэцогт сумдын нутагт цэвдэг чулуулаг тохиолдох тул геофизикийн эрлийн ажлыг онцгой аргачлалаар явуулах, цооног өрөмдлөгийн өвөрмөц технологи хэрэглэх шаардлагатай.

в/ Алс хэтэд улс ардын аж ахуйд ач холбогдол бүхий томоохон талбайд хайгуул хийж, газар доорх усны нөөц тодорхойлох усжуулаагүй томоохон

бэлчээрт газар доорхи усны байдлаар нь үнэлэлт дүгнэлт өгөх, сум МАА-н хэсэг жижиг хотууд, тосгон, ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор, МАА-н суурин цэгт усны нөөц тодорхойлох зэрэгт талбайн иж бүрэн хайгуулыг үе шаттайгаар явуулах юм. Энэ группын хайгуулд геофизикийн иж бүрэн аргаар эрлийн ажил гүйцэтгэх, нарийвчилсан хайгуулаар 20 км² талбай тутамд нэг цооног хоорондын зай хэлбэлзэх бөгөөд тодотголыг тухайн үеийн арга зүйд тусгаж байх нь зүйтэй. Ийм байдлаар сонгосон 1000 га талбайг нэг нэгж гэж авах нь зүйтэй

Дүгнэлт

1. 2006 оны газрын тоо бүртгэлийн материалаас үзвэл усан сан бүхий газар нь нийт 51118.4 га талбай эзэлдэгээс гол мөрөн 2648.6 га буюу 5.2%, нуур цөөрөм 48004 га га буюу 93.9%, булаг шанд 465.8 га буюу 0.9%, байна.
2. Баянхонгор аймгийн усны нийт нөөц нь гол төлөв Байдраг, Түйн голын сав, Говийн газар доорх усны нөөцөөс бүрэлддэг бөгөөд гадаргын ус нь хязгаарлагдмал хэдхэн голын сав газраар хэмжигддэг хүрэлцээ муутай байдаг учир цаашид газар доорхи усыг голлон ашиглах шаардлагатай байдаг. Газар доорх ус нь аймгийн бүх усны нөөцийн 22%-г эзлэх ба түүнийг бүрэн дүүрэн ашиглахад мал сүрэг ХАА-н ус хангамжинд хүрэлцэнэ.

2.7. Тусгай хэрэгцээний ангиллын газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

2.7.1. Тусгай хэрэгцээний ангиллын газрын бүтэц

Улсын тусгай хэрэгцээний газар нь нийт 2 263 508.4 га газар эзэлдэгээс улсын тусгай хамгаалалтай газар 2 172 260 га, улсын хилийн зурвас 74 500 га, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 58.4 га, шинжлэх ухааны сорилт туршилтын талбай 30.0 га, аймаг дундын отрын бэлчээр 16 660 га тус тус байдаг бөгөөд уг ангиллын газар одоогоор өөрчлөгдөөгүй байна.

2.7.2. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний ашиглалт, хамгаалалтын байдал.

Баянхонгор аймгийн нутагт улсын тусгай хамгаалалтанд дараахи 3 газрууд байна. Үүнд Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсэг 1 361 500 га, Говь Гурван сайханы Байгалийн Цогцолбор Газар 522 570 га, Хангайн нурууны Байгалийн Цогцолбор Газар 288 190 га нийт 2 172 260 га нутгууд багтдаг.

Говь Гурван сайханы байгалийн цогцолбор газар

Баянхонгор аймгийн Шинэжинст, Баянговь, Баянлиг сумдын өмнөд хэсгийн Говь-Алтай нурууны шувтаргын уулс болон тэдгээрийн хоорондох өргөн уудам хөндий, хоолой, элсэн манхнууд энэ байгалийн цогцолбор газарт багтдаг. Гурилын цав орчмын эртний амьтан ургамалын ховор үлдэц, Их Баян уулын түүх соёлын үнэт өвийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтанд авч ГГСБЦГ-т хамруулах саналыг Баянхонгор аймгийн ИТХ санал тавьсныг Засгийн Газар дэмжиж, УИХ-ын 2000 оны 29-р тогтоолоор шийдвэрлэсэн байна.

Уулсын дундаж өндөр д.т.д. 2200-2600 м ба тэдгээр нь цэрдийн галавын хурдаснаас тогтсон, эвдрэл, элэгдлийн хэвгий гадарга бүхий өргөн бэлээр

хүрээлэгдсэн байдаг. Энд дэлхийд алдартай үлэг гүрвэлийн олдвор газрууд бий.

Байгалийн цогцолбор газарт эх газрын хуурай ширүүн уур амьсгал зонхилно. Жилд дунджаар 200 мм хур тунадас орох боловч энэ нь ихэвчлэн зуны улиралд хүчтэй аадар борооны хэлбэрээр буудаг. Зарим газар 50 мм ээс ч бага тундас унадаг.

Баруунаас зүүн тийш 380 гаруй км үргэлжилсэн байгалийн цогцолбор газар нь цөлөрхөг хээр, цөлийн бүсийн янз бүрийн экосистемийг өөртөө агуулдаг. Энд чулуут цөл, элсэн цөл, хадан хясаа, хуурай хөндий, гуу жалга, хужир мараа, булаг шанд баян бүрд зэрэг зэргийг дурдаж болно. Өдлөг хялгана-таанат цөлжүү хээр, жижиг дэгнүүлт үетэнт цөл зонхилох бөгөөд Төв Азийн цөлийн төлөөлөгчид зонхилсон 620 гаруй дээд ургамал тэдгээрийн дотор 38 зүйлийн унаган ургамал тааралдана.

Багахан хэмжээний цагаан зээр, хар сүүлт, хулангийн сүрэг уулсын хоорондох уудам хөндий, цөлөрхөг хээрт тааралддаг. Асга хад, бартаа ихтэй говийн уулс нь ирвэс аргал, янгирт хамгийн тааламжтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. Элсэн манхан бүхий газраар дэлдэн зараа, элсний зурам амьдардаг. Энд бүртгэгдсэн 52 хөхтөний 8 нь Монголын улаан номд оржээ. Эгц хадан хясаа бүхий уулс, элсэн манхан хужир мараа, элэгдэл эвдрэлийн нөлөөгөөр үүссэн гуу жалгууд олон өнгөөр гэрэлтэн харагдах нь үлгэрийн орон мэт соньхон. Говийн байгалийн энэхүү давтагдашгүй өнгө төрх, амьтан ургамалын өвөрмөц ертөнц жуулчдын анхаарлыг татсаар байна. Улаанбаатараас Хархорин чиглэлд аяласан жуулчид Өвөрхангай аймгийн Богд сумаар дамжин Баянлиг сумын Цагаан агуй, Бичигт хадаар дамжин ГГСБЦГ-т аялах нь түгээмэл болж байна.

Энд Шинэжинст сумын Эрдэнэ багийн 29 өрхийн 80 орчим хүн, Баянговь сумын Хөөвөр багийн 90 өрхийн 360 орчим хүн, Баянлиг сумын Их Баян, Бага Баян зэрэг багийн 44 өрхийн 176 хүн, нийт 3 сумын 4 багийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгүүд хамрагдаж байдаг. 2006 оны байдлаар 2 багийн төв 2 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байсан ба шинээр 2 жуулчны бааз үйлчилгээний газрууд төлөвлөгдсөн.

Хангайн нурууны байгалийн цогцолбор газар.

Хангайн нурууны байгалийн цогцолбор газарт Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Өвгөн жаргалант багийн 130 966 га, Галуут сумын Мандал багийн 157 224 га нийт 288 190 га нутаг дэвсгэр багтана. Газрын сангийн төрлөөр авч үзвэл 278 050 га бэлчээр, 161 га зам харгуй, 9398 га ой, 581 га усан сан бүхий газар байна. Энд Галуут сумын Мандал багийн 245 өрх 978 хүн, 11094 тогой мал, Эрдэнэцогт сумын Өвгөнжаргалант багийн 324 өрх, 1312 хүн, 21 893 толгой мал нутагладаг.

Төв Азийн байгаль экологийн тэнцлийг хангахад онцгой нөлөө бүхий, Хангайн уулархаг мужийн байгалийн бүс бүслүүрийн үндсэн хэв шинжийн иж бүрдлийг төлөөлсөн, дэлхийн цэвэр усны нөөцөд чухал ач холбогдол үзүүлдэг гол мөрнүүд эх аван хойд, урд зүгт урсдаг усны хагалбар газрууд бүхэлдээ хамрагддаг. Энд дэлхийд ховордсон амьтан ургамалын нөөцтэйгээс гадна өвөрмөц сонин тогтоц байгалийн үзэсгэлэнт газрууд багтдаг.

Хангайн нурууны цогцолбор газар нь Хангайн нурууны ландшафтын үндсэн хэв шинжийг төлөөлсөн байгалийн үзэсгэлэнгээрээ гадаад, дотоодын зочид гийчдийн анхаарлыг ихэд татдаг газар нутгийг хамгаалах, зөв зохистой ашиглах, зохион байгуулалттай аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор байгуулагдаж, УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор батлагджээ. Нийтдээ 888.4

мян га талбай эзэлдэг. Хангайн нуруу бол Монгол орны байгалийн ерөнхий тэнцвэр, зохицолдоог хадгалж улмаар ой, тайга, говь, цөлийн аль алины тархалтын хүрээг хязгаарлаж байдаг байгалийн бие даасан их мужийг үүсгэнэ. Нөгөө талаар Хангайн нуруу бол газарзүйн байрлал уул зүйн тогтолцоо, ландшафтын тархац, түүний хувиарлалт, орон зайн хувьд ч их мужийн түвшинг илтгэнэ.

Гадаргын үнэмлэхүй өндөр нь 1500-2800 м-ийн хооронд хэлбэлзэнэ. Уулсын орой хяр хавтгайдуу бөмбөгөр хэлбэртэй, хажуунууд нь харьцангуй налуу, уулсын хоорондох хөндий хотгор өргөн тавиу юм. Хангайн нуруу нь тус орны бусад уулсаас түрүү тогтсон тул элэгдэлд нэн удаан хугацаанд автсан байна. Тийм учраас тэдгээрийн хажуу гол төлөв налуу, орой нь бөмбөгөр буюу ихээхэн элэгдэж мөлийсөн шинжтэй юм.

Геологийн тогтоцын хувьд Хангайн уулт их мужид дээд-дунд кембри, доод-дунд девон, дээд чулуун нүүрсэн, перми дээд триас-доод юрийн галавт үүссэн боржин чулуу эрс зонхилохын хамт гранодиорит мэтийн боржингийн төрлийн магмын чулуулаг элбэг тархжээ. Хангайн нурууны геологийн бүтцэнд боржин чулуу ихээхэн суурь эзлэхийн зэрэгцээ хувирмал занар, элсэн чулуу, хүрмэн чулуу зэрэг чулуулаг элбэг тохиолдоно.

Орхон голын эх авч урсдаг хэсэг маш үзэсгэлэнтэй. Энэ голын хойт, урд этгээдээр 2500-3000 м өндөр уулс, боржин, байц, хад цохио, ой хөвч бүхий их уулс сүндэрлэнэ.

Хангайн мужийн уур амьсгал ерөнхийдөө сэрүүвтэр, чийглэг байдалтай боловч газрын өндөршил, хотгор гүдгэрийн нөхцөлөөс шалтгаалж цаг уурын орон нутгийн ялгаа байнга ажиглагдана. 1-р сарын дундаж температур -22° -(-30°) 7-р сарынх $+13^{\circ}$ -($+15^{\circ}$) жилийн дундаж температур -2.5° -(-6.5°)-ын хооронд хэлбэлзэнэ. Хамгийн их хүйтний хэмжээ $-37-52^{\circ}$, хамгийн их халуун нь $+32^{\circ}$ - $+37^{\circ}$ хүрнэ.

Жилд дунджаар 220-340 мм хурдас унах ба түүний ихэнх нь (80 орчим хувь нь) зуны улиралд оногдоно. Зарим хур бороо ихтэй жил 500-550 мм тунадас унах удаа бий. Цасан бүрхүүлийн зузаан дунджаар 5-10 см, хамгийн их нь 40-50 см хүрнэ. Тус мужийн ихэнх нутагт олон жилийн цэвдэг тогтвортой оршиж, цэвдэгт үеийн зузаан нь хэдэн арван метрээр хэмжигдэнэ.

Хангайн мужийн хөрсний босоо бүсшилийг ерөнхийд нь авч үзвэл уулын ар хажууд доороос дээшээ хар хүрэн, хар шороон, нугат-хар шороон, нугат-ойн бараан, уулын тайгын ширэгт, уулын тайгын цэвдэгт, уулын нугын, уулын-нугат тундрын хөрс дараалан оршино. Гэтэл өвөр хажууд нь ойн хөрсний бүслүүр огт байхгүй, түүний оронд дээшээ их өгсөж тархсан байна. Энэ хажууд доороос дээшээ хүрэн, хар хүрэн, хар шороон, уулын нугат-хээрийн, уулын нугын хөрс тус тус дайралдана.

Хангайн нуруунд уулын нугын харьцангуй нам түвшинд тархах тул энд цэвэр уулын нугын хөрс ноёрхож түүн дээр улалж-бушилзат нуга зонхилно. Ургамалшлын төрх байдлаар маш жигд биш, эзлэх дэвсгэрийн хувьд уулын хээр бусдаас давамгайлах боловч уулсын ар хажууд шинэст, хуш-шинэст ой, тайгын ургамалшил нэлээд дэлгэрч уул нуруудын орой хярд бушилзат, бушилз-улалжит өндөр уулын нуга ба заримдаа нугат-тундр хөгжсөөр байна. Уулсын хоорондох уудам хөндий хотгорт үетэн голлосон хээрийн ургамалшил зонхилох байртай юм. Тойрогт нэг талаас Сибирийн тайгын элементүүд, нөгөө талаас Монголын хээрийн ургамалын төлөөлөгчид, түүнчлэн Дагуурын ургамалууд нэвтэрч байршсанаас уулын хээр, ойн бүслүүр ээлжлэн солигдоно. Тойргийн 124 зүйл

ургамлын 151 зүйл, 1063 зүйл мод, сөөглөг ургамал юм. Чийгсүү 336, уссаг 212, хүйтсэг 2108, чулуусаг 271 зүйл ургамалтай.

Хангайн нурууны байгалийн цогцолборт газар нь Хангайн уулархаг мужийн ландшафт ургамал, амьтны онцлогийг бүрэн төлөөлөөд зогсохгүй аялал жуулчлал явуулах өргөн боломжтой нутаг юм.

Томоохон гол мөрөн, нуур, элсэн манхан бүгд энэ нутагт байх бөгөөд байгалийн бүс бүслүүрүүд нэг дор ялгаран харагдаж байдаг ховор өвөрмөц нутаг билээ.

Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсэг

Энд дархан газрын нэг хэсэг болох Алтайн өвөр говийн “А” хэсэг хамрагдах юм. Энд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эхийн голын услалтын системийг түшиглэн хүнсний ногоо тариалж байгаа 10 орчим өрх айл, хилийн цэргийн харуулуудаас өөр хүмүүс суурьшдаггүй онгон зэлүүд нутаг бөгөөд өвлийн улиралд Баянхонгор, Говь-Алтай аймгийн цөөн тооны малчид Эдрэнгийн нуруу орчимд нутагладаг. Газар нутгийн хэв төрх нь ерөнхийдөө Алтайн салбар уулс болох Эдрэн, Тахийн шар нуруу, Тэнгэр уулын шувтаргын салбар Атас, Цагаан Богдын өндөр, нам уулс, хуурай сайр бүхий өргөн уудам хөндий хоолойнуудаас тогтоно. Хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс 2695 м өндөрт өргөгдсөн Атас уул бөгөөд хамгийн нам газар нь далайн түвшнээс дээш 583 м болно. Энд жинхэнэ Төв Азийн цөл нутгийн голлох амьтан ургамал тааралдана.

Урагшлах тусам хуурайсч Алтайн өвөр говийн өмнөд хэсэг нь хайрган бүрхүүлтэй хэт хуурай цөлд шилждэг. Энд зөвхөн өндөр уулын оройгоор хээржүү цөл тааралддаг байхад аараг толгод, өндөр уулсын ар, өвөр бэл, бэсрэг толгодоор заг – зээргэнэт, шар мод – тэсэгт, хуурай сайр садаргаар харганат эвшил зонхилно. Нам газрууд нь ургамалын нөмрөг бүрдээгүй жинхэнэ хуурай цөлийн бүсэд хамаарагдана. Гандуу хуурай уул нурууд, хөндий хоолойнууд бараг амьдралгүй мэт санагдавч манай дэлхийд ховордсон зарим амьтан ургамалын оршин амьдрах сүүлчийн нутаг билээ. Алс хол оршиж, хүн мал сийрэг байдгийн ачаар Алтайн өвөр говь хүний үйл ажиллагаанд хараахан өртөөгүй байна. Энд 410 зүйлийн ургамал, 49 зүйлийн хөхтөн, 15 зүйлийн хэвлээр явагчид, хоёр нутагтан, 150 гаруй зүйлийн шувууд байдаг. Эдгээрийн дотор говь цөлийн нөхцөлд зохицож үлдсэн баавгайн төрлийн нэг болох 30 орчим мазаалай, 300 орчим хавтгай, Говийн геккон, Тэмээн сүүл могой зэрэг ховордсон амьтад амьдардаг. Тахийн хамгийн сүүлчийн сүрэг нутаглаж байгаад 1960-аад онд устаж үгүй болжээ. Одоо Тахийн хэдэн сүргийг энд нутагшуулж байна.

Улсыг батлан хамгаалах зориулалтын газар

Энэ зориулалтаар аймгийн хэмжээнд 58.4 га газар байдаг нь Өлзийт, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баян-өндөр суманд байрлах хилийн застав, цэргийн ангиудын буудлагын талбайн газарт олгогдсон байх ба зориулалтаараа ашиглагдахаас гадна малын бэлчээрт бас ашиглагдаж байна.

III Бүлэг. Газрын менежментийн бүсүүд түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт

ХАА-н ангиллын газрын менежментийн бүсүүд, түүний нөөц нөхцөлийн төлөвлөлт

Тариалангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Тус аймагт газар тариалан хэдийгээр эдийн засгийн зонхилох салбар болж хөгжиж чадахгүй ч гэсэн нутаг орон, байгаль цаг уурынхаа нөхцөл байдалд тулгуурлан дотоодын хэрэгцээний төмс, хүнсний ногоо, малын тэжээл тариалах үйлдвэрлэлийн бааз суурийг хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Газар тариалангийн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй үр ашигтайгаар эрхлэхэд тухайн бүс нутгийн агро-уур амьсгалын онцлогыг харгалзан үзэх нь тэргүүн зэргийн ач холбогдолтой.

Тус аймаг нь өндөр уул, нуруу, хөндий өргөн уудам тал, говьтой учир агро-уур амьсгалын янз бүрийн нөхцлийг бүрдүүлж агро-уур амьсгалын хэд хэдэн мужид хуваагдана. Эдгээр мужуудын агро-уур амьсгалын голлох үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 30

Агро-уур амьсгалын үзүүлэлт

Муж	чийгийн хангамж	Дулаан хангамж	Цочир хүйтрэлтийн эрч	Хүйтрэлтгүй хугацаа/хон ог/	Гадаргын хэрчигдлын шигүү/км/	Налуужилт/г радус/	Далайн түвшинээс дээшх өндөр/м/
1	2	3	4	5	6	7	8
Чийглэг,нэн сэрүүн	1.0	1000	-3.1	30	0.5	20	2000
чийнлэгдүү сэрүүн	1.1-	1000-	-3.1	30-	0.5-	12-	1500-
Хуурайдуу сэрүүвтэр	2.6- -4.0	1500- -2000	-1.1- -3.0	80- -100	2.0- -6.0	6- -12	800- -1500
Хуурай дулаавтар	4.1- -5.5	2000- -2500	-1.0	100- -120	-6.0	3-6	800- -1500
Хуурай сэрүүвтэр	4.1- -5.5	1500- -2000	-1.0- -3.0	80- -100	0.5- -2.0	12- -20	1700
Нэн хуухай дулаан	5.6	2500	-	-120	6.0	3-6	700- -1400
Нэн хуурай дулаавтар	5.6	2000- -2500	-1.0	100- -120	6.0	3-6	700- -1400

Энэ хүснэгтээс үзэхэд тус аймагт газар тариалангийн үйлдвэрлэлийг үр ашигтай хөгжүүлэхэд дулааны хангамж хүрэлцээтэй боловч хур тунадас бага унадаг, чийгийн хангамж муутай учир тухайн бүс нутгийн онцлогт тохирсон ээлжлэн тариалах систем, хөрс элдэншүүлэх таримал тариалах, услах агротехнологийг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Агро уур амьсгалын нөхцөлд нь үндэслэн тус аймгийн сумдыг газар тариалангийн дараахи бүсүүдэд хуваав.

Хүснэгт 31

Газар тариалангийн агро бүсчлэл

Бүсийн нэр	Дэд бүсийн нэр	Хамрагдах сумд	Тарих таримал
Тархай тариалалт	өндөр уулын чийглэг сэрүүн тариалан	Гурван булаг, Эрдэнэцогт, Заг, Байдраг, Галуут, Баян-Овоо, Баянбулаг	Усалгаагүй нөхцөлд зусах, өвөлжих хөх тариа, овъёос ногоон тэжээл, рапс, олон наст буурцагт урагмал
	Уулын хээрийн гандуу тариалан	Бөмбөгөр, Баянцагаан, Хүрээмарал, Өлзийт, Бууцагаан	усалгаатай, усалгаагүй нөхцөлд зусах хөх тариа, хошуу будаа, судан өвс, ногоон тэжээл хошоон царгас, төмс, хүнсний ногоо
Бүрэн усалгаат бүрдийн тариалалт	Говийн бүсийн бүрэн усалгаатай тариалан	Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баянговь, Шинэжинст, Баян - Өндөр, Баацагаан, Эхийн гол	зөвхөн усалгаатай нөхцөлд төмс, хүнсний ногоо, тэжээлийн таримал жимс, жимсгэнэ болон гуатан

Өндөр уулын чийглэг сэрүүн, тариалант дэд бүсийн аж ахуйнуудын тариалангийн талбай нь далайн түвшинээс дээш 730-1400 м-т өргөгдсөн байх ба 10°с-ээс дээш дулааны нийлбэр 960-1700°с-д хэлбэлздэг, жилд дундажаар 120-230 мм хур тунадас унадаг, хаврын эцсийн хүйтрэлт 6-сарын 2-дахь 10 арав хоногт, намрын эхний хяруу 9-р сарын эцсийн арав хоногт ажиглагддаг. Энэ бүсийн аж ахуйнууд усалгаагүй нөхцөлд зусах, өвөлжих хөх тариа, овъёос ногоон тэжээлд, рапс, олон наст буурцагт ургамлын тэжээлд тариалахад тохиромжтой.

Уулын хээрийн гандуу тариалант бүсэд 10°с –ээс дээш дулааны нийлбэр 1700-2000°С, жилд дундажаар 70-120 орчим мм хур тунадас унадаг. Хүйтрэлтгүй хоногийн тоо 90-10 хоног байна. Хаврын эцсийн хүйтрэлт 5-р сарын 20-орчим, намрын эхний хяруу 9-р сарын 2-х арав хоногт ашигладаг. Энэ бүсийн аж ахуйнууд усалгаатай, усалгаагүй нөхцөлд зусах хөх тариа, хошуу будаа, судан өвс, ногоон тэжээлд хошоон царгас, төмс, хүнсний ногоо тариалахад бүрэн тохиромжтой.

Говийн бүрэн усалгаатай тариалангийн бүсийн 10°С-с дээш дулааны нийлбэр 2000-3100°с –д хүрдэг. жилд дундажаар 52-83 мм хур тунадас унадаг ба үүний 90 орчим хувь нь V-IX сард унадаг. Хаврын эцсийн хүйтрэлт 5-р сарын эхний 10 хоногт, намрын эхний хүйтрэлт 10-сарын дунд үеэр ихэвчлэн болдог. Энэ бүсэд зөвхөн усалгаатай нөхцөлд төмс, хүнсний ногоо, тэжээлийн таримал жимс, жимсгэнэ болон гуатан тариалах нь тохиромжтой.

Ийнхүү хөрс, байгаль, агро цаг уурын нөхцөлд тулгуурлан тус аймгийн тариалангийн газрыг газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл хөгжүүлэх бүс, газар тариаланг мал аж ахуйтай хослон хөгжүүлэх фермерийн аж ахуйн бүс, өрхийн хэрэгцээний тариалан эрхлэх бүс гэсэн 3 том бүлэгт хуваалаа / хүснэгт 32/.

1. Газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл хөгжүүлэх бүс.

Энэ бүс нутаг нь байгаль цаг уурын нөхцөлөөсөө шалтгаалан үр тарианы аж ахуй хөгжүүлэх боломжгүй нь нэгэнт судалгаанаас нотлогдсон учир ерөнхийдээ хуучин

социализмын үед ашиглаж байсан малын тэжээл тариалж байсан талбайнуудыг эргүүлэн ашиглаж төрөлжсөн малын тэжээл үйлдвэрлэх төрөлжсөн үйлдвэрлэлийн бүс нутаг болох юм /Жаргалант, Галуут, Заг, Баянбулаг, Баянцагаан, Богд, Баацагаан г. м/. Энд тариалах талбайн хэмжээний хувьд нэлээд том талбайнууд орох бөгөөд тэжээл үйлдвэрлэлийг дагнасан аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулах болно. Хөрсөн бүрхэвчийн хувьд нимгэн болон дунд зэргийн зузаан элсэнцэр, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй зарим үед гадаргадаа бага зэрэг үйрмэг чулуутай агроүйлдвэрлэлийн шинж чанараар төдийлэн сайнгүй 3,4,5 -р зэргийн хөрс тархах бөгөөд дундаж өндөр болон нам бэсрэг уулсын хоорондох хөндий, жижиг ухаа гүвээт талд байрлах талбайнуудыг хамруулав. Иймд тариалах явцад хөрс боловсруулах, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрсийг салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах агротехникийг чанд мөрдөх хэрэгтэй. Энэ бүс орчмын нутагт ялангуяа тариалалтын хугацаанд мал бэлчээрлүүлэхийг хатуу хориглох бөгөөд хураалтын дараа тодорхой хугацаанд зохицуулалтайгаар түр хугацаагаар мал бэлчээрлүүлж болно. Удаан хугацаагаар мал бэлчээх нь талбайн хөрсний бүтэц малын хөлөөр эвдэгдэж улмаар салхинд амархан хийсэх, элэгдэж эвдрэх үйл явцыг түргэснэ.

2. Газар тариаланг мал аж ахуйтай хослон хөгжүүлэх бүс.

А. Фермерийн аж ахуйн бүс. Уг бүс нь төв суурин газрын хүн амыг мал болон газар тариалангийн эцсийн бүтээгдэхүүнээр хангах зорилготой байгуулагдах учир хүн амын суурьшил ихтэй Баянхонгор хот дагуух Эрдэнэцогт, Өлзийт, Баян-Овоо цаашилбал Бөмбөгөр, Жинст мэтийн сумдаар хөгжихээр төлөвлөлөө. Энэ бүсэд уулын нарийн ам хөндий, булаг шанд, гол горхины хөлд байрлах жижгээр эсгэсэн харьцангуй чийгийн хангамж сайтай талбайнуудыг газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж болох бөгөөд түүнтэй зэрэгцэн цөөн тооны мал аж ахуйг айл өрх дангаар буюу эсвэл хэд хэдээрээ хоршсон байдлаар хослон эрхэлж болно. Талбайн хэмжээний хувьд төрөлжсөн үйлдвэрлэлийн бүсийг бодвол багавтар байна. Усалгаатай далд хөрсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал эмийн ургамал, малын тэжээлийн даршны ургамал тариалж болно. Гэхдээ тариалалтыг дэмжсэн тодорхой эзэмшилтэй төрөлжсөн фермерийн /сүүний г.м/ аж ахуйнуудыг ч ойр орчимдоо байршуулахад болохгүй зүйлгүй. Уг аж ахуй нь хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн фермерийн аж ахуй байх учир тариалангийн үйл ажиллагаанд саад учруулахгүй харин бие биенээ дэмжсэн хэрэгцээтэй үед бүтээгдэхүүнээ солилцох хэмжээнд зохион байгуулагдсан байх шаардлагатай. Тухайлбал мал аж ахуйн төрөлжсөн фермерүүд малын тэжээлээ тариалах, тариалангийнхан бүтээгдэхүүнээ солилцох, бууц сангасаар талбайгаа бордох г.м. Уг бүс нь төв суурин газар дэд бүтэц зам харилцаагаа даган хөгжих учир Өлзийт, Баян-Овоо сумдын бүтээгдэхүүнийг аймгийн төв руу, Эрдэнэцогт сумынхыг Шаргалжуут рашаан сувилал болон аймгийн төв рүү зөөвөрлөхөөр тус тус төлөвлөлөө.

Б. Өрхийн тариалангийн бүс.

Өрхийн тариалангийн бүс нь сум аймгийн хэмжээнд тариалалт явуулах боломжтой төв суурин газруудын ойролцоо хэсэгчилэн төлөвлөгдсөн бөгөөд хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах зорилгоор суурьшил даган хөгжихөөр төлөвлөгдсөн юм. Энэ бүс нутаг нь уулын болон голын нуга дагасан ихэвчлэн усалгаатай, үржил шим бүхий хөрстэй газрууд байх бөгөөд энд агроүйлдвэрлэлийн 4,5 зэргийн хөрс давамгайлна. Энэ бүс өрхийн хэрэгцээний ил болон далд хөрсний төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалахад ашиглагдана. Цөөн тооны мал бүхий иргэд тусгай зохицуулалттайгаар байх боломжтой. Нэгэнт хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах зорилгоор суурьшил даган хөгждөг зүй тогтолтой учир сумдын төв, амралт сувиллын газар, баг бригадын төвийн ойролцоох боломжтой газруудыг сум тус бүрт сонголоо / хүснэгт 32, зураг/.

3. Атаршсан газар. Одоогийн байдлаар тус аймагт 844 га атаршсан газар /хүснэгт 32, хавсралт 2 / байх бөгөөд энэ нь 2006 оны газрын тоо бүртгэлийн материалаас 5 га талбайгаар дутаж байна. Атаршсан талбайн хэмжээгээр Богд, Заг, Баянцагаан, Баянлиг зэрэг сумд дээгүүр байранд орох бөгөөд Богд сумын нутагт байрлах 399 га талбайд гэхэд хуучин услалтын систем ашиглан эмийн ургамал тариалж байсан. Баянлиг сумын 92 га мөн услалтын системтэй байсан бөгөөд малын тэжээл тариалж байсан гэх мэт бүгд эргэлтэнд байж байгаад 1990-ээд оны үеээс атаршиж ашиглагдахаа больжээ. Эдгээр талбайнууд нь бүгд хуучин усалгаатай болон усалгаагүй нөхцөлд малын тэжээл тариалж байсан талбайнууд бөгөөд усалгааны асуудлыг шийдвэл эргүүлэн тариаланд ашиглах боломжтой.

4. Төлөвлөсөн газар. Тус аймгийн хэмжээнд шинээр ашиглаж болох атар газрын судалгааг 1970 оны үед ГЗБХЗТИнститутээс хийсэн атар сонгох болон 1980 оны үед хийгдсэн хөрс судалгааны тайлбар бичиг, 2005 онд Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ажлын хүрээнд хийсэн хээрийн судалгаанд үндэслэн сум тус бүрт хэд хэдэн газрыг ирүүлж нийт **31406 га** газрыг хамрууллаа /хүснэгт 32, 33/. Эдгээр талбай нь энд тэнд хэсэгчилсэн байдлаар орших бөгөөд ихэвчлэн хуучин ашиглаж байсан талбайнууд юм. Үүний 4118га нь Атар газар илрүүлэх судалгаагаар тогтоогдсон одоогийн байдлаар бэлчээрт ашиглагдаж байгаа судлагдсан атар /шинээр хагалах/, 4549 га нь услалтын систем барьж тариаланд ашиглах бэлчээр, бусад нь хуучин ашиглаж байгаад хаясан талбайнууд юм. Хуучин хаягдсан талбайнуудын 1549 га нь 1963 онд атаршуулан орхисон талбайнууд бөгөөд одоогийн байдлаар эдгэрч бэлчээрээс ялгарахгүй болсон байна. Түүний 655 га нь Галуут суманд / Бэрхийн хоолой /, 402 га нь Баян-Овоо суманд /Шар бүрдийн хөндий/, 472 га Өлзийт суманд /Номгоны овоо/, 20 га нь Бууцагаанд, шинээр атаршуулсан 471 га-н 187 га нь Заг суманд, 22 га нь Эрдэнэцогт суманд, 121 га нь Жаргалант суманд , 7 га нь Баацагаан, 134 га нь Баян-Овоо суманд тус тус оршиж байна. Эдгээрээс гадна үлдсэн талбайнуудын ихэнхийг Байдрагийн САА байх үед малын тэжээл тарьж байгаад хаягдсан талбайнууд эзэлнэ. Шинээр эзэмших атар газрын хэмжээг газрын фондын бүсээр авч үзвэл Хангайн нурууны бүсэд отрын 15.5 %, хуурай хээрийн бүсэд 8.8%, Говийн бүсийн аж ахуйнуудад 75.4% ноогдож байна.

Эдгээр шинээр эзэмших талбайнуудын ихэнхийг малын ногоон тэжээл нэг ба олон наст ургамал тариалахад ашиглах бөгөөд зарим нэгийг таримал хадлан бий болгоход ашиглаж болох юм. Атаржсан газрыг тариаланд ашиглахдаа атар газар эзэмших технологийг мөрдлөг болгоно. Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан 2010 он гэхэд нийтдээ талбайн хэмжээг 10000 га, 2015он гэхэд 20 000га газрыг тариаланд эзэмшихээр төлөвлөлтөнд тусгав. Ингэснээс тус аймгийн тариалангийн талбайн хэмжээ 2020 он гэхэд ойролцоогоор 30 000 га-д хүрэх юм. Гэхдээ эхний ээлжинд 1963 онд хаягдсан 1549 га талбайг болон Байдраг САА аж ахуй байхад ашиглаж байсан хөрсний эвдрэлд ороогүй болон сул эвдрэлд орсон харьцангуй сайн талбайнуудыг авч ашиглах хэрэгтэй. Мөн түүнчлэн усалгаа нэвтрүүлж чадвал усалгаатай тариалах фондын талбайнуудаас авч ашиглана.

Хүснэгт 33

Төлөвлөсөн тариалангийн газрын тодорхойлолт

Д/д	Сумдын нэрс	Талбай, га	Агроүйлдвэрлэлийн групп			Тариалангийн төрөл		үүнээс УТЭБ
			III	IV	V	ТҮ	Фермер	
1	Баацагаан	6038.1	3038	300.1		5538.1	500	
2	Баянбулаг	153.7	53.7	100		153.7		
3	Баянговь	391.8	200	140.8	51	391.8		
4	Баянлиг	15.9	59	70	30	159		

5	Баян-Овоо	239.3	130	109.3			239.3	
6	Баян-Өндөр	28	28				28	
7	Баянхонгор							
8	Баянцагаан	100.7	50	50.7		100.7		
9	Богд	4718.4	2718.4	1500	500	4718.4		
10	Бөмбөгөр	482.1	482.1			2821.1	200	
11	Бууцагаан	306.7	206.7	100		206.7	100	
12	Галуут	3494.3	2494.3	1000		3494.3		
13	Гурванбулаг	112.6	112.6			112.6		
14	Жаргалант	9566.1	6566.1	3000		9566.1		
15	Жинст	1194.9	94.0	100.9	100	994.9	200	
16	Заг	2890.5	2800	90.5		2890.5		
17	Өлзийт	957.7	457	500.7			957.7	
18	Хүрээмарал	57	57				57	
19	Шинэжинст	10.9		10.9		109		
20	Эрдэнэцогт	647.7	447	200.7			647.7	
	Дүн	31406	23450.4 /74.6%	7274.6 /23.2%	681/2. 2.2%	28476	2929.7	

Жич: УТЭБ-усалгаатай тариалан эрхлэх боломж

ТҮ- төрөлжсөн үйлдвэрлэл

Тариаланд шинээр эзэмших газрын 74.6% нь буюу 23450 га нь хөрсний үржил шимийн хувьд агроүйлдвэрлэлийн III,23.2? буюу 7274.6га нь агроүйлдвэрлэлийн IV–р зэргийн талбайнууд байна. Тариалангийн талбайн байршилтын байршилтийн хувьд Хангайн нурууны болон хуурай хээрийн бүсийн сумдад газар тариалангийн үйлдвэрлэл түлхүү хөгжсөн байхад говийн бүсийн сумдын ХАА-н эдэлбэр газрын бүтцэд тариалангийн талбайн эзлэх хувь бага байна. Эдгээр сумдад хэдийгээр тариалангийн талбайг өргөтгөх боломж байгаа боловч газар тариалангийн үйлдвэрлэлд нь байгаль цаг уурын эрхшээлд байгаа одоогийн нөхцөлд найдвартай ургац авч чадахгүй байгаа учраас атар газрыг тариаланд зөвхөн улсын хөрөнгөөр усалалтын систем барих замаар эзэмшинэ. Иймд 2010-2015 он гэхэд нийт эзэмших газрын 4200 га нь усалгаатай байх юм.

Тус аймгийн тариалангийн газрыг хөрсний чадавхи агроүйлдвэрлэлийн шинж чанараар нь хувааж үзвэл дараахи байдалтай байна.

Хүснэгт 34

Тариалангийн газрын хөрсний чадавхи, агро үйлдвэрлэлийн шинж чанар.

Д/д	Тариалангийн төрөл	Нийт талбай, га	Агроүйлдвэрлэлийн шинж чанар		
			Агро групп III	Агро IV групп	Агро V групп
1	Төрөлжсөн үйлдвэрлэл явуулах тариалан	858	300	458	100
2	Фермерийн аж ахуйн хэмжээнд явуулах тариалан	635.1	535.1	100	
3	Өрхийн тариалан	199.8	149.5	50	
4	үүнээс усалгаатай тариалан	303.2	203.2	100	
5	Эргэлтэнд байгаа тариалан /нийт дүнгээрээ/	848.6	648	200.6	
6	Атаршсан тариалан	844.3	336.9	407.4	100
7	Төлөвлөсөн	31406.4	23450.4	7274.6	681

Хүснэгт 34-аас харахад эргэлтэнд байгаа тариалангийн газрын 76.4 % нь агро III групп, 23.6 % нь агро IV группын хөрстэй байна. Өрхийн тариалан болон фермерийн үйлдвэрлэлд ихэвчлэн Агро III ба IV группын хөрс ашиглагдаж байгаа нь харьцангуй бүс нутагтаа сайн хөрс юм. Ер нь дээрхээс харахад Баянхонгор аймаг байгаль цаг уур, хөрсөн бүрхэвчийн хувьд хөрс муутай газар тариалан эрхлэхэд хязгаарлагдмал учир тухайн бүс нутагт тохирсон зөв менежментийн бодлого, нэмэлт арчилгаа тордолгоо явуулах шаардлагатай.

3.2.1 Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх төлөвлөсөн асуудлууд

Усалгаатай тариалан. Эх газрын эрс тэс уур амьсгалтай манай орны нөхцөлд ялангуяа баруун болон говийн районд усалгаатай тариаланг бүхий л талаар хөгжүүлэх хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, малын тэжээлийн бат бэх ,найдвартай баазыг бий болгох явдал аль ч хөгжлийн үед чухлаар шаардагдаж байна. Баянхонгор аймгийн дийлэнх нутаг дэвсгэр говийн бүсийн хойт хэсэгт багтах бөгөөд энд Байдраг, Түйн гол зэрэг хангайн нурууны өмнөд хажуугаас эх аван урсаж нууруудын хөндийн Бөөнцагаан. Орог гэх мэт томоохон нуурыг тэжээдэг жижиг голууд байдаг боловч гадаргын усны нөөцийн хувьд хомс байгаа нь цаашид усалгаатай тариалангийн хөгжлийг хязгаарлах гол хүчин зүйл болж байна. Гэвч Баянхонгор аймагт 1971 оноос эхлэн услалтын систем эрчимтэй баригдаж эхэлснээр 1531 га талбайд 14 инженерийн хийцтэй услалтын систем улсын хөрөнгөөр баригдаж, малын тэжээл, үр тариа, төмс хүнсний ногоо голлон тариалж тодорхой хэмжээгээр орон нутгийн хэрэгцээг хангаж байв /хүснэгт 35/.

Хүснэгт 35

Баянхонгор аймгийн инженерийн хийцтэй услалтын системийн жагсаалт

Сумын нэр	Услалтын системийн нэр	Ашиглал танд орсон он	Анхны хүчин чадал /га/	Өртөг /мян.т/	Бороожуулах техник	
					Марк	Тоо Хэмжээ
Баацагаан	Хөх эрэг	1975	53	334.1	МА-200	2
Баацагаан	Хэрсэн	1977	200	957.4	МА-200	5
Баянговь	Цагаан гол	1978	109	484.3	МА-200	2
Баянлиг	Лигийн гол	1976	80	744.4	МА-200	2
Баян-Овоо	Нарийн гол	1973	50	149.6	МА-200	2
Баянцагаан	Цагдуултай	1983	150	2079.3	ДДН-100	2
Бууцагаан	Өлзийт	1975	76	415.3	МА-200	2
Бууцагаан	Баянгол	1977	28	209.8	МА-200	1
Галуут	Талын толгой	1983	142	1026.4	ДКШ-64	1
Номгон хоршоолол	Бумбатын ам	1980	96	1200.0	ДЛА-100м	1
Номгон хоршоолол	Шаргалжуут	1973	80	181.2	МА-200	2
Шинэжинст	Эхийн гол	1971	32	639.2	МА-200	1
Богд	Зүүн гол	1986	350	12200.0	ДДН-100	2
Өлзийт	Бор балгас	1986	85	2012.0	ДДА-100МА	1
Бүгд			1531	22687.5		25

Дээрх инженерийн хийцтэй нийт услалтын систем нь ЗХУ-ын болон БНУАУ-д үйлдвэрлэсэн өндөр хүчин чадалтай бороожуулах төхөөрөмжөөр тоноглогдсон байв. Энд нийт 25 бороожуулах төхөөрөмж, 8 шахуурга станц ажиллаж байсаны 67.8%-ийг МА-200 маркийн бороожуулах төхөөрөмж, 25%-г ДДН маркийнх, 9.8%-ийг өргөн авцын Волжанка ДКШ-64 маркийнх эзэлж байв.

МА-200 маркийн БНУАУ-д үйлдвэрлэдэг бороожуулах машиныг үйлдвэрлэхээ больсонтой холбогдуулаад энэ төхөөрөмжөөр тоноглогдсон услалтын системийг /нийт 707 га талбай бүхий/ ойрын хугацаанд шинэчлэх шаардлага гарч байна.

ХААҮЯ-ны мэдээгээр Баянхонгор аймгийн зарим сумын иргэд, өөрийн хүч хөрөнгөөр ил задгай усны эх үүсвэрүүдийг түшиглүүлэн 340 га талбайд энгийн усалгаа явуулж хэрэгцээгээ бага хэмжээгээр хангаж байна. Тэгэхдээ мэргэжлийг байгууллагатай тохирсон энгийн усалгаа явуулах талбай болон усны эх булгийн судалгаа явуулж, зураг төсөл зохиолгон түүний үндсэн дээр барьж байгуулан ашиглах нь байгалийн нөөц баялагийн нэг болох усны хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдвэрлэх юм.

Манай оронд усалгаатай тариаланг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх зорилгоор 1981 оноос УХЭШ институт усалгаанд тохиромжтой талбайн фондын судалгааны экспедицийг зохион байгуулан ажиллуулсан байна.

Өнгөрсөн хугацаанд тус экспедици орон нутгийн байгууллагын санал хүсэлтын дагуу Баянхонгор аймгийн нутагт нийт 31212 га талбайд урьдчилсан судалгаа явуулж, усан тариалахад тохиромжтой **20884 га** талбайг улсын усалгаанд тохиромжтой талбайн фондод бүртгэжээ. Усалгаатай талбайн судалгааг аймгийн нийт нутгаар явуулаагүй бөгөөд одоо фондын материалыг байгуулах услалтын системийг сонгон төлөвлөж бариулсан юм. Инженерийн хийцтэй услалтын системийн хүчин чадлын ашиглалтын түвшинг жил жилээр авч үзэхэд 1990 оны байдлаар аймгийн хэмжээгээр 1082 га талбайг усалж тариалсан нь нийт услалтын системийн хүчин чадлын 70.6%-тай тэнцэж байв. Тэгвэл 2005 онд энэ үзүүлэлт 6.5% болтлоо буурчээ. / хүснэгт 36/.

Хүснэгт 36

Усалгаатай талбайн ашиглалтын түвшин

Услалтын системийн нэр	Ашиглал танд орсон он	Анхны хүчин чадал /га/	1990 онд байсан хүчин чадал/га/	2005 онд байсан хүчин чадал/га/	Ашиглалтын өнөөгийн түвшин%/
Хөх эрэг	1972	53	53.0	5.5	10.4
Хэрсэн	1977	200	123.3	-	-
Цагаан гол	1972	100	104.7	10	10.0
Лигийн гол	1972	80	80.0	20	25.0
Нарийн гол	1973	50	50.0	20	40.0
Цагдуултай	1983	150	100.0	-	-
Өлзийт	1973	76	76.0	10	13.2
Баянгол	1977	28	28.0	1	3.5
Талын толгой	1983	142	130.0	-	
Бумбатын ам	1979	96	91.7	10	10.4
Шаргалжуут	1972	80	80.0	-	-
Бор балгас	1986	85	85.0	20	23.5

Эхийн гол	1971	32	20.0	3.6	11.2
Зүүн гол	1986	350	60.0	-	-
Бүгд		1531	1081.7	100.1	6.5

Хүснэгтээс үзэхэд Баянлиг сумын Лиг голын, Баян-овоо сумын Нарийн гол, Өлзийт сумын Бор балгасын услалтын системийн хүчин чадлыг 23-40%тай ашиглаж байна. Гэвч эдгээрийн инженерийн хийцийн барилга байгууламж бараг үгүй болж эвдэрч тоногдсон бөгөөд ихэвчлэн энгийн аргаар усалж байна. Усалгаатай талбайн ашиглалтын түвшин ийм доогуур байгаагийн гол шалтгаан нь ажлын зохион байгуулалт муу, орон нутгийн зарим байгууллага энэ ажилд анхаарал тавьдаггүй, эзэнгүй орхисноос эвдэрч тоногдон ажиллагаагүй болсноос гадна байгалийн хүчин зүйлс гол ус хатаж ширгэсэн ус хүрэлцээгүй болсон зэрэг олон шалтгаан байна.

Мөн зах зээлийн үед олонхи услалтын системийн талбай гидротехникийн барилга байгууламж эвдэрсэн, лайд дарагдсан, хөрс давсжиж намагжсан зэрэг шалтгаанаас ашиглагдахгүй болжээ. Жишээлбэл: Цагаанголын услалтын системийн 33 га талбайн хөрс давсжсан, түүнчлэн тариалангийн талбайг гадны үйлчлэлээс хамгаалах арга хэмжээ аваагүй, ойн зурвас огт байгуулаагүй тохиолдол нөлөөлжээ. Иймд дээрх услалтын системийн барилга, тоног төхөөрөмжийг үндсээр нь өөрчлөх шаардлагатай болжээ. Мөн түүнчлэн энгийн аргаар услаж байгаа талбайн 14.8% говийн, 65.7% тал хээрийн, 19.4% өндөр уулын бүсэнд хамаарч байгаас үзэхэд эхний ээлжинд байгаль цаг уурын таатай нөхцөл, дулааны температур бүрдсэн тал хээр, говийн бүсийн услалтын системийг ажилд оруулах шаардлагатай. Инженерийн хийцтэй услалтын системийг ажилд оруулснаар нийт талбайн 70%-д малын тэжээл, тэжээлийн үр тариа, үлдэх 30%-д төмс, хүнсний ногоо, эмийн ургамал тариалах боломжтой болох бөгөөд ингэснээр 1 га тутмаас авах ургацын хэмжээг төмс хүсний ногоо 150-200 цн, таримал тэжээл 30-40 цн хүргэх боломж бүрдэнэ.

Судлагаанаас үзэхэд Баянхонгор аймгийн услалтын системд тариалж байсан тарималуудаас төсөлд заасан хэмжээний ургацыг тэжээлийн нэг наст ургамлаас бусад ургамлуудаас авч чаддаггүй байсан ба ихэвчлэн улсын дунджаас доогуур ургац авдаг байсан байна. Иймд цаашид түүний үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд

- усалгаатай тариалангийн технологи шат дамжлага бүрийг нарийн чанд мөрдөх
- сайн чанарын цэвэршилт, соёололт сайтай, хурдан болцтой, өндөр ургацтай үр хэрэглэх
- эрдэс шим бордоог хөрсний үржил шимийн байдал, тариалсан тарималын онцлогтой уялдуулж нарийн тооцож хэрэглэх
- харьцангуй бага зардал шаардах, өндөр ургац авах чадвартай тарималуудын хувийн жинг нэмэгдүүлэх,, талбайг өнжөөхгүй байх, сэлгээнд үет ба буурцагт олон наст ургамалыг оруулах.
- хөрс боловсруулах, тарих, услах арга технологи, норм, хугацааг нарийн мөрдөх
- хөрс хамгаалах системийг нэвтрүүлэх
- аймгийн төвд ойрхон услалтын системийг сонгон авч хүчин чадлыг бүрэн дагнуулан ажиллуулах хэрэгтэй.
- усалгаатай тариалангийн хөдөлмөрийг хөнгөвчилж механикжуулах, машин техникээр бүрэн хангах
- мэргэжилийн боловсон хүчнийг бэлдэх ажлуулах, байнгын ажиллагаатай аж ахуйн нэгж салбарыг бий болгох
- нэгэнт баригдсан услалтын системийн барилга байгууламж тоног төхөөрөмж, суваг шуудуу, усалгаатай ашиглах талбайг гэрээ хэлцэл акт баримтаар баталгаажуулан паспорт хөтөлж хүлээлгэн өгөх

Усалгаатай тариаланг цаашид хөгжүүлэхийн тулд орон нутгийн нөөц бололцоог ашиглаж энгийн аргаар хадлан, тариалангийн талбайг услах талаар санаачлага гаргах, санаачлага гарган ажиллаж байгаа иргэд, аж ахуйн байгууллагыг аймгаас дэмжиж техник, мэргэжлийн туслалцаа үзүүлж услах ажлыг өрөгжүүлэх, энгийн усалгааг механикжуулах, гар ажиллагааг хөнгөвчлөх, техник хэрэгслээр хангах арга хэмжээ авбал зохино.

Энэ зорилгоор одоогийн энгийн аргаар усалж байгаа талбайд аймгийн үзлэг явуулж талбай нэг бүрийг паспортлож аймгийн бүртгэл дугаартай богохын хамт талбайг хагалж боловсруулж тэгшэлж цэвэрлэн тэлж хашиж хамгаалан инженерийн системд ойртуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай юм. Ингэснээрээ энгийн аргаар усалж байгаа нэгж талбайгаас авах ургацыг ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлэх боломжтой болно.

Усалгаатай тариалангийн цаашдын хөгжлийг хязгаарлах үндсэн хүчин зүйлд Баянхонгор аймгийн хувьд байгаль-цаг уур амьсгалын нөхцөл, усны нөөц зүй ёсоор орно.

Баянхонгор аймгийн нутаг усны аж ахуйн 6 нэгжид бүрэн хамаарна. Говийн бүсийн хойт хэсгийн жижиг голуудын сав нутгийн усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах схемээс үзэхэд зөвхөн Байдраг голын савд услан тариалах боломжтой 331.8 мян.га талбай байна. Түйн голын сав газарт усалгаатай тариалан эрхэлж болох 40.5 мян.га талбай байна. Зөвхөн энэ хоёр голын савд усалгаанд тохиромжтой 372.3 мян.га талбай байгааг харуулж байна.

Сав нутгийн схемийн дүгнэснээр усалгаатай тариалангийн хэтийн хөгжлийн чиглэл нь Байдраг голын усны нөөцийг зохицуулах арга хэмжээ авч Бөөнцагаан нуурын усны төвшинг доошлуулахгүй байх арга хэмжээ авах шаардлагатай болно. Хүснэгт 37-д ойрын болон 2016 оноос хойш барихаар төлөвлөж байгаа усалгаатай талбайн /инженерийн/ өсөлт, шаардагдах хөрөнгө оруулалтыг харуулав.

Хүснэгт 37

Төлөвлөж байгаа инженерийн усалгаатай талбайн өсөлт,
шаардагдах хөрөнгө

Сумын нэр	Ойрын ирээдүйд		Дунд үед		Алс хэт		Бүгд усалгаатай талбай
	Хуучин у/с-н х.чадал	Өртөг мян.төг	Шинээр баригдах у/с-н х.чадал	Өртөг мян.төг	Шинээр Баригдах У/с х.чадал	өртөг мян.төг	
Галуут	142	1026.4	-	-	51	816	198
Жаргалант	-	-	-	-	100	1600.0	100
Баян-Овоо	50	149.6	100	1600.0			150
Өлзийт	85	2012.0	85	2012.0	-	-	85
Бөмбөгөр	-	-	-	-	200	3200.0	200
Жинст					2000	32000.0	2000
Богд	350	12200.0	1000	14000.0	3000	48000.0	4350
Баянлиг	80	744.4	-	-	-	-	80
Баянговь	109	484.3	200	2800.0	-	-	309
Шинэжинст	32	693.2	-	-	-	-	32
Баянцагаан	150	2079.5	-	-	-	-	150
Баацагаан	253	1291.5	3000	42000.0	-	-	3253

Бууцагаан	104	625.5			100	1600.0	204
Номгон хор- Шоолол	176	1381.2	-	-	-	-	176
Дүн	1531	22687.5	4200	58800.0	5551	88816.0	11282

Алс хэтэд нийт усалгаатай талбай /инженерийн /11282 га-д хүрэх юм. Энэ үеэс Баянхонгор аймаг шаардагдах малын тэжээлийн дийлэнхи хувийг өөрийн нутагт үйлдвэрлэх юм. Ойрын ирээдүйд хуучин байсан усалтын системийг засварлаж шинэчлэн ажилд оруулах бөгөөд одоогоор эвдэрч тоногдон юу ч үгүй болсон учир шинээр барих усалтын системийн хэмжээнд зардал мөнгийг тооцов. Дунд үед шинээр 4200 га талбай бүхий усалтын систем барихаар төлөвлөж байгаа бөгөөд үүнд шаардагдах хөрөнгө оруулалт ойролцоогоор 58800 сая төгрөг болох юм. Алс хэтэд шинээр 5551 га талбайг услах ба 88816 сая төгрөгийн хөрөнгө оруулах юм.

Инженерийн хийцтэй усалтын систем барьж байгуулан ашиглахын зэрэгцээ энгийн аргаар услаж ашиглах талбайн хэмжээ цаашид өсөх болно. Хэрэв 1990 онд аймгийн хэмжээгээр 828 га энгийн усалгаатай талбай байсан бол ирээдүйд шинээр 66 га , алс ирээдүйд шинээр 398 га талбайгаар тус тус нэмэгдэх ба 2015 оны эцэст энгийн усалгаатай талбай 1292 га-д хүрэх боломжтой /хүснэгт 38/.

2015-оны эцэст нийт усалгаатай талбай 12574 га болно. Энэ талбайгаас 160000 сая орчим төгрөгийн ХАА-н бүтээгдхүүн авах боломж бүрдэнэ.

Усалгаатай тариалангийн ус хэрэглээ 1990 онд 7.1 сая м/куб байсан бол ирээдүйд 23.8 алс хэтэд 100 орчим сая м/куб хүрнэ.

Баянхонгор аймгийн гадаргын усны нөөцийн ашиглалтын түвшин энэ тохиолдолд 60 орчим хувьд хүрэх юм.

Хүснэгт 38

Төлөвлөж байгаа энгийн аргаар
усалгаатай тариалах талбайн өсөлт /га/

№	Сум аж ахуйн Нэр	Энгийн аргаар услаж, ашиглах талбай		
		1990 оны байдлаар	Ойрын ирээдүйд	Алс хэтэд
1	Галуут	-	-	-
2	Эрдэнэцогт	72	72	110
3	Гурванбулаг	92	92	92
4	Жаргалант	27	27	27
5	Баян-Овоо	-	-	-
6	Өлзийт	54	54	54
7	Бөмбөгөр	264	264	501
8	Хүрээмарал	3	3	3
9	Баянбулаг	35	35	39
10	Заг	172	187	217
11	Баянхонгор хот	-	-	-
12	Жинст	4	4	
13	Богд	-	-	-
14	Баянлиг	37	67	67
15	Баянговь	7	7	30
16	Шинэжинст	4	4	4
17	Баян-Өндөр	4	4	4
18	Баянцагаан	2	2	2
19	Баацагаан	28	28	28

20	Бууцагаан	23	44	64
21	Номгон хоршоолол	-	-	-
	Дүн	828	894	1292

Цаашид инженерийн хийцтэй том системүүдийг Баацагаан сумын Хэрсэнгийн талд /3000га/, Богд сумын Түйн голд /3000/ Баянговь сумын Хургалжийн талд /200 га/ шинээр барих хэрэгтэй. 2015 он хүртэл шинээр эзэмших нийт отрын 4735 га нь Хангайн нурууны бүсэд, 552 га нь хуурай хээрийн бүсэд, 4522 га нь говийн бүсийн аж ахуйнуудад байна. 2015 он хүртэл тариаланд шинээр эзэмших газрыг тогтоохдоо орон нутгийн саналыг үндэслэн малын бэлчээрийг гол нутгууд, хадлан бэлтгэдэг газруудыг тариаланд эзэмшихгүй байх зарчмыг баримтлав.

2015 оноос хойшхи хугацаанд усалгаатай эзэмших атар газрын 614 га нь судлагдсан атар газар, 5151 га нь атарт сонгогдоогүй бэлчээрээс инженерийн хийцтэй услалтын систем барьж эзэмших, 338 га энгийн аргаар услаж эзэмших газар байна. Алс хэтийн төлвөөр Богд, Жинст сумын нутаг Түйн голын орчимд шинээр усалгаатай газар тариалан бүхий тэжээлийн аж ахуй байх хэмжээнд атар эзэмшихээр төлөвлөлтөнд тусгаж байна.

Ер нь тус аймгийн хувьд усалгаатай тариаланг хөгжүүлэхийн тулд:

а. Юуны өмнө хуучин услалтын системтэй байсан газруудын услалтын системийг сэргээн засварлаж ажилд оруулах, эхний ээлжинд Өлзийтийн Бор балгас, Баян-Овоо сумын Хоолтын гэх мэт.

б. Өөрсдийн хүч хөрөнгөөр ажлуулж болох жижиг оврын услалтын системийг дэмжин ажлуулах

в. Энгийн аргаар суваг шуудуу татаж усалгааны асуудлыг хялбар аргаар шийдэх

г. Улсын болон гадны тусламжаар томоохон голуудын сав газар төрөлжсөн үйлдвэрлэл явуулах том услалтын систем байгуулах хэрэгтэй байна.

Газар тариалан эрхлэх давуу талууд:

1. Социализмын үед улсын хөрөнгөөр баригдсан томоохон хүчин чадал бүхий 14 инженерийн хийцийн услалтын системтэй байсан
4. Усалгаатай тариалан эрхлэх талбайн судалгаа сайн хийгдсэн учир усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой
2. Өөрийн хэрэгцээгээ тодорхой хэмжээнд орон нутгаасаа хангах боломжтой
3. Тэжээлийн болон жимс жимсгэний аж ахуй хөгжүүлэх суурь баазтай.

Газар тариалан эрхлэх сул талууд:

5. Газар тариалангийн үйлдвэрлэл явуулах нэгдсэн бодлого дутмаг
6. Байгаль цаг уурын нөхцөл муу, хөрс, байгалийн усан хангамж гэх мэт
7. Услалтын систем эвдэрч тоногдон ажиллахаа больсон
8. Тариаланд эргүүлэн ашиглах боломжтой талбайнуудыг олноор атаршуулсан, өнжөөсөн, тэдгээр талбайн эзлэх хувь өндөр
9. Аж ахуйн нэгжүүд тарж бутарсан туршилга багатай иргэд газар эзэмших болсон, усалгаатай тариалан эрхлэх туршлага хомс
10. ХАА-н техник хуучирч муудсан, сайн чанарын үр, бордоо хэрэглэх явдал дутмаг
11. Төвөөс алслагдмал оршдог, бүтээгдэхүүнээ борлуулах гарц муутай

Жимс, жимсгэнэ

Одоогийн байдлаар тус аймагт Шинэжинст, Бууцагаан суманд 3.3 га талбайд чацаргана, үхрийн нүд тариалж байна.

Төлөвлөлтөөр Шинэжинст сумын Эхийн голын жимс жимсгэнийг ЭШС, Түйн голд баригдах услалтын системийг түшиглүүлэн 468 га талбайд жимс жимсгэний талбай бий болгохоор төлөвлөж байна.

Жимс жимсгэний талбайг сонгохдоо дараах шаардлагуудыг баримтална.

- ✓ Жимс жимсгэний талбай хөрсний ул, ус нэвтрүүлэхдээ сайн, усны түвшин 1.5-2 м-с ойргүй байх
- ✓ Талбайн газрын гадаргуу 5°-8°-ээс хэтрэхгүй налуутай, тэгшивтэр байх,
- ✓ Жимс жимсгэний талбай нь хүн амын суурьшлын төв суурин газарт аль болохоор ойрхон, зам харилцаа сайтай байх

Цаашид өмнө ажиллаж байсан Эхийн голын ЭШС, Говийн ашигт ургамал тарималжуулах ЭШС зэрэг байгууллагуудыг сэргээн байгуулж модлог болон бутлаг ургамалын үр суулгац бэлтгэх чиглэлээр ажиллуулах нь зүйтэй.

3.2..2. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх талаар гаргасан

зөвлөмж

1. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх байгаль-цаг уур, нийгэм-эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд тохирсон нэгдсэн бодлого явуулах. Үүнд хойд талын Эрдэнэцогт, Баян-Овоо, Өлзийт сумдад фермерийн аж ахуй хөгжүүлж аймгийн төв болон Шаргалжуутын амралт сувиллын газрыг бүтээгдэхүүнээр хангах, хойд талын болон говийн сумдыг малын тэжээлээр хангах зорилгоор тэжээлийн аж ахуйг Жаргалант суманд хуучин аж ахуй байсан бааз суурийг түшиглүүлэн байгуулах, Үүнд атаршуулж орхисон тариалангийн талбайг эргэлтэнд оруулах замаар малын тэжээл овёос, арвайг өргөнөөр тариалж тэжээлийн үйлдвэрийг түүхий эдээр хангах тухайлбал төрөлжсөн үйлдвэрлэлийн чиглэлээр хөгжүүлэх, урд талын говийн сумдад өөрийн хэрэгцээг хангах өрхийн тариаланг хөгжүүлэхийн зэрэгцээ малын тэжээл боловсруулах жижиг цех тасгийг бий болгох, жимс жимсгэнэ, эмийн ашигт ургамлын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх чиг бодлого баримтлах
2. Усалгаатай тариалан эрхэлж болох **12574 га талбайг** судалгаагаар илрүүлсэн учир дээрх талбайг усалгаатай ашиглах арга замыг хайх энд юуны өмнө урд ашиглаж байгаад эвдэрч тоногдсон Бор Балгасын 85га, Хоолтын 50га, Шаргалжуутын 80га, Хөх эргийн 53га, Өлзийтийн 76га услалтын системийн талбайг засаж сэлбэн ашиглалтанд оруулах бусад шинээр барих их бага оврын услалтын системийн асуудлыг орон нутаг, аж ахуйн нэгжийн хүч хөрөнгө, гадна дотны зээл, төсөлд хамруулан шийдэх.
3. Тариалангийн газрын бүтэцийг сайжруулах, цулгуй уринш, өнжөөсөн талбайн эзлэх хувийг бууруулах, одоогийн байдлаар нийт эргэлтийн талбайн зөвхөн 1/3 орчим хувьд тариалалт хийж байгааг наад зах нь 2/3%-д хүргэх.
4. Газрын эзэмшил ашиглалтын асуудлыг оновчтой зөв шийдвэрлэх, эзэмшилийн хувьд маргаантай газруудын асуудлыг нэг мөр болгох, санхүүгийн хувьд чадавхитай, ажлын арга барилтай тариалан эрхлэх сонирхолтой иргэд аж ахуйн нэгжид газрыг хувиарлах, тариалалт хийхгүй он удаан жил өнжөөж орхидог байдлыг халах, тариалангийн газрын кадастрын зураг хийлгэх.
5. Нэгж талбараас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд усалгаатай тариалан эрхлэх, агромилиорацийн арга хэмжээг өргөн авч хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл талбайн арчилгаа, тордолгоог сайжруулсны үндсэн дээр

- нэгж талбараас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, одоогийн хөрсний чадавхийг шавхаж ургац авдаг арга барилаас салах.
6. Аймгийн хэмжээнд тариалангийн нийт талбайн 32.7% салхины сул эвдрэлд орсон бөгөөд цаашид энэ хэмжээ нэмэгдэх магадлал өндөр, хөрсний бүтэц хөнгөн учир хөрсийг салхины элэгдлээс хамгаалах иж бүрэн арга хэмжээг дорвитой авч хэрэгжүүлэх
 7. Төмс, хүнсний ногооны талбай нэлэнхүйдээ хортон шавьжинд идэгдсэн тул зохих байгууллагад хандаж арга хэмжээ авах, нэгдсэн журмаар хор гербицидээр хангаж устгах арга хэмжээ авах.
 8. Нийт тариалангийн талбайн 80-90% нь хөрсний шим тэжээлийн бодисоор хангалтгүй зэрэглэлд багтаж байгаа учир хөрсний үржил шимийг дээшлүүлэх, юуны өмнө орон нутгийн бордоо бууц, сангас, сүрэл зэргийг өргөн хэрэглэх. Хөрс шим тэжээлийн бодис тэр дундаа азотоор нэлээд дутмаг байгаа учир уриншинд хөрсийг азотоор баяжуулагч царгас, хошоон зэрэг буурцагт ургамлыг ногоон бордуурт өргөн хэрэглэх шаардлагатай байна.
 9. Атаршсан газраас боломжтой талбайг иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх, төлөвлөсөн газраас эхний ээлжинд хуучин ашиглаж байсан талбайнуудыг эргүүлэн ашиглах
 10. Тус аймаг тариалангийн хоёр өөр бүс 3 дэд бүсэд хуваагдаж байгаа онцлогийг харгалзан таримлаа зөв сонгон тариалах.
 11. Тариалалтын ажилд стандартын шаардлага хангаагүй цэвэршилт, соёололт муутай хог хольц ихтэй үрийг хэрэглэхгүй байх
 12. Хөрс боловсруулах, бусад тариалах агротехникийн горимыг нарийн чанд мөрдөх гэх мэт олон арга хэмжээнүүдийг тусгасан газар тариаланг амйгийн хэмжээнд хөгжүүлэн удирдах нэгдсэн систем чиг хандлага боловсруулан ажиллах хэрэгтэй байна.

Нэгэнт талбайн хэмжээ одоогий байгаа хэмжээнээс эрс нэмэгдэж байгаа учир түүнд тохирсон системтэй шинжлэх ухааны үндэслэлтэй цогц арга хэмжээнүүдийг авч явуулах шаардлага зүй ёсоор тавигдана. Заримыг дурьдвал: **Тариалах талбайн бүтэцийн** хувьд одоогийн тариалах талбайд төмс, хүнсний ногоо давамгайлж байсан явдал халагдаж тэжээлийн ургамлын тариалалт зонхилох байр суурийг эзэлнэ. Тариалах талбайн бүтэцийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Тариалах талбайн бүтэц

№	Он үзүүлэлт		2005		2015		Алс хэт	
			Талбай /га/	%	Талбай /га/	%	Талбай /га/	%
I	II		III	IV	V	VI	VII	VIII
1	Эргэлтийн талбай		14453	100	20489	100	26524	100
2	Уринш		4458	30.8	—	—	—	—
3	Тармиалсан талбай		9997.9	69.2	20489	100.0	26524	100.0
4	ү ү н э э с	үр тариа	280	3.0	—	—	—	—
		Төмс	376.3	4.0	219	1.1	223	0.9
		Хүнсний ногоо	112.6	1.0	160	0.8	155	0.6
		Малын тэжээл	9229	92.0	19510	95.2	25546	96.2
		Техникийн ургамал	—	—	600	2.9	600	2.3

2015-он ба алс хэтийн тариалах талбайн бүтэцийг боловсруулахдаа малын тэжээлийн тарималыг нийт талбайн 90 гаруй хувьд тариалах болсныг харгалзан уриншийн системгүйгээр үйлдвэрлэл явуулахаар хийлээ.

2015 онд нийт тариалах талбайд төмс 1.0% хүнсний ногоо 0.8% малын тэжээлийн ургамал 95.2 % техникийн ургамал 2.9 % эзлэх юм. Алс хэтэд нийт тариалах талбайд төмс 0.9 % хүнсний ногоо 0.6 % малын тэжээлийн ургамал 96.2 % техникийн ургамал 2.3%-г тус тус эзэлнэ.

Тус аймаг инженерийн хийцтэй услалтын системд нийт 1178 га, энгийн усалгаатай 840 га талбайд газар тариалангийн үйлдвэрлэлээ эрхлэн явуулж байна. 2015 онд усалгаатай талбайн хэмжээ 6577 га, үүнээс инженерийн хийцтэй услалтын системийн талбай 5602 га болж тус тус өсөх ба эдгээр усалгаатай талбайд төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн нэг, олон наст тарималыг тариалах юм.

Ээлжлэн тариалах системийг боловсруулж мөрдөхдөө юуны өмнө газар тариалангийн ямар бүсэд хамрагдаж байгааг онцгой анхаарах нь зүйтэй. Иймд дээр дурьдсанаар тус аймгийн газар тариалан нь газар тариалангийн агро 3 бүсэд хуваагддагийг санах хэрэгтэй /хүснэгт 31/.

1. Тархай тариалант бүсэд малын тэжээл зонхилон тариалахад тохиромжтой ба зарим нутагт усалгаатай төмс, хүнсний ногоо тариалж болох юм. Энэ бүсэд уриншгүй ЭТС-г баримталхаар төлөвлөж байна. Үүнд: 2 талбайт ЭТС,
 - а. Тэжээлийн үр тариаг дан ба холимгоор
 - б. Нэг наст төрөл бүрийн өвс
2. Бүрэн усалгаат бүрдийн тариалалтын бүс нь гандуу уур амьсгалтай учир энэ бүсийн тариаланг хөгжүүлэхэд усалгааны асуудлыг заавал шийдвэрлэх хэрэгтэй. Бүрдийн тариалант бүс нь дулааны хангамжаар сайн, ургамал ургалтын хугацаа урттай учир усалгааг хангалттай хийсэн нөхцөлд тэжээлийн таримлаас жилд 2 ургац авах боломжтой. Тус бүсэд тэжээлийн үр тариа нэг наст өвсийг тэжээлд тариалах дээрх ЭТС-г баримтална. Дээрх 2 бүсэд төмс хүнсний ногоог ЭТС-д оруулахгүй байр сэлгэх журмаар тариална.

Агротехник. Аймгийн хэмжээгээр тэжээлийн дийлэнх хувийг таримал тэжээлээс хангахаар төлөвлөж байгааг харгалзан уг таримлыг тариалахад зайлшгүй шаардлагатай хөрс боловсруулах, тарих зарим технологиос зөвлөж байна.

Атар уринш боловсруулах талаар. Тус аймагт алс хэтэд 30 гаруй мянган га талбайг эзэмшихээр төлөвлөсөн билээ. Хаягдаад наад тал нь 15 цаад тал нь 40 гаруй жил болсон эдгээр талбайнууд нь бэлчээрт шилжиж бараг атар болжээ. Иймд тэдгээрийг атар хөрс боловсруулах техник технологийг мөрдөхөөс өөр аргагүйд хүрнэ. Мөн эдгээр талбайн хөрс нь хөрсний үржил шимээр харьцангуй бага, гадны үйлчлэлээр хялбар элэгдэх хөнгөн хөрстэй агроүйлдвэрлэлийн III-зэргийн хөрс зонхилох тул атар уриншийг анх эзэмшихээс эхлэн агротехникийн наад захын шаардлагыг бүрэн хангасан байх шаардлагатай юм. Бүс нутгийн онцлогийг харгалзан 5 дугаар сарын сүүлч 6-р сарын эхэн хугацааг сонгон цант сэндэчлүүрээр 6-8 см-н гүнд 2 чиглэлээр явуулсаны дараа 20-22 см-н гүнд хөрслүүр бүхий хөмрүүлэгчтэй анжисаар хагална. Үүний дараа хөрсний ширэгжсэн хэсгийг хэрчиж тэгшлэх хог ургамлыг устгахад чиглэгдсэн борнойдолтыг хөрсний байдлыг харгалзан хэдэн ч удаа хийж болно. Атрыг эдэлбэрт оруулсны дараа 2 жил болоод ЭТС-д оруулан хөрс хамгаалах технологийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Хөрсийг элэгдлээс хамгаалах явдал манай тариалангийн үйлдвэрлэлийн үндсэн зорилтын нэг юм. Тус аймгийн нөхцөлд хөрсний элэгдэлтэй тэмцэх дараах арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хөрсийг хавж элдэншүүлэх тухай. Хөрсийг хавж элдэншүүлэх сүрэл, ургамлын үлдэгдэл талбайн гадаргуу дээр үлдэж хөрсийг салхинаас хамгаалдаг. Хавж элдэншүүлэх системийг хэрэглэхэд анхаарах хэдэн онцлог тал бий.

1. Хог ургамалтай тэмцэх арга хэмжээг эрчимтэй хийх. Хаврын ба цэвдэгш хагалгааны дараах боловсруулалтыг хийх хэрэгтэй.
2. Хавж элдэншүүлэх машин тохируулгыг зөв хийж ажлын явцад байнга хяналт тавьж байх шаардлагатай.
3. Ховил шонтой юмуу, овон товон ихтэй газарт урьдчилан тэгшлэлт хийхгүйгээр хавах аргыг хэрэглэж болохгүй.

Хавж элдэншүүлэх системд багтдаг бүх төрлийн машин багажийг талбайд явуулахдаа мөр заагч заавал тавих хэрэгтэй.

Эрдэс ба шим бордоо, химийн бодис хэрэглэх талаар. Нэгэнт хөрс үржил шимээр хангалтгүй тул тариалалтыг хийхдээ бүх тарималд орон нутгийн бордоо бууц, сангас цаашилбал эрдэс бордоог өргөн хэрэглэх зайлшгүй шаарлага бий. Ургамлыг ургах хугацаанд нь тэжээлийн бодисоор хангахын тулд янз бүрийн аргаар бордох бөгөөд үндсэн 3 арга байдаг. Үүнд: үндсэн бордоо, нэмэлт бордоо, тарих үеийн бордоо орно. Үндсэн бордоог талбайг хагалах сийрүүлэх үед хийж өгнө. Ургамал ургах хугацаанд зарим бордоог усанд уусгаж шүрших, усалгаатай хамт эсвэл мөр хоорондын болвсруулалт хийх үед гүехэн булах зэргээр хэрэглэхийг нэмэлт бордоо гэдэг. Тэжээлийн ургамалыг ихээхэн хэмжээгээр тариалах болсонтой холбогдуулан ургамлын өсөлт массыг нэмэгдүүлэх үйлчлэлтэй азотын бордоог үндсэн бордоонд хийж өгөх ба 2 урагц авах талбайдаа нэмэлт бордолтын эхний хадалт хийсний дараа бордох нь тохиромжтой юм. Таримлуудыг бордох нормыг хүснэгтээр үзүүлэв.

ХАА-н таримлуудыг бордох дундаж норм.
/1га-д үйлчлэх бодисоор/

	Таримлын төрөл	Бууц	Үйлчлэх бодис		
			Тн	Н	Р
1	Төмс	20-30	60	60-70	60-80
2	Хүнсний ногоо	30-40	50-60	50-80	40-80
3	Малын тэжээлийн ургамал	40	60-90	40-60	40
4	Даршны ургамал	40	90-120	60	20-40
5	Байгалийн хадлан	40	60-90	40-60	40

Бордоог талбайд цацах техник.

а. Хүнсний ногоо, усалгааны үр тариа, тариалхаар төлөвлөсөн хөмрүүлж хагалах талбайд РУМ-3, 1РМГ- маркийн бордоо цацагч

б. Хавж элдэншүүлэх талбайд үрлэгч СЗС-2.1, СЗП-2.1, СУ-24 гүн сийрүүлэгч КПГ-2.2-г хэрэглэнэ.

Шим бордоо: Манай оронд шим бордооноос бууцыг зонхилон хэрэглэнэ. Бууцыг богийн, бодын гэж ялгана. Өвөлжөөнөөс гараагүй 1 тн шар бууцанд азот 4.5 кг, фосфор 2.5, кали 6.0 кг агуулагдах ба өвөлжөөнөөс гаргасан 1 тн хуурай хөх бууцанд азот 2.3 кг, фосфор 1.5кг, кали 3.5 кг агуулагдана. Бууцыг нягтруулж хадгалах замаар бүтэн жил ялзруулсны дараа бордоонд хэрэглэнэ. Бууцыг ИПТУ-4 маркийн цацагчаар талбайд цацана.

Химийн бодис, хор герцид. ХАА-н таримлын ургацыг нэмэгдүүлэхэд түүнийг элдэв өвчин хортон, шавьж, хог ургамлаас хамгаалах явдал зайлшгүй шаардлагатай юм. Төлөвлөлтөнд таримал урагмлын өвчин хортон шавьж, хог ургамалтай тэмцэх зорилгоор доорх арга хэмжээг авах нь зүйтэй. Үүнд :

Тухайн жилийн тариалах үрийг сайтар цэвэрлэж наранд ээж, үрийг гранизоноор /2.0 кг-г 1 тн үр тарианд/ хордуулах. Хортон шавьжийн эсрэг химийн хорт бодис хэрглэж авиахимийн устгал хийх уриншид зэрлэг ургамлын жигд цухуйцын үед 2.4 Д бүлгийн гербицидээр устгал хийнэ. Мөн Раундафийг хэрэглэж болно. Эдгээр арга хэмжээнд зориулан аймгийн хэмжээгээр 2.4 Д группын гранизон 52.2 цн, ТМДТ гранизон 57.5 цн шаардлагатай байна.

Усалгаатай нөхцөлд тэжээлийн олон наст ургамал тариалах технологи

Тэжээлийн олон наст ургамлыг тус аймгийн нилээд сумдын энгийн ба инженерийн хийцтэй услалтын системд тариалахаар төлөвлөсөн юм.

Тархай ба бүрдийн тариалант бүсийн усалгаатай талбайд тэжээлийн олон наст ургамлыг тариалах нь:

1. хөрсийг нь жил бүр хагалж боловсруулдаггүйгээс салхины элэгдлээс хамгаалах
2. Олон наст ургамал нь тэжээлийн бодисоор ядуу хөрсийг аяндаа баяжуулж ургацыг нэмэгдүүлдэг сайн талтай.

Олон наст ургамлыг дангаар тариалж болох боловч 2-3 төрлийн үет, Буурцагт ургамлыг хольж тарихад дангаар тарьснаас 30-40%-р илүү ургац хуримтлуулахаас гадна өвсний шимт чанар ч дээшилдэг:

Хөрс боловсруулалт, тариалалт

Хөрс боловсруулалтыг хийхийн өмнө цэнэг усалгааг заавал хийсэн байна. Талбайг хагалахын өмнө 1-га –д 40 тн бууц, 150-170 кг азотын бордоогоор бордоно. Царгас тариалах талбайг азотын бордоогоор бордох хэрэггүй. Хөрсийг 18-20 см гүн эргүүлж хагалаад борнойдож булдан талбайг сайтар тэгшилнэ. Талбайг сайтар тэгшлэх нь олон наст ургамлын үр хөнгөн жижиг тул үр жигд суух бололцоотой болгодог. Олон наст үетэн буурцагтанг арвай, хошуу будаа, хөх тариа, судан өвсний үртэй хольж нөмрөгтэй тариалах нь үрийн хөгжилтийг сайжруулахын хамт ургацыг нэмэгдүүлэх сайн арга болно. Хольц тарихдаа олон наст ургамлын үрийг 100%, нэг наст ургамлын үрийг га-д 60%-р орохоор бодож тариална. Хэрэв олон наст үетэнг дангаар тариалах бол сибирийн өлөнгө га-д 10%-р аж ахуйн чанартай бол 20-25 кг, саман ерхөг 12-15 кг, Царгас 10-12 кг үрээр тарина. Үет ба буурцагтыг холимгоор таривал 60:40 харьцаатайгаар тарина. Усалгаатай талбайд тарилтыг орой хийх шаардлаггүй, 5 сарын эхний 15 хоногт тарилтыг хийнэ.

Усалгаатай нөхцөлд тарьсан өлөнгөөс ашиглалтын 1 дэх жилд 12-17 цн, 2, 3 дахь жилд 40-70 цн өвсний ургац авч болно. Үрийн ургац өлөнгө /ерхөгөд 2-4 цн/га, царгас 0.3-0.5 цн/га байна. Саман ерхөг ашиглалтын 2-3 дахь жилд 20-25 : 4 дэх жилд 25-28 цн, царгас 35-37 цн өвсний ургац өгнө. Өлөнгө ерхөгийг усалгаа бордоотой нөхцөлд 5-7 жил, царгасыг 7-3 жил ашиглаж болно. Өлөнгө ерхөгийг бутлалтын үед 2.4Д төрлийн гербицид 1 га –д 2.5-3 литрийг 400-500 литр усанд найруулж /ОВТ-1А-га-р цацаж хог ургамлыг устгана. Царгас нь эхний үедээ удаан ургаж хог ургамалд ихээхэн автагдана. Хог ургамлын хэмжээ их байвал 8 дугаар сарын дундуур хадах хэрэгтэй. Хадгалтыг оройтуулбал царгасны өвөлжилт ба хаврын сэргэн ургалтанд муу нөлөө үзүүлнэ.

Услалтын нэг удаа 300-400м/куб усаар, ургалтын хугацаанд 6-7 удаа усална. Царгасыг дангаар тариалсан үед уураг, амин хүчил, витамин ихтэй өвсний гурил бэлтгэхэд ашиглаж болно.

Судан өвс: судан өвсийг ногоон тэжээл, өвс, даршинд тариалж болно. Усалгаатай дулаан хүрэлцээтэй талбайгаас 200-300 цн/га ногоон унац, 50-70 цн өвс , 6-8 цн үр авч болно. Судан өвс хөрсний үржил шим голдоггүй хар хүрэн, хөнгөн шавранцар, элсэнцэр бор хөрсөнд сайн ургана. Тарихын өмнө болон өмнөгчид хийсэн бордооны нөлөөгөөр сайн ургана. N,P-н бордоогоор бордоход арвин ургац өгөх ба азот 1.2 цн-р бордох нь тохиромжтой. Усалгаатай талбайг намар цэвдэгшээр боловсруулна. Харин хаврын хагалгаанд тарих бол хагалахын 500-600 м³ усаар усалсны дараа хөрсийг эргүүлэлгүйгээр 18-20 см хагалж борной булын агрегат явуулна. Судан өвсийг ердийн мөрөөр 25-30 кг/га нормоор үрлэх ба үрийг 5-7 см-н гүнд тариалах нь зүйтэй. Судан өвсийг түрүүлэлтийн сүүлч ба цэцэглэлтийн эхэн үед өвсийг хадахад шим тэжээл сайтай тэжээл болдог, усалгаатай талбайгаас 2 ургац авахын тулд анхны ургац авануут азотын бордоо 25-30кг/га нормоор бордож үрлэнэ.

Рапс: зусах рапсийг тариалж төрөл бүрийн малын бэлчээрт ашиглах ба ногоон массыг хураан авч дарш, өвсний гурил хийнэ. Рапс тос ихтэй тосны ургамал

боловч уургаар баялаг, ургац ихтэй богино хугацаанд болц гүйцдэг онцлогтой таримал юм. Хавар намрын хүйтэнд тэсвэртэй учир өсвөр ба сүүний малын оройн ногоон бэлчээр болж сүүг нэмэгдүүлэх боломжтойн дээр хөрс голдоггүй, бусад ургамалд сайн өмнөгч болно. Рапсийг байцаа, манжин, гич гэх мэт тонолж цэцэгтний дараа ба ойр тарихыг цээрлэх хэрэгтэй. Рапсын үр маш жижиг тул 2-3 см-ийн гүнд хөрсний өнгөн чийг 10%-аас доошгүй нөхцөлд тарихын өмнө хойно хүнд булаар булдаж тарина. Ургалтын хугацаа богино тул эрт тариалах шаардлаггүй. Таримал бэлчээрт саалийн үнээнд зориулан тарих бол 3-4 хугацаанд 7 хонгийн зайтай тариалах нь сайн юм. 1 га талбайд үрэнд тариалхад 6-8 кг дарш, хадланд 8-10, бэлчээрт 10-12 кг нормоор тарина. Мөр хоорондын зай үр авахыг 45-60 даршинд 30-45, хадлан бэлчээрт 15 см-н зайтай тарина. рапсийн үрийн болц 80-90, дарш хадланд 55-65 хоногт гүйцэтгэнэ. Тарьсаны дараа услах мөр хоорондын боловсруулалт хийх зөгий бэлчээрлүүлж нэмэлт тоос хүртээх гэх мэт арчилгааг хийнэ. Үрийн хураалт хийх бол ангилан хадалт хийж мөрөн дээр нь хатаагаад цайруулж авна. Дарш өвсөнд цэцэглэлтийн сүүл үеэр хадаж ашиглана. Бэлчээрт зориулан тарьсаныг намар оройн бэлчээрт хэрэглэхийг өдөр бүр нарийн хувиараар мал бэлчээрлүүлж идээшлүүлэх ба өвлийн бэлчээрт хэргэлэхийг мөрлөн хадаж мөр дээр нь өвөлжүүлэн өвөл хаврын улиралд мал бэлчээн хэрэглэдэг.

Хадлангийн газрын менежментийн бүсүүд, түүний нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 10354 га /бидний судалгаагаар/ хадлангийн газартай бөгөөд тэдгээрийн тэдгээрийн иэнхи нь Гурванбулаг, Заг, Жаргалант, Бөмбөгөр, Хүрээмарал сумуудад зонхилон байрладаг болохыг дээр өгүүлсэн. Аймгийн хэмжээнд хадлангийн талбайгаас жилдээ дундажаар 2500-3500 тонн хадлан авдаг, тухайлбал 2003 онд 3535.4 тонн, 2004 онд 3094.8 тонн, 2005 онд 2574.3 тонн хадлан авсан байх жишээтэй. Бидний судалгаагаар жилдээ дээрх талбайгаас 3995.8 тонн хадлан авах боломжтой бөгөөд өөрөөр хэлбэл одоо авч байгаа хадлангийн хэмжээг ойролцоогоор 500-1500 тонноор нэмэгдүүлэх боломж бий. Дээр нь голын нуга, зэгс, уулын нугархаг ам хөндий, нугархаг хээр зэрэг газраас хадаж болох бөгөөд эдгээр талбайгаас 1600-1800 тн хадлан авч болох тооцоо бий /хүснэгт 41/. Бид хадлангийн газрыг менежментийн дараахи бүсүүдэд хуваалаа, үүнд: элдэв арчилгаа тордолгоо хийлгүйгээр тогтвортой байнгын ургац өгдөг хадлан, хашиж хамгаалах, сэлгэх ашиглах замаар тордон сайжруулах хадлан, усалгаа оруулах болон олон наст ургамлын үрийг өтгөрүүлэн цацах замаар усалгаатай тарималжуулах хадлан, бусад ангиллын газраас хадаж болох /төлөвлөсөн/ хадлан гэсэн 3 бүсэд хуваан үзсэн /хүснэгт 40/. Үүнд аймгийн хэмжээнд тогтвортой байнгын ургац авдаг хадлангийн гол бүс нутгаар Заг, Гурванбулаг, Баянбулаг, Баацагаан, Бууцагаан зэрэг сумдыг нэрлэж болох бөгөөд энд нийтдээ 4709 га талбайг хамруулж өөрсдийн хэрэгцээг хангах боломжтой гэж үзлээ. Бусад сумдын хувьд 5574 га талбайд тордон сайжруулалт хийсэний үндсэн дээр өөрсдийн дотоодын хэрэгцээний тодорхой хэсгийг хангах, ойролцоох эрчимжсэн мал аж ахуй болон хуваарьт эдлэнт фермерийн аж ахуйнуудыг хангахаар төлөвлөгдсөн. Гэвч сүүлийн жилүүдэд газрын гарц муудсанаас байнгын тогтвортой ургац авдаг талбайн хэмжээ эрс хорогдож нэмэлт арчилгаа, тордолгоо, усалгаа хийхийг шаардах болсон байна. Энд Шинэжинст суманд 71 га талбайг усалгаатай ашиглахаар орууллаа. Хойд талын хадлангийн гол бүс нутгийн хадланд өндөр уулын бушилз-үетэнт, бушилз-алаг өвст болон хээрийн үетэн-алаг өвст, хиагт, хиаг-хялганат, голын татамын дэрс-хиаг-алаг өвст, үетэн-улалж-алаг өвст хэвшилүүд 45-50%-ийн ерөнхий бүрхэцтэй зонхилж, ургац өндөр 4-5 ц/га байх ба шимт чанараар дунд зэрэг 100 кг тэжээлд 38-40 тэжээлийн нэгж агуулагдана. Харин урд талын говийн сумдад гол төлөв давсархаг нам хотос, тогтмол устай багахан нуур цөөрөм усны зах нь хадлангийн гол бүс нутаг болдог онцлогтой. Эндээс тухайн бүс нутагтаа

боломжийн ургац авах боломж бий боловч сэлгэн дэс дараатай хадахгүй бол нуурын ус багасах магадлал өндөр байдгийг анхаарах хэрэгтэй. Энд зэгст, зэгс-улалжит нугархаг хэвшил зонхилж ургац 5-6 ц/га байх ба 100 кг тэжээлд 35-37 тэжээлийн нэгж агуулагдана. Тус аймгийн Говь-хээрийн бүсэнд өөртөө хадлангийн талбайгүй Баян-Овоо, Баянговь, Баянлиг, Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Жинст зэрэг сумд байна. Эдгээр сумдад хангайн бүсийн Галуут, Гурванбулаг сумдын нутгаас 4800 га орчим хадлангийн талбайг хувиарлан эзэмшүүлж өвс хадлан бэлтгэх ажлыг зохион байгуулж болох юм. Цаашид хадлангийн талбайг өргөтгөх, бэлтгэх өвсний хэмжээг нэмэгдүүлэхийн тулд одоогийн хадланд ашиглаж байгаа бэлчээрийг сайжруулалт хийж хадланд шилжүүлэх, орон нутгийн бололцоог ашиглаж хялбар энгийн аргаар хадлан бэлчээрийг услаж үндсэн ба тордон сайжруулалт хийж ургацыг нь нэмэгдүүлэх хэрэгтэй байна Энэ зорилгоор нийт 16391га талбайг шинээр хадланд ашиглахаар төлөвлөв.

3.3.1. Хадланд шинээр эзэмших талбайнууд /төлөвлөсөн/, тэдгээрийн товч тодорхойлолт.

Одоогийн хадаж буй хадлангийн талбайн дээр нэмж Баянхонгор, Баян-Өндөр сумаас бусад бүх сумдад газрын гарц сайтай уулын ам, нугархаг хээр зэрэг бэлчээрийн газраас хадаж болох боломжтой газрын судалгааг сум тус бүрээр гаргаж байршил, хэмжээг зурагт үзүүлэхийн зэрэгцээ тэдгээрийн зонхилогч ургамал, ургац, тэжээлийн нөөц, шимт чанар цаашид хэрхэн ашиглах талаар дэлгэрэнгүй хүснэгтээр талбар бүрээр харуулав /хүснэгт 39,40,41/. Хүснэгтээс харахад бэлчээрийн газраас 39832 га талбайг хадах боломжтой. Үүний 8882га талбайг 2015 он гэхэд ашигласан байхаар төлөвлөж байна. Хадланд шинээр шилжүүлэх талбайн 4700 га нь Галуут сумын Товгорын нуруу, Баян-Овоо сумын Дуурсахын хөндий, Цагаан эрэг орчимд урьд нь хадлангийн талбай байгаад ургац нь муудаж бэлчээрт шилжсэн газар, 1273 га нь одоогоор хадаж өвс бэлтгэдэг /ургац сайтай бэлчээр, 136 га нь тариаланд ашиглаж байгаад атаршуулсан газар, үлдсэн талбай нь голын нуга -татмын чийглэгдүү, өвс ургамал сайтай, хөрсний хувьд тордон сайжруулалт хийхэд бүрэн боломжтой газар байна.

2015 оноос хойшхи хугацаанд бүгд 7509 га талбайг хадланд шинээр эзэмших ба ингэснээр хадлангийн талбайг өргөтгөх боломж маш хязгаарлагдмал болно. Өөрөөр хэлбэл тус аймагт хадлан бэлтгэх боломжтой талбайн нийт нөөц 16391 га байна. Алс хэтэд хадланд шилжүүлэх боломжтой дээрх талбайд хөрөнгө хүч ихээхэн шаардагдах бөгөөд услалтын болон сайжруулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд 5160 га талбайд услалтын, 3130 га-д үндсэн сайжруулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр шаардлагатай.

Мөн усалгаатай ашиглаж болох газрын фондод бүртгэгдсэн /услалтын систем барих судалгаа хийгдсэн/ сумын бэлчээрийн талбайг усжуулах замаар таримал хадлан бий болгох талбайгаар авсан. Эдгээр бүх талбайг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшилд байхаар төлөвлөв. Дээрх төлөвлөсөн газрууд нь одоогийн байгаа хадлангийн төвшинд нөөцийн хувьд хүрэхгүй боловч тэдгээрийг сайжруулах замаар ашиглах мөн гарц сайтай хуртай жил шууд ашиглах боломжтой талбай ч бий. Ялангуяа усжуулах замаар хадах талбайгаас тогтвортой ургац авах нэлээд боломжтой. Ер нь малын бэлчээрийг гол нутгууд, хадлан бэлтгэдэг газруудыг тариаланд эзэмшихгүй байх зарчмыг баримтлав.

3.3.2. Хадлангийн эдэлбэр газрын ашиглалтыг эрчимжүүлж, хамгаалалтыг сайжруулах

Хадлангийн талбайн одоогийн төлөв байдал, нөөцийг зөв тогтоосний үндсэн дээр түүнийг бүрэн дүүрэн зөв зохистой ашиглах явдал хадлангийн газрын ашиглалтыг сайжруулах менежментийн нэг үндэс мөн. Бид хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулах үүднээс тэдгээрийг хэд хэдэн бүлэгт хуваасан гэж дээр дурьдсан. Одоогийн нийт хадлангийн талбайн 4709 га буюу 45.5% нь байнгын хадаж ашигладаг тогтвортой ургац авдаг хадлан байх бөгөөд 4431 га буюу 42.8% нь сэлгэж өнжөөх, хашиж хамгаалах замаар тордон сайжруулж ашиглах, 1143 га буюу 11.0 % нь олон настын үрийг хачирлан цацаж өтгөрүүлэх замаар тарималжуулах, 71га буюу 0.7% усжуулах хадлан байна. Тордон сайжруулах талбайд ихэнхи сумдын одоогийн ашиглаж байгаа талбай орох бөгөөд цаашид нийт талбайг хэрхэн сайжруулах төлөвлөгөөг дор хүснэгт 42-оор харуулав.

Хүснэгт 42

Нөхөн сэргээлт, тордолт хийх хадлангийн газрын судалгаа.

№	Арга хэмжээ	Сумын нэр	Талбайн хэмжээ, га-аар	Зарцуулсан хөрөнгө* мян/төг	Хөрөнгийн эх үүсвэр
1	Услах	Шинэжинст	71	-	Улсын төсөв
2	Тарималжуулах	Бөмбөгөр, Жаргалант, Хүрээмарал	1143	-	Орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж
3	Тордон сайжруулалт хийх	Гурванбулаг, Заг, Богд, Хүрээмарал, Өлзийт г.м	4431	-	Орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж
	Бүгд		5645		

Хадлангийн талбайн эзэмшил, ашиглалтын хувьд нийт талбай бүгд орон нутгийн мэдэлд байх ба тэдгээрээс одоо гоор иргэд, аж ахуйн нэгж, гадаадын байгууллага эзэмшсэн, ашигласан, өмчилсэн хадлан байхгүй. Иймд цаашид хадлангийн талбайг иргэд, аж ахуйн нэгжүүдэд өргөн эзэмшүүлэх, ашиглуулах хэрэгтэй.

Хадлангийн талбайг ашиглах зөвлөмж :

1. Баянхонгор аймаг хадлангийн нөөц багатай учир одоогийн байгаа хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулах хэрэгтэй.
2. Хадлангийн талбайн зүйлийн бүрэлдэхүүн цөөрсөн, ургамал тачир намхан, сийрэг болсон газруудыг тордон сайжруулах эдгээр талбайг малын хөлөөс хамгаалах, жил дараалан хадахгүй сэлгэж хадах, олон наст ургамлын үр цацаж өтгөрүүлэх, хөрсийг сийрүүлэх, өвөл цас тогтоох, хурын улиралд борооны усыг хуримтлуулж услах, ялзарсан өтөг бууцаар бордох зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна.
3. Шинэжинст сумын 71 га /судалгаа хийгдсэн/ талбайг услаж хадланд ашиглах цаашилбал малын тэжээл, дарш тариалах хэрэгтэй.
4. Хадлангийн талбайд үерийн ус орохоос хамгаалж хаалт хашилт хийх, суваг шуудуу татах, том чулууг түүх, довонг тэгшлэх, хуучин борог өвс, мод бутыг цэвэрлэж хадах зэрэг ажлуудыг хийж ашиглалтыг сайжруулах
5. Хадлангийн талбайн ойролцоо тэдгээрийг түшиглэн жижиг фермерийн аж ахуй, цөөн тооны сүүний чиглэлийн эрчимжсэн мал ахуй эрхлэх боломжийг судлах.
6. Хадлангийн талбайг иргэд болон аж ахуйн нэгжүүдэд нэн даруй гэрээгээр эзэмшүүлэх хэрэгтэй.

**Бэлчээрийн менежментийн бүсүүд, түүний нөөц,
нөхцөлийн төлөвлөлт.**

3.4.1. Бэлчээрийн менежмент.

Одоогийн байгаа бэлчээр нь жилээс жилд бусад ангиллын газарт шилжиж хумигдаж байгаа мөн дээр нь байгаа бэлчээрийг зөв зохистой ашиглаагүйгээс бэлчээрийн талхлагдал, төлөв байдлын доройтол газар авч байгааг бид дээрх бүлэгт тодорхой өгүүлсэн. Иймд бэлчээрийг зөв зохистой ашиглах, үр өгөөжийг нь дээшлүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах үүднээс зайлшгүй ямар газраа ямар бодлого барих, тэр бодлогын бүсүүдийг газрын нөхцөл нөөцийг зөв тооцоолсны үндсэн дээр тодорхой менежментийн бүсүүдэд хувааж өгөх явдал юм. Ер нь тус аймагт бэлчээрийг дан ганц уламжлалт мал аж ахуйн зохицуулалттайгаар ашиглаж ирсэн бөгөөд цаашид энэ байдлыг багасгаж цөөн тооны өндөр ашиг шим бүхий эрчимжсэн мал аж ахуйн шаардлагад нийцүүлж түүний эзлэх хувийг нэмэгдүүлж хөгжүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого барина. Ингэснээр цаашид мал аж ахуй үйлдвэрлэлийн тэргүүлэх салбар хэвээр байх бөгөөд гагцхүү малын тоо толгойноос хөөцөлдөх биш нэгж малаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлнэ. Цаашид бэлчээрийн газрыг дараахи үндсэн 4 бүсэд хувааж ашиглах нь зүйтэй /зураг, хүснэгт 43/. Үүнд:

1. Хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал мал аж ахуйн бүс.

Энэ бүсэд эдлэн газрын хэм хэмжээ нь урьдчилан нормчлогдсон, газар нутгийн хувиарлалтын дагуу газар эзэмших гэрээнд заасан болзол нөхцөлийг хангасан нарийн төрөлжсөн эрчимжсэн мал аж ахуй эрхлэх фермер, аж ахуйн нэгжийг байршуулав. Иймд энэ бүсийг эрчимжсэн мал аж ахуйн бүс ч гэж ойлгож болно. Энэ бүсэд өндөр ашиг шимтэй саалийн үнээний фермийг 25, 40, 50 үнээтэй байхаар зохион байгуулах нь илүү тохиромжтой. Эдгээр үнээг дулааны улиралд дан ганц байгалийн тэжээлээр тэжээх бөгөөд харин бусад улиралд таримал тэжээл овъёос, сүрэл, дарш, тэжээлийн манжин, давс хужир, хивэг зэрэг багсармал тэжээлээр тэжээх шаардлагатай байдаг тул бэлчээрээс гадна тэжээлийн ургамал тариалах тариалангийн талбайтай байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл эдгээр аж ахуйн нэгжүүд нь эрчимт мал аж ахуйгаас гадна туслах чанарын газар тариаланг давхар хөгжүүлнэ. Иймд атаршсан тариалангийн талбайнуудыг тэжээлийн ургамал тариалахад өргөн ашиглахаар төлөвлөв. Энэ бүсийн хөрс, ургамлан бүрхэвч нь байгалийн унаган төрх байдлын хувьд нэлээд даац сайтай уулын ам хөндий, гол хөндий, булаг шанд орчмын чийгийн хангамж харьцангуй сайтай газрууд байх бөгөөд энд уулын хар хүрэн, хүрэн хөрс, нугын хар хүрэн, нугын хүрэн, хүрэн зонхилон тархах бөгөөд ургамлан бүрхэвчийн хувьд өндөр тусгаг бүрхэц бүхий үетэн-алаг өвст, алаг өвс-хялганат, алаг-өвс үетэнт, алаг өвс-үетэн-улалжит, үетэн-бушилзат, алаг өвс-бушилзат бэлчээрийн төрлүүд зонхилон тархсан байна. Иймд хойд талын Эрдэнэцогт, Өлзийт, Баян-Овоо зэрэг сумд тус бүс нутгийг хөгжүүлэхэд илүү тохиромжтой. Ирээдүйд Өлзийт, Баян-Овоо сумыг Баянхонгор сумын дэргэд дагуул хот баг байхаар төлөвлөсөн учир энд усалгаатай талбайн фондын талбайг түшиглэн фермерийн аж ахуй хөгжүүлэх боломжтой гэж үзлээ. Эдгээр дагуул хот багууд нь аймгийн төвийг бүтээгдэхүүнээрээ хангах юм. Бүтээгдэхүүнээ аль болох хүн ам ойр суурьшсан хот тосгон суурин луу зөөж тээвэрлэхээр дэд бүтэцэд ойр байх нөхцөлийг мөн харгалзан үзэв. Уг бүсэд дээрх сумдын нийтдээ 36912 га газрыг хамруулав.

Энэ бүсэд газар эзэмшигч нь байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах, хамгаалах асуудлыг бүрэн хариуцах бөгөөд үйлдвэрлэлийнхээ үр ашгийг дээшлүүлэх зорилгоор газарт оруулж байгаа хөрөнгө оруулалт нь байгаль орчинд халгүй байх, эдлэн газраа хашиж хамгаалах, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, ургацыг нэмэгдүүлэх, газрын гарцыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг бүрэн хариуцаж өөрийн хөрөнгөөр хийнэ. Эрүүл ахуйн нарийн чанд дэглэмд захирагдаж үйлдвэрлэлээ явуулах учир бусад төрлийн мал амьтан холилдон нутаглах, бусадын мал, мал тууврын зам эзэмшил дээгүүр дамжин өнгөрөхийг хатуу хориглоно.

2. Хуваарьт эдлэн болон нийтийн ашиглалтын газрыг хосолмол ашиглах суурьшилын бүс.

Энэ бүс нь байгалийн нөхцөлийн хувьд дээрх хуваарьт эдлэн газрыг арай гүйцэхгүй уулын бэл хормой, энгэр газар, тал хөндий, нам ухаа гүвээг дагаж орших бөгөөд дунд зэргийн зузаан хүрэн хөрс, хар хүрэн хөрс, нугын хөрс түгээмэл тархаж 40-45 %-ийн ерөнхий бүрхэцтэй үетэнт, хялгана-алаг өвст, хялгана-үетэнт бэлчээрийн төрлүүд зонхилно. Энэ бүсэд уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийг хориглохгүй боловч мах сүүний чиглэлийн үхэр, хонь, адууны эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэхийг хэтийн зорилгоо болгоно. Иймд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжид газрыг хувиарлан олгоно. Нэгэнт фермер аж ахуйн чиглэлийг хэтийн зорилгоо болгож байгаа учир ХАА-н газрын ашиглалтыг сайжруулах, үр шимийг нэмэгдүүлэх, аж ахуй дундын хоршилтийг дэмжиж, техник болон бусад үйлчилгээний газруудыг хөгжүүлэхийг эрмэлзэнэ. Хадлангийн газрыг тэдгээрийн дундын эзэмшилд гэрээгээр эзэмшүүлэх хэрэгтэй. Уг бүсийг ихэвчлэн Бөмбөгөр, Жинст, Баацагаан, Бууцагаан зэрэг аймгийн төв болон төв зам дайран өнгөрдөг сумуудад төлөвлөсөн бөгөөд өөрийн хэрэгцээгээ хангаад илүүдэл бүтээгдэхүүнээ амйгийн төв зэрэг төв суурин газар борлуулах арга хэмжээг авч болох юм. Энд бэлчээрийн талхлагдал бусад доройтол хойт талын сумдыг бодвол илүү ажиглагддаг хязгаарлалтай ашиглах эмзэг хөрс экологитой бүс нутаг учир түүнийг нөхөн сэргээх сайжруулах арга хэмжээг газар эзэмших гэрээнд зайлшгүй тусгаж өгөх шаардлагатай. Энэ бүсэд нийт 15891га талбай буюу нийт бэлчээрийн 0.2%-ийг төлөвлөлөө.

3. Өрхийн аж ахуйн суурьшилийн бүс.

Төв суурин газрын цөөн тооны мал бэлчээхэд зориулсан багавтар хэмжээний төв суурин газар ойр байх бүс юм. Иймд Баянхонгор суманд багахан хэмжээний газрыг дээрх зориулалтаар төлөвлөв. Бусад сумын хувьд бараг төлөвлөх шаардлагагүй учир нь төв дээр малтай айл бараг байдаггүй байна. Газрыг өрх айлаар хамтран эзэмших бөгөөд газрын эзэмшил, ашиглалт, чанартай холбогдсон аливаа асуудлыг өрх хариуцаж, малын тооноос хамааруулан түрээсийн төлбөр төлнө. Газар хязгаарлагдмал, түрээсийн төлбөр төлөх учир өндөр ашиг шимтэй цөөн тооны малтай байхыг эрмэлзэх нь чухал. Энэ бүсэд бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийг хориглож жимс, жимсгэнэ, хүлэмжийн аж ахуй, гахай, тахиа, зөгийн аж ахуй хөгжүүлэх бодлогыг давхар баримтална.

4. Уламжлалт мал аж ахуйн буюу чөлөөт ашиглалтын бүс.

Энэ бүс нь газар нутгийн хувьд нэлээд түгээмэл орон зайг эзлэх бөгөөд бэлчээрийг өвөл, хавар, зун намар гэсэн сэлгээтэйгээр нийтээр эзэмшинэ. Нийт бэлчээрийн 5250598 га буюу нийт бэлчээрийн 58.9% нь өвөл хаврын бэлчээрт 3262607 га буюу 36.6 % нь зун намрын бэлчээрт эрчимтэй ашиглагдаж байна. Нэгэнт газар нутгийн хэмжээ харьцангуй чөлөөтэй учир тал хөндий, ухаа гүвээ, голын хөндийгээр тархаж ургамлан нөмрөг тачир сийрэг, ургац, гарц багатай байна. Иймд улирлын хуваарийг нарийн чанд мөрдөж малын хөлөөс чөлөөлж сэлгээтэй ашиглахгүй бол талхлагдалд орох магадлал хамгийн өндөртэй газар юм.

Нэгэнт талхлагдсан газрыг 2-3 жил өнжөөж байгалийн аясаар нөхөн сэргэсний дараа эргүүлэн ашиглах хэрэгтэй. Аймгийн болон сумын малчин иргэд, гаднаас шилжин ирэгсэд уг бүсэд нутаглана. Улсын бэлтгэлийн мал тууврын зам уг бүсээр дамжин өнгөрөх бөгөөд энд тус аймгийн Баянбулаг /42.7 мян.га/, Гурванбулаг /53.3 мян.га, Заг /23.6 мян.га/, Жаргалант /22.6 мян.га/ сумдын нутгийг дайран өнгөрнө. Энэ замын урт нь ойролцоогоор 200 гаруй км байна/зураг, хүснэгт 43/. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтанд оршиж буй дээр дурьдсан дутагдлуудыг арилгах, ургамлын нөмрөгийн шинж төрх, хадгалагдах чанар, байгаль цаг уурын онцлог, газрын гадаргуу, ил задгай усан хангамжийн байдалд тулгуурлан сум бүрт бэлчээрийг улирлаар ашиглах бэлчээрийн ачааллыг жигдрүүлэх, ашиглагдахгүй байгаа бэлчээрийг бүрэн дүүрэн ашиглах зорилгоор сум дундын отрын бэлчээрүүдийг зохион байгуулав. Үүнд Бууцагаан, Хүрээмарал сумын нутагт ортын бэлчээр байхаар төлөвлөж 30458 га газрыг багтаалаа. Энд 40190 га бэлчээр үлийн цагаан огтонод идэгдсэн учир дээрх газруудад түүнийг устгах арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй байна. 2020он гэхэд уг бүсэд байгаа бэлчээрийн 33363га талбайг тордон сайжруулах, 9029га талбайг үндсэн сайжруулалт хийх, 77635га талбайг усжуулах шаардлагатай байна.

Сайжруулсан бэлчээрийг төрөлжсөн саалийн ферм, бордоо, эмчилгээ тэжээлийн цэгийн малын бэлчээрт зохих хугацаанд нь ашиглаж байх юм.

3.4..2. Бэлчээрийг зөв зохистой ашиглах, сайжруулах талаар.

Тус аймгийн ихэнх сумдын бэлчээрийн нөөц буурч, 1961-1963 онуудад судлагдсан хадлангийн талбайн 37 орчим хувь нь ургацаар хомсдож өвс хадах нь бүү хэл бэлчээрт хадгалахад ч хүндрэлтэй болжээ. Аймгийн нийт бэлчээрийн 46.7 % ямар нэг хэмжээгээр талхлагдаж, 1.8 % нь бусад нөлөөлөлд автсан гэж дээр дурьдсан билээ. Иймд бэлчээрийг нарийн тогтоосон дэглэм, хувиартайгаар ээлж сэлгээтэй ашиглах, хашиж хамгаалах, сайжруулах зорилт зүй ёсоор тавигдаж байна. Их талхлагдсан 2 221.0 мян.га д бэлчээрийг 2-3 жил өнжөөж, 33.8 га-д өнгөн сайжруулалтын арга хэмжээ авна. Уг арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө бэлчээрийг нарийн хувиартай ашиглах асуудлыг сумын хэмжээгээр болон мал аж ахуйн хэсэг, багуудын хэмжээнд бүрэн шийдвэрлэх шаардлагатай. Бэлчээрийн улирлын хуваарь нь бэлчээр ашиглалтыг тухайн сум, баг, хэсгийн байгаль цаг уурын онцлогтой уялдуулаад зогсохгүй МАА-н үйлдвэрлэлийн материалыг баазыг бэхжүүлэхэд чиглэгдсэн, хөрөнгө хүчийг үр ашигтай зарцуулах чухал үндэс суурь болдог байна. Бэлчээрийн улирлын хуваарь дотроо өвөл-хавар, зун-намрын гэсэн 2 үндсэн хэсэгт хуваагдах боловч бололцоотой газар зун-намрын бэлчээрийг хооронд нь сэлгэн ашиглах нь бэлчээрийн талхлагдлыг багасгахад их ач холбогдолтой. Үүний зэрэгцээгээр улирлын бэлчээрийг жилд ашиглах хугацаагаар нь сэлгүүлэн ашиглах нь бэлчээр сэлгэх үндсэн арга болно. Бэлчээрийг энгийн хувиартай ашиглахын тулд :

- ✓ Зуны улиралд говийн бүсээс бусад нутгийн бэлчээрийг ургамлын бутлалтын үеэс цэцглэлтийн эхэн үе хүртлэх хугацаанд үндсэн ургацыг малд идүүлэн ашиглах зорилгоор өндөр уулын районд 30-36 хоногт нэг удаа
- ✓ Уулын хээрт 28-36 хоногийн зайтай 1-2 удаа
- ✓ Хээр, говийн нутгуудад 35-40 хонгийн дараа нэг удаа хэнзэлж ургадаг ургамлын биологийн онцлогт тулгуурлан доорхи зарчмыг баримтална. Бэлчээрийг хувиартай ашиглах:
 1. Зуны улиралд ашиглах бэлчээрийг Өндөр уул, хээрийн бүсэд 6-10, Цөлөрхөг хээр, говьд 10-12 хэсэгт хуваана.
 2. Бэлчээрийн ургамал жигдрэн ургаж мал ногоонд цадах болсон буюу ойролцоогоор өндөр уулын районд 30/Ү-10/ҮI, хээрт 20/Ү-30/Ү-нд ,цөлөрхөг хээр говийн районд 15/Ү-23/Ү-нд зусланд гарч хуваарьт бэлчээрийн эхний хэсэгт малаа бэлчээнэ.

3. Зурваслан хувааж хувиарласан бэлчээрийн нэг хэсэгт малыг 4-5 өдөр хариулж дараагийн хэсэгт шилжүүлэн хариулах журмаар бэлчээрийг ээлж дараатай ашиглана.
4. Хуваарьт бэлчээрийн нэг хэсгийг 4-5 өдөр ашигласны дараа ургамал хэнзлэн ургаж дахин мал бэлчих боломж бүрдэх хүртэл ашиглахгүй амраана. Амраах хугацаа нь ойролцоогоор өндөр уулын районд 30-36 хоног, хээрийн бүсэнд 28-36 хоног, говийн бүсэд 36-40 хоног байна. Гантай зун говийн сумдад нэг нутаг районы бэлчээрийг тогтоосон хуваарийн дагуу нэгээс илүүгүй ээлжээр ашиглана. Эдгээр арга ажиллагаа нь бэлчээрийг аль болхоор жигд ашиглах малыг өдөр бүр соргог бэлчээрт хариулж бэлчээрлүүлэх зорилготой байна.

Өвөл-хаврын улирлын бэлчээрийг ашиглах технологи нь аль болохоор тэжээлийнх нь нөөцийг цаг улирлын онцлогт тохируулан ариг гамтай ашиглахад чиглэгдэнэ. Энэ зорилгоор өвөл-хаврын бэлчээрийг ойрын, үндсэн, нөөц гэж 3-4 хэсэгт хувааж ашиглана. Ойрын бэлчээрийг тарга хүч муутай, өсвөр мал, уналгын малыг идээшлүүлхээр хувиарлана. Үндсэн бэлчээр буюу цаг агаарын тохиромжтой үед ашиглах бэлчээрийг 10-15 зурваст хувааж, нэг зурваст малыг 4-5 өдөр дараалан хариулаад, дараагийн зурваст шилжүүлэх журмаар нийт бэлчээрийг ашиглана.

Үндсэн бэлчээрийг ашиглахдаа алсаас нь дотогшуулах журмыг баримтална. Нөөц бэлчээрийг нийт бэлчээрийн 15-20%-г эзэлж байхаар бодож хамгаална. Хээрийн болон говийн бүсийн сумдад нөөц бэлчээрийг голлох салхины дээд талд хийнэ. Боллоцотой газруудад нөмөр бэлчээрийг уулын энгэр, өвөр газарт гаргаж, онцгой хүчтэй шуургатай үед ашиглана.

Бэлчээрийг хаших нь бэлчээрийг хамгаалж, хуваарьтай ашиглах нэг гол арга юм. Хашсан бэлчээрийн байршилтыг оновчтой тогтоож зохистой ашиглахын тулд ашиглалтын тодорхой хэсгүүдэд хуваана. Саалийн фермийн үнээ тугалд буурцагт ба үет ургамал алаг өвс зонхилсон голын хөндийн чийглэг нугын бэлчээрийг, бог малын суурьт нарийн өвс ургамалтай тал, гүвээ, толгой бүхий газрын бэлчээрийг хаших нь тохиромжтой.

Бэлчээрийг сэлгэж ашиглах арга нь талхлагдуулахгүй байлгах, талхлагдсан бэлчээрийн ашиглалтыг тохируулж зохицуулах замаар ургацыг сэргээхэд чиглэгдсэн чухал арга хэмжээ юм. Тус аймгийн нутагт бэлчээрийг 5 жилээр сэлгэн ашиглах нь тохиромжтой байна.

5 жилээр бэлчээр сэлгэх үлгэрчилсэн схем

Он	Т а л б а й				
	I	II	III	IV	V
I жил	2	3	4	1	0
II жил	3	4	1	0	2
III жил	4	1	0	2	3
IV жил	1	0	2	3	4
V жил	0	2	3	4	1

«I,II,III,IV-ашиглах ээлж хугацаа :0-амрах хугацаа»

хүснэгт 44

Бэлчээр ашиглалтыг сайжруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Авах арга хэмжээ	Газрын байршил	Хөрөнгө мян/төг	Тайлбар
---	------------------	----------------	-----------------	---------

1	Худаг усан санг барих	-	-	
2	Худаг усан санг засварлах	Рашаант, Бад, Тарнын гол дагуу		
3	Зам харгуйг сайжруулах	Бугат, Хутаг-Өндөр		Алслагдсан бэлчээрт зам харгуй гаргах
4	Хашиж хамгаалах	Урд талын сумд		
5	Усжуулах бэлчээр	Ихэнхи сумдад 39258га		
	Бүгд			

Сүүлийн жилүүдэд бэлчээрийн талхлагдал ихсэж байгаатай холбогдуулан төрөөс бэлчээрийг зохистой ашиглах нэгдсэн бодлого явуулах, бэлчээрийг амрааж хуваарьтай ашиглах, байгалийн аясаар нөхөн сэргээх, малын тоо толгойг нэг дор хэт их төвлөрөөлэхгүй бэлчээрийн даацад тохируулах, өндөр үр ашигтай цөөн тооны эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бодлогыг барих, бэлчээр усжуулалтыг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Бэлчээр хамгаалах асуудалд бэлчээрийн усан хангамж, түүнийг эзэмшилд өгөх, цаашилбал төлбөр тогтоох асуудал ч хөндөгдөнө.

Хадлан бэлчээрийг сайжруулах арга хэмжээ

Бэлчээр хадланг сайжруулах арга хэмжээг *тордон сайжруулах* буюу өнгөн сайжруулалт хийх, таримал хадлан бэлчээр бий болгох буюу *үндсэн сайжруулалт* хийх 2 үндсэн системд хуваан үздэг.

Тухайн талбай дахь ургамлын бүтэц бүрэлдхүүнд аж ахуйн хувьд онцгой ач холбогдолтой ургамал 20-25%-с багагүй, нийт талбайн 23-30%-аас илүүгүй хэсэг нь дов сондуултай бут сөөгтэй байгаа нөхцөлд өнгөн сайжруулалтын арга хэмжээг үр дүнтэй гэж үздэг. Харин хэт талхлагдсан, намагжсан, бут сөөгтэй, ашиглах боломж муудсан бэлчээр, хадлангийн талбайд хөрсийг хагалж боловсруулан нэг, олон наст ургамлын үр тарих замаар таримал хадлан бэлчээрийг бий болгох нь /үндсэн сайжруулалт/ илүү ашигтай байна.

Баянхонгор аймгийн хөрс ургамлын судалгаанаас үзэхэд тус аймагт бэлчээрийн үндсэн сайжруулалтыг 9.0 мян.га-д өнгөн сайжруулалтыг 33.8 мян.га –д хадлангийн үндсэн сайжруулалтыг 3.1 мян.га–д тордон сайжруулалтыг 32.4 мян.га –д тус тус хийх боломжтой байгаа ба үүнээс 2015 он гэхэд бэлчээрийн үндсэн сайжруулалтыг 4.4 мян.га –д тордон сайжруулалтыг 7.6 мян.га-д , хадлангийн үндсэн сайжруулалтыг 2.5 мян.га-д тордон сайжруулалтыг 24.0 мян.га-д хийхээр төлөвлөж байна.

Хадлан бэлчээр сайжруулах цогцолбор арга хэмжээг 3 үндсэн бүлэгт хуваана.

- ✓ Гидротехникийн арга хэмжээнд услах, илүүдэл устай нөхцөлд усыг нь зайлуулах замаар уг газрын ус, чийгийн горимын арга хэмжээ орно.
- ✓ Техник тордолтын арга хэмжээнд янз бүрийн хог бут сөөг, чулуу, дов сондуулаас уг талбайг цэвэрлэх, гадаргыг нь тэгшлэх
- ✓ Агротехникийн арга хэмжээнд : -хөрсийг боловсруулах / сийрэгжүүлэх, хагалах, сэндэчлэх/ -эрдэс бордоо хэрэглэх,
- ✓ нэг ба олон наст ургамал тарилах хачирлах, ширэглэх/

Дов сондуулыг хэмжээгээр нь 15 см хүртэл намхан, 15-20 см дунд зэрэг , 50 см түүнээс дээш бол өндөр гэж ангилна. Чулууг хэмжээгээр нь 30 см хүртэл жижиг, 35-60 см дунд, 65 см болон түүнээс дээш бол том гэж ангилна.

Хадлангийн талбайг зохистой ашиглахад юуны өмнө тухайн талбайн ашиглалтын картыг жил бүрээр хөтлөх, түүндээ зонхилох ургамлын нэр, чийгийн хангамж , хадланд ашиглаж ирсэн хугацаа техник бордолт, сайжруулалтын арга хэмжээ , ямар техникээр боловсруулалт хийдэг, хаддаг байсан, бордооны төрөл, тун, усалгааны горим, ургац зэргийг тогтмол бүртгэж байх шаардлагатай.

Тус аймагт хадлангийн талбайг сэлгэлгүй ашиглаж ирснээс ургац нь жилээс жилд буурч байгаад дүгнэлт хийж ашиглалтыг нь сайжруулах, үр өгөөжийг нь дээшлүүлэх арга хэмжээг аж ахуй бүр авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Нэмэлт хүч хөрөнгө, материалын зардал гаргалгүйгээр хадлангийн урагцыг нэмэгдүүлэх, сэргээх хамгийн энгийн арга бол жил бүр хадлангийн талбайг ээлжлэн сэлгэж хадах явдал юм.

Хуурай сэрүүн уур амьсгалтай тус аймгийн хувьд 3 жилийн сэлгээний хэлбэрийг тохиромжтой гэж үзэж байна.

Ургамлын ургалтын үе шатаар
сэлгэн хадах 3 талбайт хадлангийн сэлгээний схем

Талбайн хэсэг		Талбайн дугаар		
		I	II	III
Хадах он	2007	Т	Ү	Ц
	2008	Ц	Т	Ү
	2009	Ү	Ц	Т

Тайлбар :Т-Түрүүлэлтийн үе
Ц-Цэцэглэлтийн үе
Ү-Үр боловсролтын үе

Дээрх сэлгээг хэрэгжүүлэхийн тулд нийт хадлангийнхаа талбайг 3 хэсэгт хуваана. хадлангийн талбай цэцэглэлтийнхээ үеэс эхлэн сайн ургац өгдөг. Энэ үед 3 хуваасан талбайнхаа 1 хэсгийг хадна. Үүнийхээ зэрэгцээгээр үлдсэн хоёр талбайнхаа нэгийг ургамлын түрүүлэлтийн үед хадагдаж байгаа өвс нь тэжээллэг чанар өндөртэй, витаминт өвс бэлтгэхэд бүрэн тохиромжтой байдаг. 3-р хэсгийг хамгийн их ургац өгөх ургамлын үр боловсролтын үед нь буюу хамгийн сүүлд нь хадна. Дараагийн жил үр боловсролтын үед хадсан талбайгаа хамгийн эхэнд нь ургамлын түрүүлэлтийн үед хадаж, дараа нь цэцэглэлтийн үед хадсан талбайгаа хадах байдлаар ургамлын ургалтын үе шатаар нь сэлгэнэ. Ийнхүү ургамлын хөгжлийн өөр өөр үе шатанд нь сэлгэн хадсанаар хадлангийн талбайд ургах олон зүйл ургамлыг үрээрээ үржих бололцоог бий болгож ургацыг нь бууруулахгүй байх бололцоотой.

Хадлангийн талбайн ургацыг бууруулахгүй байх , ашиглалтыг нь сайжруулах явдал талбайг сайтар арчилж хамгаалах асуудлаас шалтгаалдаг. Мөн өвөл хадлангийн талбайд цас тогтоохын тулд хадах үедээ салхины хөндлөн чиглэлд хоорондоо 20 метрээс ихгүй зайд 2 метр өргөн дэл зурвас үлдээж хадна.

Хавар жижиг гол горхины усыг боох шуудуугаар эсвэл цас бороо урсдаг жалга, гуу, хотгор газарт бууц шороогоор далан байгуулах зэргээр хадлангийн талбайг услах хэрэгтэй. Усалгаатай буюу чийгийн хангамж сайтай хадлангийн талбайг эрдэс ба шим бордоогоор бордоход ургац нь эрс нэмэгдэнэ. Азотын бордооны нормыг га-д 60-90 кг үйлчлэх бодисоор бодож 170-250 кг фосфорыг 40 кг үйлчлэх бодис буюу 100 кг –аар бодож цацалгаар хольж цацана. Талбайг малын бууцаар га-д 15-20 тн байхаар тооцоолж 3-4 жилд 1 удаа бордоно.Түүнээс гадна намар өвлийн цагт булаг шанд горхийн халиаг ашиглах, цас борооны ус их урсдаг

хотгор газарт усыг шингээх зорилгоор хадлангийн талбайн хөрсийг тракторын анжис ашиглан цан гарах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэглэнэ.

Тус аймагт хадлан бэлчээрийн сайжруулалтыг тодорхой зураг төслийн дагуу гүйцэтгэнэ.

3.4.3 Бэлчээрийн усан хангамжийн асуудал.

Мал аж ахуйн усан хангамж нь мал сүргийг жилийн бүх улиралд усаар хангах байдал, үүний үндсэн дээр мал аж ахуйг жилийн тодорхой түвшинд усаар хангах төлөвлөлт хийх, усны эх үүсвэр шинээр бий болгох, зарим эх үүсвэрийг сайжруулан тохижуулах, засварлах, тээвэрлэж мал услах зэрэг арга хэмжээг шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Мал сүргийг хэрхэн хангаж байгааг дараах байдлаар авч үзэв .Үүнд:

- Бэлчээрийн талбайд усны эх булаг, уст цэг хэрхэн байрласан хийгээд бэлчээр усжуулалтын түвшинг тодорхойлох
- Одоогийн мөрдөж байгаа мал усалгааны нормоор авч үзэхэд нийт мал сүргийг усаар хангахад шаардагдах усны жилийн хэмжээг тооцон, 2006 оны эх үүсвэр, уст цэгүүдээр өгч байгаа усны хэмжээний хоорондын дүйлт
- Мал сүргийн усан хангамжийн барилга байгууламжийн хүрэлцээ, байршил, барилга угсралтын болон болон хайгуулын ажлын бүтэц, техник-эдийн засгийн үндэслэл
Бэлчээр усжуулалтын түвшинг усжуулсан бэлчээрийн талбайг нийт бэлчээрт харьцуулсан харьцаагаар тодорхойлов. Ингэж тодорхойлохдоо дараах материалыг ашигласан болно.

Үүнд:

- ✓ Усны эх үүсвэр, уст цэгийн байршлын 1:100.000 масштабтай зураг, түүнд 2006 онд хийсэн тодотгол зураг
- ✓ Усжуулсан бэлчээрийн талбайг тодорхойлох аргачлал
- ✓ Уст цэг усны барилга байгууламжийн жил бүрийн тоо бүртгэлийн материал

Аймгийн бэлчээр усжуулалтын байдлыг сумдаар, зун–намын, өвөл–хаврын улирлаар болон жилээр гарган тооцоход одоогийн байдлаар нийт бэлчээрийг жилийн туршид ашиглахад 72.0 хувийг, Зун-намрын бэлчээрийн 75.5%, өвөл-хаврын бэлчээрийн 69.7 %-г усжуулсан байна.

Хүснэгт 45

Аймгийн бэлчээр усжуулалтын байдал

Д/Д	Сумдын нэр	Нийт бэлчээр- Ийн талбай /мян.га/	Үүнээс		Усжуулсан Бэлчээрийн Талбай /мян.га/	Үүнээс		Усжуулалтын түвшин	
			Зун- Намрын	Өвөл хаврын		Зун намар	Өвөл хавар	Зун намар	Өвөл хавар
1	Баацагаан	714.9	357.4	357.5	519.7	279.1	240.6	78.1	67.3
2	Баянбулаг	315.8	210.4	105.4	245.5	192.7	52.8	91.6	50.1
3	Баянговь	424.4	212.6	211.8	364.4	191.6	172.8	90.1	81.6
4	Баянлиг	690.4	441.0	249.4	416.6	330.8	85.8	75.0	34.4
5	Баян-Овоо	322.1	161.5	160.6	221.5	121.0	100.5	74.9	62.6
6	Баян-Өндөр	728.2	380.1	348.1	517.6	248.2	269.4	65.3	77.4
7	Баянцагаан	538.2	305.8	232.4	383.1	228.1	155.0	74.6	66.7
8	Богд	383.3	191.7	191.6	246.3	115.4	130.9	60.2	68.3
9	Бөмбөгөр	299.4	149.7	149.7	234.5	92.7	141.8	61.9	94.7
10	Бууцагаан	573.0	286.5	286.5	528.9	274.8	254.1	95.9	88.7
11	Галуут	339.1	113.4	226.1	240.8	106.9	133.9	94.27	59.2
12	Гурванбулаг	437.1	218.6	218.5	182.7	130.5	52.2	59.7	23.9

13	Жаргалант	412.5	206.2	206.3	283.1	204.3	78.8	99.1	38.2
14	Жинст	523.0	261.5	261.5	327.9	225.4	102.5	86.2	39.2
15	Заг	251.8	151.2	100.6	227.9	151.2	76.7	100	76.2
16	Өлзийт	383.0	137.4	245.6	271.8	99.6	172.2	72.5	70.1
17	Хүрээмарал	424.7	209.0	215.7	322.6	162.8	159.8	77.9	74.1
18	Шинэжинст	961.8	459.7	502.1	495.4	115.8	379.6	25.2	75.6
19	Эрдэнэцогт	274.5	141.1	133.4	199.4	119.2	80.2	84.5	60.1
20	Баянхонгор	5.1	2.9	2.2					
21	Дүн	9002.7	4597.7	4405	6229.7	3390.1	2839.6	77.2	63.6

Хүснэгт 46

Аймгийн бэлчээр усжуулалтад усны эх үүсвэрийн эзлэх байдал

Д/Д	Сумын нэр	Бэлчээрийн нийт талбай Мян.га	Жилийн туршид Усжуулах бэлчээр		Ү Ү Н Э Э С		
			Мян.га	Усжуулсан	Байгалийн Эхүүсвэрээр /%	Энгийн худаг аар /%	Инженерийн байгууламж аар /%
1	Баацагаан	714.9	415.8	56	1.0	26.2	72.8
2	Баянбулаг	315.8	33.0	11.4	19.4	6.4	74.2
3	Баянговь	424.4	348.2	75.4	9.1	7.0	83.2
4	Баянлиг	690.4	643.8	56.8	0.8	33.9	62.3
5	Баян-Овоо	322.1	186.8	58	2.0	14.7	83.3
6	Баян-Өндөр	728.2	329.0	72.0	3.1	18.9	78.0
7	Баянцагаан	538.2	369.1	68.6	14.3	12.9	72.8
8	Богд	383.3	170.4	44.6	1.5	9.5	89.0
9	Бөмбөгөр	299.4	189.6	62.7	1.9	41.8	56.3
10	Бууцагаан	573.0	320.9	65.6	3.1	2.8	94.1
11	Галуут	339.5	76.7	16.7	58.1	4.2	37.7
12	Гурванбулаг	437.1	28.2	6.8	27.7	7.1	65.2
13	Жаргалант	412.5	77.4	20.2	2.0	3.6	94.4
14	Жинст	523.0	298.2	57.2	13.3	18.1	68.6
15	Заг	251.8	39.5	17.2	57.2	4.1	38.7
16	Өлзийт	383.0	164.0	42.8	0.5	21.8	77.7
17	Хүрээмарал	424.7	161.6	39.2	2.4	4.2	93.4
18	Шинэжинст	961.8	343.1	72.0	2.0	24	74.0
19	Эрдэнэцогт	274.5	9.6	2.4	88.5	00	11.5
20	Баянхонгор	5.1					

Жилийн туршид усжуулсан байдлаар авч үзэхэд голлох байр суурийг инженерийн байгууламж /70%/, энгийн худаг 12%, ил задгай усаар үлдсэн хувийг усжуулж байна. Гэтэл дулааны улиралд ашигладаг бэлчээрийн 53 %-г ил задгай усаар хангаж байгаагаас Галуут, Гурванбулаг, Жаргалант, Эрдэнэцогт сумын бүх бэлчээрийг, Баянбулаг, Заг сумдын 75%-г усжуулдаг байна. Баянцагаан сумын тухайд 15%, Баянговь, Баянлиг, Баян-өндөр, Шинэжинст суманд 2-5%-г бусад сумдын 30-50% -г ил задгай усаар усжуулж байна. Өвөл хаврын бэлчээр усжуулалтанд тухайн улиралд мал сүрэг хэрхэн усаар хангагдсан байгааг малын ус хэрэглээг тооцож гаргах шаардлагатай юм. Мал сүргийн ус хэрэглээг авч үзье: Мал сүргийн ус хэрэглээг тооцохдоо дараахь үзүүлэлт болон аргачлалыг үндэс болгов. Үүнд:

1. 2006 оны эхэнд байгаа малын тоог тэжээлийн нэгжээр хонин толгойд шилжүүлэн сумдаар

2. Нэг хонинд шаардагдах усны нормыг өвөл-хаврын ба зун –намрын байдлаар тус тус тооцов.

Өвөл-хаврын улирлын нэг хоногт хэрэглэгдэх усны хэрэгцээ нь сум бүрд 622-1573м/куб байх ба аймгийн хэмжээгээр хоногт 17000 м/куб ус хэрэглэнэ.

Нийт малд шаардлагатай усны хэмжээг бодохдоо:

$$\langle Qx \cdot N \cdot q \cdot t \rangle$$

N-нийт малын тоо

q-улиралд нэг хонинд шаардагдах усны норм, л/хоног

t-улиралд байх нийт хоног

Хоногт шаардагдах усны хэмжээ ба үйлдвэрлэж байгаа усны хэмжээний харьцуулалтыг жилийн өвөл –хаврын нэг хоногт бодох нь зүйтэй юм. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа бүх худгуудаас өвөл-хаврын улирлын нэг хоногт гараж авах усны нийт хэмжээг доорхи байдлаар бодно .

Үүнээс:

Q i-нэгэн төрлийн худгаар гаргах усны хэмжээ

n-тухайн худгийн төрлийн тоо.энэ нь гол төлөв өрөмдмөл, богино яндант, уурхайн , энгийн гэсэн 4-н байдлаар илэрхийлэгдэнэ. нэг төрлийн худгаар хоногт гаргах усны хэмжээг

$$\langle Qi = 3600 \cdot q \cdot K2 \cdot n \cdot t \rangle$$

Үүнээс: q-худгийн дундаж ундрага, л/с

K1-худгийн ус өгөлтийн байдлыг тооцох коэффцент 0.9-0.5 хэлбэлзэнэ

K2-тухайн улиралд ашигладаг худгийн ашиглалтын бэлэн байдал ба шаардлагын байдлыг тооцох коэффцент

Тухайлбал: өвөл-хаварт ашиглах өрөмдмөл худгийн 85%, уурхайн ба богино яндант худгийн 70%, энгийн худгийн 50 %-г нэг өдөрт ашиглана гэж тооцно.

n-тухайн төрлийн худгийн тоо

t-худгийг хоногт ажиллуулах нийлбэр хугацаа

тооцооны эдгээр үзүүлэлтүүдийг хүснэгт 1,4,5,7,8-д үзүүлэв.

Мал сүргийн ус хангамжийн байдалд өгөх дүгнэлт, үнэлэлт: Мал сүргийн усан хангамжийн байдалд өгч байсан үнэлэлт нь гол төлөв усжуулсан бэлчээрийн талбайн хэмжээ, нийт ус хэрэглээгээр дүгнэдэг байлаа. үүнд: дараах дутагдал оршиж байна.

-нийт усан хэрэглээг байгаа устай нь харьцуулахгүй байх

-усжуулсан талбайн хувьд харьцангуй сайн газар бодит байдалд ус дутагдаж байлаа.

Сумдын мал сүргийн ус хангамжийн үнэлэлтэд дараах үзүүлэлтийг авч үзнэ.

а/ Бэлчээрийн талбайн усжуулагдсан байдлын коэффицент буюу усжуулагдсан талбайг нийт бэлчээрт харьцуулсан харьцаа. Энэ кофицент /Кб/ : 0.5 хүртэл талбайн хувьд усжуулалт хангалтгүй .

-0.5—0.75

-0.75—ба дээш бол талбайн хувьд хангалтгүй гэсэн үнэлэлт өгөх

б/ Усаар хангагдсан байдлыг тооцохдоо тухайн улиралд усны эх үүсвэр тус бүрээр хоногт өгч байгаа усны хамгийн доод хэмжээг /Q мин/ ,аж ахуй болон сумын нийт малд нэг хоногт хэрэглэгдэх шаардлагад усны хэмжээнд харьцуулсан харьцаа буюу үүнийг усаар хангагдсан байдлын коэффцент гэж үзнэ.

Энэ коэффцентийг зуны улиралд тооцоход боомжгүй тул өвөл-хаврын улиралд тооцов. Коэффцент Ку нь :

-0.7 хүртэл байвал хоногт өргөж байгаа усны /доод/ хэмжээ нь малын хэрэгцээт усыг хангаж чадахгүй байгааг

-0.7-0.85 байвал усны хэмжээ хангалттай байгааг

-0.85 –аас дээш байвал усаар бүрэн хангагдсан байгааг үзүүлэх юм.
Мал сүргийг өвөл-хаврын улиралд усаар хангагдсан байдлыг авч үзье.
Мал сүргийн ус хангамжаар өвөл-хаврын улиралд сайн нөхцөл бүрдсэн суманд Баянговь, Баян-Өндөр, Богд, Өлзийт, Шинэжинст хангалтгүй нөхцөлд Баянбулаг, Галуут, Жаргалант, Жинст, Заг, Эрдэнэцогт, Гурванбулаг зэрэг сумд орох ба эдгээрээс Гурванбулаг сум ихээхэн муу нөхцөлд байгаа.

Ус хангамжийн муу нөхцөлд байгаа сумдын нутаг дэвсгэр нь гидрогеологи, геоморфологийн онцгой нөхцөлд байгаагаас ийнхүү шалтгаална.

Харин энэ сумдын нутаг дэвсгэр зун-намрын улиралд гадаргын усаар сайн хангагдсан байдаг онцлогтой.

Мал сүргийн ус хангамжийн одоогийн нөхцлийг жилээс жилд сайжруулах алс хэтэд МАА-н үйлдвэрлэлийг усаар тогтвортой хангахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1/ Бэлчээр усжуулалтын түвшинг нэмэгдүүлэх замаар ус хангамжийн нөхцлийг сайжруулах. тодорхой түвшинд нь байлгахад чиглэгдсэн арга хэмжээ, алс хэт буюу 2015 он гэхэд одоо байгаа ихэнх барилга байгууламж элэгдэж, зарим нь данснаас хасагдахад хүрнэ. Эдгээрийг нөхөн хангахад чиглэгдсэн хайгуулын болон барилга угсралт, шинэчлэлт, их засварын ажлыг гүйцэтгэх болно.

2/ Алс хэтэд мал сүргийн тооны өсөлт, ашиг шимийн нэмэгдүүлэлтийг даган мал сүргийн ус хэрэглээ өсөх тул түүнийг хэрэгжүүлэх усжуулалтын арга хэмжээг авч явуулна.

3/ Бэлчээр усжуулалтын түвшинг нэмэгдүүлэх, ус хэрэглээний өсөлтийг хэрэгжүүлэхэд газар доорхи усны эх үүсвэрийг эрж хайх арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ асуудлыг авч үзэхдээ газар доорхи усыг бий болгох, агуулах, түүнийг арилгах, ашиглах нөхцлийг судлах хэрэгтэй. Үүний тулд Баянхонгор аймгийн геологийн тогтоц, геоморфологийн онцлог, гидрогеологийн хэв шинж, цэвдэг чулуулгийн тархац болон бусад хүчин зүйлсийг судлах, эрэл хайгуулын онцлог, арга зүйг нэвтрүүлэх хэрэгтэй юм.

Дээр дурьдсан чиглэл тус бүрийг авч үзье

1/ Бэлчээр усжуулалтын түвшинг нэмэгдүүлэхдээ доорх байдлуудыг анхаарах шаардлагатай юм. Үүнд: Усжуулаагүй байгаа бэлчээрийн талбай нь гол төлөв өндөр уулын орой, хормой, толгод, цэвдэг, чулуулаг тархсан газар байна. Энэ байдалд нь бэлчээрийн талбайн усжуулалтын түвшинг 2015 оны байдлаар гэхэд зөвхөн 80% -д хүргэж зорилт дэвшүүлэх бөгөөд түүнээс илүүгээр шийдвэрлэх боломжгүйг харуулж байна.

Бэлчээр усжуулалтын нэгэнт бий болсон буюу болох түвшинг тэр хэмжээнд байлгахын тулд жил бүр худаг нэмж байгуулах, шинчлэх өргөтгөх замаар нэмэгдэх уст цэгийг тооцохдоо нэг уст цэгийн эдэлгээний дундаж хугацаа 18 жил гэж үзвэл 2007 оноос 2025 он хүртэл 17 жил буюу одоо байгаа инженерийн хийцтэй уст цэгийн 90%-г нэмж байгуулах болно. үүнийг сум нэг бүрээр үзүүлэв. Хүснэгт №10

2/ Цаашид болон алс хэтэд ус хэрэглээг хангахын тулд усны барилга байгууламж нэмж барих замаар мал сүргийн ус хангамжийн нөхцлийг сайжруулах болно. Үүнийг тооцохдоо суурь онд байгаа уст цэгийг үндэс болгон алс хэтэд байх тоог дараах 2 коэффициентийг үндэслэн тооцох боломжтой

хүснэгт 47

Газар доорхи усны эх үүсвэрээс 1 хоногт өргөж болох усны
/хамгийн бага/ хэмжээг тооцох үзүүлэлт

Уст цэгийн төрөл	Дундаж Ундрата л/с	Ус өргөлтийн Коеффцент К1	Худгийн ашиглалтын түвшинг тооцох коэф/к2	Нэг хоногт мал услах хугацаа,цаг	Тооцооны нийлбэр үзүүлэлт
Өрөмдмөл худаг	1.0	0.9	0.85	5	3.82
Богино яндант	0.8	0.8	0.7	3	1.34
Уурхайн худаг	0.6	0.8	0.7	3	1.00
Энгий худаг	0.3	0.5	0.5	3	0.23

хүснэгт 48

Өвөл хаврын улирлын нэг хоногт нийт малд шаардлагатай ус ба худгуудын ус өргөх чадварыг харьцуулсан үзүүлэлт

Сумдын нэр	Нийт малын тоо	Хэрэгцээт ус м/куб .хоног	Ашиглаж байгаа худгийн Тоо				Нэг хоногт гарсан
			Өрөмдмөл л худаг	Богино яндант	Уурхайн худаг	Энгий худаг	
Баацагаан		1195.5	17	42	74	146	316.5
Баянбулаг		751.7	9			34	151.9
Баянговь		592.2	12	52	45	115	664.49
Баянлиг		1573.3	13	25	112	293	945.1
Баяновоо		757.3	11	22	23		340.2
Баян-Өндөр		738	16	54	61	103	782.8
Баянцагаан		778.3	15	68	40	104	764.4
Богд		1012.2	8	14	51	73	425.7
Бөмбөгөр		598.3	8	29	26	85	413.8
Бууцагаан		1072.2	28	45	48	129	881.7
Галуут		1491.1	8	1		118	129.7
Гурванбулаг		912.2	4			3	57.4
Жаргалант		768.9	20				275.0
Жинст		716.1	15	24	34	60	494.1
Заг		773.8	7		1	14	111.4
Өлзийт		912.8	10	17	39	79	425.3
Хүрээмарал		622.2	17	13	20	61	419.0
Шинэжинст		612.0	15	81	56	229	988.2
Эрдэнэцогт		1312.8					
Дүн			237	519	630	1608	9362.3

хүснэгт 49

Аймгийн мал сүргийн ус хэрэглээ

Сумын Нэр	Ус хэрэглээ /мян.га/			Хонгийн /м.куб/	
	Жилийн	Улирлын		Зун Намар	Өвөл хаврын
		Зун намар	өвөл хаврын		
Баянхонгор	66.1	35.9	30.2	199.5	167.8
Баацагаан	507.0	291.8	215.2	1621.1	1195.5
Баянбулаг	271.8	136.5	135.3	758.3	751.7
Баянговь	254.6	148.0	106.6	822.2	592.7

Баянлиг	546.1	262.9	283.2	1460.5	1573.3
Баяновоо	328.9	192.5	136.4	1069.4	757.8
Баян-Өндөр	271.8	138.3	133.5	752.0	738.0
Баянцагаан	337.1	197.0	140.1	1094.4	778.3
Богд	418.7	236.5	132.2	1313.8	1012.2
Бөмбөгөр	240.0	132.3	107.7	735.0	598.3
Бууцагаан	379.2	204.8	193.0	11347.4	1072.2
Галуут	535.0	266.6	268.4	1481.1	1491.1
Гурванбулаг	329.1	164.9	164.2	916.1	312.2
Жаргалант	278.3	139.9	138.4	777.2	768.9
Жинст	307.9	179.0	128.9	994.4	716.1
Заг	281.3	142.0	139.3	738.9	773.8
Өлзийт	392.0	227.7	164.3	1265.0	912.8
Хүрээмарал	234.6	122.6	112.0	631.1	622.2
Шинэжинст	247.2	136.5	110.7	724.0	612.0
Эрдэнэцогт	456.3	220.0	236.3	1222.2	1312.3
Дүн	6701.0	3575.1	3125.9	19829.0	17359.2

хүснэгт 50

Инженерийн хийцтэй худгийн дундаж үзүүлэлтүүд

Сумдын нэр	Өрөмдмөл худаг			Богино яндант			Бетон хашлагат худаг		
	Дундаж ундрага л/с	Дундаж өртөг мян.төг	Дундаж гүн /м/	Дундаж ундрага л/с	Дундаж өртөг мян.төг	Дундаж гүн /м/	Дундаж ундрага л/с	Дундаж өртөг мян.төг	Дундаж гүн /м/
Галуут	1.45	133.63	86.8	0.5	15.2	15.0		15.78	
Шинэжинст	1.2	94.3	77.66	1.12	21.47	13.2	0.389	16.92	7.2
Баацагаан	2.6	75.88	66.8	1.11	20.99	14.19	0.55	15.9	8.47
Баянлиг	1.49	90.39	66.9	2.5	21.25	14.39	0.535	16.64	8.42
Баянговь	1.44	80.34	74.27				0.346	15.48	6.98
Богд	1.49	98.67	98.1	1.085	20.31	13.89	0.673		7.55
Байдраг	2.04	146.91	97.3					15.98	
Бууцагаан	1.2	73.5	65.8	1.05	15.8	23.6	0.455	11.26	9.51
Өлзийт	1.46	124.28	70.49	0.9	20.2	13.6	0.58		8.7
Баянбулаг	1.65	120.56	101.5						
Заг		68.8							
Гурванбулаг	0.8	115.4	98.2						
Хүрээмарал	1.28	96.2	83.0	0.58	18.03	13.0			
Хуучинжинст	1.58	88.7	76.2	0.86	21.0	14.6	0.59	10.98	7.64
Баян-Овоо	1.38	105.28	68.8	0.97	17.92	7.45	0.42		7.3
Баянцагаан	0.87	102.5	36.9		18.8		0.45		8.8
Баян-Өндөр	1.6	37.12	57.35	0.51	13.34	9.54	0.39		7.20
Эрдэнэцогт	1.05		36.5						
Бөмбөгөр	0.82		20.5				0.46		7.7

хүснэгт 51

Өвөл хаврын улиралд сумдын мал сүргийн ус хангамжийн үнэлэлт.

Д/Д	Сумдын Нэр	Бэлчээрийн талбайн Усжуулагдсан байдлын коэф Кб	Усаар хангагдсан байдлын коэфцент Ку	Нэгдмэл Коэфцент	Ус хангамжийн байдлын үнэлэлт
1	Баацагаан	0.67	0.68	—	Ус хангамжийн нөхцөл сайн
2	Баянбулаг	0.50	0.20	—	Хангалтгүй
3	Баянговь	0.82	1.08	—	Маш сайн
4	Баянлиг	0.84	0.60	—	Сайн
5	Баяновоо	0.63	0.46	—	Дунд зэрэг
6	Баян-Өндөр	0.77	1.0	—	Сайн
7	Баянцагаан	0.67	0.982	—	Сайн+
8	Богд	0.68	0.42	—	Дунд зэрэг
9	Бөмбөгөр	0.94	0.69	—	Сайн
10	Бууцагаан	0.88	0.82	—	Сайн +
11	Галуут	0.59	0.08	—	Хангалтгүй
12	Гурванбулаг	0.24	0.06	—	Их муу
13	Жаргалант	0.38	0.35	—	Хангалтгүй
14	Жинст	0.39	0.68	—	Хангалтгүй
15	Заг	0.76	0.14	—	Хангалтгүй
16	Өлзийт	0.70	0.46	—	Дунд зэрэг
17	Хүрээмарал	0.74	0.67	—	Сайн
18	Шинэжинст	0.75	1.08	—	Сайн
19	Эрдэнэцогт	0.60			Сайн

хүснэгт 52

Бэлчээр усжуулалтын түвшинг нэмэгдүүлэх, /тухайн түвшинд байлгах/ замаар ус хангамжийн нөхцлийг сайжруулах тооцоо

Сумын нэр	2005 оны түвшинд усжуулагдсан Байх талбай	Энэ хугацаанд шинээр нэмж Усжуулах /мян.га/	Нэг уст цэгийн усжуулах тал. Мян.га	Шинээр усжуулах барилгын тоо	Суурь онд байгаа И/Х- тэй уст цэг	1987-2005 онд усжуулсан талбайг хэвийн хангамжинд байлгахад шинээр нэмэх	Бүгд уст цэгийн тоо
Баацагаан	661.5	48.0	4.7	10	140	126	136
Баянбулаг	197.5	14.6	3.4	5	10	10	15
Баянговь	410.7	31.0	6.3	5	114	103	108
Баянлиг	997.9	73.9	5.0	15	184	162	177
Баяновоо	235.3	17.4	3.6	5	62	56	61
Баян-Өндөр	348.8	25.8	6.9	5	141	127	133
Баянцагаан	898.9	31.9	5.0	6	126	114	120
Богд	248.5	18.4	3.6	6	76	68	74
Бөмбөгөр	258.5	19.15	3.6	6.0	66	60	66
Бууцагаан	582.7	43.1	4.7	10	125	113	123
Галуут	271.0	20.0	2.8	7	13	13	20
Гурванбулаг	162.4	12.0	3.4	4.0	7	7	11
Жаргалант	291.16	21.5	2.3	9	25	23	32
Жинст	451.7	33.5	6.3	5	79	72	77
Заг	210.2	15.6	3.4	5	10	10	15
Өлзийт	281.7	20.8	3.4	6	67	61	66
Хүрээмарал	340.9	25.3	3.8	7	51	46	53
Шинэжинст	370.5	27.4	7.8	4	160	144	148
Эрдэнэцогт	287.8	21.3	2.6	7	2	2	9
Нийт	6343.66	519.15	82.6	127.0	1468.0	1317.0	1444.0

хүснэгт 53

**Ус хэрэглээний өсөлтийг хангах замаар
Мал сүргийн ус хангамжийг нэмэгдүүлдэх тооцоо**

	Сумдын нэр	Ус хэрэглээний өсөлтийн коэффициент /Ку/	Тооцооны коэффициент /КухКи -у/	Суурь оны уст цэгийн тоо	Алс хэтэд нэмж байгуулах уст цэг
1	Баацагаан	1.044	0.57	140	50
2	Баянбулаг	1.415	0.839	10	8
3	Баянговь	1.237	0.237	114	27
4	Баянлиг	1.093	0.420	184	77
5	Баяновоо	1.027	0.335	62	21
6	Баян-Өндөр	1.010	0.313	141	44
7	Баянцагаан	1.010	0.313	126	39
8	Богд	1.010	0.313	76	24
9	Бөмбөгөр	1.010	0.313	66	21
10	Бууцагаан	1.070	0.391	125	49
11	Галуут	1.012	0.315	13	4
12	Гурванбулаг	1.246	0.619	7	4
13	Жаргалант	1.214	0.578	25	14
14	Жинст	1.080	0.404	79	32
15	Заг	1.383	0.797	10	8
16	Өлзийт	1.010	0.313	67	21
17	Хүрээмарал	1.31	0.703	51	35
18	Шинэжинст	1.010	0.313	160	50
19	Эрдэнэцогт	1.105	0.436	2	2
	Нийт				520

а/ Одоогоор сумдын малын нийт ус хэрэглээний 60% /дундаж/-г инженерийн байгууламж бүхий уст цэгээр хангаж байгааг аймгийн дунджаар 90% хүргэх зорилт дэвшүүлж өсгөх коэф./Ки/-ыг 1.3 байхаар тооцоонд авч болно.

б/ Алс хэтэд байх малын тоо толгойн өсөлт нь сум бүрд өөр өөр байгааг харгалзан ус хэрэглээний өсөлтийн коэффициентийг тооцно.

$$K_y = \frac{2005}{1987} :$$

Үүнд: K_y -ус хэрэглээний өсөлтийн коэф.

Q-2005 алс хэтэд байх бүх малын ус хэрэглээ ,сум тус бүрээр гаргана.

Q -1987 –суурь оны түвшинд байгаа ус хэрэглээ .эдгээрийг хүснэгт 19-д харуулав. мал сүргийн ус хэрэглээг инженерийн байгууламжаар хангах. 90% хүргэхэд шаардагдах уст цэгийн тоог:

$$N \text{ алс} = N_{\text{суурь}} (K_i * K_y - 1)$$

гэж олж болох юм.

Аймгийн сум нэг бүрээр гаргасан коэффициент, уст цэгийн тоог хүснэгт №1-10-д үзүүлэв.

Ойрын үед бэлчээр усжуулалтанд хийх хөрөнгө оруулалтын хуваарилалт

Бууцагаан

	Газрын нэр	гүн	Ундрага		Хөрөнгө
1989	Улаан хуц	40	1,3	Засвар	4 541 350
1973	Хойлогийн худаг	60	1,5	Засвар	6 812 040
1981	Улаан үзүүрийн худаг	46	2	Засвар	5 222 564

1989	Хөтөл ус (Шавгын хоолой)	45	1,3	Засвар	5 109 030
------	---------------------------	----	-----	--------	-----------

Бөмбөгөр

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1976	Харгана	50	1,6	Засвар	5 676 700
	Хунзат	30	1,0	Шинэ	3 406 020
1976	Шар чулуу	40	1,0	Засвар	4 541 360

Жаргалант

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1975	Яргайтын ам (Өлийн ам)	60	1,5	Засвар	7 550 640
1976	Хүрэн хад (Цохиот)	85	1,0	Засвар	10 696 740
1976	Могойн хөндий	50	1,2	засвар	6 292 200
	Эрдэнэ толгойн худаг				

Баянхонгор

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
	Шаргалжуутын худаг	45		шинэ	5 109 030
1976	Цагаан эрэг 7-р баг	33	3,2	Засвар	3 746 622
	Уяачдын худаг	50		Шинэ	5 676 700
	Хөшөөт	20		шинэ	2 516 880

Гурванбулаг

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1972	Жаргалант хөндий	80	1,5	засвар	9 082 720
1986	Дуулгант хөндий	100	1,5	Засвар	11 353 400
1972	Мөсөнгийн өвөр	80	1,5	засвар	9 082 720

Баянбулаг

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1982	Баруун өвдгийн худаг	90	1,2	Засвар	10 218 060

Хүрээмарал

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1970	Бор дэнж	86	1,3	засвар	9 763 924

Заг

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1986	Өвөр Бумбатын шар хоолой	80	3,0	засвар	10 067 520

Эрдэнэцогт

	Газрын нэр	Гүн	Ундрага		Хөрөнгө
	Хүрэмтийн Ар улаан	40		Шинэ	4 541 360

Баянлиг

	Газрын нэр	Гүн	Ундрага		Хөрөнгө
1976	Таравын худаг	96	1,5	засвар	10 899 264
1980	Хулсны ам	104,0	1,0	засвар	9 709 225

Баянговь

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1974	Бор үзүүр	120	1,0	засвар	11 202 960
1976	Барилдаан	78	1,2	засвар	7 281 924

Шинэжинст

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1975	Баянзүрх	80	1,2	засвар	7 468 640
1978	Навтгар	120	1,1	Засвар	11 202 960

Баян-Өндөр

	Газрын нэр	Гүн	ундрага		хөрөнгө
1989	Сувраа заг	120	1,5	засвар	11 202 960
1988	Эхэн гүний далай	76	1,2	засвар	7 095 208

Баянцагаан

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1976	Эрээлэн	90	1,0	Засвар	8 402 220
1978	Баянбулаг	70	1,3	Засвар	6 535 060
1980	Эрээн дэрс	78	1,1	засвар	7 281 924

Баацагаан

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1979	Хоолойн толгой	80	1,2	засвар	7 468 640
1981	Сультын нуруу	68	1,0	Засвар	6 348 344

Галуут

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1989	Хонгорын өвөр	60	8,0	Засвар	7 550 640
	Бумбатын хоолой	58		шинэ	7 298 952

Баян-Овоо

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1985	Ар цалуу	26	0,8	Засвар	3 271 944
1979	Овооны худаг	60	1,0	засвар	7 550 640

Жинст

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1980	Хонхор бударгана	90	3,5	засвар	11 325 960
1974	Баруун хонгорын тал	71	1,5	Засвар	8 934 924

Богд

	Газрын нэр	Гүн	ундрага		хөрөнгө
1984	Цагаан хороот	45	0,9	Засвар	5 662 980
1978	Шандны аман ус	20	1,0	засвар	2 516 880

Өлзийт

	Газрын нэр	Гүн	ундрага		Хөрөнгө
1980	Ангал	70	1,4	засвар	8 809 080
1978	Зүүн шийрийн шанд	64	1,2	Засвар	8 054 016

3.1.12. Тэжээл үйлдвэрлэл, түүний хэтийн төлөв

Баянхонгор аймаг 1990 оны үед байдлаар 9.2 мян.га талбайд малын тэжээлийн ургамал тариалж 8.5 мян.тн таримал тэжээл үйлдвэрлэж байсан. 2015 оноос

эхлэн газар тариалангийн үйлдвэрлэлийн таримлын бүтцэнд таримал тэжээл 19.5 мян.га талбайг эзлэх болсноор 33.9 мян.тн тэжээлийн нэгж, алс хэтэд 55.9 тн тэжээлийн нэгж тэжээл үйлдвэрлэх боломжтой. Одоогийн байдлаар аймгийн дүнгээр хадлангийн талбай ургац сайтай бэлчээрээс 2-3 мян.тн өвс бэлтгэж байна.

2015 онд хадлан 31.6 мян.га, ургац сайтай 12.9 мян.га бэлчээрийн талбайг хадаж ашиглах ба хадлангийн талбайн 24.4 мян.га –г услаж, тордон сайжруулснаар нийт 28.7 мян.тн өвсийг өөрийн аймгийн нутаг дэвсгэр дээр бэлтгэх ба мөн өөрсдийн хүчээр гадны аймгийн нутаг дээр 6.4 мян.тн өвс бэлтгэнэ. Нийт 35.2 мян.тн өвс бэлтгэнэ.

Алс хэтэд бэлтгэх өвсний хэмжээг нэмэгдүүлэхийн тулд хадлангийн талбайг 40.6: бэлчээрээс хадаж ашиглах талбайг 44.4 мян.га-д хүргэж 49.2 мян.тн өвс аймагтаа бэлтгэх бололцоотой байна.

Судалгаанаас үзэхэд аймгийн бэлчээрийн хангамж дундажаар 65.7 % байгаа боловч сум тус бүрт харилцан адилгүй хамгийн их ачаалалтай сум Баянхонгор, Галуутад 139.2% байхад хамгийн бага Шинэжинст, жинст суманд 60.2% байна. Сум тус бүрийн бэлчээрийн тэжээлийн хангамжийн хувь харилцан адилгүй байгаа нь тухайн сумын бэлчээрийн даац, малын тоо, хоорондоо зохицоогүйгээс шалтгаалж байна.

Иймээс сумдын бэлчээрийн тэжээлийн хангамжийг сайжруулахын тулд бэлчээрийн дутагдалтай байгаа дээрх сумдад малын тоог төлөвлөгөөгөөр зохицуулж, цаашид өсгөхгүй байхын зэрэгцээгээр дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар төлөвлөлтөнд тусгаж байна.Үүнд:

1. Сумуудын хооронд нутаг бэлчээрийн шилжүүлэлт хийж зохицуулах
2. Бэлчээрийг улирлын сэлгээтэй ашиглах, усжуулаагдаагүй бэлчээрийг усжуулж ашиглах, талхлагдсан бэлчээрийг сэргээх арга хэмжээ авах
3. Бэлчээрт үндсэн ба тордон сайжруулалт хийх, таримал бэлчээр бий болгож мал төллүүлэх, бааз, саалийн фермийн малыг хангах зэрэг арга хэмжээнүүдийг авч явуулна.

Эдгээр арга хэмжээний үр дүнд сум тус бүрийн бэлчээрийн хангамж харьцангуй жигдэрч, нийт малд шаардагдах бэлчээрийн хангамжийг 100-гаас дээш хувьд хүргэх юм.

Алс хэтэд малын тоо өсөхийн хирээр бэлчээрийн тэжээлийн хангамж буурч ирэх боловч аймгийн дүнгээр 105.7 % байх болно.

Бэлчээрийн тэжээлээр хангах арга хэмжээ төлөвлөхийн зэрэгцээ цаг агаарын хүндэрсэн нөхцөлд малын нэмэгдэл тэжээлээр тэжээх олон мал бордох ферм, саалийн энгийн ба механикжсан ферм байгуулж байгаатай холбогдон хийж тэжээлийн үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрлийг олшруулахаар төлөвлөлтөнд тусгаж байна.

Судалгаанаас үзэхэд 1990оны үед дундаж үзүүлэлтээр бүгд 45.1 мян.тн тэжээлийн нэгж малын тэжээлд зарцуулсан бөгөөд нийт зарцуулж байгаа тэжээлийнхээ 44.3% буюу 20.0 мян.тн –ыг өөрийн хүчээр бэлтгэж 55.7 хувийг гаднаас худалдаж авч байна. Хонинд шилжүүлсэн 1 толгой малд 23.3 кг нэмэгдэл тэжээл зарцуулж байсан ба малын төрлөөр авч үзвэл нэг үхэрт 107 кг, хонинд 16.2 кг ямаанд 20.6 кг, адуунд 32.9 кг, Тэмээнд 40.4 кг нэмэгдэл тэжээл оногдож байна. Зөвхөн өөрийн хүчээр үйлдвэрлэж байгаа тэжээлээр нь тооцвол 1 хонинд шилжүүлсэн нэг малд 10.3 кг дээрх үзүүлэлтүүд нь нэг малыг тэжээх зохистой нормын хэмжээнд хүрэхгүй байна.

Тус аймгийн 2015 он, алс хэтэд байх нэмэгдэл тэжээлийн хэрэгцээг тооцохдоо аймгийн зоо-уурын үзүүлэлт мал бэлчээрлэх боломжгүй хонгийн тоог харгалзан үзэв. Цаашид дотооддоо үйлдвэрлэх тэжээлийн хэрэгцээг нэмэгдүүлэх 2015 онд 49694.4 тн, алс хэтэд 78109.7 тн тэжээлийн нэгжид хүргэх ба шаардагдах бүх тэжээлийнхээ 63-83 хувийг өөрийн хүчээр бэлтгэх болно. Аймгийн дүнгээр 2015 он алс хэтэд шаардагдах тэжээлийн балансийг дараах хүснэгтэнд харуулав

Малын тэжээлийн тооцоо

Он	Шаардагдах Тэжээл/тн,тэж, Нэгж/	Хангах тн,тэж,нэгж			Хангамжийн хувь
		өөрийн үйлдвэрээр	Худалдаж авах	Бүгд	
2015	78.5	48.8	29.7	78.5	100
Алс хэтэд	95.9	81.8	14.1	95.9	100

өөрийн дотоодод үйлдвэрлэх тэжээлийг нэмэгдүүлснээр нэг малд ногдох нэмэгдэл тэжээлийг 2015 онд 22.3 кг, алс хэтэд 37.1 кг-д хүргэнэ.

Хот тосгон бусад суурин газрын суурьшилын бүсийн газрын нөөц нөхцөлийн төлөвлөлт.

Нийгэм соёлын үйлчилгээний түвшин хангалтгүй, үйлдвэрлэл аж ахуйн уялдаа холбоо сул, зөвхөн засаг захиргааны үүрэг давамгайлсан сумдыг зах зээлийн харилцааны нийтлэг шаардлагын үүднээс нутаг дэвсгэрээр бүсчлэн , эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн чиг баримжаатай болгох асуудал хөдөөгийн хөгжлийн тулгамдсан асуудал болоод байна. Төвийн болон хязгаар нутгийн хөгжлийн ялгааг тэнцвэржүүлэх, хүн амын хэт төвлөрөл, их нүүдлийг сааруулах, бүс нутгууд харьцангуй бие дааж хөгжих, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх угтвар нөхцлийг бүрдүүлэх асуудал дэд бүтцийн оновчтой сүлжээнд суурилна. Одоогийн байгаа сууршлын бүсүүдийн хил заагийг тэлэн өргөжүүлэхэд болохгүй зүйл үгүй боловч энд байгаа шаардлагагүй сул чөлөөтэй зориулалтын бус газруудыг суурьших үйл явцад ашиглах, аль болох нягтралыг сайжруулах замаар зохистой ашиглах, Суурингуудын орчныг экологийн тэнцвэржүүлэх бүс болгож хамгаалалтын дэглэмийг сайтар мөрдөх хэрэгтэй.

Хот суурингийн газрыг зөв оновчтой ашиглаж, хамгаалахын тулд суурьшилын тэг гортиг доторх нутаг дэвсгэрийг хотын функциональ бүсүүдэд төрөлжүүлэн ангилж /хүснэгт 54/ тэдгээрийн ерөнхий чиг , үүрэг роль, онцлогийг тодорхойлов. Үүнд:

1. Амины орон сууцны бүс. Энд сумын төвүүдэд орших айл өрхийн дангаараа буюу хэд хэдээрээ тодорхой эзэмшил газар хайс, хашаатайгаар нэг буюу хэд хэдэн байр орон сууцыг блоклон барьсан хөршийн хэлбэрээр оршин сууж байгаа амины орон сууцны барилгын газрыг багтаасан бөгөөд энд нийтдээ га талбайг хамрууллаа. Энэ бүс нь Жинст, Богд, Жаргалант зэрэг сумдын суурьшилын бүсэд тод ажиглагдана. Энд бие засах газар, муу усны цооног, хогийн цэг зэрэг нь нийтийнх байна. Ихэвчлэн гадна талаараа жижиг хайс хашаа барьжээ.

2. Нийтийн орон сууцны бүс. Энэ бүс нь аймгийн төвд тод илрэх бөгөөд 3-4 давхар баригдсан төвлөрсөн усан хангамж, инженерийн системд холбогдсон газар байх бөгөөд эзэмшил газар багатай, байрнаас хайш хаашаа 50 м газрыг нийт дундаа эзэмшинэ. Энд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дэлгүүр зэрэг тусгайлан баригдсан цогцолбор үйлчилгээний төв баригдаагүй. Энд тэнд бичил хороолол маягаар 3-5 ширхэгээр нэг дор баригдсан байна. Гаднаа аж ахуйн жижиг агуулахын зориулалттай амбаар сав, нэгдсэн нэг хогийн цэгтэй. Эдгээр бичил хорооллууд нь социализмын үед хот төлөвлөлт, архитектурын төслийн дагуу баригдсан нийтдээ га талбайг эзлэн оршино. Орон сууц хувьчилсантай холбогдуулан орчныхоо газрыг хашаажуулж түүнээс залгуулан гэр хороолол үргэлжлэх болсон нь нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэлийг алдагдуулж байна.

3. Гэр хорооллын бүс. Энэ бүс нь дээрх 2 бүсийг бодвол аль ч сумд

нэлээд түгээмэл хөгжингүй оршино. Эзлэх талбайн хувьд ч харьцангуй их 1178.3 га талбайг эзлэн оршдог бөгөөд нийт хүн амын дийлэнх хувь амьдардаг орон сууцны нэг хэлбэр юм. Энд айлууд хороо, гудамны хэлбэрээр уг бүсийг үүсгэх бөгөөд 1 гудам хооронд 10-20 м, 1 өрхөд 20*35 м газар дундажаар оногдоно. Цахилгаан, зөөврийн усан хангамж, зарим газар өрхийн эмнэлэг, дэлгүүр, ТҮЦ байна. Хогоо суурьшилын бүсийн хогийн цэгт голдуу зөөвөрлөн хаядаг. Гэр хорооллын газрыг төлөвлөхдөө зам, шугам сүлжээ, усан хангамж, сургууль, эмнэлэг цэцэрлэг зэрэг хүн амын үйлчилгээнд зайлшгүй хэрэгцээт объектуудыг барих газрыг урьдчилан төлөвлөж тусад нь авч үлдэх хэрэгтэй. Гэр хорооллын газар нь дийлэнх хүн амын орон сууцны хэрэгцээг хангадаг учир цаашид сум бүрт тодорхой хэмжээний газрыг шинээр олгохоор төлөвлөж өгсөн /зураг/ бөгөөд гэхдээ эхний ээлжинд гудам хооронд байгаа онгорхой, тасархай газруудыг нөхөж олгох, цаашид шинээр төлөвлөсөн газарт газар олгох нь зүйтэй. Энд нийтдээ 293.8 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд гэр хороололд олгохоор төлөвлөвөө. Хойшид газраа зүлэгжүүлэн цэцэрлэгжүүлж тохижуулсан өрхийг газрын татвар төлбөрөөс чөлөөлж, харин газрыг бохирдуулсан хайр гамгүй эдэлсэн айлын газрын төлбөрийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Гэр хороололын газрыг оновчтой нормчлон төлөвлөж олгоогүйгээс зарим айлын хашаа цахилгаан шугам сүлжээний хамгаалалтын бүс болон, худгийн эрүүл ахуйн бүсэд орсон байдаг. Түүнчлэн гудамжинд машины орц гарцыг төлөвлөөгүйгээс хүн ба машин техникт илүү явалт үүсэж, үр ашиггүй зардлыг нэмэгдүүлнэ.

4. Нийтийн үйлчилгээний бүс нь дотроо үүрэг, зорилго, хариуцлагынхаа дагуу хэд хэдэн төрөлжсөн бүсэд хуваагдаж болох боловч “бүгдийг нэг дороос” гэсэн зарчмыг баримтлан худалдаа ахуйн үйлчилгээний салбаруудыг нэг дор төвлөрүүлэн төлөвлөх ёстой. Энэ бүсэд банк, холбоо, дэлгүүр, гуанз, бар, ресторан, хүнсний зах зэрэг үйлчилгээний газруудыг багтааж га газрыг хамрууллаа. Гэвч зарим суурин газруудад энэ бүсийн ялгаа одоогоор тод ажиглагдахгүй байгаа боловч хойшид баримтлах үүднээс боломжтой газруудад уг бүсийг ялгаж өгөв. Энэ бүс нь эдийн засгийн нөлөө бүхий төв суурин газруудыг холбож өгсөн замаас зайлшгүй хол зайд тухайн үйлчилгээний газар руу ирэх хөдөлгөөнийг хүлээн авч хэд хэдэн цэг рүү саадгүй сарниулж чадах орон зайн нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой боловч дээрх суурин газрууд нь томоохон хотуудын хэмжээнд хүртэл хөгжиж чадаагүй учир эсрэгээр зам дагуу төв суурин газраа бараадан байрласан байна.

5. Спорт, амралтын бүс. Энэ бүсэд спортын болон соёлын ордон, морин тойруулга, морь барих газар, наадмын талбай, биеийн тамирын талбай зэргийг хамарч нийтдээ га талбайг эзлэнэ.

6. Ногоон байгууламжын бүс. Уг бүсэд төв суурин газруудын эзэмшил доторх болон зориудаар байгуулсан сад, цэцэрлэг хойшид байгуулж болох ногоон байгууламжийг хамруулав. Уг бүс нь хүн амын эрүүл мэнд, нөхөн сэргэх, алжаал ядаргаагаа тайлах, агаарын бохирдлыг багасгахад чухал үүрэг гүйцэтгэх учир хот төлөвлөлтөнд байх зайлшгүй бүс юм. Одоогоор уг бүс нь га талбайг эзлэж байгаа нь нийт суурьшилийн бүсийн дөнгөж %-ийг эзлэж байгаа нь туйлын хангалтгүй байгаа учир цаашид энэ хэмжээг га талбайд хүргэхээр төлөвлөв.

7. Аж үйлдвэрийн бүс. нь аймгийн төвөөс бусад сумдад төдийлэн тод ялгарахгүй бөгөөд харин улсын нөөцийн өвсний фонд, хөдөө аж ахуйн машин – тракторын бааз-засварын газар, авто граж-засварын газар, саалийн ферм, гахай тахианы ферм, газар тариалангийн бригад, салаа, ХАА-н бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийдэг жижиг цех, үйлдвэр агуулах гэх мэтийн хэлбэрүүдээр илэрдэг онцлогтой. Уг бүсийн газрыг төлөвлөхдөө аль болох хотын тэг гортигийн гадна буюу салхин дор газар байгуулах нь хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд чухал ач холбогдолтой. Баян-Овоо, Өлзийт сумдыг Баянхонгор хотын дагуул хот баг байхаар төлөвлөж байгаа учир энд ХАА-н элдэв үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудыг байгуулж болох юм.

8.Эрүүл мэнд соёл боловсролын бүс. Энд бага дунд ерөнхий боловсролын сургууль, ТМС, цэцэрлэг, эмнэлэг зэрэг газруудыг аль болох тусад нь ялгаж бүс байхаар төлөвлөсний дээр бусад зориулалтын газарт олгохгүй байх нь зүйтэй.

9. Засаг, захиргааны бүс. Энд мэдээжийн хэрэг, аймаг болон сумын захиргаа, банк, холбоо гэх мэтийн захиргаа, удирдлагын ач холбогдол бүхий объектуудыг байхаар төлөвлөв.

10.Зам харилцааны бүс. Энд хот суурингийн тэг гортиг доторхи төв болон туслах чанартай замуудыг төлөвлөж га газрыг багтаалаа. Эдгээр замууд нь 5-7 м-ийн өргөнтэй байх бөгөөд дээр нь хамгаалалтын зурвас 1-3 м байна. Хатуу хучилттай болон ердийн шороон зам байж болно.

11. Өрхийн мал аж ахуйн бүс. Хөдөөгийн хот суурин газрын иргэд цөөн тооны мал агуулах сонирхол өндөр байдгийг харгалзан мал бүхий иргэдэд зориулж уг бүсийг ялгаж өглөө. Энэ бүс нь суурьшилын бүсийн тэг гортигноос гадна байхаас гадна мал бэлчээх зам нь хотын тэг гортиг дундуур гарахгүй аль болох бэлчээр усандаа ойр байхаар төлөвлөнө. Мөн малаас гарч байгаа өтөг бууцыг ч хаана хаях газрыг бодолцох хэрэгтэй. Ялангуяа Баянхонгор хотын хувьд мал аж ахуйн бүсийг Өлзийт, Баян-Овоо суманд байхаар төлөвлөв.

12. Ногооны газрын бүс. Ногооны бүсийг аль болох суурьшилын тэг гортигноос гадна талд үржил шим бүхий хөрстэй, усалгаанд ойр газар олгох хэрэгтэй. Энд Баянхонгор сумын хувьд хотын хойт талд болон зүүн хойд талд Түйн голын хөндий орчмоор байж болох юм. Бусад сумдын хувьд сумын төв хүн амын суурьшилд ойр байвал зохимжтой боловч гол нь талбайн хөрс, усалгааны эх үүсвэрийг бодолцож хийх нь зүйтэй. Тухайлбал Бууцагаан, Баянцагаан, Өлзийт, Баян-Овоо, Жинст, Богд, Жаргалант зэрэг сумдад ногооны газрыг сумын төвийн дэргэд төлөвлөх бололцоотой.

13. Эрүүл ахуйн бүс. Хот суурингийн тэг гортиг дотуур дайран өнгөрч байгаа гол горхи, булаг шанд, мөн худаг, усан сан зэргийг ундны усны эх үүсвэр хэмээн үзэж тэдгээрт 100 м-ээс доошгүй өргөнтэй эрүүл ахуй хамгаалалтын бүс татав. Хотын тэг гортиг гортиг дотор дээрх зайлшгүй байх ёстой, тусгай үүрэг хариуцлага бүхий функциональ бүсүүдийг ялгаж өгсөнөөс гадна ойрын ирээдүйд барилгажих газар, шинээр суурьших гэр хорооллын газар мөн цаашид хот тэлэн өргөжих бүсийг тусад нь төлөвлөв. Үүнд.

14. Барилгажих бүс. Энд юуны өмнө одоогийн байгаа барилгажсан талбайн нягтралыг дээшлүүлэх асуудлыг нэн тэргүүнд тавих бөгөөд дараагийн ээлжинд бидний дурьдсан газруудад газар олголт хийх юм /зураг/. Газар олголтыг хийхдээ барилгажих хэсгээс гадна тухайн орчны тохижилт, хашаа хайс, зам харгуй, ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн асуудлыг давхар хөндөж цаашид үүнд хяналт тавих хэрэгтэй. Энд нийдээ га газрыг шинээр барилгажих газарт олгохоор сум бүрт төлөвлөв.

15. Шинээр олгох гэр хорооллын газар. нь барилгажих газрын нэгэн адил одоогийн гэр хороолол дотор байгаа онгорхой цоорхой газар, гудамуудыг нөхөх гүйцээх замаар хийгдэх бөгөөд дараагийн ээлжинд бидний заасан газруудад гэр бүлийн хэрэгцээнд шинээр газар олгоно / зураг/. Гэхдээ гэр хорооллын газарт байх өрхийн эмнэлэг, хүүхдийн цэцэрлэг, худаг, дэлгүүр зэрэг наад захын үйлчилгээний газруудыг байхаар төлөвлөж газрыг бусад хэрэгцээнд олгохгүй байх хэрэгтэй. Энэ хэрэгцээнд сум бүрт тухайн газрыг зааж нийт 293.8 га газрыг төлөвлөв.

16.Хот тэлэн өргөжих бүс. Хот хэтийн ирээдүйд тэлэх бүсийг сум тус бүрийн нутагт тодорхой хэсэг хэсэг газрыг гаргаж нийт га газрыг хамрууллаа. Энд ойрын ирээдүйд шинээр уул уурхай бусад үйлдвэрлэл, зам харилцааг даган хөгжих шинэ хот суурин байхгүй одоогийн байгаа суурингийн эдэлбэр газрыг тэлэн хөгжихээр төлөвлөллөө. Харин Баянхонгор сумын дэргэд орших Баян-Овоо,

Өлзийт сумдыг Баянхонгор хотын дагуул хот баг байхаар төлөвлөсөн бөгөөд энд цаашид голчлон эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх газар тариалан-мал аж ахуйн бүс нутаг байх юм. Шаргалжуут баг нь нутаг дэвсгэрийн хувьд Эрдэнэцогт суманд засаг захиргааны хувьд Баянхонгор суманд харъяалагдаг нь аливаа ажил төрөл зохион байгуулахад зохимжгүй тул шууд Эрдэнэцогт сумын мэдэлд байхаар төлөвлөв.

Дээрхээс гадна хот суурин газрын төлөвлөлтөнд хотын хогийн цэг, оршуулгын газрыг зайлшгүй байхаар төлөвлөж өгөх шаардлагатай бөгөөд тэдгээрийг одоогийн байгаа газарт, хэмжээг бага зэрэг тэлэх маягаар ойрын үед ашиглахаар төлөвлөв.

Төв суурин газруудын төлөвлөлийн зургийг сум, томоохон багийн төв тус бүрээр 1:2 000 масштабаар хэвлэн гаргав.

17. Хог хаягдлын бүс Суурин газрын хогийн цэг нь салхины зонхилох чиглэлийн доор байрлаж, тэмдэгжүүлсэн, ухаж шан хүрээ татсан, ангилан ялгах талбайтай байх зүй ёсны шаардлага гарч байна. Хогийг шатаах булах зэрэг уламжлалт аргаас гадна дахин боловсруулахүйлдвэрийг зохион байгуулах шаардлагатай.

Дүгнэлт .

Баянхонгор аймгийн хот суурингийн суурьшилын бүс нь ерөнхийдээ социализмын үеийн хот төлөвлөлтийн дагуу баригдсан. Зах зээлийн үед нэг хэсэг барилгажих асуудал нэг хэсэгтээ зогсонги байдалд орсон боловч сүүлийн үед аж ауйн нэгж байгууллага, гадаадын төсөл, улсын төсвөөр нэлээдгүй шинэ барилга баригдах буюу сэргээн засварлах ажил эрчимтэй явагдаж байгаа. Гэр хорооллын хувьд ч харьцангуй үсрэнгүй хөгжиж байна. Аймгийн төв Баянхонгор сум нь зах зээлийн харилцааны шинэ нөхцөлд хотын ерөнхий төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлсэн цөөхөн хэдэн сумын тоонд ордог, энэ утгаараа бусад сумдаа бодвол суурьшилын бүсийн функциональ бүсүүдийн ялгаа нэлээд тод ажиглагддаг сум юм. Бусад сумын төвүүдийн суурьшилийн бүсүүдийн хувьд функциональ бүсүүдийн ялгаа төдийлэн ажиглагдахгүй нэг нь нөгөөгөө орлох маягаар явдаг. Харин гэр хорооллын бүс харьцангуй тод ялгарна. Иймд цаашид хот суурингийн суурьшилын бүс газрыг үндэслэлгүй тэлэх асуудлыг хязгаарлах, барилгажилтын нягтралыг сайжруулах, бүсүүдийн ялгаа, үүрэг ролийг тодотгох, орон зайн шийдэлийг зөв зохицуулах хэрэгтэй. Төлөвлөлтийн ажлын хүрээнд га газрыг гэр хорооллын газарт, га газрыг шинээр барилгажих газарт, бусад зориулалтаар хот тэлэх газарт га талбай олгохоор тус тус төлөвлөв. Мөн аймгийн төвийн дэргэд орших Баян-Овоо, Өлзийт сумдыг Баянхонгор хотын дагуул хот баг байхаар төлөвлөсөн бөгөөд энд цаашид голчлон эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх газар тариалан-мал аж ахуйн бүс нутаг байх юм. Шаргалжуут баг нь нутаг дэвсгэрийн хувьд Эрдэнэцогт суманд засаг захиргааны хувьд Баянхонгор суманд харъяалагдаг байдлыг халж шууд Эрдэнэцогт сумын мэдэлд байхаар төлөвлөв.

3.5.3. Үйлдвэр уурхайн бүс газар, тэдгээрийн нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Ноос, ноолуурт анхан болон дунд шатны боловсруулалт хийх замаар нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүн, эсгий эдлэл үйлдвэрлэх

Сүү, тараг, цөцгий тос, ингэний ундаа зэрэг цагаан идээ боловсруулах орчин үеийн технологи бүхий

Мах махан бүтээгдэхүүн үйлвэрлэх, бог малын өлөн гэдэс боловсруулан экспортод гаргах

Бод , богийн арьс шир боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Хүн амын өргөн хэрэглээний, гэр ахуйн болон ердийн хөсөг, мал аж ахуйн тоног төхөөрөмж, хадлан, тэжээл үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэх

Техникийн үйлчилгээ оношилгооны төвлөрсөн цэг, тоног төхөөрөмж үйлдвэрлэх

Эмийн ургамал боловсруулж эм бэлдмэл үйлдвэрлэх

Рашаан ус савлах

Баянхонгор , Шинэжинст сумдад шахмал түлшний үйлдвэр байгуулах, тоосгоны үйлдвэрт өргөтгөл шинэтгэл хийх замаар жилд 2,5 сая тоосго үйлдвэрлэх, Баянхонгор, Эрдэнэцогт сумдад хүрмэн блокийн үйлдвэр байгуулагдах юм. Шинэжинстийн Хотгор дэрс, Өвөрчулуутын нүүрсний орд газруудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах шаардлагатай.

Давхардсан тоогоор 362 аж ахуйн нэгж 2 736 899 га талбайд ашигт малтмалын эрэл хайгуулын ажил гүйцэтгэж байгаа нь Баянхонгор аймгийн нийт нутгийн 23,6% болж байна. Эдгээр ажлын үр дүнгээр доор дурьдагдаж байгаа ашигт малтмалын орд, илрэл, эрдэсжсэн цэгүүдийн эдийн засгийн ач холбогдол бүр тодорхой болох юм.

Түүнчлэн одоо 65 ашиглалтын лицензээр эзэмшиж байгаа 13 492,2 га газрын 71,5 % буюу 9645,5 га газар уурхайн эдэлбэрт орох болно.

Бичил уурхайн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж байгаад нутгийн иргэдийн хяналт тогтоох,

Бичил уурхай эрхлэгчдийг Иргэний хуулийн 481 дүгээр зүйлд заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулан бүтэц зохион байгуулалтыг өөрсдөөр нь тогтоолгох,

Бичил уурхайн нөхөрлөлд олгох талбайн хэмжээг нөхөрлөлийн нэг гишүүнд ногдох нэгж талбайн хэмжээг үндэслэнм тогтоох бөгөөд энэ нь ойролцоогоор 15-20 га орчим байх

Үйлдвэржилтийн бүс газарт ойрын жилүүдэд ашиглах ашигт малтмалын орд илрэлүүд, түүнийг түшиглэн босох уул уурхайн үйлдвэрүүдийн хэтийн төлөвийг тодорхойлж, уурхайнуудыг түшиглэн байгуулагдах үйлдвэржилтийн бүс газруудыг төлөвлөв.

Баянхонгор аймгийн нутагт хар металлаас төмрийн 12 илрэл, хромын 1 илрэл, гянт болдын 1 илрэл, өнгөт металлаас зэсийн 1 орд, 27 илрэл, молибдений 1 илрэл, цайрын 1 илрэл, никелийн 1 илрэл, мышякийн 2 илрэл, цагаан тугалганы 2 илрэл, хар тугалганы 1 илрэл, үнэт металлаас алтны 24 орд, 55 илрэл, мөнгөний 4 илрэл , сурьмын 1 илрэл, металл бус ашигт малтмалаас чулуун нүүрсний 2 орд, 9 илрэл, хүрэн нүүрсний 2 орд, 9 илрэл, шатдаг занарын 2 илрэл, бал чулууны 2 илрэл, гялтгануурын 2 илрэл хайлуур жоншны 3 илрэл, исланд жоншны 1 илрэл, хайлшийн кварцын 10 илрэл, маргенцийн 1 илрэл, гоёлын чулууны 13 илрэл, мусковитийн 6 илрэл, магнетитийн 1 илрэл, фосфоритын 1 илрэл, баритын 1 илрэл, барилгын материалаас тоосгоны шаврын 3 орд, шохойн чулууны 2 орд, 2 илрэл, хайрганы 1 орд, элсний 1 орд, барилгын чулууны 4 орд, өнгөлөөний чулууны 2 илрэл, будгийн түүхий эдийн 2 орд 1 илрэл, гөлтгөнийн 1 илрэл, 4 орд, асбестийн 1 орд, 2 илрэл, давсны 4 орд 2 илрэл илрээд байгааг нэгтгэн үзвэл

34 төрлийн ашигт малтмалын 47 орд, 173 илрэл тогтоогдоод байна. Эдгээрээс эдийн засгийн хувьд ашигтай ойрын 15 жилд ашиглалтанд орох магадлалтай ашигт малтмалын 24 орд газрыг сонгон газар бүсчлэн хуваарилах төлөвлөлтөд тусгалаа.

3.5.4. Амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын талаар

Ойрын ирээдүйд дараах нутгууд шинээр амралт сувилал, аялал жуулчлалын 4 бүс нутгууд болон хөгжих магадлал сайтай.

1. Бөөнцагаан нуур орчмын бүс

Баянхонгор хотоос Бөмбөгөр сум 95 км, Бууцагаан сум 79 км, Хүрээмарал сум 44 км, Баацагаан сум 130 км, буцаад Баянхонгор хот 143 км. Аялах замын урт 500 км аялах хугацаа 3-4 хоног.

Бууцагаан сумын Дунд мандал, Адаг мандал ууланд сүг зураг, шаантаг бичигтэй хад байдгийг 1998 онд улсын хамгаалалтанд авчээ.

Баацагаан суманд Төрийн шагналт яруу найрагч Ч. Лхамсүрэнгийн гэр музейг үзнэ.

Хангайн нурууны өвөр, Алтайн нурууны ард орших нууруудын хөндийн таван нуурын хамгийн том талбайтай нь Бөөнцагаан нуур юм. Далайн түвшнээс дээш 1326 м өндөрт орших 240 х.д.км талбайтай энэ нууранд алтайн шар загас, усны ховор шувууд байдаг.

Их Аргалант уул манай агнуурын нөөц газрын нэг.

Байдраг голын адгийн зүүн салаа Цагаан гол Адгийн цагаан нуурт цутгана. Одоогоос 100 орчим мянган жилийн өмнө Хангайн сүүлчийн мөстлөг хайлж байх үед Бөөнцагаан, Адгийн цагаан, Орог, Хаяа нуурууд их устай байснаа мөс хайлж дууссаны дараа голуудын ус татрах үед энэ нууруудын ус татарч эхэлсэн. Адгийн цагаан нуурт ус их байх үед байсан хуучин дэнжүүд одоогийн нуурын түвшнээс их дээгүүр маш тод харагддаг.

2. Эхийн гол-Амарбуянтын хийд орчмын бүс

Шинэжинст сумаас Баянцагаан сум 75 км, Баян-Өндөр сум 57 км, Амарбуянтын хүрээ 45 км, буцаад Шинэжинст сум 80 км

Шинэжинстийн төвөөс урагш Ногоон цавын хоолой, Эхийн голын чиглэлд аялж болно.

Шинэжинст сумын төвөөс Говь Алтайн нурууг урагш нэвтлэн гарах хадан хавцалыг Цагаан хаалга уул гэдэг.

Цагаан хаалга уулнаас урагш Алтайн өвөр говиор аялахад Жартын хөв, Далтын хөв, Зуунмодны баян бүрд зэрэг үзэсгэлэнтэй сайхан тал говь нутгаар явна. Зуун модны баян бүрдэд тооройн төгөлтэй, устай, өвс ургамалтай үнэхээр сайхан нутаг.

Зуун модны баян бүрдээс цааш 20 км орчимд замын баруун талд байдаг 1160 м өндөр унтарсан галт уулыг дөш хайрхан гэнэ.

Ингэн хөөврийн хоолойн баруун захад орших Ногоонцавын хоолой гэдэг эртний төрмөлийн эриний нуурын олон олон өнгөт хурдсыг үзнэ. Түүний улаан, шар, ногоон өнгөт давхрагаас алаглан харагдах хориод м өндөр 8-10 км урт үргэлжилсэн эгц эрэг үнэхээр үзэсгэлэнтэй. Эндээс Цэрдийн галавын үеийн үлэг гүрвэл, аварга яст мэлхийн чулуужсан яс олддог.

Цувилуур Харын нурууны зүүн дор орших бөгөөд Цагаанбогдын нурууны хойд талын салбар уулсын арын уулсын ул хөрсний усаар тэжээгдэж байдаг олон булагийн нийлбэр эхийн голын баян бүрдийг тэжээдэг. Нийт 17 км орчим урт, 5 км орчим өргөн талбайг хамарсан энэ баян бүрдэд Монголын улаан номд орсон тоорой, сухай, жигд, лидэр элбэг ургадаг. Наранд халан харлаж гялайсан чулуурхаг сүрлэг нүцгэн уулстай, өвс ургамалгүй ээрэм говь цөлд орших энэ ногоон арал зундаа 42,2 хэм хүртэл халдаг манай орны хамгийн халуун цэг юм. Жилд дунджаар 13,4 мм хур тунадас унана. Эхийн голд 1-р сард дунджаар - 11,6 хэм , 7-р сард 26,4 хэм халуун байдаг.

3. Заг - Байдрагийн бүс

Жаргалант сумын төвөөс Биндэръяа Хөх нуур 30 , Гурванбулаг сумын Хөх нуур 75 км, Гурванбулаг сум 35 км, Баянбулаг сум 75 км, Заг сум 82 км, Халиутын рашаан 40 км , буцаад Байдраг сум 50 км. Аялах замын урт 400 км, аялалын хугацаа 2-3 хоног

Байдрагийн гол Хангайн нуруунаас эх авч урагшаа 310 км урсаад Бөөнцагаан нуурт цутгадаг. Байдраг голд алтайн шар загас, хадран загас байдаг. Байдраг голд Биндэръяа хөх нуураас их авсан Загийн гол Заг сумын төвөөс доош холгүй цутгадаг. Энэ хоёр голын бэлчирт Монголын хаадын чуулга болж байсан газрыг Хүрэн бэлчир гэдэг.

Баянхонгор аймгийн Заг сумын нутагт Заг, Байдрагийн голын уулзвараас 10 км орчимд далайн түвшнээс дээш 1273 м өндөрт Халиутын рашаан байдаг.

Заг сумын төвөөс 28 км зам саадгүй бөгөөд бусад талаасаа очиход нилээд хүндрэлтэй. Рашааныг Дулаан хар, Цахирын нуруу, Дамжуургын нуруу, Хадат хавцал, Ямбат уул гэх мэт хуучин төрмөлийн эриний хувирмал тунамал хурдас чулуулагаас голлон тогтсон хадат сэрвэн уулс , хад цохио хүрээлэн оршино. Ямбат ууланд бага зэрэг хусан ой, Тосвойн амны Цахирт хусан цагдуултай. Халиутын рашаан орчим голын захаар шохойлог элсэнцэр, хөрстэй голын наанги шаварлаг хөрстэй, цахилдаг, халгай, шаваг, ганга зэрэг хээр тал, хадат толгод, голын захын ургамалтай, рашааны дэргэд голын хөвөөний зурвас зүлэг дагуу цагаан бургас бут бага зэрэг байдаг.

Хуучин төрмөлийн эрийний саарал өнгөтэй их зузаан шохойн чулуу, саарал алаг гантиг зэрэг цогцлолын их эвдэрсэн бүс газрын чулун дундаас 14 булаг оргилох бөгөөд бүгд адил чанартай. Байдрагийн голын баруун эргээс 2-3 м зайтай голын зах дагаж урсаад голд нийлнэ.

Заг сумын нутагт 56 м урт Сэндэртийн агуй байдаг.

4. Гурванбулаг сум Хөх нуур орчмын бүс

Гурванбулаг сумын төвөөс баруун хойш мөстлөгийн морренд боогдож үүссэн 10 орчим үзэсгэлэнт нуур байдаг Тэдгээрийн хамгийн том нь 15 км орчим урт Хөх нуур юм.

Хөх нуураас эх авсан Богино уулзварын гол Нарийн голтой нийлэн Хар усан голд цутгаж цааш явсаар Буянтын голд цутгана.

Баянбулаг сумын Хөшөөтийн хөндийд Хөшөөт нуурын баруун урт довцог дээр чулуун хөшөөнүүд байдаг

Зам, шугам сүлжээний газрын төлөвлөлт

Авто замын газрын төлөвлөлт

Шинээр авто замын тавигдахгүй, зөвхөн замын хучилт өөрчлөгдөх, шинээр зам паспортжуулж улсын бүртгэлд авах зэрэг ажлууд л хийгдэх тул тооцоонд 72 км замын өргөн өөрчлөгдөж 288 га газар нэмэгдэж тооцогдох юм.

Төмөр замын газрын төлөвлөлт

Баянтээг – Баянхонгор - Бууцагаан - Хүрээмарал - Говь-Алтайн Жаргалангийн чиглэлд 399,7 км төмөр зам тавигдана. Түүнчлэн Арвайхээр - Шивээхүрэнгийн чиглэлийн 88,4 км төмөр зам Баянлиг сумын нутгаар дайран өнгөрөх юм. Нийт төмөр замын урт нь 488,1 км байна. Төмөр замын зурваст 5569,2 га, өртөөнд 720 га бүгд 6289,2 га газар шаардлагатай.

3.6..3. Шугам сүлжээний газар, түүний төлөвлөлт

Баянхонгор-Улиастайн 220 кВ-ийн 255,8 км шугам барихад 639,5 га газар шаардлагатай.

Өвөрхангайн Баруунбаян - Улаанаас - Баянлиг сумын төв рүү 35 кВ-ийн 110 (61,6) км шугам, Баянлиг-Баянговийн 10 кВ-ийн 45 (42,5) км шугам

Баруунбаян-Улаан-Богд 15 кВ-ийн 90 (33) км шугам Богд – Жинстийн 15 кВ-ийн 32 (25,2) км шугам

Баянхонгор –83- Бөмбөгөр- Бууцагааны 35 кВ-ийн 66,6 (149,6) км шугам, Бөмбөгөр - Баацагааны 15 кВ-ийн 80 (70,7) км шугам , Бөмбөгөр-Загийн 35 кВ-ийн (41,4) км шугам, Бууцагаан -Хүрээмаралын 15 кВ-ийн 63,2 км

Баян-Овоо - Галуутын 15 кВ-ийн 84 (85,8) км, Гуулин-Баянбулагийн 10 кВ-ийн (40,2) км шугамууд шинээр ашиглалтанд орно.

Өнөөгийн түвшинд Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумуудын төвүүдийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр цахилгаанжуулах асуудал яригдаж байгаа боловч Баянцагааны төвд дизель станц байгуулан 10 кВ-ийн шугам Баян-Өндөр 27,6 км, Шинэжинст 27,9 км сумууд руу татах хувилбар байж болохыг үгүйсгэхгүй. Эдгээрт нийт 1608,2 га газар шаардлагатай.

Холбооны шугамын газар нэмэгдэхгүй, Шинээр шилэн кабелийн сүлжээнүүд бий болох боловч тэр нь одоо байгаа холбооны шугам бүхий газраар тавигдана. Өөр газраар тавигдсан ч хуучин холбооны шугам нь ашиглалтаас хасагдах тул холбооны шугамын зурвасын хэмжээ өөрчлөгдөхгүй. Шинжлэх ухаан технологийн дэвшил хурдас ч утасгүй холбоо, хөдөлгөөнт холбоо амьдралд нэвтрэх болсноор ирээдүйд холбооны шугамын газрын хэмжээнд өөрчлөлт орох болбол зөвхөн хасагдана.

3.7. Ойн сангийн газрын төлөвлөлт.

Ойн санг менежментийн дараахи 3 бүсэд хуваалаа /зураг, хүснэгт 55/. Үүнд:

1.Онцгой бүсийн ой. Энд УТХГазарт орших Эрдэнэцогт сумын 1906 га, Галуут сумын нутагт 8377 га ой болон Баянлиг-24680га, Шинэжинст-93566га, Баян-Өндөр-236057га, Баянговь-2366га сумын нутагт байх заган ойг онцгой бүсийн ойд багтаалаа. Уг газар ямар нэг аж ахуйн үйл ажиллагаа явуулах, мод огтлохыг бүрмөсөн хориглох бөгөөд зөвхөн хамгаалалтын бүсэд нь аялал жуулчлалын үйл ажиллагааг тусгай заавар журмын дагуу явуулна. Өөрөөр хэлбэл зөвхөн ойг нөхөн сэргээх, хамгаалах, тордон сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг явуулна.

2. Хамгаалалтын бүсийн ой. Хамгаалалтын бүсийн ой нь нэлээн өргөн хүрээтэй бөгөөд дээр хэлснээр Баянхонгор аймгийн ой нь ерөнхийдээ хамгаалалтын шинж чанарыг агуулна. Учир нь тус аймгийн нутаг дэвсгэрт тархсан ой нь ашиглалтын нөөцгүй учир аж ахуйн гэхээсээ илүү байгаль орчны тэнцвэрт байдал хөрс, усыг хамгаалах ач холбогдол нь илүү гэж үздэг байна. Иймд энд аливаа ашиглалт, аж ахуйн элдэв үйл ажиллагааг хориглож, аялал жуулчлал, ойн дагалдах баялаг, самар, жимс, мөөг түүх, мал бэлчээх, хадлан хадах, ойн цэвэрлэгээ огтолгоо хийх зэрэг зарим нэг үйл ажиллагааг тодорхой хуулинд заасан хэм хэмжээний дагуу хязгаарлалттай ашиглахыг зөвшөөрдөг. Энд бид нийт 369.7мян.га газрыг хамруулсан бөгөөд түүний 7443га талбайг хөгшин шинэс, 10015га залуу шинэс,, 622.2 мян. га талбайг заган ой эзлэж байна. Энд арчлах, тордохоос өөр зориулалтаар мод огтлохыг хориглоно.

3. Ойн сангийн бусад газар. Энд нийтдээ 19023 га газрыг хамруулсан бөгөөд энд Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд байгуулах ойн зурвасыг 500м-ийн өргөнтэйгээр Баацагаан, Бууцагаанн Баянлиг, Богд, Жинст сумын нутаг дээгүүр дайран өнгөрөхөөр авлаа. Мөн түүнд зориулсан мод үржүүлгийн газрыг Баянхонгор, Богд, Бөмбөгөр, Жаргалант, Заг, Өлзийт зэрэг сумдын нутагт нийт 154га талбай байхаар төлөвлөв. Эдгээрээс гадна огтолсон ой 4397 га, өвчин хортонд идэгдсэн талбай 394 га байна. Ойн цоорхой, ойн захаас гадагш 100 м өргөнтэй өвслөг газар нь аж ахуйн хэрэгцээнд өргөн ашиглагддаг бөгөөд энд иргэд малаа бэлчээх, хадлан хадах, зуслан гарах зэрэг үйл ажиллагааг явуулдаг учир энэ орчмын газар хамгийн ихээр талхлагдаж хүний сөрөг үйл ажиллагаанд өртдөг. Иймд тус газрыг зөв зохистой унаган төрх байдлыг алдагдуулахгүй ашиглах, байгалийн жамаар мод өсөн үржих нөхцөл бололцоог хангаж өгөх бодлого барин ашиглах нь зүйтэй.

Дашрамд дурдахад газрын тоо бүртгэл, Ой хайгуул төслийн төвийн болон бидний судалгааны материалуудаар ойн талбай ялангуяа заган ойн талбай нэлээд зөрүүтэй байгаа бөгөөд үүнийг газрын нэгдмэл сангийн ажлаар тодруулах шаардлагатай. Ер нь газрын тоо бүртгэлийн материалын ойн сангийн газарт тусгай хамгаалалттай газар байгаа ойг оруулан тооцдоггүй болно.

3.7. Ойн нөхөн сэргээлт, хамгаалалт.

Арчилгааны огтлолт. Дээр дурьдсанаар тус аймгийн ой нь аж ахуйн ач холбогдолгүй зөвхөн арчилгааны огтлолт, ойн цэвэрлэгээ зэрэг ойн нөхөн сэргээлт, байгалийн сэргэн ургалт, хамгаалалтанд чиглэгдсэн үйл ажиллагуунууд явагдана. Иймд тус аймгийн шинэсэн ойд явуулах арчилгааны огтлолты нас, өтгөрөл, эрчмийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 56

		Өтгөрөл
--	--	---------

Огтлолтын хэлбэр	Огтлолт явуулах нас, жилээр	1.0-0.9	0.8-0.7
		Эрчим %	
Гэрэлжүүлэх	-	-	-
Тохируулах	21-40	40-50	30-40
Сийрэгжүүлэх	41-60	30-45	20-30
Завсрын	61ба түүнээс дээш	20-30	20

Хангайн бүсийн ойд шинэс голдуу байдаг учир гэрэлжүүлэх огтлолтыг хийх шаардлагагүй. Харин бургастай холилдон ургасан тохиолдолд 10-12 настайгаас нь гэрэлжүүлэх огтлолтыг хийж болох юм. Ер нь тус амйгийн хувьд анхны огтлолтыг 21-25 настайд нь хийвэл зохино. Энэ огтлолт нь ойн бүтэц, бүрэлдэхүүн ба нягтралыг зохицуулах, моддын өсөлтийг сайжруулах зорилготой. Тохируулах огтлолтоор бүрэлдэхүүнд арчилгаа хийж шилмүүст модны байршилтыг талбайд жигд болгон өсөлтийн нөхцөлийг сайжруулна. Сийрэгжүүлэх огтлолтыг өсөлт сайтай моддын иш болон титэмийн хэлбэрийг сайжруулах зорилгоор хийдэг. Завсрын огтлолтыг үлдсэн сайн моддын өсөлтийн нөхцөлийг сайжруулах зорилгоор хийнэ. Шинэсэн ойд гэрэлжүүлэх ба тохируулах огтлолтын давталтыг 4-10 жилийн хугацаатайгаар тус бүр 4 удаа, сийрэгжүүлэх огтлолтыг 8-15 жилийн хугацаатайгаар 2 удаа, завсрын огтлолтыг 10-20 жилийн хугацаатайгаар 1-2 удаа хийх нь зүйтэй. Манай орны нөхцөлд шилмүүст мод вегетацийн эхний хагаст өндрөөшөө их өсдөг тул модны өндрийн өсөлт дууссан тэр үед өвөл болтол сийрэгжүүлэх ба завсрын огтлолт хийх нь ашигтай байдаг. Арчилгааны огтлолтын түүвэрт Эрдэнэцогт, Галуут, Өлзийт гэсэн 3 сумын нутагт байгаа 0.7-0.8 өтгөрөлтэй 25 ялгарлыг оруулан арчилгааны огтлолтыг дараахи байдлаар хийхэд /хүснэгт 57 / огтлогдох нийт нөөц нь 13.2 м³ байна. Жилд огтлогдох арчилгааны огтлолтын хэмжээ 1310 м³ байх ба үүний 1000 м³ хэрэгцээний мод байх юм. Үүнийг завсрын огтлолтоор хийж гүйцэтгэх бөгөөд моторт хөрөөгөөр бэлдэж ердийн хөсөг, тарактор ашиглан тээвэрлэнэ. Цагаалах зурвасыг 2-3 м өргөнтэйгээр 30-32м тутамд гаргах нь аж ахуйн ач холбогдол сайтай байдаг. Огтлох модонд өсөлт сайтай модыг дагалдагч мод, өсөлтийг сайжруулагч мод, өсөлтөөр хоцорсон мод, өвчилсөн мод зэрэг орох бөгөөд харин үрийн мод, өсөлт сайтай сайн чанарын гол мод, ашигтай шувуу үүрэлсэн мод зэргийг огтолж болохгүй.

Хүснэгт 57

Арчилгааны /завсрын/ огтлолт хийх заавар

Сумын нэр	мод	2005-2020 онд хийх а/о, талбай, нөөц			Огтлолтын давтагдах хугацаа	1 жилд хийх огтлолтын хэмжээ, нөөц мян.м ³				1га-с гарах нөөц, м ³
	Шинэс	Талбай,га	Нөөц, мян. м ³	огтлогдох нөөц, мян. м ³		Талбай,га	Бүгд	хэрэгцээнд	бүх нөөцөд харьцуулбал	
Эрдэнэцогт		457	55.4	11.1	10	46	11	0.9	80	0.2
Галуут		34	4.1	0.8	10	3	0.08	0.06	80	2.5
Өлзийт		50	6.5	1.3	10	5	0.13	0.1	80	2.0
Дүн		541	66.0	13.2		54	1.31	1.0		0.5

Ойг хортон, түймрээс хамгаалах. Ойн түймэр нь ойн экосистемд томоохон сөрөг өөрчлөлт үзүүлдэг хүчин зүйл юм. Аймгийн хэмжээнд одоогоор шатсан ой байхгүй боловч хэзээ ч гарч болзошгүй аюулд байнга бэлэн байх нь ойг хамгаалж буй нэг хэлбэр юм. Ойтой талбайг шатамхайн зэрэглээр ангилсан судалгаанаас үзэхэд Хангайн сумдын нийт ойн 92.2% нь шатамхайн 4-р зэрэгт, 7.8% нь 3-р зэрэгт

хамаарах бөгөөд үүнээс Жаргалант сумын ойн 7.8% шатамхайн 3-р зэрэгт 4.2% нь 4-р зэрэглэлд тус тус багтаж байна. Улс орон зах зээлийн харилцаанд шилжсэнээр иргэд ойн дагалдах баялаг самар жимсийг өргөнөөр түүх, ан гөрөө хийх, хадлан хадах зэргээр ойд түймэр их тавих болсон. Мөн нөгөөтэйгүүр цаг уурын хуурайшилт нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй. Иймд ард иргэдэд түүнээс сэргийлэх сургалт семинар сурталчилгааг өргөн хийх, зайлшгүй тохиолдолд түүнтэй тэмцэх бэлтгэл, арга ажиллагааг байнга хангасан байх шаардлагатай. Ой гадны нөлөөгөөр гэмтэх, мод бэлтгэх, түймэрт өртсөний дараа ойд *хортон шавьж* үүсэх таатай нөхцөл бүрддэг байна. Аймгийн хэмжээнд Эрдэнэцогт сумын 394 га талбайд *сибирийн хүр хорхой, бийрэн сүүлт зэрэг хортон тархсан учир зохих байгууллагаас тэмцлийн ажлыг даруй хийх хэрэгтэй байна*. Уг хорхой, шавьж нь модны залуу нахиа найлзуурыг иддэг учир модлог ургамал бүрмөсөн хатаж үхдэг байна. Манай оронд түүнтэй тэмцэхдээ нутгийн омгийн бактерийн бэлдмэл, денробациллин, леподизм, хлорофос зэргийг өргөн хэрэглэдэг. *Хүний сөрөг үйл ажиллагаанаас хамгаалах*. Энд модыг хулгайгаар огтлох, өсвөр залуу мод, бут сөөгийг хугалж гэмтээх, огтлох ойн дагалдах баялаг самар жимсийг заасан хэмжээнээс илүү түүх, ойн чадавхиас хэтэрсэн хэмжээнд мал бэлчээх, хадлан хадах зэрэг асуудлуудыг хориглоно.

Ойн нөхөн сэргээлт, ойжуулалт. Ойн менежментийн нэг чухал асуудал бол ойн нөхөн сэргээлт юм. Үүнд байгалийн аясаар байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар болон зориудаар ойжуулах гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ. Ойжуулалтын ажлыг мод ихээр огтолсон Эрдэнэцогт сумын 497га, Жаргалант сумын 188га, Өлзийт сумын 94га мөн Баянлиг сумын 3618га /заг/ сумын нутагт хийх шаардлагатай байна. Эдгээрээс эхний ээлжинд Эрдэнэцогт сумын 20га талбайд цаашид энэ хэмжээг аймгийн хэмжээнд 100га-д талбайд хүргэх хэрэгтэй. *Ойжуулалтын ажлыг* юуны өмнө ой ургаж байгаад гадны нөлөөгөөр ойгүй болсон талбайд эхлэн хийх хэрэгтэй байдаг бөгөөд учир нь ойгүй болсон газар хээрших процесс эрчимтэй явагдаж мод ургах экологийн нөхцөл алддаг учир аль болох хурдан хугацаанд нөхөн сэргээх ажлыг хийх хэрэгтэй. Үүний тулд тарих технологийг нарийн баримтлах, ойгүй болсон талбайд 2 жилийн дотор ширэгжилт явагдахаас өмнө ойжуулах, шилмүүст ойд огтлолт явуулсны дараа навчит үүдрээр солигдохоос өмнө шилмүүст үүдрээр ойжуулах, ойжуулалтыг 2-3 настай шинэсний тарьцаар 1 га-д 4300 ширхэг байхаар, үрээр бол 1.2 кг буюу 1000 ш байхаар тооцож суулгах, цаашид мод үржүүлгийн газрыг олноор байгуулах хэрэгтэй. *Байгалийн сэргэн ургалтанд* туслах арга хэмжээнд хөрс боловсруулах, эрдэсжүүлэх зэрэг үр ургах нөхцөлийг бүрдүүлэх, өсвөр модыг хамгаалах, түүний өсөлтөнд саад болж буй сахлаг өвс, гишүү модыг зайлуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй. Заган ойн хувьд ч мөн ялгаагүй түүнийг сэргээн ургуулах байгалийн сэргэн ургалтыг дэмжих, насны онцлогт тохирсон арчилгааны огтлолтыг цаг тухайд нь хийж байх шаардлагатай. Бидний тооцоогоор

2005-2010 онд	356 га
2010-2015 онд	445 га
2015-2020 онд	445га

талбайд заган ойг сэргээн ургуулах арга хэмжээг мэргэжилийн байгууллагын тусламжтайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд байгаль цагуур, зам харилцаа, усан хангамж зэргийг харгалзан Богд суманд загийн аж ахуйг байгуулж жилд 345 ц загийн үр бэлтгэж 2010 он гэхэд 5-60 сая суулгац үржүүлэх боломжтой болно. Ингэснээр заган ойн талбайг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх юм.

Зардлын тооцоо. Ойг хамгаалах нөхөн сэргээх ажлын зардлын бүдүүвч тоймыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 58

Зардлын тооцоо

Хийгдэх ажил	Хийх хугацаа	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ, төг	Бүгд, мян.төг
Арчилгааны огтлолт	2006-2015	Га	540	2590	1398.6
Ойжуулалт		Га	100	3900	390.0
Хортон устгах	2007	Га	200	4800	960.0
Ой хамгаалах бусад	2006-2015	Га	12600	950	11970.0
Заган ойг сэргээн ургуулах	2006-2020	Га	1246	13840	17245.0
Дүн					31 963.6

3.8. Усны сангийн газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Баянхонгор аймагт усан сангийн газар 51.1 мян,га буюу нийт нутаг дэвсгэрийн дөнгөж 0.4%-ийг эзэлдэг. Иймд нэгэнт гадаргын ус хязгаарлагдмал хэдхэн том голын сав газарт түшиглэж байдаг тус аймгийн хувьд гүний усыг ашиглах боломжийг хайх, гадаргын усны ашиглалтыг сайжруулах зөв менежментийн бодлого зайлшгүй хэрэгтэй. Судалгаагаар Баянхонгор аймаг нь нийт хэрэглээний усныхаа 22%-ийг газрын доорх гүний усаар хангах нөөцтэй болох нь тогтоогдсон байна. Бид уг ажлын хүрээнд усны нөөц, түүний байгалийн тэнцэл, усны чанарыг хамгаалах, түүний ай сав газар, эрэг орчмын бүс газар, усархаг, намгархаг газрыг зохистой ашиглах, хамгаалах үүднээс 2 бүс тогтоолоо /хүснэгт 59/. Үүнд:

1. Эрэг орчмын бүс. Эрэг орчмын бүсийг тогтоохдоо нуур, гол горхины эргийн дагуу 50 м өргөнтэй, усархаг, намгархаг газрын эргэн тойрны 100 м өргөнтэй зурвас газрыг усны эрэг орчмын бүс болгон авч нийт 87316 га талбайг хамрууллаа. Уг бүсэд усны чанарт нөлөөлж болох аливаа үйл ажиллагаанд чанга хяналт тавихаас гадна энэ зурваст газар хагалах, барилга байгууламж барих, орчны төрх байдлыг өөрчлөх, нуур голын усанд ан амьтан чөлөөтэй хүрэх замыг алдагдуулахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Нуурын эргийн бүс түүнд цутгадаг гол горхины эргийн бүс, тэдгээрийн эх авсан газрын бүс аль болох нэгдмэл байх, өөрөөр хэлбэл нэг нь нөгөөгөө өргөтгөж байхад анхаарах нь чухал.

2. Усны эрүүл ахуйн бүс. Гол горхи, булаг шанд, худаг, усан сан нь усан хангамжийн эх үүсвэр гүйцэтгэж байгаа бол тэдгээрт 100 м-с доошгүй өргөнтэй эрүүл ахуйн бүс тогтооно гэж заасан байдаг. Иймд бид төв суурин газрын ойролцоох болон ундны усны эх үүсвэр болсон газруудад эрүүл ахуйн бүсийг тогтоож нийт 3891 га талбайг хамрууллаа. Уг бүсийг ундны усны эх үүсвэр гэсэн утгаараа эрүүл ахуйн бүсийн нэгэн адил хамгаалах бөгөөд аливаа барилга байгууламж, жуулчны бааз, хоноглох газрыг нуур, голын эргээс 100 м хол байрлуулах мөн аливаа химийн бодис, зоо мал эмнэлгийн ариутгал-боловсруулалтын цэг, ХАА-н түүхий эд боловсруулах, үйлдвэрлэх газрыг усны хамгаалалтын бүсийн гадна, урсгалын доод хэсэгт байрлуулж хаягдсан усыг тусгайлан цэвэрлэж зайлуулах ёстой. Сүүлийн үед хууль бусаар алт олборлогч “Нинжа” нар хүн амьтны ундны эх үүсвэр болсон булаг шанд, гол горхи, худгийн усыг алт угаах үйл ажиллагаанд хэрэглэж тэдгээрийн гольдрилыг хаах, өөрчлөх онц аюултай химийн бодис хэрэглэх зэрэг явдалтай хатуу тэмцэл хийх хэрэгтэй. Ялангуяа алт их олборлодог Баян-Овоо, Шинэжинст, Гурванбулаг, Бөмбөгөр,

Галуут сумд анхаарах хэрэгтэй. Мөн гол горхины эх, нуур тойрмын эргэн тойронд 2 км дотор байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүхийг хориглох ба удаан хугацаагаар олон тооны малыг бөөнд нь бэлчээрлүүлэхээс аль болох зайлсхийх хэрэгтэй. Усны урсгалын дээд талд оршин буй ус ашиглагч усны байгалийн горим, тэнцэл, чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй бусдын ус ашиглах нөхцөлийг боогдуулахгүй байх үүргийг хуулиар хүлээнэ. Хэний эзэмшил, ашиглалтанд байгааг үл харгалзан бэлчээр дэх уст цэгийг нийтээр эзэмшинэ. Ер нь усны нөөц, чанарыг доройтуулахгүй байх үүднээс усны эх булгийг хамгаалах, тохижуулах, зүлэг мод тарих, хайс хашаа хатгах, усыг ашиглахдаа түүний нөөц чадавхид зохицуулан ашиглахыг эрмэлзэх нь усны ашиглалтыг сайжруулах нэг үндэс болно.

3.9. Улсын тусгай хэрэгцээний газрын бүсүүд, түүний нөөц, нөхцлийн төлөвлөлт.

3.9.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, нөхцлийн төлөвлөлт

Байгалийн мужлалаар Хангайн нурууны өвөр биеийн дэд муж, Нууруудын хөндийн дэд мужид хамаарах Баянхонгор аймгийн нутагт мужийн төлөөллийн хувьд авч үзвэл тусгай хамгаалалттай газар бараг байхгүй.

Иймд дархан цаазат, байгалийн дурсгалт болон байгалийн нөөц газрын ангилалаар дараах газруудыг 1 321 мян га талбайгаар улсын тусгай хамгаалалтанд авахаар БОЯ-наас судалгаа хийж, үндэслэлийг боловсруулсан байна. Гэвч энэ нь дэндүү их талбайг хамарч байгаа бөгөөд хэрэв бид ийм их газрыг хамгаалалтанд авбал аж ахуй эрхлэх газрын хэмжээ хүрэлцэхгүй нөгөө талаасаа хамгаалах хүч хүрэлцэхгүй болно. Улсын тусгай хамгаалалтанд авсан тухай УИХ-ын тогтоол гараад түүнээс цааш хамгаалалтын арга хэмжээнүүд авагдахгүй байдаг өнөөгийн практик ойрын ирээдүйд үгүй болох юм. Эдгээр шалтгааны үүднээс талбайг нь багасган 632 884 га талбайг тусгай хамгаалалтанд авахаар төлөвлөлтөнд тусгалаа.

1. Баянхонгор, Өвөрхангай аймгийн нутгийг дамнан орших Их Богд, Бага Богд, Арц Богд уулсыг хамарсан нийт 560 мянган га талбай бүхий Гурван богдын ДЦГ,

Их, Бага Богд уул нь Говь-Алтайн нурууны хамгийн өндөр уул. Баянхонгор аймгийн нутагт оршино. Их Богд уул нь өргөргийн дагуу 50 орчим км үргэлжилнэ. Бага Богд нь Их Богдоос зүүн тийш 60 орчим км үргэлжилдэг. Нутгийн ардууд тахин шүтдэг, ховор амьтан, ургамал бүхий үзэсгэлэнт сайхан уул. Улсын тусгай хамгаалалтад авахаар санал боловсруулсан. Баянхонгор аймагт 271 мян. га

Îðîä íóóð

2. Галуут сумын нутагт орших Олгой нуур, Галуутын хавцал зэрэг газруудыг хамарсан 190 мянган га талбайг ДГ, *Îëäíé íóóð-Òîäöîä ääéððäí íü* Баянхонгор аймгийн Галуут сумын төвөөс баруун урагш Олон нуурын урд захад орших, үзэсгэлэнтэй сайхан нуур.

Галуутын хавцал– энд олон тооны хээрийн галуу, хар өрөвтас, ангир мэт зүйл өндөглөн зусч байдгийн хамтаар ус, намгийн шувууд болон идлэг шонхор, бүргэдүүд цөөнгүй тааралдана. 35,4 мян. га

3. Эрдэнэцогт сумын Шаргалжуут рашааны орчмын 50 мянган га талбайг ДГ, *Øäðäâëæóóðüí äîë* нь Хангай нурууны өврөөс эх авч баруун урагшаа 70 орчим урсаад Түйн голын зүүн гарт цутгана. Шаргалжуутын гол руу түрж орсон хадат хошууны

энгэрээр боржин хадан дороос оргилох 100 гаруй тооны халуун рашаан байдаг. Уулаараа хар модон ойтой. Байгаль эхийн бүтээсэн гайхамшигт дурсгал мөн. 13,4 мян. га

4. Гурванбулаг сумын Хөх нуурыг 90 мянган га талбайгаар ДГ, 21,9 мян. га

5. Бууцагаан сумын Богд уулыг 170 мянган га талбайтайгаар ДГ, *Áîäü óóë-Áàÿì õóðóó ïü* Хангайн нурууны өвөрт Баянхонгор аймгийн нутагт орших 3012 м өндөр уул юм. Ховор амьтан, ургамалтай 11,6 мян. га

6. Шинэжинст сумын Ногоон цавын хоолойг 110 мянган га талбайтайгаар ДГ, *Ногоон цав* Онгон уулаас баруун хойшоо орших хоолой. Өвөрмөц тогтоцтой үзэсгэлэнтэй, байгалийн дурсгалт газар болгох боломжтой. 78,4 мян. га

7. Баацагаан сумын Бөөнцагаан нуурыг мянган га талбайтайгаар БНГ *Бөөнцагаан нуур* Баянхонгор аймгийн Баацагаан сумын нутаг Нууруудын хөндийд байдаг бүлэг нуурын хамгийн том нуур.

8. Баянхонгор Архангай аймгийн нутгийн заагт орших Унтаа Ямаатын нурууг 320 мянган га талбайгаар БНГ, Баянхонгор аймагт 15,4 мян га

Нууруудын хөндийн дэд муж хамгийн эмзэг экосистемтэй хамгаалах шаардлагатай нутаг хирнээ огт төлөөлөлгүй, нэг ч тусгай хамгаалалттай газар байхгүй мужид хамаарна. Сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын дулаарал, хүний байгальд үзүүлж буй сөрөг нөлөөний улмаас элсний нүүлт хөдөлгөөн ихсэх, говийн нуурууд ширгэх, ургамал нөмрөг алдрах, цөлжих үйл явц эрчимтэй явагдах боллоо. Энэ нь Монгол орны эмзэг экосистем бүхий говь цөлийн бүсэнд, түүний дотроос Нууруудын хөндийд идэвхтэй явагдаж байгаа нь анхаарал татаж байна. Харин 1980-аад оны үеэр хэд хэдэн нуурууд ширгэсэн нь дээрх хүчин зүйлээс гадна хүний үйл ажиллагааны шууд үр дагавар байлаа. Судалгаанаас үзэхэд нууруудын цутгал голуудын урсацын балансад шууд болон дам нөлөөлж байгаа хүний үйл ажиллагаа Байдраг голд 26-30.8%, Түйн голд 25-36.6%, Онгийн голд 16-25.4%, Таацын голд 17-26.3% байлаа. Зөвхөн 200 га талбайг услах хүчин чадалтай Хэрсэнгийн талын услалтын систем Бөөнцагаан нуурын үндсэн тэжээл Байдраг голын урсацын 16.4%-ийг авч байсан нь нуурын түвшин татрах үндсэн шалтгаан болсон.

Хоёр нутагтан болон мөлхөгчдийг хамгаалахын тулд Нууруудын хөндийн дэд мужид зайлшгүй хамгаалалтад авах газрыг сонгох нь зүйтэй.

Нууруудын хөндийн дэд мужид Монголын орогномол загас болох алтайн сугасыг хамгаалсан газар байгуулах нь зүйтэй. Энэ нууруудын онцлог нь загасны амьдралын биологийн төрх байдал, нутагшлын зүй, механизмыг нээн илрүүлэх байгалийн лаборатори болж байгаа юм.

Хангайн нурууны өвөр хэсэг, заримдаг цөлийн бүсийн шилжилтийн зааг нутаг болох энэхүү нутаг нь ус намгархаг газрын шувууд ихээр цуглардаг өвөрмөц орчин учраас “Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенцийн жагсаалт (Ramsar site)-д Орог нуур, Таацын цагаан нуур, Бөөн цагаан нуур, Адгийн цагаан нуурууд 1998 онд бүртгэгджээ.

Одоогоор ТХГН-ийн сүлжээнд зайлшгүй орох ёстой газруудын тоонд *Нууруудын хөндийн дэд мужийн* Бөөн цагаан нуур (317262 га), Орог нуур-Таацын цагаан нуур-Хатуу уул (4580278 га), Тайшир (27277 га) газруудыг хамгаалалтад авах шаардлагатайг судлаачид тогтоосон байна. Иймээс говийн нуурууд ширгэж экологийн тэнцвэрт байдал алдагдах, цөлжих үйл явц эрчимтэй явагдаж байгаа өнөө үед Олон улсын Рамсарын конвенцид хамрагдаад байгаа нууруудыг улсын тусгай хамгаалалтад авах, говь цөлийн үнэт эрдэнэ болсон нуурууд,

тэдгээрийн ус намгархаг орчныг хамгаалах, байгалийн үзэсгэлэн, аялал жуулчлал хөгжүүлэх боломжийг ашиглан зохион байгуулалттай аялал жуулчлал хөгжүүлэх зорилго бүхий байгалийн цогцолборт газрыг байгуулах шаардлагатай байна.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах талаар.

Биологийн төрөл зүйлийн нөөцийг зохистой ашиглах хамгаалах үйл ажиллагаанд нутгийн иргэдийн оролцоог дээшлүүлж тэдний хүчинд тулгуурласан менежментийг хэрэгжүүлнэ. Ховордож буй тарвага зэрэг амьтадыг хамгаалах зорилгоор зарим нутгийг иргэдэд гэрээгээр хамгаалуулах туршилтын ажлыг зохион байгуулна. Шинээр зам дэд бүтэц төлөвлөхдөө ан амьтдын гүйдлийн замыг хаахгүй байхад анхаарна.

Монголд ургадаг Урал чихэр өвсний нөөцийн 70 орчим хувь нь Баянхонгор аймагт ургадаг. Чихэр өвсний үндэснээс Япон, Солонгос зэрэг технологийн өндөр чадамжтай орнуудад вирусын эсрэг үйлчилгээтэй бэлдмэлийг гарган авч байна. Энэ ургамалыг тармилжуулах замаар хангалттай нөөц бий болгож, экспортлох хэрэгтэй.

Монгол тарвага тус аймгийн нутаг дэвсгэрийн зонхилох хувийг эзэлдэг ойт хээр, уулын хээр, тал хээр ийн бүс бүслүүрт тархаж экологийн тэнцвэрт чухал үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн өөх тос, мах, арьс зэргийг нь бүгдийг нь ашиглаж болдог иргэдийн амьжиргаанд ач тустай амьтан юм. Гэвч тахал гэдэг аюулт өвчний нянг тээг болдог тул иргэдийн амь нас эрүүл мэнд, эдийн засагт хохирол учруулж болох талтай. Иймээс энэ амьтантай холбоотой асуудалд шинжлэх ухааны үүднээс хандах шаардлагатай. Тарвага агнахаас өөрөөр амьдрах боломжгүй иргэдэд амьдралын өөх их үүсвэртэй болгох талаар дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Арьсны зах зээлийг хянах арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй

3.10.1. Газар хамгаалалтын арга хэмжээ

Өнөөдөр байгаль орчныг хамгаалах асуудал улс орны амьдралаар дэвшигдэж байгаа хамгийн чухал зорилтын нэг болж байгаа бөгөөд ялангуяа сүүлийн жилүүдэд манай оронд үйлдвэр, тээвэр, зам харилцаа эрчимтэй хөгжиж ,хот суурин газар олширч, байгалийн баялагийг олзворлож ашиглах явдал улам өргөсөж байгаатай уялдаж байгальд үзүүлэх хүний үйл ажиллагааны нөлөө эрс нэмэгдэж ирэв. Энэ байдлыг даган манай орны аль ч бүс нутаг районд байгаль хамгаалах асуудлын нийгмийн үүрэг ихээхэн өсч ирлээ. Иймээс газар ус, хөрс ургамал, ан амьтан, ой модны нөөц баялагийг зүй зохистой ашиглаж хамгаалахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд аймаг орон нутгийн хууль хяналтын байгууллагууд онцгой анхаарах шаардлагатай байна. Зөвхөн Баянхонгор аймгийн хувьд л гэхэд сүүлийн жилүүдэд аж ахуй болон хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас олон нуур гол горхи ширгэж ирсэн байна. Энэ нь тус аймагт байгаль хамгаалах асуудал хурцаар тавигдаж байгаагийн тодорхой гэрч юм. Хэдийгээр Баянхонгор аймаг хангай говь хосолсон өргөн уудам нутагтай манай улсын томоохон аймгуудын нэгд ордог боловч эдэлбэр нутгийнх нь ихэнх хувийг хур тунадас бага унадаг хуурай гандуу говь-цөлөрхөг газар эзлэж байгаа нь байгаль хамгаалах асуудалд онцгой хариуцлагатай хандах нөхцлийг бий болгож байна. Тухайлбал: Ус чийгийн нөөцийг бий болгон өөртөө татан, урсгал усны эх , аймгийн нутгийн дөнгөж 0.15 %-г эзлэж байгаа нь дээрх нөхцлийг харуулж байна. Говийн сумдын заган ойн нөөц 602.3 мянган га-р тооцогдож байгаа ч түүний ихэнх нь үнэн чанартаа газар дээрээ ихээхэн сийрэгжиж, заган ой байсныг гэрчилэх ул мөр

төдийхөн болж үлджээ. Мөн аймгийн усны фондын талбай 52.4 мян.га –д хүрч байгаа ч гэсэн сүүлийн жилүүдэд Байдраг, Түйн гол зэрэг томоохон голуудын усны нөөц ихээхэн багасаж, Орог нуур, Адгийн цагаан нуур зэрэг олон нууруудын ус арилж ширгэхийн аюулд хүрч ирсэн байна.

Байгалийн бүсээр нь авч үзвэл тус аймгийн нутгийн 62.5 % говь, 17.2%-нь хээрийн бүсэд , 20.3% нь хангайн бүсэнд тус тус хамрагдаж байна. Өөрөөр хэлбэл аймгийн нутгийн 80 орчим % нь ил задгай усны нөөц багатай, хуурай гандуу байдалтай говирхог нутаг юм. Энэ нь ой мод болон ургамал усны нөөц баялагт аль болхоор ариг гамтай, ухаалаг, нарийн тооцоотой хандахын чухлыг харуулж байна.

Аймгийн ойгоор /шинэс/ бүрхэгдсэн талбайг нутгийн хангайн бүсэд орж байгаа 6 сумдын эдэлбэр нутагт байх 12600 га шинэсэн ой эзлэх бөгөөд энэ нь дээрх сумдын газар нутгийн дөнгөж 0.8 % байгаа нь ой модны нөөцөөр асар бага байгааг харуулж байна. Иймээс нутгийн ой модны хомс нөөцийг аль болохоор хайрлан хамгаалж, модыг нь авч ашигласан газраа ойжуулахад Баянхонгорчууд бусад аймгуудынхаас ч илүү анхаарах шаардлагатай. Гэтэл тус аймгийнхан угаасаа бага модныхоо нөөц рүү дайрч түлшинд өргөн хэрэглэсээр ирсэн нь голын ус татрах, уг голуудын усаар тэтгэгдэж, тэжээгдэж байсан нууруудын ус ширгэх аюулд оруулаад байна. Мөн түүнчлэн өөрийн аймгийн нутгийн модны нөөцөнд хайр гамгүй хандаад зогсохгүй, мод бэлтгэх зорилгоор Архангай, Өвөрхангай аймгууд руу явдаг байна.

Тус аймгийн говийн сумдад манай орны заган ой багагүй нөөц байх бөгөөд бусад ой модны нэгэн адил зөвхөн авч ашиглахыг урьдал болгож ирснээс зөвхөн Баянлиг 3618 га заг сүйтгэгдсэн байна.

Заг бол говь газрын гүний усны нөөц горимыг зохицуулж, элсний нүүлтийг барьдаг ганц элемент төдийгүй говь нутагт амьдардаг мал, амьтаны тэжээлийн гол бааз, нөмөр нөөлөг газар болдог. Түүний залуу нахиа навчны үзэсгэлэнт ногоон өнгө говийн байгалийг чимэж байдаг.

Баянхонгор аймагт нүүрсний нөөц, чанараар муугүй Баянтээгийн нүүрсний уурхай бий. Энэ уурхай өөрийн аймгаар зогсохгүй бусад аймгуудын нүүрсний хэрэгцээг хангасаар ирсэн түүхтэй. Мөн Баянхонгор аймаг нь ан амьтаны нөөц сайтай аймгуудын нэг юм. Иймээс манай оронд бэлтгэж байгаа тарваганы арьсны ихэнхийг тус аймгаас бэлтгэж байгаагаас гадна тус аймагт дэлхийд ховорт ордог Мазаалай, Хавтгай, Хулан, Бөхөн зэрэг амьтад ч цөөн бус юм. Иймээс ч Говийн Их дархан газарт тус аймгийн нутгийн нилээд хэсэг нь хамрагдаж байна. Баянцагаан сумын Шалын хоолой, Хар аргалантын уулын орчимд хүн амьтан ихээр зорчих болсноос ан амьтдын байршлыг алдагдуулж нөөцийг багасгаж байна. Тус аймагт ан агнуурын хууль дүрэм зөрчих явдал багасахгүй байгаагийн дотор ялангуяа тарваганы арьсны үнэ нэмэгдсэнтэй холбогдож олз ашиг хичээсэн хүмүүс тарвагыг олноор агнах, хугацаа нь болоогүй байхад агнаснаас тарваганы тоо эрс цөөрсөн байна. Иймд БОЯ-наас түүнийг түр хугацаагаар агнахыг хориглосон юм. Говийн баянбүрдийн унаган төрхийг алдагдуулах, ан амьтаныг нь дайжуулах зохисгүй хандлага тус аймагт мэр сэр гарсаар байна. Тухайлбал: тус аймгийн нутаг дахь Говийн их дархан цаазат газарт байгаа Баянтоорой, Захуй, Зарман, Зуунмод, Эхийн гол зэрэг баян бүрдүүдийн унаган төрх жилээс жилд өөрчлөгдсөөр ирсэн нь зөвхөн ашиглахыг урьдал болгож ирсэн ганц талын өрөөсгөл хандлагатай холбоотой. Үүний жишээг зөвхөн Эхийн голын ганц баян бүрдээр авч үзэхэд тус 1990оны үед Баянбүрэд байгаа айлууд 60-80 тн, жилдээ эрдэм шинжилгээний байгууллагын хэмжээгээр 240-460 тн заг түлшинд хэрэглэж, ойр орчныхоо загийн нөөцийг ихээхэн багасгаснаас элсний нүүлт хүртэл эрчимжихэд хүрчээ. Тэрчлэн тус баянбүрдэд хонин толгойд шилжүүлснээр 600 гаруй мал жилийн туршид бэлчээрлэж орчныхоо бэлчээрийн даацнаас даруй 250 гаруй толгойгоор давж байгаагаас газрын хөрсийг дагтаршуулан, өвс ногоо нь сэргэж ургах нөхөн үржих явцад зохисгүйгээр нөлөөлөх болсноос бэлчээрийнх

нь ургац буурч, ургамлын нөмрөг нь сийрэгжих болсон байна. Ийм байдлаас шалтгаалж Эхийн голын орчимд байсан 19 булаг шандын ихэнх нь хатаж ширгэж иржээ. Мөн ийм байдлаас болж Говийн их дархан газар дахь баян бүрдүүдийн заг, тоорой, сухай, хулс зэгсний нөөц багасаж хавтгай мазаалай, бөхөн, хулан нь хулжиж дайжих болсон байна. Цаашид уг байдлыг зогсоож засахын тулд юуны өмнө говь нутгийн амьдралын амин сүнс нь болсон баян бүрдүүдийг хамгаалах, ус нь татарч, ургамал нь сийрэгжсэн газруудыг нь сэргээх нь чухал байна. Аймгийн нутгийн 80 орчим хувь нь Говь хээрийн бүсэнд хамрагддагаас тус аймгийн байгаль хамгаалах байгууллагын гол зорилтын нэг нь усны нөөц баялагийг хайрлаж хамгаалах явдал юм.

Одоогийн байдлаар тус аймгийн Байдраг, Түйн гол зэрэг томоохон голуудын ус татарч зарим газраа бүр тасархад хүрчээ. Ийм байдал нь юуны өмнө эдгээр голуудын эхийг бүрдүүлж буй Хангайн нурууны модыг ихээр сүйтгэсэнтэй холбоотой. Үүний зэрэгцээгээр Байдраг, Түйн голуудын сав дагуух газруудын харгана, бургасыг их хэмжээгээр устгасны дээр тус голуудын усыг тал тал тийш нь салбарлуулан олон суваг шуудуу татаж усных нь алдагдлыг ихэсгэсэнтэй ч холбоотой. Тухайлбал: Түйн голын усны нөөцийг багасгаснаас уг голын усаар тэжээгддэг Орог нуурын ус багасаж ширгэхэд хүргэсэн байна. Ийм Түйн голын усыг нарийн тооцоотой ашиглах, ялангуяа услалтын систем барих ажилд хянуур хандах, Түйн голыг хуучин голдиролд нь оруулан урсгах замаар усных нь нөөцийг нэмэгдүүлж Орог нуурыг ширгэхээс аврах зорилт тавих хэрэгтэй. Мөн Орог нуурын усны нөөцийг нэмэгдүүлэхэд эргэн тойрных нь загийг хамгаалж сэргээх, модлог бутлаг ургамал тарьж ургуулах нь чухал. Гэвч тус аймаг өөрийн хэрэгцээт нөөц тэжээлээ дотоод нөөц бололцоогоо түшиглүүлэн үйлдвэрлэх өндөр зорилт дэвшүүлж, усалгаатай тариаланг нэмэгдүүлэх, хадлан бэлчээр ихээхэн хэмжээгээр сайжруулах чухал шаардлага гарч байгаагаас усны нөөц баялагийн ашиглалтанд улам хатуу хяналт тавих шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Ийм нөхцөлд тус аймаг усныхаа нөөцийг аль болхоор илрүүлэн ашиглахын зэрэгцээгээр цас, борооны усыг хуримтлуулж нуур, цөөрөм байгуулж хадлан, тариалангийн талбайг усжуулах арга зам, боломжийг эрж хайх нь чухал байна.

ХАА-н эдэлбэр газрын 99.8%-г бэлчээр эзлэж харьцангуй өргөн уудам нутаг дэвсгэрийг хамарч, бэлчээрийн даац 65.7%-тай байгаа боловч аймгийн хэмжээгээр талхлагдсан бэлчээр 416.4 мян.га-д хүрч нийт бэлчээрийн 46.7 % нь талхлагдсан байна.

Талхлагдсан бэлчээрийн хэмжээг байгалийн бүсүүдээр авч үзэхэд хангайн бүсэнд орж байгаа 6 сумдын бэлчээрийн 4.0 %, хээрийн бүсэд орж байгаа 5 сумдын бэлчээрийн 8.8%, говийн бүсэд хамрагдаж байгаа 8 сумдын бэлчээрийнх нь 4.4% нь тус тус талхлагдалд орсон байна. Ингэж тус аймгийн хэмжээгээр бэлчээр ихээр талхлагдахад зарим талаар говийн сумдын олонхид нь сүүлийн хэд хэдэн жил дараалан ган болсон байдал нөлөөлсөн ч бэлчээр ихээр талхлагдах явдал нийт сумдад нийтлэг байгаа нь байгаль-цаг уурынхаа нөхцлөөс илүү ашиглалтынхаа нөхцөлтэй холбоотой болохыг ч бас харуулж байна. Ялангуяа дулааны улирлын бэлчээрийг аль ч сум, аж ахуйд ямарч системгүй нийтэд нь хувиар заагүй шахам хавтгайруулан ашиглаж ирснээс талхлагдсан бэлчээрийн зонхилох хувийг зун-намрын улирлын бэлчээр эзлэхэд хүрчээ. Тухайлбал: тус аймаг 1990-аад оны ихээр Эрхэт тайчийн 130 орчим мянган.га бэлчээрийг зун-намрын отрын нутаг болгон ашиглаж ирсэн юм. Гэтэл уг отрын нутгийн бэлчээрийг олон сум бие биенээсээ өрсөн ногоо дөнгөж цухуйх үеээс нь олон жил ямарч ээлж сэлгээгүй ашиглаж ирснээс одоо тус аймгийн хамгийн их талхлагдсан бэлчээр бүхий газрын нэг болж байна. Ийм байдалд томоохон голуудын сав, сум, бригадын төв зэрэг газрууд нийтлэг орсоор байна. Тэрчлэн говийн сумдын бэлчээр ихээр талхлагдахад сүүлийн хэдэн жилийн хангайн байдал нөлөөлснөөс гадна, усан хангамжийн хүрэлцээ, хүртэмж муу байгаа байдал ч бас баггүйгээр нөлөөлж иржээ.

Хэдийгээр гаргасан худаг уст цэгээр нь тооцоход говийн сумын усан хангамж 50.0 %-с доошгүй байгаа ч үнэндээ түүний 30 шахам % элдэв согог, эвдэрлийн янз бүрийн шалтгааны улмаас ашиглагдахгүй байна. Ийм байдлаас болж жилийн ихэнх улиралд хүн мал нь цөөн тооны ус, худаг дээрээ төвлөрч байдаг нутаг газрууд ч багасгахгүй байна. Энэ нь говийн сумдын бэлчээрийн талхлагдах явцыг эрчимжүүлж байгаа нэг үндсэн шалтгаан нь болсоор ирсэн юм.

Говийн сумдад зарим газрын бэлчээрийн даацыг хэтрүүлж ашиглаж байгаагаас элсэрхэг хөрстэй газруудад янз бүрийн хэлбэртэй элсэн манхан далан үүсэх байдлаар элсний нүүлт ихсэж байна. Ийм газруудад юуны өмнө салхины хүч ихтэй уулсын хоорондох хөндий хоолойнууд хамгаас түрүүнд орж байна. Хээрийн бүсийн сумдын бэлчээрийн талхлагдахад усан хангамж, улирлын бэлчээрийн хүрэлцээний байдал нөлөөлж байгаагийн дээр уг сумдын нутгийг хөндлөн гулд дайрч гардаг машин замууд тал хөндий газрын энгээр тарч, олон салаа болж зарим газруудад замын салаа 80-90 хүрч ихээхэн талхлагдахад хүргэж байгаа нэг үндсэн шалтгаан нь болоход хүрч байна. Тухайлбал: Бууцагаан сум машин замын хөл, тоосонд нэрвэгдэснээс 30 худаг ашиглагдахгүйд хүрсэн байна. Мөн Бөмбөгөр сумын нутгаар дайрч гарсан хот хоорондын төв зам сумын төв, олон чиглэлд хуваагдаж, чиглэл тус бүрийн замууд нь 20-30 салаа болон асар их бэлчээр нутгийн хөрсийг сүйтгэж өвс ургамлыг нь тоосоор дарахад хүргэж байна.

Бэлчээрийн ашиглалтыг сайжруулах, юуны өмнө зун, намрын улирлын бэлчээрийг тодорхой системтэй ээлж сэлгээтэй ашиглах, бэлчээрийн талбай, түүний эдэлбэр газрыг хамгаалахад чиглэгдсэн байгаль хамгаалалтын арга хэмжээг эрчимжүүлэх, малыг хэт төрөлжүүлэх нэг төрлийн малыг нэг л нутаг усанд олон жил тогтмол ээрч хоргоож ирсэн явдлыг халах хэрэгтэй байна.

Тус аймагт тариалан, хадлангийн талбайгаар бага боловч зөвхөн Жаргалант суманд 10 гаруй мян.га атаршсан талбай бий. Ер нь газар тариалангийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт арчилгаа тордолгоог бага хийж ирсэн бөгөөд цаашид газар тариалангийнхаа үйлдвэрлэлд тодорхой эргэлт өөрчлөлт хийх нь байгаль орчинд сөрөг үр дагавар бага авчирна.

Баянхонгор аймгийн хадлангийн талбай улсын газрын тоо бүртгэлээр 10.0 мян.га гэж тооцогдож байгаа ч зарим талд жинхэнэ хадланд ашигласан талбайнх нь хэмжээ, түүний тал хувиас хэтрэхгүй байх явдал олонтоо гарч байна. Энэ нь байгаль-цаг уурын нөхцлийн зэрэгцээгээр хадлангийн талбайг зохих ёсоор хамгаалж, тодож чадахгүй байгаагаас шалтгаалж иржээ. Дээр дурьдсан байдлуудаас дүгнэлт хийхэд тус аймгийн байгаль хамгаалах арга хэмжээг эрчимжүүлэх, эдэлбэр газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулахад дор дурьдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

1. Байдраг, Түйн голуудын усны нөөцийг бууруулж багасгахгүй байх зорилгоор уг голуудын усны урсгалын үндсэн голдиролыг хамгаалж сайжруулах, голуудын сав дагуух газруудын бургас, харганыг нөхөн сэргээх, тус голуудыг түшиглүүлж баригдсан услалтын системүүдийн усны алдагдлыг усыг нь голуудад нь буцаан оруулдаг болгох замаар багасгах
2. Орог нуур болон бусад томоохон нууруудын зэгсийг хадланд ашиглахыг бүрэн зогсоож, Онцгой нөхцөлд байгаль хамгаалах байгууллагын зөвшөөрөлтэйгээр аж ахуйн хэрэгцээнд ашигладаг болох
3. Ой мод заг бүхий газруудыг орон нутгийн бүрэн хяналтанд авч ойжуулах, загийг нь нөхөн сэргээх арга хэмжээг тодорхой төлөвлөгөөний үндсэн дээр авч хэрэгжүүлэх
4. Элсний нүүлт өргөжиж байгаа газруудын судалгааг нарийвчлан гаргах ашиглалтанд нь байнгын хяналт тавьж байх.
5. Говийн их дархан газрын баянбүрдүүдийг аж ахуйн ашиглалтаас чөлөөлж, онцгой нөхцөлд зөвхөн байгаль хамгаалах байгууллагуудын зөвшөөрөлтэйгээр ашигладаг болох.

6. Тус аймгийн нийт бэлчээрийн 46.7% талхлагдсаныг харгалзан аймгийн зүгээс тодорхой ажил зохиож, сумдын талхлагдсан бэлчээрийг сэргээх сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
7. Газрын маргааныг хурдан шуурхай шийдвэрлэх үндсэн дээр эдэлбэр газрын маргаанаас бэлчээр талхлагдах, хадлан тариалангийн талбайн р өгөөж буурах зохисгүй үйл ажиллагааг зогсоох шаардлагатай газруудад сум дундын отрын бүс нутаг байгуулах замаар эдэлбэр газрын ашиглалтыг бүрэн сайжруулах,
8. Зам засах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, малчдыг ердийн хөсөг унаагаар хангах замаар ашиглалт багатай байгаа уулархаг газруудын ашиглалтыг сайжруулах.
9. Тариалангийн талбайн хөрс үржил шимийг хамгаалахад онцгой анхаарч, сумдын нийт тариалангийн талбайг зурваслан тариаланд шилжүүлэх, ойн зурвас байгуулах асуудлыг одооноос анхаарч уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлыг сумын жилийн санхүүгийн төлөвлөгөөнд тусгаж байх.
10. Шинээр эзэмших атар эзэмшихдээ нягт нчмбай хандах.
11. Сумдын төвийн эдэлбэр газрын хөрс ихээхэн эвдэрч байгааг зогсоох зорилгоор сумдын төвийн эргэн тойрныг хамгаалалтын бүс нутаг, хашаа хайс хамгаалалттай болгох
12. Бэлчээрийн хөрс ургамлыг ихээр сүйтгэж байгаа олон салаа замуудын тоог цөөлж журамлахад аймгийн байгаль хамгаалах болон тээврийн удирдах газрын хүчийг чиглүүлэх
13. Бөөнцагаан, Орог нууруудад хамгаалалтын бүс тогтоож, аймгийн хамгаалалтанд авах, Гурванбулаг Хөх нуур, Галуут сумын Галуутын хавцал, Их богд уул, орон нутгийн дархан цаазтай газар болгох нь чухал юм

3.10.2. Нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн тархалт

Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралтын “Нэн ховор ургамлын жагсаалтад” орсон 133 ургамлаас 17 зүйл, ховор ургамлын жагсаалтад орсон 317 ургамлаас 8 зүйл ургамал болон Монголын улаан номонд орсон 128 зүйл ургамлаас 14 зүйл ургамал тус аймгийн нутаг дэвсгэрийн 120 цэгт тэмдэглэгдсэн байна \ зураг, хүснэгт-46\.

Баянхонгор аймгийн нутагт тархсан Монголын улаан ном, байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн нэн ховор, ховор ургамлын жагсаалтын Монгол, латин нэрийг хүснэгтээр харуулав.

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр нь хангай говь, хээр хосолсон өргөн уудам нутаг дэвсгэрийг хамрах тул байгалийн бүс бүслүүр бүрт өөрийн өвөрмөц шинж төрхийг агуулсан олон зүйл нэн ховор, ховор ургамал тархдаг. Тухайлбал өндөр уулын бүсэд вансэмбэрүү, ягжмаа, алтан гагнуур, дөрвөлсөн мүгээ, цагаан дэгд, алтайн сонгино, том навчит дэгд, ямаан сэрдэг, өндөр уул хоорондох голын нугад монгол хундгана, хар агширгана, бөөн цэцэгт лүзэсгэлэн, төвд баягзаваа, тал хээрийн бүслүүрт монгол тарваган шийр, хужирлаг чийглэг нугад марзны ортууз, урт буурцагт тарваган шийр, говь цөлийн бүсэд цөлийн аргамжин цэцэг, лидэр, чихэр өвс, морин зээргэнэ, төрөл бүрийн ортууз, хунчир зэрэг ургамал зонхилон тааралдана. Эдгээрийг ардын уламжлалт эмнэлэг, ахуй амьдралд өргөн хэрэглэнэ.

Хүснэгт 46

Баянхонгор аймагт тархсан нэн ховор, ховор ургамлын жагсаалт

№	Монгол нэр	Латин нэр	Ургах орчин	Тархалт	Статус, ач холбогдол
1	Томнавчит Дэгд	<i>Gentiana macrophylla</i>	Ойн зах, гол горхины эрэг	Эрдэнэцогт, Жаргалант	Нэн ховор, эмийн
2	Вансэм-бэрүү	<i>Saussurea involicurata</i>	өндөр уулын таг, уулархаг газраар	өндөр уулын бүсэд	Нэн ховор, эмийн
3.	Төвд баягзаваа	<i>Lancea tubetica</i>	өндөр уулын нуга, гол горхины хөвөөгөөр	Эрдэнэцогт, Заг, Гурванбулаг	Нэн ховор, эмийн
4	Алтан гагнуур	<i>Rhodiola rosea</i>	өндөр уулын таг, уулархаг газраар	өндөр уулын бүсэд	Нэн ховор, эмийн
5	Алтайн сонгино	<i>Allium altaicum</i>	өндөр уулын таг, бэл хормой	өндөр уулын бүсэд	Ховор, Эмийн
6	Ягжмаа	<i>Pyrolia rotundifolia</i>	өндөр уул, нуурын зах	Галуут, Жаргалант	ховор
7	Дөрвөлжин мүгээ	<i>Rhodiola quadrifida</i>	өндөр уулын таг, бэл хормой хад асгатай уулархаг газраар	Эрдэнэцогт, Галуут, Жаргалант, Гурванбулаг	
8	Бөөн цэцэгт лүзэсгэлэн	<i>Libanotus condensata</i>	Өндөр уулын нугад	Эрдэнэцогт, Гурванбулаг	
9	Цөөн цэцэгт улаагана	<i>Ribes pauciflorum</i>	Өндөр уул, нуруунд	Баянзүрх уул, Улаан даваа	
10	Цагаан дэгд	<i>Gentiana algida</i>	Өндөр уул, нуруунд	Эрдэнэцогт, Галуут, Баянбулаг, Гурванбулаг	Ховор эмийн
11	Хар агширгана	<i>Veratrum nigrum</i>	Өндөр уулын ам хөндий нугад	Эрдэнэцогт, Галуут,	
12	Монгол хундгана	<i>Adonis mongolica</i>	Ойн бүслүүрийн доод зах, хээрийн бүсийн дээд захын заагт уулын хормойн болон бэлийн элдэв өвст хээр,	Эрдэнэцогт, Галуут, Гурванбулаг	Нэн ховор
13	Ямаан сэрдэг		Өндөр уул, нуруунд	Баянбулаг, Гурванбулаг, Жаргалант	Нэн ховор
14	Марзны ортууз		Хуурай ам хөндийд	Заг, Жаргалант, Баянбулаг	
15	Монгол тарваган шийр		Цөлөрхөг хээрт	Галуут, Жаргалант,	ховор, эмийн
16	Бужгар сараана		Уул нуруунд	Жаргалант	Нэн ховор,

					эмийн
17	Өргөст ортууз		Хад асгатай хуурай энгэр бэлээр	Баянбулаг Гурванбулаг	
18	Урт буурцагт тарваган шийр		Уулын өвөр хөндий	Баянбулаг Бөмбөгөр	Ховор, эмийн
19	Өргөст тошлой		Гурванбулаг сумын Хөх нуур, Гурванбулаг уул	Гурванбулаг	эмийн
20	Өрөл		Хар ат ууланд	Бөмбөгөр	эмийн
21	Ацан ажигана		Хайрга чулуутай, хуурай хээр бүхий энгэр, асга хад заримдаа мөлгөр хайрга элсэрхэг хөрсөнд	Бүх сумдад, уулын болон тал хээрт	Ховор, Эмийн ургамал
22	Цөлийн аргамжин цэцэг	<i>Cistanche deserticola</i>	Элсэрхэг хотос хоолой	Баянлиг	Нэн ховор эмийн
23	Хуурамч хонин арц	<i>Juniperus pseudosabina</i>	хад асгатай уулархаг газраар	Баянлиг, Баянговь	Нэн ховор, эмийн
24	Морин зээргэнэ	<i>Etheda equisetina</i>	цөлийн уулын хээрт	Баянлиг, Баянговь, Шинэжинст, Богд	Нэн ховор, эмийн
25	Үнэгэн сүүлхэй лидэр	<i>Sophora alopesuroides</i>	цөлийн хээрт	Баянлиг, Богд	ховор, эмийн
26	Грубовын ортууз	<i>Oxytropis Grubovi</i>	цөлийн хээрт	Говийн сумд	Нэн ховор
27	Урал чихэр өвс				
28	Элдэв навчит улиас	<i>Populus diversifolia</i>	цөлийн хээрт	Баянлиг	Нэн ховор
	Алтан харгана	<i>Caragana</i>	хад асгатай элсэрхэг уулархаг гадарга бэлээр	Говийн сумд	Нэн ховор
	Монгол хунчир	<i>Astragalus Mongolicus</i>			Ховор
	Потанийн хотир				
	Баруунхуур айн чихэр өвс	<i>Glycyrrhiza squamulosa</i>	цөлийн хээрт	Богд, Баянлиг, Баацагаан	Нэн ховор, эмийн
	Үсхий нохойн хэл				
	Цагаан дэгд	<i>Gentiana algida</i>			ховор
	Шарилжин навчит хувилганга	<i>Pedicularis abrotanifolia</i>	цөлийн хээрт	Говийн сумд	Нэн ховор, эмийн

	Монгол хундага				
	Алтаншар шарилж	Artemisia xanthochroa	цөлийн хээрт	Говийн сумд	Нэн ховор, эмийн
	Согтоонги дэрс	Achntherum inebrians	уулархаг гадаргаар	Говийн сумд	ховор
	Семеновын гиш	Vicia Semenovii	цөлийн хээрт	Говийн сумд	ховор
	Пиллотын шивэлз	Ptilagrostis pellota	уулархаг гадаргаар	Говийн сумд	ховор
	монгол тавилгана	Coteneaster mongolicus	цөлийн хээрийн уулын бэлээр	Говийн сумд	
	Юнатовын хунчир	Astragalus Junatovii	цөлийн хээрийн уулын бэлээр	Говийн сумд	
	Иконниковын чаргай	Scorzeneria ikonnikovii	цөлийн хээрийн уулын бэлээр	Говийн сумд	
	Тоорой	Ulmus pumuila	давсархаг нуга нам хотост	Говийн сумд	

Ерөнхий дүгнэлт

1. Төлөвлөлтийн хугацаанд Баянхонгор аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд мал аж ахуйн үйлдвэрлэл тэргүүлэх байр суурийг эзэлсэн хэвээр байх бөгөөд гагцхүү түүний чанар чансааг дээшлүүлэх нэгжээс авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх чиг бодлогыг барина. Үүний тулд нийгэм эдийн засгийн хөгжилийн өнөөгийн нөхцөл байдал, тулгуурлан хэтийн төлөвийг 2005 - 2010, 2010 - 2015, 2015 - 2020 он хүртэл 5 жилийн хугацаатайгаар 3 үе шатаар төлөвлөв. Энэ хугацаанд газар тариалангийн үйлдвэрлэлийг туслах чанартайгаар хөгжүүлж тэжээл үйлдвэрлэлийн бат бөх бааз суурийг бий болгоно. Үүнд
2. Бэлчээрийн газарт уламжлалт чөлөөт газар ашиглалттай бэлчээрийн мал аж ахуй ноёрхох боловч цаашид түүний эзлэх хувь хэмжээг багасгаж эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэл барина. Ийнхүү чөлөөт газар ашиглалттай уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн бүсэд 8 844 791га талбай буюу нийт бэлчээрийн 90 гаруй хувийг, эрчимжсэн фермерийн мал аж ахуйн бүсэд 36 912га талбайг, хосолмол аж ахуйн бүсэд 15 891га, өрхийн мал аж ахуйн бүсэд 5 068 га талбайг тус тус хамруулав.
3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөхүүлэн дэмжих зорилгоор малын тэжээл тариалах талбайн хэмжээг эрс нэмэгдүүлж 30 000 га талбайд хүргэнэ. Үүний тулд бэлчээрийн газраас урд ашиглаж байгаад хаягдсан буюу атар сонголтоор илрүүлсэн талбайг хагалах замаар нийт 31406га талбайг шинээр эзэмших ба услалтын системийн барилгыг засварлаж усалгаатай талбайн хэмжээг га-д хүргэнэ. Мөн өрхийн хэрэгцээний төмс хүсний ногоог өөрийн бүс нутагт тариалж дотоодын хэргэцээгээ бүрэн хангана.
4. Одоогийн байгаа хадлангийн талбайг тордон сайжруулах, иргэд, аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх замаар түүний ашиглалтыг сайжруулан сум орон нутгийн дотоодын болон хувиарт эдлэн эзэмшилтэй эрчимсэн мал аж ахуйн хэрэгцээг хангах чигийг баримтлана. Төлөвлөлтийн хугацаанд бэлчээрийг усжуулах, тордон сайжруулах тарималжуулах, хаших замаар хадлангийн талбайн хэмжээг 39833 га талбайгаар нэмэгдүүлнэ.
5. Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээнд зориулан гэр хорооллын газар 293.8 га, барилга байгууламжийн доорхи газрын хэмжээг 151.4 га, хот тэлэх

- бүсийг 163.6 га талбайгаар тус тус нэмэгдүүлэхээр төлөвлөв. Үүнд Баян-Овоо, Өлзийт сумыг Баянхонгор хотын нэг баг байхаар төлөвлөв.
6. Уурхайн газарт одоогийн ажиллаж байгаа уурхайнууд лицензийн талбайгаа 100% бүрэн дүүрэн ашиглахад олборлолтын талбайн хэмжээ 14620 га болохоор төлөвлөв.
 7. Ойн сангийн газар нь хортон шавьжинд идэгдэх, түлш болон ахуйн хэрэгцээнд түлээ мод огтолж байгаатай холбогдуулан ойжуулалтын ажлыг 100 га талбайд, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг 540 га талбайд, нийт 12600 га талбайд байгалийн сэргэн ургалтанд дэмжих ажлыг хийхийн дээр одоогийн байгаа мод үржүүлгийн талбайг өргөтгөх замаар 154 га байхаар төлөвлөв.
 8. Шинээр баригдах аялал жуулчлал амралт сувилалын газрууд, хүүхдийн зусланд зориулан 48 га газар бэлчээрээс хасагдаж байна.
 9. Нийт 623.9 мянган га бүхий 10 хэсэг газрыг улсын тусгай хамгаалалтанд авч байгаа бөгөөд энэ хэмжээгээр ойн сангийн газраас хасагдах болно
 10. Уг ажлын нэг онцлог тал бол тухайн нутаг орны нийгэм эдийн засгийн хөгжилийн хэтийн төлөвийг газрын нөөц, нөхцөлийн судалгаан дээр тулгуурлан газрын ангилал тус бүрээр хийсэнд оршино. Энэхүү бичиг баримтаар нийгэм эдийн засгийн хөгжилийн төлөв тодорхойлогдоод зогсохгүй газрын нөөцийг эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай ашиглах, түүнийг унаган төрх байдлаар нь хадгалах, хамгаалах зэрэг байгаль орчны цогц асуудлуудыг хөндөж өгснөөрөө чухал ач холбогдолтой. Мөн түүнчлэн газрын харилцаа, газар эзэмших ашиглах эрх зүйн орчин боловсронгуй болох, газар ашигласны төлбөр түрээсийн орлого нэмэгдэх, ингэснээр түүнийг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгийн эх үүсвэр бүрдэх боломж тодорхой хэмжээгээр бүрдэнэ.

Ашигласан хэвлэлийн жагсаалт

1. Аймгийн ГЗБЕТөлөвлөгөө болосруулах арга зүйн заавар. 2006.
2. Баянхонгор аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр
3. Баянхонгор аймгийн хөгжлийн үндсэн чиглэл
4. Баянхонгор хотын ерөнхий төлөвлөгөө
5. Баянхонгор аймагт нийгэм эдийн засгийн болон байгаль экологийн талаар хэрэгжиж байгаа төслүүдийн судалгааны тайлангууд
5. Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал (1996 он)
6. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (1994 он)
7. Монгол улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр (1998 он)
8. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001 он)
9. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (1998 он)
10. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (1997 он)
11. Төрөөс хөдөөгийн хөгжлийн талаар баримтлах бодлогын чиглэл (1996 он)

12. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2000 он)
13. Монгол улсын Засгийн газрын “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”-ийн бодлогын баримт бичиг
14. Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал (1995 он)
15. Монгол улсын эдийн засаг, нийгмийн 2002 оны хөгжлийн үндсэн чиглэл, 2003-2005 оны хөгжлийн хандлага (2001 он)
16. Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр (1996 он)
17. Төрөөс ХАА, Хүнсний үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого /2002 он/
18. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр /2000 он/
19. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр /2002 он/
20. Баянхонгор аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллын тайлан, 2005
21. Баянхонгор аймгийн статистикийн мэдээ, 2005.
22. Ш. Цэгмид” Монгол орны физик газар зүй” 1969.
23. Ш.Баясгалан Д.Даваадорж . Монгол орны ХАА-н уур амьсгалын лавлах.1996
24. Баянхонгор аймгийн цаг уурын станцын мэдээ,2005
25. Баянхонгор аймгийн хөрсний тайлбар бичиг, зураг.1983
26. А.А.Юнатов БНМАУ-н ургамлан нөмрөгийн үндсэн шинжүүд.1976.
27. Баянхонгор аймгийн бэлчээрийн ТБЧУХБ. Глобус ХХК. 2002.
28. Баянхонгор аймгийн тариалангийн талбайн хэмжилт бүртгэлийн материал,УГЗБХЗТИнститут, 1985.
29. Баянхонгор аймгийн тариалангийн талбайн хөрсний элэгдэл эвдрэлийн тайлбар бичиг, ГБХүрээлэн, 1991.
30. Баянхонгор аймгийн тариалангийн талбайн хянан баталгааны материал. ХАУТЛ. 1999, Глобус ХХК.2005.
31. Д. Доржготов “ Монгол орны хөрс, 2003.
32. Баянхонгор аймгийн газар ашиглалтын зураг 1:50 000
33. “Ойн судалгаа, ой зохион байгуулалтын ажил” Ой хайгуул төслийн төв,1991
34. “Баянхонгор аймгийн заган ой” Ой хайгуул төслийн төв,1990
35. Баянхонгор аймагт усалгаатай ашиглаж болох талбайн судалгаа” УХТЭШХ,1982.
36. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. /Байгалийн ургамлын тухай Монгол Улсын хуулийн ховор ургамлын жагсаалт № 153. 1995 оны 8-р сарын 25.
37. Байгалийн ургамлын тухай Монгол Улсын хуулийн хавсралт. Нэн ховор ургамлын жагсаалт.